

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ НЭГДСЭН ХУРАЛДААН



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-110
<hr/>	
1.“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а/ хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжлэл/	9-10
2.“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжлэл/	10
3.“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	10-17
4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	17-37
5.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх	37-93
6.“Женев хотноо 1958 онд баталсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	93-106
7.Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай	107-110

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
03 дугаар сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Баделхан, Э.Бат-Амгалан, Б.Бейсен, С.Ганбаатар, Н.Ганибал, Ц.Идэрбат, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Н.Учрал, Д.Цогтбаатар, Ж.Чинбүрэн, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Д.Батлут, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан, Э.Батиугар, Д.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Ж.Мөнхбат, Ш.Раднаасэд;

Тасалсан: Б.Жавхлан;

Хоцорсон: С.Батболд- 1 цаг 30 минут, С.Одонтуяа- 40 минут, Ж.Сүхбаатар- 20 минут, Ж.Эрдэнэбат- 1 цаг 50 минут.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:12/

**Нэг. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а/ хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжлэл/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а/ хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 6

Бүгд: 46

87.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а/ хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./10:20/

**Хоёр. “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжлэл/**

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 5

Бүгд: 46

89.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./10:21/

**Гурав. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө ишлэжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Х.Булгантуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын Засгийн газрын референт Д.Нямдэлгэр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ, менежментийн багийн ахлах нягтлан бодогч Н.Найданболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Х.Булгантуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, Б.Энх-Амгалан, А.Адьяасүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Х.Булгантуяа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хууль санаачлагч байхгүй тул хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэхийг хойшлуулав.

Уг асуудлыг 10 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

*Дөрөв. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Тогтохсүрэн, Д.Өнөрболор, Б.Энхбаяр, Б.Энх-Амгалан, С.Одонтуяа, Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ш.Адьяа нар үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 21

Бүгд: 49

57.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

***Тав.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Дашпүрэв, мөн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга И.Батхүү, Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх, Аудитын менежер Б.Долгорсүрэн, аудитор Б.Булган, А.Мөнхбадрал, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын референт Д.Бямбадулам, С.Нямбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын тандалт судалгааны багийн ахлагч, судлаач Б.Анар, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Үнэлгээ, мониторингийн багийн ахлах референт А.Цэвээнгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Санчирдорж, Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга А.Мөнхбат, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Нарангэрэл, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Баасанпүрэв, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Хонгорзул, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Энхбат, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дарга Ц.Батбаатар, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн талаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх, тайланг хэлэлцсэн талаар Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хорооноос хамтран гаргасан санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг нар танилцуулав.

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 76 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 65.8 хувийн ирцтэйгээр 13 цаг 08 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутаас эхлэв.*

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 00 минутаас хуралдааныг даргалав.*

Танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, М.Оюунчимэг, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Д.Сарангэрэл, Б.Энхбаяр, Г.Амартүвшин, Ш.Адьяаа, О.Цогтгэрэл, Ч.Ундрам, Ц.Мөнх-Оргил, Ж.Батжаргал, С.Одонтуяа, Б.Жаргалмаа, Т.Доржханд, Б.Баттөмөр, Б.Баярсайхан, Д.Өнөрболор нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Хонгорзул, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв.

Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцлээ.

*Уг асуудлыг 16 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа. “Женев хотноо 1958 онд баталсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга Э.Мөнхнасан, мөн газрын ахлах шинжээч Ц.Нэргүйбаатар, шинжээч Ц.Баяржаргал, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Ажлын албаны мэргэжилтэн

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

А.Энхболд, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн дарга Н.Зориг, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Тээврийн салбарын эрхлэгч И.Базаррагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, Ш.Адъяаа, Б.Дэлгэрсайхан нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хэлэлцээрийг соёрхон батлах тухай санал хураалтыг хойшлуулав.

*Уг асуудлыг 17 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

#### ***Долоо.Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 17 цаг 59 минутаас хуралдааныг даргалав.*

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Жамъянгийн Мөнхбатыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн 25

Татгалзсан 17

Бүгд 42

59.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжсэн тул Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс



2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:02/

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн урилгаар Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 8в ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн “Лобби” бүлгээс санаачилсан “Шүгэл” төслийн талаар танилцуулж, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нь амжилт хүсэв.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 7 цаг 01 минут үргэлжилж, 76 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 65.8 хувийн ирцтэйгээр 18 цаг 03 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 08 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023  
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР  
ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** УИХ-ын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Олон улсын иргэний нисэхийн конвенцын 50 дугаар зүйлийн а/хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл,

2 дугаарт, Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Энэ 2 үргэлжлүүлэн хэлэлцэнэ, завсарлага авсан байгаа юм.

3-д, “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төсөл,

4-т, ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

5-д, Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын ЗГ-ын 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.

6-д, Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

7-д, Женев хотноо 1958 онд баталсан дугуй тээврийн хэрэгслүүд тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НУБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн орсон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл,

8 дугаарт, УИХ-ын гишүүнээс чөлөөлөх тухай асуудал хэлэлцэнэ.

Маргааши энэ нийтийн албаны хууль. Монгол Улсын ЗГ-аас энэ нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зөрчлийг зохицуулах тухай хуулийг маргааши хэлэлцэнэ. Энэ ЗГ-ын гишүүнээс чөлөөлөх тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг маргааши хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж өгөөч гэж хүсэлт ирүүлснийг харгалзаж маргааши хэлэлцэхээр болсон байна.

2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Олон улсын иргэний нисэхийн конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ дахь АН-ын бүлгээс завсарлага авсан.

Завсарлага авсантай холбогдуулан АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлэх үү. Ганибал гишүүн завсарлага авчихсан юм. Завсарлагын хугацаа,

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үргэлжлүүлж хэлэлцэх үү гэдгийг. Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Олон улсын иргэний нисэхийн конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ тогтоолын төслөөс АН-ын бүлэг өнгөрсөн 7 хоногт завсарлага авсан. Завсарлага авсан гол шалтгаан нь энэ навигацитай холбоотой навигацийн орлого гээд улсын төсөвт бас хэдэн зуун тэрбумаар тавих тооцогдох хэмжээний орлого тавьчихсан байдаг. Нөгөө талдаа энэ маань маш их хэмжээгээр тасарчихсан байдаг. Энэ нь бас уг гарал үүсэл нь дайнтай холбоотой бас энэ дайнтай холбоотой авсан хориг арга хэмжээнүүдтэй холбоотойгоор ийм эцсийн дүндээ энхийг эрхэмлэж байсан манай улсын хувьд ийм том хэмжээний бас төсвийн тасалдал орлогын дутагдал үүсчхээд байгаа. Тэгэхээр үүний учир шалтгаан болоод үүн дээр цаашид бид нар бас ямар бодлого баримталж болох вэ? Бид нар бас яаж эдийн засгийн хувьд хохирол багатай эндээс гарч болох вэ гэдэг бодлогын шийдэл бас хаана байна вэ гэдэг дээр АН-ын бүлгийн зүгээс бас өнгөрсөн 7 хоногт ийм утга санаатайгаар завсарлага авсан.

Тэгээд энэ хууль санаачлагчид болоод хуулийн төслийг оруулж ирсэн хүмүүсээс энэ зүйл дээрээ илүү цаашид энэ эдийн засгийн асуудал дээрээ илүү бас анхаарч ажиллана биз. Тэгээд энэ конвенцыг цаашид үргэлжлүүлэн хэлэлцэхийг дэмжиж байна.

**Г.Занданиатар:** Ингээд завсарлагын хугацаа дууссан байна.

Энэ асуудлыг энэ конвенцтой бас шууд холбогдохгүй гэдгийг бас Зам, тээврийн хөгжлийн сайд хэлсэн. Ингээд Монгол Улс, Олон улсын гэрээний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а/ хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар эцэслэн батлах санал хураалт явуулна.

Нийт гишүүдийн олонхоор энэ хуулийн төслийг соёрхон батлах ёстой. Энэ бол конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталж байгаа нэг өгүүлбэртэй л хууль байгаа. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд УИХ-ын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно оо гэж заасан. Энэ заалтын дагуу хуулийг эцэслэн батална.

Байнгын хорооны саналаар протокол соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Өнөөдрийн анхны санал хураалт, бүртгэлийн санал хураалт явуулж байна. Гишүүдийн ирцийг бүртгэнэ ээ, энэ санал хураалтаар. Эсрэг дарагдсан гишүүд чуулганы хуралдаанд оролцоогүй таслагдаж байна гэж гарч ирж байгаа шүү. Адьшаа, Анандбазар, Батсуурь, Болорчулуун, Булгантуяа, Ганбат, Мөнх-Оргил, Оюунчимэг, Саранчимэг, Тэмүүлэн, Хүрэлбаатар, Цогтгэрэл, Чинзориг, Л.Энх-Амгалан нарын 14 гишүүд ирцэд бүртгэлтэй боловч саяын бүртгэлийн санал хураалт дээр татгалзсан горимоор гарч байна.

Дашдондогийн Ганбат гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн 2 хүрээд ирээч. Сайн байна уу. Хүмүүсээ дуудаж байгаарай.

Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Протокол соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Тест гэж би хэлсэн.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Техникийн бүрэн бүтэн байдлын шалгалтын санал явуулахад Одонгийн Цогтгэрэл, Ганзоригийн Тэмүүлэн нарын гишүүд дэмжсэн боловч. Бүртгэлийн болон төстийн санал хураалт дууссан. Одоо санал хураалт явуулна. Адьшаа гишүүн байсан юм байна шүү дээ. Та саналаа өгчихвөл, тэгээрэй.

Ингээд санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар Протокол соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Доржханд гишүүн саналаа өгөөрэй.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Хуулийн төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Хуулийг уншиж танилцуулъя. Энэ протокол соёрхон батлах тухай энэ олон улсын конвенц баталж байгаа хуулиуд нэг л өгүүлбэр байгаа гэдгийг би бас сануулаад уншиж танилцуулъя.

Протокол соёрхон батлах тухай. Нэгдүгээр зүйл. Канад Улсын Монераль хотод 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан Олон Улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а/ хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг Монгол Улсын ЗГ-ын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.20 цаг

Дараагийн асуудалд орёё.

**Олон Улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Байнгын хорооны саналаар хуулийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа суугаарай.

Бас нийт гишүүний олонхоор буюу 39-өөс дээш гишүүн дэмжиж байж хууль эцэслэн батлагдах хуулийн дэгтэй гэдгийг сануулаад санал хураалтдаа орёё.

Байнгын хорооны саналаар Протокол соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хуулийн төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Зам, тээврийн хөгжлийн сайд аа.

Уншиж танилцуулъя. Протокол соёрхон батлах тухай. Нэгдүгээр зүйл. Канад Улсын Манериал хотод 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг Монгол Улсын ЗГ-ын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.21 цаг

Дараагийн асуудалд орно.

**“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлын талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Амарбаясгалан

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сайд байгаа юм уу. Нямбаатар сайд танилцуулчих уу.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

**Х.Булгантуяа:** Эрхэм УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлд УИХ төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргах бүрэн эрхтэй гэж заасан. Төрийн өмчид байгаа илүүдэлтэй ашиглалтгүй эд хөрөнгийг хэрэгцээ шаардлагатай байгаа орон нутагт шилжүүлж хөрөнгийн зохицуулалт хийх, Төрийн хэмнэлтийн тухай, ЗГ дахь хяналтын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хяналтыг сайжруулах зорилгоор “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг улс орон даяар зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гарган ажилладаг бөгөөд уг тооллогын дүнгийн дагуу төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн суудлын автомашиныг орон нутгийн хэрэгцээнд шилжүүлэх асуудлыг тогтоолын төсөлд тусгасан болно.

ЗГ дахь хяналтын тухай хууль батлагдсанаар МХЕГ, 21 аймаг, нийслэл дэх салбар нэгжийг татан буулгаж чиг үүргийг нь холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлэхээр болсонтой холбогдуулан шилжин ажиллах төрийн

албан хаагчдын ажиллаж байгаа эд хөрөнгийг орон нутгийн өмчит байгууллагад шилжүүлэх шаардлага үүссэн тул мөн төсөлд тусган боловсрууллаа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна. Индэрт урьж байна.

**Ч.Ундрам:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь дараах зорилгоор тогтоолын төслийг боловсруулж өргөн мэдүүлсэн байна. Үүнд: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан тус газрын эзэмшилд байсан төрийн өмчийн эд хөрөнгийг аймгийн ЗДТГ, БОАЖГ, Эрүүл мэндийн газар, Боловсролын газарт шилжүүлэх, хот суурины ус хангамж ариутгах татуургын байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцдаг байгууллагууд аймаг, нийслэлийн өмчид шилжсэнтэй холбогдуулан шинээр баригдсан болон хуучин ашиглаж байсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үйлчилгээ, арчилгаа, цэвэрлэгээ, зохицуулалт, хэрэглээнээс хамаарч, орон нутгийн өмчид байлгах, нийтийн эзэмшилд зориулан Улсын төсөв, ТӨК-аас санхүүжүүлэн барьсан хөрөнгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит байгууллага хариуцах, нийгмийн эрүүл мэндийн түргэн тусламж үйлчилгээ, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зорилгоор аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагад эд хөрөнгө шилжүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинуудыг алслагдсан сумдын цагдаагийн, эрүүл мэндийн байгууллагууд болон хот тохижилт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчийн байгууллагад шилжүүлэх. Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж төсөл санаачлагч үзсэн бөгөөд тогтоолын төслийг Ди парламент. мн цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Ч.Ундрам төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэхэд ямар зарчмыг баримтлан хуваарилсан талаар болон аймгийн төвөөс алслагдсан сум, багт дахин автомашин хуваарилах боломжтой эсэх талаар, УИХ-ын гишүүн Б.Баттөмөр ТӨК-уудын менежмент засаглалыг сайжруулах бодлогын асуудлыг УИХ хэлэлцэж тавилга эд хөрөнгийг орон нутагт шилжүүлэх асуудлыг ЗГ агентлагийн түвшинд шийддэг болох талаар, УИХ-ын гишүүн С.Чинзориг орон нутгийн өмчид шилжүүлж байгаа автомашинуудыг эхний ээлжид эрүүл мэндийн газруудад хуваарилах боломжийн талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг

та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хүрэлбаатарын Булгантуяа Монгол Улсын сайд, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Барсүрэнгийн Баасандорж ЗГХЭГ-ын дэд дарга. Баасандорж хаана байгаа юм. Баасандорж даргыг дуудъя. Энэ ордонд байж байж яагаад орж ирдэггүй юм бэ. Баасандорж даргыг дуудъя. ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, ТӨБЗГ-ын дарга Болдын Цэнгэл, ЗГХЭГ-ын Салбарын удирдлага зохицуулалтын газрын дарга Шаравын Мөнхцэрэн, ЗГХЭГ-ын салбарын удирдлага зохицуулалтын газрын ЗГ-ын референт Дамбын Нямдэлгэр, ТӨБЗГ-ын төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга Даваахүүгийн Нарангэрэл, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт шалгалтын багийн ахлагч Даваанямын Ган-Эрдэнэ, ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газрын менежментийн багийн ахлах нягтлан бодогч Нанзаддоржийн Найданболд. Барсүрэнгийн Баасандорж, Дорждэрэмийн Цолмон нар Ажлын хэсэг хууль санаачлагч байхгүй бол хуулийн төслийг хэлэлцүүлгийг хойшлуулж болно гэж заасан байгаа шүү. Тэр хаана байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуух асуулт асуух УИХ-ын гишүүд нэрээ бүртгүүлнэ ээ. Амгалангийн Адьяасүрэн гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьяаа гишүүн асуулт асууна.

**Ш.Адьяаа:** Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх тухай энэ хуулийн төсөл өнөөдөр энэ УИХ-д орж ирж байна. Энэ хэчнээн төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх юм бэ гэсэн нэг ийм мэдээллийг авъя.

Нөгөө талаасаа энэ чинь Монгол УИХ-ын ЗГ-аас хэмнэлтийн тухай хууль бид нар батлаад үүнийг хэрэгжүүлэх тухай өнөөдөр яриад л явж байгаа. Гэтэл өнөөдөр энэ их хэмжээний хөрөнгийг дуудлага худалдаагаар зарж борлуулаад, төсвийн шаардлагатайгаа бусад зүйлд зарцуулах ийм бодлого байж болдоггүй юм уу. Тэгээд л хөдөө орон нутагт байгаа ААН-үүд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд чинь бас сандал ширээ тэр бүх юм чинь байж л байгаа шүү дээ. Тэгээд энэ хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлнэ гэж ЗГ нэг юм ярьдаг. Гэтэл дахиад л тэр хэмнэлтийн хууль хэрэгжих асуудал энэ бодлого чинь ерөөсөө хэрэгжихгүй байгаа. Тэгээд үүнийг зарж борлуулаад тэр төсвийн бусад зүйлд зарцуулах ийм боломжийг яагаад эрэлхийлж болохгүй байна. Энэ олон сандал ширээ, олон машин тэрэг, техник тэгээд үргүй зардлууд чинь улам нэмэгдэж байгаа шүү дээ. Энэ дээр ямар бодлого байна гэдэг нэг хариулт авъя.

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг 85 Болдын Цэнгэл.

**Б.Цэнгэл:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр УИХ-ын оруулж ирж байгаа асуудал дан ганц автомашины асуудал биш хөдлөх болон үл хөдлөх хөрөнгүүдийн асуудал орж ирж байгаа. Машины тухайд ерөнхийдөө үлдэх өртөгтэй балансын үнэ нь нэг ойролцоогоор нэг тэрбум орчим төгрөгийн ийм балансын үнэтэй тээврийн хэрэгслүүдийг үлдэх өртөгтэй учраас төрийн өмчөөс орон нутгийн өмч рүү шилжүүлэх энэ асуудлыг бид оруулж ирж байгаа юм. Бусад оруулж ирж байгаа асуудлын тухайд гэх юм бол Дарханы станцын хөрөнгөөр хийгдсэн буюу төрийн хөрөнгөөр хийгдсэн гэрэлтүүлгийн системийг орон нутгийн яг харьяалах байгууллагад нь шилжүүлэх, үүнийг бас худалдах боломжгүй. Үүнийг шууд ингээд шилжүүлж байгаа. Иргэдээ ая тухтай амьдрах нөхцөл боломжийг хангах үүднээс нь шилжүүлж байгаа.

СХД-ийн хүүхэд эмэгтэйчүүдийг түр хамгаалах байрыг тухайлбал хүүхдийнх нь хүүхэд залуучуудын хэлтэст дүүргийн хэлтэст нь шилжүүлж өгөх жишээтэй. Ийм асуудлууд явж байгаа. Машины тухайд гэх юм бол төрийн хэмнэлтийн хууль гарсан. Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хөдөө сая өвөлжилт хүндэрсэн ийм аймгууд, энэ хуулийн 6.5-д заагдсан байгууллагуудад шилжүүлэх ЗГ-ын шийдвэр гарсан учраас үүнийг үлдэх өртөгтэйг нь УИХ-ын тогтоолоор шийдье. Үлдэх өртөггүйг нь бол Төрийн өмчийн бодлого төлөвлөлтийн газар өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд шийдэх нь зүйтэй гэж засгаас шийдсэн дагуу энэ асуудалд орж ирж байгаа юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя. Нэг 1 минут.

**Г.Адьяа:** Энэ зөвхөн машины тухай асуудал яриагүй ээ. Үл хөдлөх хөрөнгийн асуудал. Түүнчлэн энэ эд хогшил тавилгын асуудлуудыг хөндөж асуусан байгаа. Нөгөө талаасаа энэ Боомтын сайд чинь энэ асуудлыг хариуцаад байгаа юм байна. Тэгэхээр энэ Боомтын сайд энэ төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх энэ асуудлыг яагаад хариуцдаг юм. Дээр нь энэ боомт руу энэ эд хөрөнгө бас шилжих гэж байгаа юм уу? Энэ нэг эргэлзээтэй асуудал байна. Энэ асуудал дээр Булгантуяа сайдаас би хариулт авъя, үүнийг хариуцаад энэ Боомтын сайд чинь өөр чиг үүрэгтэй гэж бид ойлгож байгаа. Гэтэл энэ нэг орон нутгийн өмч хөрөнгийг шилжүүлэх, худалдан авах энэ асуудал чинь бас Боомтын сайдын харьяанд очсон юм уу гэдэг ийм асуудлыг надад нэг хариулт өгмөөр байна.

**Г.Занданшатар:** Булгантуяа сайд хариулъя.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Х.Булгантуяа:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Үүнийг ЗГ-ын хэрэг эрхлэхээс оруулж байгаа. ЗГ-ын хэрэг эрхлэхээс төрийн өмчийн удирдлага зохицуулалтын газартай оруулж байгаа. Тэгээд хэрэг эрхлэхийн дарга өнөөдөр эзгүй байгаа учраас өмнөөс нь үгийг нь уншиж танилцуулж байгаа юм. Тэгээд манай ажлын хэсэг төрийн өмчийн удирдлага зохицуулалтын газар, ЗГ-ын хэрэг эрхлэхээс холбогдох бас мэргэжилтнүүд нь байгаа.

**Г.Занданшатар:** 83, нэмж хариулъя.

Адьяаа гишүүний асуултад тодруулж хариулъя. ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар хяналт шалгалтын баг Ган-Эрдэнэ.

Энэ сандал ширээг орон нутаг руу шилжүүлж байгаатай холбоотой асуудал дээр өнгөрсөн онд мэргэжлийн хяналтын байгууллага салбарын яаманд болон орон нутгийн байгууллагууд руу хяналтынхаа чиг үүргийг шилжүүлсэн. Үүнтэй холбоотой 21 аймаг, нийслэл рүү 1079 албан тушаалтан өөрийн хэрэглэж байсан компьютер, тоног төхөөрөмж, сандал ширээтэйгээ тухайн хяналт хэрэгжүүлж байгаа орон нутгийн болон төв байгууллагууд руугаа шилжиж очсонтой холбоотойгоор чиг үүрэг нь шилжиж байгаатай холбоотой, албан тушаалтнуудын тоног төхөөрөмж, ширээ сандал, нэг бүрийн техник хэрэгслүүд хамтдаа шилжиж байгаа асуудлыг энэ тогтоол дээр оруулж ирсэн байгаа гэдгийг тодруулж хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Товч тодорхой нэг ажлын хэсэг хариулчхаж болдоггүй юм уу? 84.

**Д.Нарангэрэл:** Барилга байгууламжийн тухайд гэвэл энд цөөхөн барилга орж ирсэн байгаа. Хүүхэд хөгжлийн чиглэлээр Дорнод аймгийн Тагнуулын хэлтэс шинэ барилгатай

болоод хуучин барилгыг нь Хүүхэд залуучуудын хөгжлийн төв болгоё гэсэн санал орон нутгаас ирсэн. Энэ саналыг ЗГ-аас дэмжсэн учраас тогтоолын төсөлд Дорнод аймгийн өмчид шилжүүлэхээр орж ирсэн байгаа. Үүнийг худалдах санал гараагүй. Орон нутагт нь шилжүүлээд зориулалтаар нь ашиглаад явъя гээд.

Мөн прокурорын газрын барилга шинэ барилга ашиглалтад орсон учраас хуучин барилгыг цагдаагийн байгууллагад байр талбай дутагдалтай байгаа учраас өгье өө гэсэн ийм юу байгаа.

Дээрээс нь тэр СХД-ийн хүүхэд хөгжлийн төв, хүүхэд эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад нь зориулаад төсөл хэрэгжүүлэхэд зориулаад барилгыг нь шилжүүлж байгаа. Ийм л 3 төрлийн барилга байгаа. Эд нарыг дуудлагын худалдаагаар худалдах боломжгүй байсан.

Автомашин тухайд гэвэл дуудлагын худалдаагаар бид нар татан төвлөрүүлсэн машинаас худалдаж байгаа, худалдсан орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байгаа. Энэ жагсаалтад хамарч байгаа машин бол эрүүл мэндийн байгууллага ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энэ ер нь маш хүндэтгэлгүй хандаж байна. Үүнийг ер нь хойшлуулна аа, тэгж байгаад. Юу ч гэсэн Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асуучих. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна.

**Б.Энх-Амгалан:** Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай тогтоолын төслийг дэмжиж байгаа юм. Үүнийг ТӨБЗГ нэлээн ул суурьтай судалж оруулж ирсэн байх гэж найдаж байна. Би асуулт асуухгүй үг хэлье.

Тэгэхдээ ер нь зарим нэгэн улсын онц чухал объектуудыг хувьчлах асуудлыг бас эргэж харах ёстой, орон нутгийн



2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

өмчид шилжүүлэх асуудлаа бас эргэж харах шаардлага хэрэгцээ байгаа юм. Энд харилцаа холбооны харилцааны салбарын зарим нэгэн нийгэмд үйлчилгээ үзүүлдэг ийм зөвшөөрөл тусгай зөвшөөрөл олгодог ийм хэсгүүдийг бас салбар нэгжийг хувьчлах асуудал их буруу байна гэдэг нь харагдаад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр зэрэг эм эн өргөтгөлтэй сайт, FM радиогийн энэ төслүүдийг чинь ингээд өгчихсөн, тэгээд тэрийг нэг хүн ингээд хуваарилаад сууж байдаг. Тэгээд үүнээс болоод бас нэг аюулгүй байдлын асуудал, тэгээд мэдээллийн тархцын асуудал, тэгээд дуртай хүн нь авдаг, тэгээд түүгээр дамжуулж янз янзын мэдээлэл тархи угаалт явагддаг ийм асуудлууд байх ийм нөхцөл байдал байгаа юм.

2 дахь нь цэвэрлэх байгууламж ариутгах татуурга усан хангамжийн асуудал. Ариутгах татуургын байгууламжуудыг бас шилжүүлж, хувьчлах нь бас их осолтой байгаад байгаа юм. Одоо энэ Харгиа гээд цэвэрлэх байгууламж, ус суваг ингээд л төв цэвэрлэх байгууламж руу химийн хорттой бодис оруулаад байна. Түүнээс болоод энэ умбуур бодис нь байхгүй болоод байна, ашигтай бактериуд нь устаад байна, цэвэрлэх байгууламж хэвийн ажиллах нөхцөл нь бүрдэхгүй байна, яг хажууд нь бас ийм юм байгуулчхаад яваад байна гээд ингээд ийм асуудлууд яриад байдаг юм. Тийм учраас энэ чинь бас их чухал объект юм байна гэдэг ийм ойлголт байгаа.

Дараагийнх нь энэ дулаан халаалттай холбоотой асуудал, эрчим хүчний хангамжтай холбоотой асуудал, ДЦС-тай холбоотой асуудлуудыг нэлээн анхаарахгүй бол Говь-Алтай аймаг гэхэд хамгийн өндөр үнэтэй дулаан халаалт хэрэглэж байгаа юм. Хамгийн өндөр үнэтэй цахилгаан хэрэглэж байгаа юм. Тэгээд яадаг гэхээр зэрэг жоохон өвөл болоод ирэхээр зэрэг нөгөөхийгөө хаагаад хаячихдаг. Тэгээд ЭХЯ тэрнийх нь араас хөөцөлдөөд л гүйгээд байдаг, тэгээд өвөл болчихсон хойно нөгөөдхийг нь эрхийг нь цуцалж болдоггүй, яаж ч болдоггүй

ингээд хамгийн өндөр үнэтэй ингээд дулаан халаалт хэрэглэдэг ийм юм руу орчхож байгаа юм. Бас энэ Тусгай хамгаалалттай газар нутаг дээр байж байгаа төрөөс өмнө хийгдсэн энэ рашаан сувилал буюу энэ байгалийн цогцолборт газар хийгдсэн энэ юмнуудыг чинь бас ингээд орон нутгийн өмчид шилжүүлчихээр Иргэдийн хурлаараа оруулаад нөгөөдхийг нь аваачаад хувьчилж байна гээд тэгээд газар хөзөртэй нь зараад хаячихдаг ийм юмнууд сая аудитын дүгнэлтээр гарсан. Тэгэхээр ийм чиглэлийн чухал объектуудыг бас хамаагүй ингээд хувьчлах, хувьд шилжүүлэх энэ асуудлуудыг бас эргэж харж байж улсын онц чухал объектуудынхаа бас нэг жагсаалтууд дээр бас нэг эргэж харах шаардлага хэрэгцээ байна шүү гэдгийг би бас та бүхэнд хэлж байгаа юм. Та бүхэн үүнийг анхааралдаа аваарай. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах уу. 85 Болдын Цэнгэл. Цэнгэл дарга аа, тэр хураагдсан машин энэ тэрүүдийн хуваарилалтыг та яаж будилуулж байгаа юм? Түүнийгээ бас яриарай.

**Б.Цэнгэл:** Энх-Амгалан гишүүний асуулт юу санал хэлсэн. Гэхдээ бид Энх-Амгалан гишүүний ярьж байгаа асуудалд онцгой анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал бид Замын-Үүдийн дулааны станц ашиглалтад орсонтой холбогдуулаад 2 уурын зуухыг тухайлбал нэгийг нь Говь-Алтайд, тийм нэгийг нь Хөвсгөл аймагт бас шилжүүлэх асуудал өнөөдрийн энэ бас тогтоол дотор орж ирж байгаа. Ер нь энэ орон нутагт байж байгаа энэ уурын зуух болон энэ бага оврын станцуудыг хувьчлах асуудал дээр бас нэлээн болгоомжтой хандах гэдэг байр суурийг бид барьж байгаа. Аймгийн Засаг даргаас хувьчлах тухайд санал орж ирсэн боловч үүнийг бид түдгэлзүүлсэн байж байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Амгалангийн Адыасүрэн гишүүн асуулт асууна.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**А.Адьяасүрэн:** Ингээд төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө ишлжих болгонд УИХ-аар хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэр гарах гэж цаг заваа их барах юм. Судлаад үзэхэд ингээж хэлэлцэж ирсэн практик 1996 оноос хойш эхэлсэн юм байна. Жишээлэх юм бол, би ингээд энэ өнөөдөр Баянхонгор аймагт юу хуваарилагдаж байгаа юм гээд харах дээр зэрэг ингээд нэг тавилга, эд хогшил, нэг 52 ширхэг ширээ сандлын асуудал, 24 ширхэг ширээ сандлын асуудал бүүр сүүл рүүгээ хоёрхон ширхэг үл хөдлөхийн асуудлыг бид нар ингээд ярих гээд энд сууж байгаа байхгүй юу. Гэтэл ингээд л Монгол Улсад бидний хийх ажил зөндөө байна шүү дээ. Жишээлэх юм бол Гэр бүлийн тухай хуулийн хүлээлт их байна. Боловсролын тухай хууль хэзээ яаж батлагдах гэж байна гээд боловсролын салбарын багш, ажилтнууд болоод эцэг эхчүүд шаардаж байна. Нийгмийн даатгалын багц хуулиуд, тэтгэврийн шинэчлэлийн тухай гээд маш олон асуудал байхад Их Хурал дэмий юманд цаг заваа үрэх юм гэж би боддог. Иймэрхүү жижиг сажиг асуудлыг ЗГ-ын хэмжээнд нь шийддэг болчихмоор байна шүү дээ. Тэгэхээр одоо энэ асуудлыг одоогийн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэ төсөлд хэрхэн яаж тусгаж байгаа юм бэ?

Ер нь энэ асуудлыг ЗГ-ын хэмжээнд болоод ер нь арай хөнгөхөн шийдэх ямар арга шийдэл байгаа талаар та нар бас саналаа хэлнэ үү гэж би бас та бүгдээс асуух гэсэн юм.

**Г.Занданшатар:** Энэ маш чухал асуулт байгаа юм даа. 87.

Адьяасүрэн гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ Баасандорж. Адьяасүрэн гишүүнтэй ер нь саяын хэлсэн саналтай зарчмын хувьд нэг байна. Яг энэ ч үүднээсээ Монгол Улсын ЗГ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТӨК-ийн тухай хуулиудыг УИХ-д өргөн мэдүүлчихсэн байгаа. Энэ хуулийн төслүүд дээр яг одоо бид нарын өнөөдөр хэлэлцэж байгаа асуудлуудыг ЗГ-ын

түвшинд шийдвэрлэх нь зүйтэй гээд хуулийн төсөлд тусгачихсан байгаа. Харин 96 оны хуулийн яг 8 дугаар зүйл дээр одоо хүчин төгөлдөр үйлдэж байгаа хуулиараа яалт ч үгүй энэ оруулж ирж байгаа асуудлыг Их Хурлаар хэлэлцэх хуультай учраас ингээд ЗГ-аас энэ асуудлыг танилцуулж оруулж ирж ирж байгаа юм.

Мөн тэтгэврийн даатгалтай багц хуультай холбоотой, мөн боловсролын багц хуулиудыг мөн УИХ дээр өргөн мэдүүлчихсэн. Одоо яг хэлэлцэх эсэхээ хийгээд ажлын хэсэг ЗГ-аас өргөн мэдүүлсэн хуулиуд дээр ажлын хэсэг ажиллаж байгаа. Боловсролын багц хуулиуд дээр.

**Г.Занданшатар:** Тэгээд энэ асуудлыг би энэ Болдын Цэнгэл даргад Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль орж ирсэн. Энэ орон нутгийн өмч гэж тодорхойлсон мөртөө өөрөө захиран зарцуулах эрхгүй тавилга эд хогшил одоо 96 оны төрийн ба орон нутгийн өмчийн хуулиас хойш ийм буруу практик явчихсан. Ингээд Их Хурлаар орж ирж шийдэгддэг, тавилга, эд хогшил, машин тэрэг, өмч гэдэг чинь ерөөсөө өмчийн эрх зүйн үндсэн ойлголт нь өөрөө захиран зарцуулах эрхтэй байхыг, эзэмших ашиглах эрхтэй байхыг өмчийн эрх зүйн үндсэн суурь ойлголт шүү дээ. Тэгээд орон нутгийн өмч гэж нэрлэдэг мөртөө орон нутаг нь өөрөө захиран зарцуулах цаашилаад нарийвчлаад ярих юм бол энэ бонд өмчийн эрх зүйн бүх асуудал ингээж шийдэгддэггүй. Үүнээс чинь болоод орон нутгийн өмч гэж байхгүй ерөөсөө л төрийн өмч гэж байгаад захиран зарцуулах ашиглах эрх нь орон нутагтаа байдаг. Ийм нэгдсэн өмчийн ойлголт олон улсын эрх зүйд байгаа. Энэ холбооны улс л биш бол орон нутгийн өмч гэж байхгүй гэсэн. Өмч гэж байгаа л юм бол тэр чинь захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрх нь бүүр цаашилбал өмчлөх эрхтэйгээ нягт уялдах ёстой. Тэгээд энэ ингээд, ийм хуулийн гажуудал, хуулийн энэ зөрчил, хийдэлтэй байдлыг засаа гэхээр засахгүй.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгсэн мөртөө Эрдэнэт гээд том асуудал болохоор УИХ-аар оруулж ирдэггүй ишийдчихдэг практиктай. Тэгээд тавилга, эд хогшил, машин тэрэг ингээд шилжүүлэх болохоор УИХ дээр орж ирээд ингээд цаг зав аваад байдаг.

Үүнтэйгээ ер нь хуулийн төслөө оруулж ирэх ёстой байхгүй юу. Ингээд хууль санаачлагч байхгүй байгаа учраас энэ асуудлуудтайгаа цогцоор оруулж ирж. Хэлэлцэх асуудлаас хойшлуулаа. УИХ-д хүндэтгэлтэй хандана. Болдын Цэнгэл гуай та тэр машинууд яасан, тэр хэмнэлтийн хуулиар хураагдсан машинуудын яаж хуваарилсан тэр тайлангаа хамт оруулж ирнэ ээ. Яагаад тэр орон нутгуудад хуваарилахгүй ингээд төрийн тусгай албадад хуваарилахгүй тэгээд хэмнэлтийн хуулиар машинуудыг зөв газарт, орон нутагт нь, тусгай албадад хуваарил гэж өгсөн болохоос биш тэгээд дураараа ийш тийш нь зарцуулаад байх гэж өгөөгүй байх шүү. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй чинь хамт шалгаж үзнэ.

Ийм учраас хойшлуулья.

10.47 цаг

Дараагийн асуудалд орно.

**ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун танилцуулна.

**Х.Болорчулуун:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол УИХ-аас Алсын хараа- 2050, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг салбарын хөгжлийг дэмжих урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг баталсан.

Энэхүү бодлогын хүрээнд ХХААХҮ-ийн салбарт УИХ-д өргөн мэдүүлж яаралтай горимоор батлуулах шаардлагатай 3 хуулийн төслийн нэг нь ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл юм. ХХААХҮ-ийн салбарын бодлого нь ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах нөхцөлийг бүрдүүлж, ДНБ үйлдвэрлэлд салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн МАА-г хот суурин орчимд бүсчлэн хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан хүн амыг эрүүл бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахад чиглэгдэж байна. Энэхүү бодлого зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байсан таримал ургамлын үр, суулгац, сортын үрийн үржүүлэг, ургамал хамгааллын бодис, бордоо, шатахууны импортын худалдаа, ХАА-н техник тоног төхөөрөмжийн дилерийн болон түрээсийн үйлчилгээ, засвар, сэлбэг хэрэгслийн худалдаа, эрчимжсэн МАА-г дэмжих ХАА-н зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээ зэрэг ажил үйлчилгээг аж ахуйн тооцоонд шилжүүлж өөрөө өөрийгөө санхүүжүүлэх хэрэгсэл шаардлага үүсэж байна.

Цаашилаад ХАА-н үйл ажиллагааг эрхлэгч нь орлого нэмэгдүүлэх тэдгээрийн зах зээлийн бодит эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, шударга, хүртээмжтэй хуваарилалтын тогтолцоог бүрдүүлэх ХАА-н үйлдвэрлэлийн технологитой уялдсан тасралтгүй нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, дотоодын үйлдвэрлэгчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдүүлэх зорилгоор аж ахуйн тооцоо ТӨК байгуулах нь зүйтэй гэж үзсэн.

Энэхүү ТӨК нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ашигт ажиллагаа, хөрөнгийн ашиглалтыг

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сайжруулах, улсын төсөвт учруулж буй өрийн дарамтыг бууруулах, ХАА-н салбарт олгох дэмжлэгийн нэр төрөл, тоо хэмжээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг бий болгох зэрэг олон эерэг үр дүн үзүүлэх боломжтой юм. Үүний зэрэгцээ ХАА-н үйлдвэр эрхлэгчид тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн таримал ургамлын үр, сорт, бордоо, ургамал хамгааллын бодис, шатахуун, газар тариалангийн тоног төхөөрөмж, усалгааны багаж хэрэгслийг хямд үнээр тариалангийн технологийн хугацаанд нийлүүлэх болно.

Мөн үйлдвэрлэлийн менежментийг сайжруулан шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх буудайн хадгалалтын нөхцөл нь сайжрах цаашлаад үр ашиг нэмэгдэнэ гэж тооцож байна. Иймд дээр дурдсан ач холбогдлыг харгалзан ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн ХАА-г дэмжих сан болгон уг санг эшилсэн бусад заалтуудыг хасах замаар ХАА-н дэмжих санг татан буулгах, ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Индэрт урьж байна.

**Ж.Батсуурь:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2023 оны 3 сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар ХАА-г дэмжих санг ХАА-н корпорац ТӨХХК болгосноор ХАА-н үйл ажиллагаа эрхлэгчдийн орлого нэмэгдэж, зах зээлийн бодит эрэлт хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, шударга, хүртээмжтэй хуваарилалтын тогтолцоог бүрдүүлэх, ХАА-н үйлдвэрлэл технологитой уялдсан тасралтгүй нийлүүлэлтийн сүлжээ бий болгох, дотоодын үйлдвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж, хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Ж.Батжаргал ТӨК болсноор хаврын бэлтгэл ажилд хүндрэл үүсэх эсэх, УИХ-ын гишүүн Г.Амартүвшин компанийн хэлбэрт шилжсэнээр гарах бодитой өөрчлөлтийн талаар, УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн компанийн засаглал, өмчлөл, чиг үүргийн талаар асуулт асууж, хариулт авсан болно. УИХ-ын гишүүн Батжаргал хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа хэдий ч тусгай сангийн чиг үүргийг шинээр байгуулагдах ААН-д бүрэн хийдэлгүй шилжүүлэх зорилго бүхий хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоолын төслийг шинээр боловсруулах, улмаар шинээр байгуулагдах компанийн засаглалд малчид, иргэд ААН-ийн төлөөллийг оруулах замаар хамтын оролцоог хангах төрийн өмчийг хязгаарлах нь зүйтэй гэсэн саналыг гаргасан байна.

ЗГ-ын тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хууль шинэчилсэн найруулгын дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хууль түүнд нэмж шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Жамбын Батсуурь гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүн ХХААХҮ-ийн сайд, УИХ-ын гишүүн Хаянгаагийн Болорчулуун, тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, тус яамны ГТБХЗГ-ын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, ХАА-г дэмжих сангийн гүйцэтгэх захирал Батжаргалын Цогтсаран, ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Базаррагчаагийн Уранчимэг.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүн байна уу. Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүн асуулт асууна.

**Н.Энхболд:** Зарчмын хувьд ийм юм зохион байгуулалтад орохыг нь дэмжиж байна. Ер нь хуучин сангийн үйл ажиллагаа бас олон шүүмжлэлд өртөж байсан. Удирдлагуудыг нь яаж томилдог, тэр нь яаж ажилладаг гэдгээс эхлээд. Одоо ингээд компанийн зохион байгуулалтад орохоор удирдлага, зохион байгуулалт, томилгоо нь ямархуу байх вэ. Урдхынхаасаа өөр байж чадах уу. Биеэ даагаад үйл ажиллагаа явуулах ийм чадвартай нэгж болж чадах уу. Үүнийг нь юугаар зохицуулах юм. Хууль дээрээ үг үсэг хэрэггүй юм уу, эс үгүй бол хууль

гарсны дараа дахиад тэр компанийг яаж зохион байгуулах, ямар удирдлагатай байх, бизнесийн зарчмаар ажиллах юм уу, эс үгүй бол төрийн байгууллагаас хамааралтай, улс төрөөс хамааралтай байдаг урьдынх маягаараа ажиллах юм уу? Энэ тал дээр нь ямар байр суурьтай бэлдсэн ямар асуудлууд байгаа вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ төв дээрээ ийм ганцхан корпорац байгуулчихлаа. Энэ нь орон нутагтайгаа яаж холбогдож ажиллах юм, хэнтэй нь харьцаж ажиллах юм, шууд ААН-үүдтэй харьцаад явчих юм уу эс үгүй бол аймаг ААН-үүдийн удирдлагатай харьцахгүй, аймгийн удирдлагатай ч юм уу сумын удирдлагатай харьцаад явчих юм уу. Энэ тал дээр ямар бодлого байр суурьтай байгаа вэ?

Ер нь энэ төрийн хамаарлаас салах тал дээр нь ямар ялгаа гарах юм. 2 асуултын гол цаад санаа нь энэ л дээ. Яаж зохион байгуулах юм, тэр төв дээрээ нэг ийм ганц корпорац байх юм бол орон нутаг, аж ахуйн байгууллагуудтайгаа яаж харьцах юм, зарчим нь ямар байх юм. Тэгж л үр дүн гарна уу гэхээс зүгээр нэрийг нь өөрчлөөд энэ дээр ямар ч үр дүн гарахгүй шүү дээ. Урьдын адил тариалан, МАА-г дэмжих сангуудын удирдлагуудыг томилдог тэр зарчмаараа ингээд яваад байвал бас л нэрээ өөрчлөгдсөнөөс цаашиггүй л юм болно. Хамааралгүй болгох энэ улс төрөөс, засгаас хамааралгүй биеэ даагаад явах жинхэнэ бизнесийн зарчмаар ажиллаад явах энэ тал дээр нь ямар өөрчлөлт хийх юм.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Баярлалаа. Нямаагийн Энхболд гишүүний асуултад хариулъя. ХАА-г дэмжих сан хуучин Тариалан дэмжих сан, МАА-г дэмжих сан 2 нийлээд ХАА-г дэмжих сан болсон. ХАА-г дэмжих сан үнэхээр өнөөдөр өр авлагын тулам болсон, өглөг буяны л газар болсон.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Одоо авлага өглөгийнх нь хэмжээ 200 тэрбум хэлбэлзэж байна. Энэ янзаар нь яваад байж үнэхээр болохгүй нь. Аж ахуйн байгууллагын бүтэц зохион байгуулалтаас шалтгаалсан ч юм бий. Бас улс төрийн шийдвэрээр шийдвэр гаргаж хөнгөлөлт, чөлөөлөлтийг маш их хийснээс энэ өр авлагыг чинь нэмэгдүүлсэн тал бий. Ямар ч байсан сан гэсэн байдлаар ингэж төсвийн ард түмний татварын хөрөнгийг ингэж үргүй, цаашид ингэж явуулаад, зарцуулаад байж болохгүй нь гэдэг нь тодорхой болсон.

Ийм учраас ХАА-г дэмжих сан корпорац болж үйл ажиллагааныхаа чиглэлийг зах зээлийн горимд шилжүүлж, аж ахуйн тооцоотой ажиллах, үр бүтээлтэй ажиллах ийм боломжийн хангахын тулд өөрчлөгдөж байгаа юм гэдгийг бас хэлье.

Удирдлагын хувьд яах вэ гэвэл удирдлагын хувьд гүйцэтгэх захирал байгаа, гүйцэтгэх захирал удирдлагыг сонгон шалгаруулалтаар дотооддоо явуулж шалгаруулна. ХАА-г дэмжих сан зөвхөн төвдөө гэхэд 40 гаран 50 шахуу хүнтэй байгаа. Корпорац болсноороо орон тооны цомхотгол хийгдэнэ. Аль болохоор чадварлаг цөөн хүнтэй ажиллах ийм боломж бүрдэнэ. Мөн орон нутгийн Хөтөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий гээд олон газар салбартай. Эд нар ч гэсэн бас дагаад аж ахуйн тооцоон дээр орж ажиллана. Орон тоо, бүтцийн хувьд бас өөрчлөгдөнө өө гэдгийг бас хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууна.

**Н.Энхболд:** Тэр удирдлагуудыг нь томилох, сонгон шалгаруулалт хийх ажлыг нь хэн хийх вэ? Урьдын адил яам төрийн байгууллагуудаас зохион байгуулж хийх үү, эс үгүй бол өөр маягаар хийх үү. ТУЗ ч гэдэг юм уу, тариаланчдын, малчдын бусад чиглэлүүдийн төлөөллийг оруулсан ийм ТУЗ байгаад, тэр нь нөгөө

гүйцэтгэх захирлаа сонгон шалгаруулдаг энэ байдлаар хийж болохгүй юу? Одоо бид нарыг дахиад нөгөө одоо яамнаас шалгаруулаад л эхэлбэл өө тэгээд ялгаагүй л юм байна даа, түрүүчийн адил тэгээд л нэг сонгон шалгаруулалт нэртэй, тэгэхдээ өөрсдийнхөө нөлөөнд ажиллаад байх хүнийг л тавьчихлаа гэсэн ийм яриа гарах вий дээ гэж болгоомжилж байна. Тэгэхээр яг сонгодог бизнесийн зарчмаар ажиллуулъя гэж байгаа бол биеэ даах чадварыг нь хангаж өгсөн тийм ТУЗ-тэй байгаад тэрнээс нь өөрөө тэрэнд нь тал бүрийн төлөөлөл ордог. Тэр нь нөгөө сонго ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Болорчулуун дарга 83, Цэндгомбын Болорчулуун.

Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун Энхболд гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр ХАА-г дэмжих сан татан буугдсанаар цаашид үйл ажиллагааг нь ХАА-н корпорац ТӨК чиглүүлж үйл ажиллагааг нь авч явахаар байгаа. Энэ компани байгуулагдчихсан. Тэгэхээр компани Компанийн тухай хуулиар компанийн дүрмээр зохицуулагдаж үйл ажиллагаагаа явуулна. Тэгэхээр Компанийн тухай хууль дээр Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, ТУЗ-өөсөө гүйцэтгэх захирлаа сонгон шалгаруулалтаар зарлаж ингэж авах ийм зохицуулалттай байгаа. Тэгээд ТУЗ дээрээ нэр дэвшүүлэх хороо гэж байгаа. Энэ хорооноосоо сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаад энэ дээр үүний үндсэн дээр гүйцэтгэх захирлыг томилох ийм зохицуулалттай байгаа. Үүнийг нь компанийн дүрэм дээр тусгаад өгчихсөн байж байгаа. Тийм учраас хуучныхаасаа арай өөрөөр .../минут дуусав/

**Г.Занданшатар:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Энхболд гишүүн ээ. Хуучин ТДС буюу ТД сан одоо нэмэгдээд нөгөө Мал хамгаалах сан 2 болоод ХАА-г дэмжих сан болсон.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Энэ санг ТӨК болгоод тэгээд зах зээлийн зарчмаар нь явуулъя гэдэг ийм санал байна гэж ойлгож байна. Би 2 зүйлийг тодруулъя гэж бодож байна.

Нэгдүгээрт нь, яг өнөөдрийн байдлаар ХАА-г дэмжих сангийн нийт актив хэд байна аа? Энэ дотроос өр, авлага нь ямар байдаг юм, өр авлага, найдваргүй өр авлага нь ямар байдаг юм. Хамгийн чухал юм бол санд энэ л байгаа юм л даа. Тэгээд энэ нь ямар байдаг вэ гээд нэгдүгээрт нь үүнийг асууя.

Хоёрдугаарт нь, бид нар энэ газар тариалангийн салбар бол манай стратегийн гол салбар, стратегийн гол салбар. Бид дэмжих зайлиггүй шаардлага үүсдэг, үүсдэг. Жишээлбэл үрийн бодлого дээр нь ч юм уу, техник технологийн шинэчлэл дээр нь ч юм уу, заавал ингээд дэмжлэг гарч ирдэг. Тэгэхээр цаашидаа төрөөс энэ газар тариалангийн салбарыг дэмжье гэхээр энэ өгч байгаа санхүүжилт энэ сангаар дамжих юм уу, яах юм бэ гэдэг асуудал байгаа юм. Хуучин ЗГ-ын тусгай сан учраас тусгай сангаараа дамжаад явчихдаг. Энэ нь өөрөө хуультай байсан. Тийм. Одоо нэг компани нэртэй болоод бүр хяналтгүй болоод цаашаа явах гэж байгаа юм уу гэдэг асуудал байхгүй юу.

Тийм учраас би 2-т нь энэ цаашидаа төрөөс ингээд стратегийн бүтээгдэхүүнээ дэмжихийн тулд өгч байгаа дэмжлэг энэ сангаар дамжих уу гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр энэ сангийн менежмент энэ сангийн асуудал бол бас анхаарал татахаас өөр аргагүй болоод байгаа юм.

**Г.Занданшатар:** 82  
Батжаргалын Цогтсаран.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ХАА-г дэмжих сангийн гүйцэтгэх захирал Цогтсаран байна. 22 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө буюу актив талдаа нийт 382 тэрбум 642 сая 655000 төгрөг байна. Үүнийг задалж үзүүлбэл

эргэлтийн хөрөнгө нь 299 тэрбум, үндсэн хөрөнгө нь 83 тэрбум, бараа материалын үлдэгдэл 78.2 тэрбум, харилцахад 3.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн хэмжээнд өр төлбөрийг харьцуулж үзвэл богино хугацаат өр төлбөр 138 тэрбум, хугацаа хэтэрсэн өр төлбөр 18 тэрбум төгрөгийн дүнтэй байна. Энэ 18 тэрбум бол 10-аас дээш насжилттай харьцангуй бусад зээлээ бодвол хугацаа хэтэрсэн ийм өр авлага байгаа. Бараа материал нийт 78.2 тэрбум төгрөг байна. Үүнээс нөөцийн бараа материал 74.4 тэрбум, хангамжийн материал 3.7 тэрбумын үлдэгдэлтэй байна. Өр төлбөрийн хувьд иймэрхүү мэдээлэл байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Цэндгомбын Болорчулуун 83.

**Ц.Болорчулуун:** Тогтохсүрэн гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр компанийн үндсэн зорилт дээр тодорхойлоод өгчихсөн, компанийн үндсэн зорилт бол ХАА-н салбарыг дэмжих, дэмжлэгийн нэр төрөл хүртээмжийг нэмэгдүүлэх гээд энэ дүрэм дээр нь ингээд заагаад өгчихсөн байж байгаа. Тэгэхээр энэ салбарт хэрэгжүүлэх өгөх энэ дэмжлэгүүд энэ компаниар үргэлжлээд явна гэж ингэж ойлгож болно.

Хуучин ЗГ-ын тусгай сангийн хууль дээр ХАА-г дэмжих сангийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны чиглэл нь үндсэн 7 чиглэлтэй, 7 чиглэлд үйл ажиллагаа явуулж байсан. Тэгэхээр энэ өсөн нэмэгдэж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйл ажиллагааны цар хүрээтэй холбоотойгоор бид нар компанийн энэ үзүүлэх дэмжлэг үйл ажиллагааны чиглэлийг 16 болгож өргөжүүлсэн байгаа. Тэгэхээр нийтдээ энэ 16 чиглэлд үйл ажиллагаагаа энэ компани явуулаад дэмжлэгээ үзүүлээд явах ийм бололцоотой гэж үзэж байгаа юм. Тэгээд хуучин ЗГ-ын тусгай сангийн тухай хуулиар бас энэ яг бид нарын авч

хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээний зарим нэг нь бас хязгаарлагдмал байсныг 16 болж өргөжүүлж өгсөн байгаа. Тэгэхээр одоо яг энэ зах зээлийн энэ үетэйгээ хөл нийлээд явахад бүрэн бололцоотой гэж ингээж харж байгаа юм.

Төрөөс олгож байгаа яг мөнгөн урамшууллын дэмжлэг бид нар ХААЯ-наасаа, бусад дэмжлэгүүд бол тийм, тийм, энэ сан дээр бас үрийн болон улаан буудайн нөөц бүрдүүлж ирсэн энэ ажиллагааг цаашид компаниараа энэ дэмжлэгүүдээ үргэлжлүүлээд явуулна гэж ингээж тооцоолсон байж байгаа. Энэ компаниараа дамжаад явна л гэж.

### **Г.Занданшатар:**

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

**Д.Өнөрболор:** ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар орж ирж байгаа юм байна. ХАА-г дэмжих санг бас татан буулгаж, ХАА-н корпорац нэртэй компани болгож байгаа юм байна. Санг татан буулгаж байгаа энэ үндэслэлийг нь харахаар сангийн хөрөнгийн чадвар доройтсон, активын чадвар буурсан, эргэлтийн хөрөнгийн хомсдолд орсон гэсэн байх юм. Тэгэхээр энэ яг яам хийж байгаа дүгнэлт юм уу эсвэл энэ хөндлөнгийн хяналт тавьсан байгууллагууд бас өгсөн зөвлөмжийн дагуу хийж байгаа зүйл үү гэж асууя. Холбоотой хэд хэдэн бас асуудлууд байна.

Ер нь энэ сангуудыг тойрсон олон нийтийн маш их олон шүүмжлэл их байдаг. Ер нь яагаад ийм байдалд орох болов оо гэсэн шалтгааныг би бас яг тодорхой асуумаар байна. Энэ сан ер нь энэ хүнсийг нэмэгдүүлэх, энэ хүнсний салбарын үнийн өсөлтийг бууруулах дээр ер нь ямар үүрэг гүйцэтгэж ирсэн бэ? Одоо энэ сангийн байгаа энэ санхүүгийн үзүүлэлт ер нь яг ямар байгаа юм бэ? Сая Тогтохсүрэн гишүүний асууж байгаагаар, миний ойлгосноор бас тайлбар тэр асуултад хариулт өгч

байгаагаар нийт эргэлтийн хөрөнгө нь 299 тэрбум, нийт хөрөнгө төгрөгийн 382.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй тэгсэн хэрнээ авлага нь 217.2 тэрбум төгрөгийн ийм авлагатай, энэ авлага нь бараг бүхэлдээ ийм найдваргүй болчихсон гэж ойлгогдоод байна. Тэгэхээр ер нь энэ болохоо байгаад тийм ээ, энэ ийм аж ахуйн тооцоонд шилжиж байгаа юм байна гэж ойлгогдоод байна л даа.

Тэгээд ер нь энэ ингээд хараад байхад энэ ТӨК-удын энэ цаг хугацаа, бусдын боломж, энэ хөгжлийн бодлого гээд энэ олон зүйл ингээд алдагдсан байх юм. Энэ алдагдсан боломжийн энэ хариуцлага гэж ер нь зүйл байдаг юм уу, байдаггүй юм уу? Энэ талаар би бас асуумаар байна.

Нөгөөтээгүүр энэ ТӨК байгуулахад энэ маш олон шалгуур шаардлагууд байдаг. Нэн ялангуяа энэ олон улсын жишгээр аваад үзэх юм бол энэ судалгаа, шинжилгээ хийж эрсдэлийг үнэлж байж тийм ээ, хийдэг. Тэгээд энэ сан яг энэ аж ахуйн хэлбэрт шилжихэд яг өнөөдөр бэлэн байгаа юм уу, бэлтгэл нь хангагдсан байгаа юм уу? Энэ хувьцаа эзэмшигчид нь ер нь яг ямар улсууд байгаа юм бэ? Энэ компани боллоо гэхэд ер нь яг өнөөдөр энэ хэдий хэмжээний эргэлтийн хөрөнгөтэй байгаа, цаашид энэ үйл ажиллагаа нь ер нь хэвийн явах тал дээр өөрөөр хэлэх юм бол энэ бизнесийн зарчмаар ажиллах боломжийг нь ер нь хэрхэн бүрдүүлэх юм бэ? Энэ компанийн засаглал, удирдлага зохион байгуулалтын талаар бас тайлбарлаж өгөхийг хүсье ээ.

Энэ ТӨК-ийг олон нийтийн хяналтад шилжүүлнэ гэж бид нар ярьдаг. Тэгэхээр энэ компани олон нийтийн хяналтад байх нөхцөлийг ер нь хэрхэн бүрдүүлсэн байгаа вэ? сая сайдын уншсан мэдээллээс ингээд харахаар үндсэндээ мал, МАА эрчимжсэн МАА гэсэн тайлбарыг хэлж байна. Дурдаж байна. Гэтэл гишүүдэд ирсэн байж байгаа эх сурвалжийг аваад үзэх юм бол зөвхөн газар тариалангийн буюу үр тариа, улаан



2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

буудайн үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллана л гэж ойлгогдоод байгаа. Энэ бичиг баримт дээр. Тэгэхээр ер нь ХАА-н бусад салбар энэ компанийн үйл ажиллагаанд хамаарах уу? Ер нь энэ хүнсний ногоо, МАА ялангуяа эрчимжсэн МАА шилээ дарсан маш их шийдвэрлэх асуудлууд байна. Тэгэхээр энэ асуудлуудыг энэ асуудлаар шийдэгдэж байгаа юу гэдэг тал дээр бас хариулт авъя. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

**Х.Болорчулуун:** Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Яагаад ХАА-н санг ХАА-н корпорац болгож байгаа юм бэ гэвэл аж ахуйн тооцоотой, эдийн засгийн тооцоотой, ашигт ажиллагаатай явуулахын тулд болгож байгаа юм. Зах зээлийн горимд нь шилжүүлж түрүүний хэлдэг өр авлага нь дэндүү их болсон. Тооцоо хяналт алдагдсан. Энэ байдлыг зөвхөн ХХААХҮЯ шалгаж дүгнээд шийдвэрлэж байгаа биш Сангийн яам, Аудит орж байж зайлиггүй энэ бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх шаардлагатай гэсэн бас дүгнэлтэд хүрсэн юм. Ийм учраас бас өөрчлөлтийг оруулж байгаа гэдгийг бас хэлье ээ.

Энэ өр төлбөр бий болсон энэ хариуцлага яаж явагдаж байна вэ, авч байна вэ гэж асууж байна. Сүүлийн 1, 2 жил бас энэ өр төлбөртэй, мөнгөө төлөхгүй, бараа бүтээгдэхүүн техник авчхаад өр төлбөр үүсгэсэн иргэн, ААН-үүдийг өр төлбөрийг нь идэвхтэй хөөцөлдөж байгаа. Мөн төлөхгүй бол Монголбанкны хар дансанд оруулж байгаа. Ингэхэд бас идэвхтэй төлөлт эрс нэмэгдсэн гэдгийг бас хэлье. Корпорац болсноор улам энэ өр төлбөрийг барагдуулах дээр аж ахуйн тооцоон дээр идэвхтэй сайн ажиллана.

Мөн олон түмний хяналтад орох боломжтой юу вэ? Одоогоор энэ сан гэж энэ өглөг буяны газраа үндсэндээ ХАА-н корпорац болгож аж ахуйн тооцоон дээр шилжүүлж байна. Компани болгож.

Цаашидаа тодорхой хувийг нь хувьцаа гаргаж олон түмний хяналтад, мөн тариалангийн ААН-үүдэд шилжүүлэхэд болохгүй юм байхгүй ээ. Энэ тал дээр бас судалгаа бас хийгдэж байгаа гэдгийг бас хэлье.

Мөн энэ сан өнөөдрийг хүртэл бас Монгол Улсын газар тариалангийн хөгжилд мэдээж хэдий муу дутагдалтай тал байгаа ч гэсэн тодорхой үр дүнг өнөөдрийг хүртэл бас үзүүлж ирсэн. Ялангуяа үрийн хөнгөлөлт, тарианы болон ногооны үр, мөн малын удмын сангийн хөгжил энэ болгон дээр энэ сан дандаа дэмжлэг үзүүлж, Монголын ХАА-н хөгжилд бас үнэтэй нэг хувь нэмрээ оруулсныг бас хэлмээр байна.

**Г.Занданшатар:** Үйл ажиллагааны чиглэл гэсэн, үйл ажиллагааны чиглэл 83 Болорчулуун.

**Ц.Болорчулуун:** Өнөрболор гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр цаашид үйл ажиллагаа явуулах ХАА-н корпорац ТӨК-ийг 2021 оны ЗГ-ын 394 дүгээр тогтоолоор байгуулсан байгаа. Тогтоолд байгуулснаар төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь ХХААХҮЯ байгаа. Одоо бол үйл ажиллагааны чиглэл нь ЗГ-ын тусгай сан буюу ХАА-г дэмжих санд 7 чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ нь бас энэ зах зээлийн одоогийн энэ үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэж байгаатай холбоотой бид нар энэ УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх гээд энэ олон арга хэмжээг хэрэгжүүлэхэд бас хязгаарлагдмал байгаа учраас компанийн цаашидын үйл ажиллагааг 16 чиглэлд явуулахаар ингэж бас өргөжүүлж тэлж өгсөн байж байгаа. Тийм учраас бид нар энэ компани байгуулагдсанаар компанийн тухай хуулиар алдагдал хүлээхгүйгээр ашигтай ажиллах зарчмыг баримталж бас тодорхой үр дүнгээ өгсөн. Энэ салбарт хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнгээ өгсөн. Ийм төрийн өмчит хуулийн этгээд байна гэж ингэж тооцоолж байгаа.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

**Б.Энхбаяр:** Хуучнаар ХАА-г дэмжих сан, МАА-г дэмжих сан гэж байсан. Энэ сан нэлээн асуудал болж, тэгэнгүүт нь нэрийг нь өөрчлөөд, муу нэрээ цэвэрлээд ХАА-н дэмжих сан болгосон л доо нэгтгээд. Одоо бол тэнэ санг ХАА-н корпорац төрийн өмчийн компани болгох гэж байгаа юм байна. Компани дотроо паблик компани биш ХХК болгох гэж байна. Ингээд гол зорилго ашгийн төлөө үйл ажиллагаа болгоно оо гэж байгаа юм байна. Тэгэхээр би хууль санаачлагчаас буюу ЗГ-аас 2, 3 асуулт байна.

Нэгдүгээрт, УИХ-ын гишүүн Цогтбаатар нарын гишүүд санаачлаад төрийн өмчийн компанийг нэгээр ч нэмэхгүй байх хуулийн тогтоолын төсөл санаачлаад УИХ намрын чуулганы төгсгөлд хэлэлцэх эсэхийг нь шийдсэн. Тэгэхээр УИХ бол төрийн өмчийн компаниудыг ер нь нэмэхгүй байх, эсрэгээрээ паблик болгох, олон нийтийн хяналтад оруулах, татан буулгах ийм бодлогыг баримталж энд үүний төлөө байгаа. Тэгэхээр энэ бодлоготой хэр нийцэж байгаа юм бэ гэсэн эхний асуулт байна.

2 дахь асуулт нь, ер нь яамд аж ахуй үйл ажиллагаа эрхэлдэг явдал бол энэ 30 жилд худлаа үлгэр, авлига, мөнгө угаалт болж дууссан гэдэг нэн тодорхой болж байгаа юм. Өнгөрсөн парламентын хувьд тэр ТДС гээд түүний чинь бараг 50 хувийг нь манай нэг Хөдөлмөрийн баатар 14 компаниараа дамжуулаад хүртэж байсан гэдэг зүйлийг энэ Хүрэлбаатар сайд ярьж байсан шүү дээ. Энэ УИХ-ын чуулганд. Тэгээд шалгалтын дүнгээ болохоор гаргаагүй олон нийтэд, ил болгоогүй. Тухайн үед энэ Сангийн яам шалгаж байсан юм шиг байгаа юм. ЗГ-т танилцуулсан юм шиг байгаа юм. Энэ ер нь яг юу болж дууссан бэ гэсэн 2 дахь асуулт байна.

3 дахь асуулт нь, ер нь энэ ноос, ноолуур, гурил энэ тэгээд газар тариалангийн хөтөлбөрүүд бол бүгд эрх мэдэлд ойр бүхий хүмүүсийн хамаарал бүхий компаниудад хөнгөлөлт үздэг давуу байдал олгодог зүйл гэдэг нь нэн тодорхой болж байгаа, нэн тодорхой болж байгаа. Энэ бол дэмжих биш ер нь дэмжих гэдэг үгэнд нэг итгэлгүй болчихсон шүү. ЗГ-ын хөтөлбөрүүд бүгд дэмжих гэдэг гоё үгтэй. Энэ сангууд бүгд дэмжих гэдэг гоё үгтэй. Тэгээд үүний цаана дандаа худлаа, тийм сайхан сэтгэлийн үзүүрт дандаа шар тос биш, атга ийм хар юм байдаг гэдэг юм бол их тодорхой болоод байгаа шүү дээ. Энэ баланс цэвэрлэх гээд байна уу, үгүй юу. Зүсийг нь хувиргаад. Тэгээд төрийн өмчийн компани гэхээр чинь баланс нолиос эхлэх гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ яг ямар учиртай юм болох гээд байна аа?

Бид нар сая Хөгжлийн банкны сонсгол дээр 14 онд хэрэгжүүлсэн Баттулга Ерөнхийлөгчийг ХАА-н сайд байхад хэрэгжүүлсэн тэр 260 тэрбум төгрөг Голомтоор дамжуулаад зээлчихсэн, сайдынх нь тушаалаас өөр нэг ч материал ХААЯ-нд байхгүй гэж гарч ирсэн шүү дээ. Ямар ч материал байхгүй.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. ХАА-г дэмжих сан ТӨК болоод ер нь ямар хэрэгтэй юм бэ гэж асууж байна. Би энэ дээр бас хэд хэдэн үндэслэлүүдийг хэлье ээ. Нэг, төрийн зарим чиг үүргийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байсан таримал ургамлын үр, суулгац, сортын үрийн үржүүлэг, ургамал хамгааллын бодис, бордоо, шатахууны импортын худалдаа, ХАА-н техник тоног төхөөрөмжийн дилерийн болон түрээсийн үйлчилгээ, засвар, сэлбэг хэрэгслийн худалдаа, эрчимжсэн МАА-г дэмжих, ХАА-н зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээ зэрэг ажил үйлчилгээг аж ахуйн

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тооцоонд шилжүүлж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, бие даасан үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ ээ. Хамгийн гол нь.

2-т, ХАА-н үйл ажиллагаа эрхлэгчдийн орлого нэмэгдүүлэх тэдгээрийн зах зээлийн бодит эрэлт хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.

3-т нь, ХАА-н үйлдвэрлэгчийг зах зээлийн үнийн өсөлт, санхүүгийн дарамтаас хамгаалах шударга хүртээмжтэй хуваарилалтын тогтолцоог бүрдүүлнэ.

4-д, ХАА-н үйлдвэрлэлийн технологитой уялдсан тасралтгүй нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн богино хугацаанд хариу арга хэмжээ авч хэрэгдүүлэх боломж бүрдэнэ.

5-д нь, үйлдвэр үйлчилгээний ашигт ажиллагааны түвшинийг 5 хувиас хэтрүүлэхгүй байж ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд таатайгаар нөлөөлөхүйц дэмжлэг үзүүлэх боломж бүрдүүлнэ.

6-д нь, үйлдвэрт шаардлагатай засвар үйлчилгээ технологийн шинэчлэлийг богино хугацаанд хийж гүйцэтгэснээр байгууллагын өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

7-д нь, авлага барагдуулалтын чиглэлээр санхүүгийн урамшуулалд тулгуурласан бодлого хэрэгжүүлсэн мөнгөн хөрөнгийн хуримтлал нэмэгдэж төлбөрийн чадвар дээшилнэ. Өөрөөр хэлбэл авлага тэр дундаа хугацаа хэтэрсэн авлага сайжирна, барагдуулалт.

Эдийн засгийн бодит үр ашиг нийгмийн үр өгөөжийг хослуулсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж бараа материалын илүүдэл нөөцөөс сэргийлнэ. Бодит эрэлт хэрэгцээнд тулгуурласан

төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, байгууллагын хөрөнгийн зохистой харьцаа бүрдэж, төлбөрийн чадвар сайжирна. Улсын төсөвт учирч буй өрийн дарамтыг бууруулна, зээлжих чадвар нэмэгдэх зэрэг олон ач холбогдолтой гэдгийг бас хэлье ээ.

Цаашидаа таны хэлдгээр үүнийг хувьцаа эзэмшигч нь ХХААХҮЯ байгаа, паблик компани болгоход болохгүй юм байхгүй. Энэ тал дээр бас судалгаа хийгдэж байгаа гэдгийг бас хэлье. Энэ паблик компани болох ялангуяа олон нийтийн газар тариалангийн компаниудын дундын корпорац болох энэ ажил бүр 10 гаран жилийн өмнө бас яригдаж л байсан юм. Өнөөдрийг хүртэл бас сан гэсэн байдлаар ингээд яваад ирсэн, сан гэсэн нэг өглөг буяны газар болсон энэ өр авлага нэмэгдүүлсэн энэ байгууллагаа ямар ч байсан эхний ээлжид төрийн өмч өмчит корпорац болгож ингэж шийдэх нь туйлын зөв алхам гэдгийг бас хэлье.

Энэ цаашидаа паблик компани болох үйл ажиллагаа идэвхжиж байна гэдэгт итгэл төгс байна.

Сая асуулаа. Өөрөө бас энэ Энхбаяр гишүүн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг зарим компаниудын мөнгө угаалт болсон юм биш үү. Зарим компаниуд ингээд өр авлага их үүсгэсэн гэж байна. Өнөөдөр яг авлага, өглөгийнх нь харьцаа 200 тэрбумд эргэлдэж байна. Өөрөө аж ахуйн тооцоон дээр явж чаддаггүй ийм хязгаарлагдмал үйл ажиллагаа сан болохоор, корпорац болсноор энэ байдал өөрчлөгдөнө.

3-д нь, ХАА-н хөнгөлөлт чөлөөлөлт хэрэгтэй юм уу гэж байна. Бүх улс орон ХАА-даа тэр тусмаа газар тариаландаа ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Гүйцээж хариулах уу? Хаянгаагийн Болорчулуун гишүүн, сайд гүйцээж хариулъя.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Х.Болорчулуун:** Бүх улс орон ХАА тэр тусмаа, газар тариаландаа хөнгөлөлт чөлөөлөлтийг урамшууллыг ямагт олгож байдаг. Манайхаас тааламжтай цаг агаартай, бороо хур элбэгтэй, өндөр ургац авдаг газар хүртэл ХАА-даа хөнгөлөлт чөлөөлөлт, үр бордоо, шатахуун техникийг олгож урамшууллыг олгож байдаг. ХАА-н компаниуд, ялангуяа газар тариалан, компаниуд аж ахуй салбар бол хэдийгээр татвар төлөлт, уул уурхайтай адилхан өндөр биш ч гэсэн маш их нийгмийн харилцааг үүсгэдэг. Хөдөлмөр ажлын байрыг олноор бий болгодог. Өөрөөр хэлбэл нийгмийн салбар.

2 дугаарт, аливаа улс орон хүнсээрээ гаднын хараат болохыг хэзээ ч хүсдэггүй. Тийм учраас стратегийн хүнсийг бий болгож энэ дээр бодлогын ач холбогдолтой дэмжлэгүүдийг үргэлж өгч явдаг юм гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууя.

**Б.Энхбаяр:** Тэгэхээр ХАА-г дэмжинэ гээд ХААЯ өөрөө дэргэдээ нэг компани байгуулж дэмжинэ гэдэг логикийг би ойлгохгүй байгаад байгаа юм. Энэ чинь өөрөө компани байгаад байна шүү дээ, ашигийн төлөө. Тэгэхээр энэ чинь эсрэгээрээ ХАА-н бизнес эрхэлж байгаа хувийн хэвшилтэйгээ өрсөлдөнө гэж ойлгоод байна шүү дээ. Ашигийн төлөө юм чинь. Төр тэд нартай өрсөлдөж яах гээд байгаа юм. Одоо энэ сая сонсгол хийж байхад би харлаа, энэ энэ салбараас. Энэ алтан тариан Цэнгүүнээс өөр ер нь төрийн дэмжлэг энэ зээлд хамрагдаагүй, мөндгөрөөрөө явж байгаа бизнес байхгүй юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ чинь бизнесийн чөлөөт өрсөлдөөнийг нухчхаад байна шүү дээ. Эрүүл өрсөлдөөн гарч ирэх боломжгүй, 3 хувийн, 8 хувийн бизнестэй яаж 10 хувийн 20 хувийн зээлтэй бизнес өрсөлдөгч өрсөлдөх юм. Нухчин дараад байгаа байхгүй юу. Төр өөрөө.

**Г.Занданшатар:** Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Сан гээд би түрүүнд хэллээ шүү дээ. Өр авлагынх нь хэмжээ маш их болчихсон, 200 тэрбумыг эргэлдэж байна. Энэ байдлыг цаашид зогсоож, эдийн засгийн эргэлтийг нь сайжруулж, энэ корпорацыг компанийнхаа аж ахуйн тооцоон дээр аж явуулах л ийм шийдвэртэй энэ асуудал орж байгаа. Цоо шинэ сангийн тэр баланс дээр байгаа дебет кредитийг арилгаад байхгүй болгоод нэрийг нь өөрчлөөд корпорац болгож байгаа асуудал биш ээ. Энэ тэнд байгаа дебет кредит, өр авлага бүгд балансаас баланст шилжинэ ээ. Харин үүнийг улам цэвэрлэх, цэгцлэх ажиллагаа компани болсноороо хэрэгжинэ. ХАА-н корпорац бол юу ХАА-н компаниудтайгаа ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Тэгэхдээ ер нь энэ хууль ер нь энэ 1 минут нэмнэ гэж байхгүй л дээ. Энэ тэгээд энэ ХАА-г дэмжих сангийн хөрөнгийн чадвар доройтож эргэлтийн хөрөнгийн хомсдолд орсон нь, тэгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа талаар санхүү эдийн засгийн дүгнэлт гарах ёстой. Энэ дүгнэлт гараагүй. Яагаад ингээд ЗГ-аас бүрдэлт дутуу юмыг өргөн баригдуулахгүй шүү гэж байхад Тамгын газар ийм хууль авсан юм бэ? Санхүү, эдийн засгийн дүгнэлт, Сангийн яамны дүгнэлт байхгүй, энэ буруу практик тогтоогдсон байна гэж байна. ХАА-н дэмжих санг татан буулгахтай холбоотой харилцааг зохицуулах буюу өөр харилцааг зохицуулах зорилготой хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслөөр өмнө нь баталсан дээрх хуульд нэмэлт оруулахаар тусгасан нь логикгүй байна, буруу практик тогтоож байна.

Хүчин төгөлдөр болох хугацааг их хууль дээрээ тодорхойгүй байхаар заасан зохицуулалтуудын хооронд зөрчилтэй байна. Тэгээд энэ хувийн хэвшлийн хяналттай юм байхгүй бол энэ сангууд чинь ингээд л ахиад л муу өглөг, авлага, ахиад л нэг юм авлига хээл хахууль, эргэж төлөгдөхгүй хамгийн гол нь. Удирдлага

менежментийн тогтолцоог нь боловсронгуй болгох юм тодорхойгүй.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна. Түүнд Болорчулуун сайд саяынхаа тодорхой хариулаарай.

**Б.Энх-Амгалан:** Би энэ ХАА-н корпорац болох гэж байгаа санааг нь дэмжиж байгаа юм. Тэгсэн ороод ирсэн хуулийнх нь юмнуудыг нь харахаар бас их эвгүй болоод байна л даа. Та нар яаж бодохоор энэ ХАА-н дэмжих сангийн тайланд байгаа тэр хөрөнгө өр авлагыг ХАА-н корпорац руу шилжүүлэхээд тэгээд тэд нар корпорац болчихоор өр нь амархан барагдчихна гэж гаргалгаа гаргаж байгааг би нэгдүгээрт ойлгохгүй байна.

Хоёрдугаарт, энэ хуучин материал импекс техникийн импорт шиг л нэг баахан импорт л хийж баахан худалдаа хийх нь л дээ. Трактор, комбайн, техник тоног төхөөрөмж, усалгааны багаж хэрэгсэл таримал ургамлын үр, суулгац гээд л, бордоо гээд л баахан л юмнууд шатах тослох материал, бензин тос зарах юм байна л даа, янз нь. Тэгээд энэ чинь 217 тэрбум төгрөгийн өртэй компани юу өртэй ийм сан аваад тэгээд корпорац болчихоор өр нь арилаад ашигтай ажиллана гэдэгт би л лав итгэхгүй байна. Яаж тооцоо гаргахаар ингээж гаргасан юм. Тэр сан чинь ААН-үүдэд зээл олгоод буцаад авах гэж байгаа л ийм үйл ажиллагаа шүү дээ. Тэгээд чанаргүй зээл л олгосон байна шүү дээ. Буруу зээл олгосон байна шүү дээ, эргээж төлж чадахгүй компанид олгосон байна. Тэгээд өөрсдөө энэ үйл ажиллагааг явуулахаар зэрэг үүнийг төлчихнө өө гэдэг юмыг яаж гаргаад байгаа юм бэ? Актив муудсан эргэлтийн хөрөнгө байхгүй болчихсон учраас үүнийг хийнэ гээд нэг юм яриад байдаг.

Хоёрдугаарт энэ чинь нөгөө нэг нэмэгдэхүүний байрыг солиход нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүй гэдэг л юм болох гээд байна шүү дээ. Зарчмын

том өөрчлөлт гараагүй, зүгээр л корпорац болгож байгаа юм. Тэгээд ХХК болгож байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг л өр авлага нь сайжраад л ингээд явчихна гэдэг ийм юм яриад байх юм. Үүнийг би нэгдүгээрт ерөөсөө ойлгохгүй байгаа юм.

Хоёрдугаарт, энэ ХХК болчихоор та нар чинь энэ хувьцаа гаргах юм байна, үнэт цаас худалдаж авах юм байна, тэгээд энэ ТУЗ-тай байх юм байна, Хувьцаа эзэмшигчдийн хуралтай байх юм байна, гүйцэтгэх удирдлагатай байх юм байна ингээд бүтэц чинь данхайгаад яваад өгнө өө. Тэгээд ТУЗ-д чинь 9 хүн байх юм байна, тэр нь тэгээд ХААЯ-наас байх юм байна, тэгээд яам өөрөө компани байгуулж байна гэсэн үг. Тэгээд энэ чинь нөгөө төрөөс олгогдож байгаа хөнгөлөлттэй зээл, хөнгөлөлт чөлөөлт тусламж энэ тэр ингээд ороод ирэхээр нөгөө монопол эрх гээч юм чинь гараад энэ салбарт үйл ажиллагаа яг хэвийн явуулж байгаа нэг хөл дээрээ тогтох гэж ядаж байгаа ААН-үүдээ татаад унагаачихна. Нөгөө төрийн мөнгө уйлдаггүй гэдэг шиг. Тэгээд энэ ТУЗ-д орж байгаа хүмүүс чинь нэг улс төрчийн нэг хамаарал бүхий нөхөр орно. Тэгээд энэ компани цаашидаа ашигтай ажиллахгүй байж байгаад тэгээд энэ сангийн юм. Тэгээд үл хөдлөх хөрөнгө ч үгүй, эргэлтийн хөрөнгө ч үгүй болох ийм юм руу орно л доо. Энэ дээр яг өмнөх юм давтагдаж байгаа.

Аудитын байгууллагаа энэ компани өөрөө сонгоно гэж байгаа юм. Компанийн хуулийн дагуу ажиллана гэж байгаа юм. Тэгээд Компанийн хуулийн дагуу ажиллаж байгаа юмыг бид нар орж үзнэ ээ, ёстой хоншоор нь дутна. Уучлаарай, компанийн тухай хууль дээр явж байгаа юм. Бид нар энэ манайх ХХК, ТУЗ-аараа асуудал оруулаад шийдчихсэн гээд л явчихна. Яг энэ Таван толгой энэ тэр шиг юм болно. Ингээд үүнийхээ ард дахиад зүгээр тэгвэл танай үйл ажиллагаа ямар байгааг үзье гэхээр уучлаарай бид нар аудитаа манай гүйцэтгэх удирдлага өөрөө сонгочихсон, тэгээд тэр аудитын дүгнэлтээр бид нар

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

явна гээд аудитаар захиалгаа хийж байдаг. Ийм юм цаашаа явах юм бол наадах чинь ингээд бодитой ажиллаад, үр дүнтэй явах ийм юм байхгүй байх. Бизнесийн бодит төлөөллүүдийг нь оролцуулаад энэ чинь нийгмийн нээлттэй компани болох юм бол харин хариуцлагажих байх. Тэгээд энэ бүх салбартаа явуул. Тэгэхгүй нэг жоохон бойжих гэж байгаа хэдэн компаниудаа давуу эрхээрээ татаж унагаах л ийм юм надад харагдаад байна л даа. Энэ 2 дээр надад нэг хариулаадхаач.

**Г.Занданшатар:** Болорчулуун сайд хариулья. Саяынхаа асуудлуудад нэгтгээд хариулахгүй бол гишүүдэд их эргэлзээ байна шүү.

**Х.Болорчулуун:** Энхбаяр гишүүн ч түрүүн хэлсэн, сая Энх-Амгалан гишүүн хэллээ. Энэ ХАА-н корпорац бол ХАА-н компаниудтайгаа өрсөлдөхгүй, харин тэднийгээ дэмжиж ажиллана. Түүнээс өрсөлдөөд машин техник оруулаад, тоног төхөөрөмж оруулаад ингээд байх юм биш. Ер нь ХАА дэмжих сангийн үүссэн гол өр нь үндсэн хөрөнгө буюу ХАА-н том үнэ өртөг бүхий техникүүдийг гаднаас зээлээр авдаг, тэрийгээ хөнгөлөлттэй тарааж өгдөг. Олон жилийн хугацаагаар. Эндээс авхуулаад хүү, хүүгийн өрөнд өссөн үндсэн өр үүссэн. Түүнээс эргэлтийн богино хугацааны дэмжлэг үзүүлээд намар нь аваад байх ингэхэд бол ААН-үүд дэмжээд л явчихна шүү дээ. Ялангуяа үр бордоон дээр улсын хөнгөлөлт чөлөөлөлт дэмжлэгийг энэ компаниар дамжуулаад эргүүлээд богино хугацаанд аваад явахад өр нэмэгдэж үүсэхгүй.

Цаашидаа сан гэж ингээд үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байсныг харин өргөжүүлж, аж ахуйн тооцоон дээр ажиллаж, чөлөөтэй болгож, компаниудаа, газар тариалангийн компани, мөн ХАА-н компаниудыг дэмжих үүднээс л энэ байгуулагдаж байгаа. Ер нь цаашидаа хамгийн зөв шийдэл нь олон нийтийн хяналтад

оруулж 50% энэ тэр нь 51 хувийг нь ч яах вэ публик компани болгож ингэх нь зүйтэй гэсэн ийм ер нь чиглэлтэй байгаа. Ийм ч учраас эхний ээлжид тэр сан гэж өглөг буяны газар байсныгаа корпорац болгож шилжүүлж байгаа юм. Цаашидаа таны хэлдгээр олон нийтийн хяналтад оруулахын төлөө бас ажиллана гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн тодруулж асууна, 1 минут.

**Б.Энх-Амгалан:** ХАА-н корпорац гэдэг ХХК бусад компаниудыгаа дэмжиж ажиллана гэдгийг би ерөөсөө ойлгохгүй юм. Энэ чинь ХХК чинь ашгийн төлөө байгууллага байгаа байхгүй юу. Энэ хууль дээр чинь өөрөө байж байна шүү дээ. Компани нь доор дурдсан үндсэн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлнэ. Таримал ургамлын сорт, үр жимс үржүүлнэ, тэжээлийн нөөц бүрдүүлнэ, газар тариалан ХАА уламжлалт болон эрчимжсэн МАА эрхэлнэ, трактор, комбайн, техник тоног төхөөрөмж, хүлэмж, багаж хэрэгсэл оруулж ирнэ. Дотоодын зах зээл дээр үйлдвэрлэдэггүй бараа материалыг импорт оруулж ирнэ. Үгүй тэгээд өрсөлдөхгүй яах ч үгүй бусдыг нь дэмжинэ гэдгийг чинь би ерөөсөө ойлгохгүй байна шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ 9 ТУЗ-ийн гишүүд чинь ХААЯ-наас тавигдаж байхад ямар юмных нь хяналт өрсөлдөхгүй гэх юм байх юм бэ?

Гуравдугаарт, энэ аудитын дүгнэлт чинь өөрсдөө сонгож байхад ямар юмных нь хяналт байх юм бэ. Олон нийтийн компани болж байгаа публик компани болж байгаа үүнийг шууд дэмжээд явахад бэлэн байгаа юм. Энэ оруулж ирсэн төсөл дээр чинь би энэ төслийг нь л уншиж байна шүү. Тэгээд та нар хувьцаа ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Тэр мэргэжлийн холбооны хууль энэ тэр батлагдвал тэр

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Газар тариалангийн холбоо, ХАА-н холбоод энэ тэр нь ТУЗ нь удирдана шүү дээ, 4 талтай л байх ёстой юм байна лээ.

Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Болорчулуун сайдаас бас хэд хэдэн юм асууя. Яах вэ, Болорчулуун сайдын энэ хийж байгаа ажлуудад яах вэ, бас зөв зүйтэй зүйлүүд байгаа. Тэгэхдээ сүүлийн үед ерөөсөө иргэд энэ төрийн институц, ТӨК, ерөөсөө итгэхээ больчихлоо шүү дээ. Сая тэр Хөгжлийн банкны сонсгол дээр та нар харсан л байх. Тэгэхээр энэ агуулга зорилго нь зөв сонсогдоод байгаа юм. Жигтэйхэн гоё ХАА-г хөгжүүлээд л нөгөө хувийн хэвшлийнхнийгээ дэмжээд гээд. Хөгжлийн банк бас зорилго нь тийм л байсан юм шүү дээ. Ерөөсөө улс орны хөгжлийг шинэ түвшинд авчих төслүүдэд зээл өгнө өө л гэсэн. Гэтэл хэлбэр нь болохгүй байгаа байхгүй юу, хэлбэр нь. Тэгэхээр би энэ хэлбэр дээр асар их эргэлзэж байна л даа. Та нар жишээлэхэд МАН-ын бодлого гээд л жигтэйхэн 10 их наядыг зээл өгөөд л ерөөсөө бүх хүмүүсийг л ядуурлаас гаргачихна гэсэн жижиг бизнест тэр зээл чинь очоогүй шүү дээ. Тэр 10 их наядын зээл банкнуудаар очсоны 7 хоногийн дотор Монгол Улсын хадгаламж 5 дахин билүү өссөн гээд Эдийн засгийн байнгын хорооны дарга судалгаатай ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь дахиад л нөгөө хүмүүсийн нөгөө итгэх итгэлийг сулруулсан ийм хачин юм болчих гээд байна л даа. Тэгэхээр энэ корпорацын гол зорилго нь юу юм бэ? Том том бизнесүүдээ дэмжих гээд байгаа юм уу, энэ том том газар тариалангийн, том хүнсний үйлдвэрээ дэмжих гээд байгаа юм уу эсвэл жижиг бичил бизнесийг дэмжих гээд байгаа юм уу гэдэг бас би бас гол зорилгыг нь асуумаар байна. Бичил бизнесийнхэнтэй яаж ажиллах юм. Одоо би хотоос сонгогдсон гишүүн, ерөөсөө хашаандаа ногоо тарья, дарга аа, хүлэмж авах гэсэн юм зээл олдохгүй байна гээд л ингээд явж байна. Тэгэхээр энэ зорилгыг нь нэлээд асуумаар байна.

Хоёрдугаарт, түрүүн Энхбаяр гишүүн нэлээн тодорхой асуучихлаа шүү дээ. Тариалан дэмжих сан гэж байгаад баахан том компаниуд зээл аваад тэгээд хамгийн сүүлд эцэстээ тэр зээл төлөгдөөгүй бүх материалыг нь жалганд аваачиж шатаасан гээд л хэвлэлээр бичээд байсан. Тэгээд энэ өмнөх өрүүдээ та нар яаж барагдуулах юм бэ үүнийг эсвэл тэр банкнуудтай ярьж байгаа юм уу, эсвэл энэ ХААЯ-нд ингээд өр барагдуулахад асуудал маш их байгаа. Тэгэхээр ёстой энэ ХАА-г дэмжих сан дээрээ ёстой энэ шүүр ажиллагаагаа явуулаад энэ өрийг нь ил болгоод ингээд явах хэрэгтэй. Тэгээд Цогтбаатар гишүүн чинь хууль тогтоол батлуулсан шүү дээ, дахиж бурхан минь ТӨК л байгуулахаа больё, энэ ёстой хамгийн том алдаа байлаа гэсэн. Одоо тэгээд дахиад дараагийнх нь орж ирэхээр яах юм үүнийг зохицуулмаар байна. Тэгэхээр миний гол асуулт яг эдийн засгийн тооцоо судалгаа яг яаж гарсан бэ? Энэ корпорац нь байгуулагдаад 23 он, 24 онд яг ямар үр ашигтай ажиллах юм бэ? Компани болох юм байна шүү дээ. Тэгэхээр эдийн засгийн үр ашгийн тооцоог нь би асуумаар байна. Яагаад гэхээр аливаа төсөл дандаа хэмжигдэхүйц байх ёстой. Тэгэхээр энэ тооцоог нэг гарсан бол хэлж өгөөч ээ. Бид нар тэдэн онд ингээд ингээд ажиллах юм, тэчнээн ААН-д зээл өгөх юм, таны хэлээд байгаа бичил бизнесүүдийг чинь ингэж дэмжих юм гэдэг ч юм уу энэ зүйлүүдийг нэг жоохон тодорхой яриад өгөөч гэсэн ийм асуулт байна.

Тэгээд ер нь ард иргэд итгэх итгэл байхгүй болчихлоо л доо. Бизнес эрхлэх ч сонирхолгүй болчихлоо. Тэгэхээр энэ нэг энэ корпорац байгуулснаар дахиад л нөгөө хардлага сэрдлэг үүснэ. Тэгээд л яах вэ гэхээр бид нар чинь бас нэг тойрог тойргийнхоо хүмүүст нөгөө тариаланчид, ногоочид туслах гээд л энэ корпорацынхантай уулзах байх л даа. Ийм ийм төсөл нь байна, үүнийг дэмжээд өгөөч гээд л. Тэгэхээр эргээд л нөгөө дахиад л саяын Хөгжлийн банк шиг нөгөө

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ашиг сонирхлын зөрчлөөр ингээд яриа хөөрөө хийсэн гээд ингээд явчихна. Тэгэхээр энэ заавал ийм корпорац байгуулах яг гол шаардлага нь юу юм. Ер нь бараг энэ бизнесийн эрх чөлөө байхгүй болчихлоо шүү дээ. Нэг социализм руугаа л эргээд яваад байгаа нэг ийм зүйлүүд харагдаад байгаа. Тэгэхээр дэлхий даяараа социализм чинь өөрөө нураад уначихсан байхгүй юу, дэлхийд ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах юм бэ? Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Санг корпорац болгохын ач холбогдол юу вэ гэж байна. Үгүй сан гээд ингээд яваад байж болохгүй байна, өр нь жилээс жилд нэмэгдээд байна. Корпорац болгож аж ахуйн тооцоон дээр ажиллуулах зайлиггүй шаардлагатай. Цаашидаа компани энэ компанийг яах вэ хувьцаа эзэмшигчдийн ХХААХҮЯ байгаа, цаашидаа паблик компани руу шилжүүлэх ийм зорилготой. Ийм алхмаа эхлээд сангаа болиулаад компани корпорац болгоод, цаашидаа олон нийтийн хяналтад оруулах ёстой. Тэгэхгүй энэ өр авлага нь хэтэрлээ. Энэ корпорац ААН-үүдтэй ХАА-н компаниудтайгаа өрсөлдөөд байх биш бас энэ яах вэ зарим үйл ажиллагааны чиглэл дээр нь бас илүү юм бичсэн байна. Ер нь бид өшөө нарийвч, ялангуяа хувийн хэвшлийнхэн хийж чадах хийж болж байгаа юмтай энэ компанийг өрсөлдүүлж явуулахгүй ээ. Ялангуяа тэр техник тоног төхөөрөмж дилерийг түрээсийн үйлчилгээ эрхэлнэ гэж. Энэ компаниуд тэгэх шаардлагагүй ээ. Хувийн хэвшил харин төрөөс олгож байгаа дэмжлэг урамшуулал энэ компаниар дамжина. Хамгийн гол нь энэ өр авлагыг цэгцлэх асуудал байгаа юм гэдгийг бас хэлье.

Олон жил бугшсан улс төрийн шийдвэрээр, ЗГ-аас ч тэр, та бүхэн мэднэ. Ногоон трактороос авхуулаад бараг малчин болгонд тараасан Хятадын

ногоон трактор 50 хувийн хөнгөлчихсөн, энэ компани дээр өр нь үүсээд л байж байгаа. Энэ болгоныг хамгийн гол нь өр авлагыг нь цэгцлээд цаашидаа энэ компанийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, шинэ шатанд гаргах үүднээс л энэ корпорацыг байгуулж байгаа юм гэдгийг бас хэлье.

Энэ бичил бизнес юм уу том компаниудыг дэмжих аль алиныг нь нэгийг нь ч дэмжье гэсэн асуудал биш. Мэдээж цаашидаа корпорац юу ХАА-г эрхэлдэг бүх л компаниудаа дэмжлэг үзүүлж ажиллах болно.

**Г.Занданшатар:** Одонтуяа гишүүн тодруулах уу, больчихсон уу? Жигжидийн Батжаргал гишүүн. Үүнийг хойшлуулъя.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

**Ж.Бат-Эрдэнэ:** ХАА-г дэмжих санг корпорац болгоод ААН-ийн хэлбэрт оруулаад явъя гэдгийг үндсэндээ дэмжиж байгаа, Болорчулуун сайд аа. Гэхдээ энэ чинь хаа сайгүй хулгай нүүрлээд ерөөсөө нуруугаа авхуулчихаад байна шүү дээ. Хэн нэгэн та яах вэ, Та шинэчлэл хийе эд нар гээд явж байгаа байх. Магадгүй таны ард нэг сайд орж ирнэ, дахиад үүнийг чинь өөрчлөөд явчих ч юм уу, энэ чинь өөрөө дэмжлэг үзүүлэх компани тийм үү. Дэмжлэг үзүүлдэг компани шүү дээ. Ер нь ХАА дээр дэмжлэггүйгээр явахгүй ээ. Энэ ойлгомжтой, дэмжлэг үзүүлж байж бид нар явна. Тэгэхээр энэ дүрэм юмандаа энэ дэмжлэгийнхээ асуудлуудыг хэр тусгасан юм бэ? Сая эндээс асуултууд орж ирээд байна шүү дээ. Зэрэгцээд хэн нэгэн компанийн захирал нь орж ирэнгүүтээ ашгийн төлөө ажиллаад нөгөө ААН-үүдтэйгээ өрсөлдөөд ч юм уу явчих ийм боломж бололцоо бас гарчих вий, яах вэ гэж. Тэгэхээр үүнийг яаж хуульдаа тусгах юм бэ, үүнийг яаж хамгаалах юм бэ, яаж зогсоох юм бэ гэсэн асуудлууд.

Хоёрдугаарт, төрийн өмчийн 100 хувийн өмчлөл бүхий ХХК болох гээд байх



шиг байна. Ер нь публик компани болж байгаа таны хүсээд байгаа зүйл ерөөсөө бүх юм ил тод байх ёстой шүү дээ. Нөгөө нэг хүн ААН-үүдэд ингээд юмнуудаа өгөөд л хямдралтай өгөөд буяны компани биш болгох гээд байна шүү дээ, үндсэндээ бол, үүнийг чинь дэмжээд байна. Тэгэхээр публик компани болж байж бид нар энэ дээр хяналтаа тавья. Тэгэхээр публик хэзээ нэгэн цагт публик компани болох юм уу, эсвэл дахиад публик компани болгохгүйгээр нөгөөдүүлийг нь аваад явчих гээд байгаа юм уу? Үүнийг хянахын тулд хэдүүлээ ямар хамгаалалт хийж өгөх юм? Эсвэл дагалдсан үүнийг гарах дагалдсан Их Хурлын тогтоол гаргаж байж тогтоол дээр нь нөгөөдхөө зааж өгөх үү? Нэг ийм зүйл дээр бас нэг хэлж өгөөч, 2 дугаарт,

Гуравдугаарт, ХХААХҮЯ-ныхаа бодлого алдагдчихав уу. Ер нь бид нар алдчихаад байгаа шүү дээ, өөрсдийнхөө үүнээс гаргаад л Төрийн өмчийн хороон дээр өгөөд явчихдаг ч байдаг юм уу? Ингээд гарахаараа л ХАА-н бодлого яг зорилтот бүлгээ дэмждэг нөгөө ХАА-н бодлого чинь өөрснөө алдагдаад явчих уу, үгүй юү? Би бол үүнээс их эмзэглэж байгаа шүү. Жишээ нь, ХААЯ дээр энэ олон жил ажилласан газрын дарга эд нар орон нутагт ямар ажиллагаа явуулах вэ? Яах вэ? Аль компанийг дэмжих вэ? Юун дээр нь дэмжлэг үнэхээр хэрэгтэй байдаг юм. Тийм бүх зүйлийгээ мэдэж байгаа шүү дээ та бүхэн чинь. Гэтэл жоохон хөндийрөөд явчихвал тэр ТӨХ дээр чинь ТӨБЗГ дээр энэ бодлогыг чинь аваад явж чадах уу, үгүй юү? Тэнд дахиад нэг хувьсгалч дахиад нэг гайхалтай мундаг амьтан гарч ирээд нөгөөдхийг нь ингээд хэдэн тийш нь нөгөө тийш нь ингээд зувчуулаад зулгаагаад аваад явчих уу гэсэн ийм зүйл болчихоод байгаа юм.

3 дахь бол нөгөө хэн 4 дэхэд нь нөгөө миний түрүүний хэлсэн хяналт. Тэгээд идэж уудаг, үрэгдүүлдэг шамшигдуулдаг ийм зүйлээ хэдүүлээ яаж хянаж явах вэ гэж ийм асуулт байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Сан чигээр нь ингээд байгаад байвал эзэн биегүй, улсын төсвийн хөрөнгө шамшигдаад л ингээд л байх нь ойлгомжтой байгаа юм. Тийм болохоор эхний ээлжид ингэж корпорац болгож байгаа. Корпорац болгосноороо энэ чиг үүргийг өшөө нарийвчилна. Яг ХАА-н компаниудтай өрсөлдөх тийм байдлаар нь үйл ажиллагааны чиг үүргийг бий болгохгүй ээ. Хувийн хэвшлийнхний хийж байгаа чадаж байгаа юман дундуур энэ ТӨК орохгүй гэдгийг бас хэлье ээ. Чиг үүрэг нь бүүр хатуу бас өшөө нарийвчлан бас энэ дээр бас зарим илүү дутуу үгнүүд бас бичсэн байна. Эцсийн дүнд улсаас олгож байгаа төсвийн дэмжлэг, урамшуулал мөн хөнгөлөлт, ялангуяа үрийн энэ сав агуулах, элеватор дээрээ түшиглэж энэ өөрөө үндсэн хөрөнгө өндөртэй компани энэ дээрээ түшиглэж л үйл ажиллагаа явуулж, ХАА-н компаниуддаа дэмжлэг үзүүлнэ гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** ХАА-н санг, ХАА-г дэмжих санг ХАА-н корпорац болгож сан гэдэг үгийг корпорацаар сольж орж ирж байна л даа. Утга агуулгын хувьд уг нь гадаад улс орнуудад их зөв зүйтэй хувилбар. Гэтэл үүнийг ингээд уншаад үзэхээр ерөөсөө яг хуучин агуулгаараа, зүгээр л тэр нэг сан гэдэг үгийг корпорац гэдэг үгээр сольсноос өөр яг энэ бодлогын баримт бичиг дотор юу өөр байгаа юм? Засаглалын хувьд яах юм? Энэ сангийн удирдлагыг хэн сонгох юм? Хуучин яамнаас засгаас тавигддаг л байсан тэр чигээрээ л юм байна. Энд чинь ямарваа нэгэн хараат бус гишүүн, засаглалын бусад хэлбэрүүд, салбарын мэргэжилтнүүдийн оролцоо, зүйлүүд яг хаанаа байх юм, шийдвэр яаж гарах юм гэдэг дээр ямар ч өөр үг үсэг, өгүүлбэр, ганц ч зүйл энд алга. Нэг л тийм гоё, гоё

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үгнүүдийг түүж аваад уншлага болгодог, эргээд бүх зүйл хэвээрээ. Одоо дахиад ингээд янз бүрийн аж ахуйн тооцоотой, ашгийн төлөө байдаг энэ арга барилыг авч явдаг ер нь баялгийн сангийн санг, баялгийн корпорац, баялгийн сан гээд олон зүйлүүд үүний цаана байдаг. Энэ бүгдийг бүр нийгэмд ямар ч хэрэггүй үг, өгүүлбэр болгож л хувиргах юм байна л даа.

Тэгэхээр Болорчулуун сайдаас яг энэ юугаараа өөр юм бэ? Засаглалын хувьд, санхүүжилтийн хувьд, үйл ажиллагааны хувьд ашгийн төлөө байх юм уу, ашгийн төлөө байх юм бол ишийдвэр яаж гарч байх юм? Төрөөс хамааралтай байдал нь бас яг яах юм. Одоо өмнөх өр зээл, тооцоонуудаа ийшээ бүгдээрээ шилжиж ирэх юм уу? Өр авлага тооцоонууд нь энэ чинь нэг баахан л зүйл ХАА-г дэмжих сан, ТДС, МАА-н сан ч билүү нэг баахан ийм үндсэндээ нэг ийм алдагдалтай гэж хэлэхэд дэндүү болчихсон, бүх татаас бүх зүйл тэнд овоорчихсон нэг тийм бүтцүүд тэнд цаана нь байгаа шүү дээ. Энд ямар бүтцийн өөрчлөлт энд яг хийгдэх юм? Үүнийг дагаад. Хэрхэн яаж энэ корпорац гэдэг үг утга агуулга руугаа дөхөж очих юм. Энэ зүгээр л нэг нэр өөрчилснөөс өөр, ар өвөрт нь ингээд харахад энэ хуулийн төсөл дээр энэ тогтоолын төсөл дээр юу ч олж харагдсангүй, бүр 1 ширхэг ч юм олж харсангүй, энэ дээр.

Хамгийн гол нь засаглал нь яг яаж өөрчлөгдөх юм, хэн хаанаас нэг сонгон шалгаруулалт энэ тэр гээд үг байх шиг байгаа юм. Одоо ч гэсэн угаасаа тийм үг хаа сайгүй угаасаа төрийн албаны хуульд ч гэсэн байж л байгаа шүү дээ. Хараат бус гишүүд, мэргэжилтнүүд, салбарынхан энд хаанаа яаж оролцох юм бэ?

**Г.Занданшатар:** 83 Цэндгомбын Болорчулуун газрын дарга.

**Ц.Болорчулуун:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнөөдрийн оруулж байгаа энэ ЗГ-ын

тусгай сангийн тухай хууль түүнийг дагаж мөрдөх журмын тухай гэсэн 2 хуулийг оруулж ирж байгаа. Энэ хуулиар бол хуучин ЗГ-ын тусгай санд байсан ХАА-г дэмжих санг татан буулгах л ийм зохицуулалт оруулж байгаа. Журмын тухай хуулиараа ХАА-г дэмжих сангийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр авлагыг ХАА-н корпорац ТӨК-д шилжүүлэх ийм зохицуулалтыг гэсэн үндсэн ийм 2 зохицуулалтаар оруулж ирж байгаа.

Цаашид үйл ажиллагаа явуулах компани нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны 394 дүгээр тогтоолоор батлагдчихсан дүрмийг нь баталчихсан байгаа. Энэ компаниар үйл ажиллагаанд явна. Тэгэхээр энэ компанийн үйл ажиллагаа бол Компанийн тухай хуулиараа тухайлах юм бол хувьцаа эзэмшигчийн хурал, ТУЗ, төлөөлөн удирдах зөвлөлөөсөө гүйцэтгэх удирдлага буюу гүйцэтгэх захирлыг сонгох ийм журмаар явна. ТУЗ-ийн дүрэмдээ хуульдаа 9 гишүүнтэй байх ёстой, үүний 3 гишүүн нь хараат бус гишүүн, 6 гишүүн нь төрийн төлөөлөл байна. Төрийн төлөөлөл байх нь зөвхөн ХААЯ биш бусад ТӨБЗГ, ХААИС, ЦУОШГ ч гэдэг юм уу ийм энэ компанийн үйл ажиллагаатай холбоотой төрийн төлөөллүүдээс бүрдсэн байна гээд ингээд тусгачихсан байж байгаа.

Тийм учраас одоо үйл ажиллагаа нь яваагүй байгуулагдсан компани байгаа учраас цаашидаа энэ компанийн тухай хуулиар үйл ажиллагаа нь чиглэгдээд явах юм гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Адьяаа гишүүн үг хэлнэ. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн. Үг хэлэх гишүүд нэрээ өг. Адьяаа гишүүнээр тасаллаа, Занданшатарыг нэмлээ. Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулаад дагаж мөрдөх журмын тухай хуульд нь өөрчлөлт оруулахаар орж ирж байгаа юм. Тэгэхээр үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байна. Яах аргагүй Монгол Улсын эдийн засгийн үндсэн салбар энэ ХАА-н салбарын хөгжлийг дэмжих бүтцээ бид энэ аж ахуй бизнесийнх нь харилцааг зах зээлийнх нь жаягаар явуулах ийм бодлого чиглэлийг барьж байгаа явдлыг үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байгаа.

Гэхдээ манай ХАА-н салбарын үйл ажиллагаа бол дандаа технологийн цаг хугацаатай байдаг ийм салбар. Хаврын тариалалтын ажил эхлэх хаяанд тулсан байна. Тийм учраас ямарваа нэгэн хийдэгдэл, хоцрогдол үүсгэхгүйн үүднээс ХАА-г дэмжих сангийн чиг үүрэгт байгаа үүргүүдийг уг компаниар шуурхай гүйцэтгүүлэх асуудлыг бид энэ хуулийн өөрчлөлтийг дагуулж гарах шийдвэртээ тусгаж өгөхгүй бол болохгүй байгаад байгаа юм. Үүнийг нэгдүгээрт бодох ёстой гэж. Тэгж байж бид энэ цаг үеийнхээ ажлуудын бэлтгэл зохион байгуулалтыг бүрэн хангаж, тэр хэмжээгээрээ үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг технологийнх нь цаг хугацаанд явуулж, түүнийхээ үр дүн дээр бас ахиу бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоо боломж маань бүрдэнэ гэж ингэж харж байна. Нэг.

2 дахь зүйл. Бид нар төрийн өмчтэй компаниудыг олон нийтийн оролцоотой хяналттай болгох тухай асуудал их ярьж байгаа. Тийм учраас энэ шинээр байгуулагдаж байгаа тэр корпорац гэнэ үү, компани байна уу түүнийг 34-өөс доошгүй хувийг нь олон нийтийн болгох ёстой. Ингэж байж бид нар олон нийтийн оролцоо хяналтыг хангана. Нэг. Хоёрдугаарт, ер нь энэ ХАА-н салбарын үйлдвэрлэл эрхэлж байгаа улсуудынх нь хүрээнд тэр үнэт цаасыг нь гаргаж, тэр нөхдийн оролцоо, үйл ажиллагааг татах замаар энэ корпорацын үйл ажиллагааг жигд явуулах ёстой юм байна гэж ингэж хараад байгаа. Тийм учраас тэр дагаж гарах

шийдвэр дотор бас энэ төрийн өмчтэй энэ аж ахуйн байгууллагыг олон нийтийн засаглалтай болгох хугацаа, чиглэл, юмнуудыг тов тодорхой оруулж өгч байж, сая малчид тариаланчдын бас эрх ашиг энэ компаниар дамжиж хангагдах ёстой. Би энэ компанийг энэ ХАА-н салбарын тогтвортой хөгжлийг хангах, төрийн бодлого чиглэл бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн ийм төвлөрүүлэн зуучлах чиг үүрэгтэй компани байх юм байна гэж ингэж хараад байгаа.

Тийм учраас энэ талаас нь асуудалд анхаарах ёстой. Ер нь манай ХАА-н дэмжих сан үндсэндээ газар тариалангийн үйлдвэрлэл дээрээ илүү их түшиглэсэн ийм сан яваад байсан. Энэ МАА-н салбар, эрчимжсэн МАА-н салбарынхаа хөгжлийг дэмжих асуудал энэ корпорацын бас гол чиг үүрэг дотор байх ёстой шүү. Үүнийг онцгой анхаарах ёстой. Ингэж байж бид нарийн тавьж байгаа тэр хүнсний хангамж аюулгүй байдлын асуудал, хүнс үйлдвэрлэгч, экспортлогч орон болох тэр том зорилтуудыг хангах, энэ ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, бизнесийн байгууллагуудын санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа харилцаануудыг орхигдуулахгүйгээр авч хэрэгжүүлэх ийм үүрэг чиглэлийг дагаж гарах шийдвэрт орох ёстой гэсэн ийм саналыг зориуд хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьяа:** Өнөөдөр энэ УИХ дээр ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ялангуяа энэ ХАА-тай холбоотой сангийн эрх зүйн байдлын тухай энэ хуулийн төсөл орж ирж хэлэлцэх гэж байна. ХХАА-н сайд томилогдсоноосоо хойш бас энэ ХАА-г хөгжүүлэх ялангуяа энэ малыг эрүүлжүүлэх, ХАА-г чиглэсэн гадаад экспортын бодлогын талаар бас тодорхой сайн зүйлийг хийж байгаа.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Гэхдээ энэ оруулж ирсэн хууль өнөөдөр энэ доод мэргэжилтнүүд нь оруулж ирсэн юм уу, аль эсвэл энэ сайд нь ийм юм оруулж ирмээргүй байна. Энэ ЗГ-ынхаа бодлогын эсрэг юм оруулж ирж байна.

Энэ төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өнөөдөр УИХ хэлэлцэж байгаа. Энэ тариалан эрхлэх сангийн ажиллагаа ямар байсан, тэр Дарханы арьс ширний үйлдвэр энэ ТӨК-уд гээд олон ийм хэл ам дагуулсан шийдэл байхгүй, төрийн өмч хөрөнгө тэр тусгай сангаар дамжуулж завидаг ийм схем чинь энэ ХААЯ дээр урьд нь байсан шүү дээ. Үүнийхээ асуудлыг шийдээгүй байж нэг нэрийг нь өөрчлөөд ярихаар сайн болно гэж ойлгохгүй байгаа. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг цаашид байгуулахгүй гэж энэ УИХ, ЗГ чинь ийм бодлого явуулж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ сангийн үйл ажиллагаа корпорац болохоороо сайн болдог. Тэгээд үүний үзэл баримтлал түүнчлэн энэ үйл ажиллагааных нь талаар олон гишүүд байр сууриа илэрхийлж байна шүү дээ. Энэ зөв юм ярьж байна. Бид өнөөдөр нэг сайд нь гарч ирээд л урьд нь байсан юмныхаа тэр үр дүнг, хариуцлага, ашиг орлого, алдаа дутагдлыг нь дүгнэхгүйгээр нэрийг нь өөрчлөөд оруулж ирдэг ийм жишгийг тогтоож болохгүй, үүнийг дэмжихгүй байгаа. Яагаад гэхээр энэ Тариалан эрхлэх сан гэдэг үүгээр дамжуулж олон татвар төлөгчдийн мөнгө зээл тусламжийг үрэн таран хийсэн энэ асуудал одоог хүртэл сөхөгдөж тавигдахгүй байгаа. Тэгээд ингээд корпорац гэхээр нэг сайхан болчихдог.

Тэгээд үүний үзэл баримтлалын хувьд, засаглалын хувьд ч гэсэн том алдаатай асуудлууд байна гэж ойлгож байна. Засаглал нь яах юм гэдэг нь тодорхойгүй. Хэн удирдах юм, ямар эх үүсвэрээр үүнийг санхүүжих юм, тэгээд энэ нь энэ ХАА-н чиглэлийн хувийн хэвилийнхэнтэй өрсөлдөгч маягийн ийм ойлголтыг авахаар ийм танилцуулга

байна шүү дээ. Үүнийгээ эргээж харж ингээд татаж авбал яасан юм бэ гэсэн ийм бодолтой байна.

Өнөөдөр энэ газар тариалангийн асуудал цаг нь туллаа. Энэ сан байгуулахгүй болохгүй байна гэдгийг нь зарим гишүүд ярьж байна. Энэ андуурал шүү. Энэ сан байхаар сайхан болчихдог. сан байхгүй болохоор энэ газар тариалангийн бүх энэ яамны бодлогын үйл ажиллагаа чинь явагддаггүй ийм байдал үүсэж байна гэдэг ийм зовлон тоочиж ийм үг ярьж, үүнийг УИХ-аар явуулах ийм асуудлыг хэзээ ч бид зөвшөөрөхгүй гэж ойлгож байгаа. Ийм байр суурьтай байна. Үүнийгээ тодорхой болгоё. Урьд нь байсан тэр тариалан эрхлэх сан бусад сангуудынхаа үр дүнг энэ Их Хуралд танилцуулсны дараа, үүний үр дүнг тооцсоны дараа, зайлшгүй энэ ЗГ, УИХ-ын бодлогоос чинь зөрсөн ийм асуудал оруулж ирэх хууль, эрх зүйн хувьд, бодлогын хувьд, хөгжлийн хувьд ямар ийм зайлшгүй шаардлага байсан бэ гэдгийг тогтоосны дараа, хэлэлцээний дараа үүнийг шийдэл гаргавал өнөөдөр бас хууль дээдлэх зарчим, өнөөдрийн энэ төр засаг ЗГ-аас явуулж байгаа бодлоготой нийцэх байх гэсэн ийм байр суурьтай байгаагаа илэрхийлье.

**Г.Занданшатар:** Энэ чинь ЗГ-аас өргөн барьсан хууль шүү дээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Дэмжсэн дэмжээгүй үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Болорчулуун сайд аа, яг энэ агуулга чиглэлээрээ энэ хууль дэмжигдэхгүй нь байна, хэлэлцэгдэхгүй унахаар байна. Гишүүдийн бас олон гишүүд дэмжихгүй санал хэллээ. Хуулийн 3 том зөрчил байна.

Нэгдүгээрт, ийм сангийн хуульд өөрчлөлт оруулахад Сангийн яамны санал, дүгнэлт байх ёстой гэж ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасан. Энэ дүгнэлт хавсаргагдаагүй байна.

Хоёрдугаарт, ХАА-н дэмжих санг татан буулгахтай холбоотой харилцааг зохицуулах буюу өөр харилцааг зохицуулах зорилготой хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслөөр өмнө баталсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан нь хууль зүйн техникийн хувьд алдаатай байна.

Гуравдугаарт, бас ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд уг хууль хүчин төгөлдөр болох хугацааг заасан боловч энэ зохицуулалтыг их хууль дээр нь оруулахаар төсөлд тусгаагүй. Өөрөөр хэлбэл дагаж мөрдөх журмын тухай хуулиар үүнийг зохицуулахаар зааж байгаа нь хууль хүчин төгөлдөр болох хугацаа их хууль дээр тодорхойгүй байхаар харагдаж байна.

Хуулийн төслийн танилцуулга, үр нөлөөний тайланд ХАА-г дэмжих сангийн хөрөнгийн чадвар доройтож, активын чанар буурч, эргэлтийн хөрөнгийн хомсдолд орсноос цаашидын үйл ажиллагаа хэвийн явуулах боломжгүй болсон талаар дурдсан байна. Гэтэл энэ сангийн үйл ажиллагааг яаж шинэ шатанд гаргах вэ, өөрчлөх вэ, нийгэм эдийн засгийн үр дагавар, цаашид хөрөнгийг хэрхэн бүрдүүлэх, одоогийн өглөг авлагын хэмжээ ямар байгаа, санхүүгийн тайлан бүртгэлтэй хөрөнгийг хэрхэн тооцох зэрэг нарийвчилсан тооцоо мэдээлэл танилцуулгууд цаашид

сайжруулах бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Ийм учраас энэ авлигатай тэмцэх асуудал бол энэ сангуудын менежментийг хараат бус зөв зохистой байлгахаас эхэлнэ шүү дээ. Ахиад л нэг юм баталдаг, ахиад л баахан авлига, сангийн зээл болдог ийм гашиун турилгааг давтмааргүй байна. Ийм учраас 2 хувилбар байна. Үүнийг бүр нарийвчлан дэмжээд яах вэ, батлаад явъя гэвэл цаашидаа явмаар байна. Хоёрдугаарт, энэ менежмент энэ тэр нь тэр хувийн хэвшлийн оролцоотой, мэргэжлийн холбоотой оролцоотой, хяналттай явахгүй бол ингээд л үе үеийн ХАА-г дэмжих сангийн нэрийн доор баахан зээл, хууль гардаг, эргэж төлөгддөггүй. Тэгээд л ЖДҮ-ийн сан юу боллоо. Тариаланг дэмжих сан юу боллоо. Гочоо юу боллоо гэдэг шиг энэ асуудлууд бас тэгээд энэ яг энэ хаврын тариалалтын өмнө бас ингээд энэ Батжаргал гишүүн ч гэсэн хэлээд байгаа. Ингээд ийм л эгзэгтэй асуудал дээр энэ асуудал тулж ирж байна. Ийм учраас үүнийг бас нухацтай ярилцах нь зүйтэй байх гэж бодож байна.

Санал хураалт явуулах уу. Болорчулуун сайд аа яах вэ. Ахиж өргөн барьж нухацтай боловсруулаад өргөн барьсан нь дээр байх. Дэмжээд янзална гэхээр бас шинэ хууль бичих хэрэгтэй болно шүү дээ. Сангаараа байх болохгүй, корпорац болгох гэхээр энэ бас нэрийг нь өөрчилж байгаагаас цааш хэтрэхгүй. Тэгээд ийм нэг 2 ацан шалаан дээр л Их Хурлыг авчраад дандаа тавьчих юм даа.

Муурыг хар юм уу цагаан байх нь гол биш хамгийн гол нь хулгана барьдаг байх хэрэгтэй гэж байгаа шүү дээ. Тэгтэл нэр нь сан байж байгаад корпорац болно уу, банк ч болно уу, ямар ч болсон хамаагүй, хамгийн гол нь менежмент нь, зохион байгуулалт нь, деталь нь сайжрах ёстой.

Санал хураалт явуулъя.

Хүүхдүүд байж байгаарай, дараа нь танилцуулна.

Ингээд төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж Байнгын хороо үзсэн байна. Тэгээд Байнгын хорооны саналаар ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1 хувиар төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн байна. Гишүүдийн олонх төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжжүүлъя.

Төсвийн байнгын хороо Тэмүүлэн сайд үүнийг Баялгийн сангийн хууль, компанийн хууль энэ тэр олон хуультай нийцүүлж их шинэчлэх шаардлага гарлаа. Төрийн ба орон нутгийн өмчийн компанийн тухай хуультай.

Зочид танилцуулъя.

УИХ-ын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийн урилгаар СБД-ийн ерөнхий боловсролын I дүгээр сургуулийн 8в ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Энэ СБД-ийн Ерөнхий боловсролын I дүгээр сургуулийн 8в ангийн багш, сурагчид бол үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг уралдаанд түрүүлсэн сурагчид байна. Тэгээд сурагчид та бүхэндээ энэ хүчирхийллийн эсрэг үе тэнгийнхнийхээ дээрэлхэхийн эсрэг дуу хоолой болж уралдаанд түрүүлсэн явдалд баяр хүргэе.

Энэ таширамд Нэгдсэн Үндэстний Байгууллагын санаачилгаар, дэмжлэгээр энэ хүүхдийн хүчирхийллийн эсрэг “Шүгэл” гэдэг ийм төслийг хэрэгжүүлж байгаа юм байна манай БЗД-т

Булгантуяа гишүүд нар хэрэгжүүлсэн. Эмэгтэй гишүүд маань уриалга гаргасан байгааг сонордуулъя. Эмэгтэй гишүүдийн “лобби” бүлгээс.

Ер нь хүүхэд хохирсон гэмт хэрэг, дарамт, хүчирхийлэл, орчны эрсдэлээс үүдэлтэй болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн тоо, үүнтэй холбоотой гэмт хэргийн тоо буурахгүй байна. Гэмт хэргийн улмаас 2020 онд 1181 хүүхэд, 2021 онд 1365 хүүхэд, 2022 онд 2014 хүүхэд хохирсон байна. Үүнд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд зонхилж байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна. Хүүхдийн эсрэг ийм олон гэмт хэрэг үсрэнгүй өсөөд байна. Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 42000 хүүхэд осол гэмтэлд орж, Гэмтэл согогийн үндэсний эмнэлэгт хүрэлцэн ирсэн байна. Зам, тээврийн ослоор 2674 хүүхэд, түлэгдэлтэд 2589 хүүхэд, унаж бэртсэн 20750 хүүхэд байна.

Хүүхдийн эрхийг нь ноцтой зөрчсөн, хүүхдэд ээлгүй орчин, сургуулийн орчин хүүхэд бага насны хүүхдийн бие махбодод халдаж, эрүүл мэнд амь насанд нь эрсдэлд оруулсан хэргүүд гарч нийгмийг цочроон бухимдуулж байна. Иймд иргэд олон нийтийн хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

УИХ-аас энэ Гэр бүлийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, үүнтэй холбоотой Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг хуулиуд, Хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг нэн яаралтай энэ ЗГ, УИХ энэ хүүхэд хамгааллын төрийн бус байгууллагууд, олон нийт, олон улсын байгууллагууд хамтарч ажиллах хэрэгтэй байна, энэ чиглэлээр. Хүүхэд Монголын ирээдүй, нийгмийн тусгал, хүүхдийн эрхийг хамгаалах бүхий л боломжуудыг бид

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сурталчлан таниулж, бодит арга хэмжээ авах ёстой дэмжиж байх ёстой. Би нэг жишээг онцлон тэмдэглэе гэж бодож байна. Жишээлбэл хүүхэд хамгааллын “Шүгэл” төслийг Нэгдсэн Үндэстний байгууллагын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр БЗД-т хэрэгжүүлж эхэлсэн байна. Хүүхэд хамгааллын шүгэл нь гамшиг, онцгой нөхцөлийн байдлын үед мөн гэнэтийн осол гэмтлийн үед, дарамт гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өөрийгөө хамгаалах, тусламж дуудах хэрэгсэл чухал хэрэгсэл болдог байна. Олон улсад ч гэсэн ийм шүгэл гэдэг ийм төсөл хэрэгждэг, шүглийн дуут дохио бол хүүхдийн тусламж хүссэн дуудлага гэдгийг эцэг эхчүүд, асран хамгаалагчид, иргэд олон нийт хүлээн авч шууд тусламж үзүүлэхэд бэлэн байх хандлага, зан үйлийг төлөвшүүлж тогтоох хэрэгтэй байна. Энэ бол энэ төслийн үндсэн зорилго юм байна лээ. Шүглийн дуу хаана гарна, тийшээ ахмад хүмүүс анхаарч хүүхэд хамгаалах эрхэм үйлст санаа зорилго нэгтэйгээр тусалж дэмжиж байх хэрэгтэй.

Ингээд энэ УИХ дахь эмэгтэйчүүдийн “лобби” бүлэг энэ шүглийн хэрэглээг сурталчлан таниулж, энэхүү төслийг орон даяар хэрэгжүүлэхийг уриалж байгаа юм байна. Хүүхэд шүгэлдвэл та бүхэн туслаарай гэсэн уриалгыг дэмжүүлж байна.

Хүүхдүүддээ баярлалаа. Сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Аав ээждээ уламжилж энэ бас шүгэлтэй явцгааж байгаарай.

12.08 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

**Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын ЗГ-ын 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны**

### **төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.**

Үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн биелэлт болон ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Ч.Хүрэлбаатар:** УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд гарган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн, УИХ-д өргөн мэдүүлсний дагуу танилцуулж байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2022 оны явцын дундаж үнэлгээ 74.2 хувьтай гарлаа.

Монгол Улсын 2021-2022 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 9 бүлгийн хүрээнд 150 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2022 оны явцын дундаж үнэлгээ 45.7 хувьтай байна.

ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 бодлого, 259 зорилгын хүрээнд 1087 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2022 оны байдлаар 69.8%, өссөн дүнгээр 39.3 хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 6 бодлогын хүрээнд 23

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зорилт дэвшүүлж, 300 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2022 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 67.5 хувьтай байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүлэг тус бүрээр нь авч үзвэл Ковид 19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 89.3%, Хүний хөгжлийн бодлого 66.5%, Эдийн засгийн бодлого 61.2%, Засаглалын бодлого 70.1%, Ногоон хөгжлийн бодлого 69%, Нийслэл ба бүс нутаг орон нутгийн хөгжлийн бодлого 84.5 хувийн хэрэгжилттэй байна.

Цар тахал, дайн, дэлхийн улс орнуудад тулгамдаж буй инфляц зэрэг хүндрэлүүд учирч байсан хэдий ч 2022 оны I дүгээр улиралд -3.8 хувьд хүрч унаад байсан эдийн засаг 2022 оны эцэст 4.8 хувьд хүрч өссөн байна. Монгол Улсын ЗГ-аас экспортыг эргэн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны эхний хагаст 8.1 сая тонн буюу өмнөх оноос 12.7 хувиар агшаад байсан нүүрсний экспорт 2022 оны эцэст 31.6 хувьд хүрч, 2021 оноос даруй 2 дахин өссөн байна. Зэсийн баяжмалын хувьд 1.4 сая тонн экспортолж өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар өссөн. Ингэснээр АМНАТ-ын орлого 2.7 их наяд төгрөг, уул уурхайн орлого 4.1 их наяд төгрөг хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 750 орчим тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан.

ЗГ-аас 2022 оны 10 дугаар сард гадаад валютын үндсэн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 362 дугаар тогтоол гаргаж хэрэгжүүлсэн нь гадаад валютын орлого урсгалыг нэмэгдүүлэхэд нөлөөлж улмаар Эрдэнэс таван толгой, Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет, Дарханы төмөрлөгийн үйлдвэрүүд болон Оюутолгой компани нийт 1.1 тэрбум гаруй ам.доллар төвлөрүүлж 2022 оны эцэст валютын нөөц 3.4 тэрбум ам.долларт хүрээд байна.

УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслүүдийн талаарх, энэ гүйцэтгэлийн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг танилцуулна. 2 Байнгын хорооны дүгнэлтийг дараа нь танилцуулъя, тийм ээ.

Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 17.3, 18.4-д зааснаар аудитын тайланг Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч Ядамсүрэнгийн Сарансүх танилцуулна. Индэрт урьж байна.

**Я.Сарансүх:** УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1-д заасан төрийн аудитын байгууллагын чиг үүрэг, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоолыг үндэслэн Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд аудитыг гүйцэтгэж, дүгнэлт зөвлөмжийг гаргалаа.

УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг 6 бүлэг 23 зорилго бүхий 300 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 11.7 их наяд төгрөгийн хөрөнгө шаардлагатай байхаар баталж, гүйцэтгэлээр богино хугацааны зорилго, зорилт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 3.8 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний зорилго, зорилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг үнэлэхэд 82 буюу 27.3% нь үр дүнтэй, 71 буюу 23.7% нь



тодорхой үр дүнд хүрсэн, 88 буюу 29.3% нь эрчимжүүлэх шаардлагатай, 59 буюу 19.7% нь үр дүнгүй, зорилтот шалгуур үзүүлэлт хүрэх түвшнийг хангаагүй байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн дундаж үнэлгээ 60.1 хувьтай байгааг бодлогын зорилт тус бүрийн үнэлгээгээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: Ковид 19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 95%, Хүний хөгжлийн бодлого 65%, Эдийн засгийн бодлого 51.2%, Засаглалын бодлого 60.5%, Ногоон хөгжлийн бодлого 49.5%, Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого 83.5 хувьтай байна.

Аудитаар цуглуулсан нь нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах гол дүгнэлтийг гаргаж байна.

1. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт 5 жилийн хүрэх түвшинээр батлагдсан нь Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т заасны дагуу төсөл арга хэмжээ тус бүрийг хувиар харьцуулан үнэлж дүгнэх боломжгүй байна.

2. ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 285 төсөл, арга хэмжээг уялдуулан боловсруулж, харин 15 төсөл, арга хэмжээ буюу хүний хөгжлийн бодлогын 6, эдийн засгийн бодлогын 8, нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлогын 1 төсөл, арга хэмжээг тус тус уялдуулаагүй байна.

3. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд туссан зарим төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй нь Монгол

Улсын 2022 оны төсвийн тухай хуульд санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгаагүй. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуультай нийцэлгүй байгаатай холбоотой байна.

4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журамгүй, хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн санг эрхлэн хөтлөх журмыг шинэчлэн батлаагүйгээс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хөгжлийн урт, дунд, богино хугацааны болон салбар, бүс, орон нутагт мөрдөж буй бодлогын баримт бичгийн бүртгэл, мэдээллийг нэгтгэх, бодлогын уялдааг хангах, төлөвлөлт хийх, хэрэгжилт, үр дүнг нэгтгэх, түүнд хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна.

5. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулахдаа зарим төсөл, арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшнийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй, богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн тайлагнал, хэрэгжилтийн хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлан шалгах хяналт хангалтгүй, шат шатны хяналт шинжилгээ үнэлгээг нотолгоонд үндэслэж хийгээгүйгээс бодит үнэлгээ болоогүй байна.

6. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоолол судалгаа хийгдээгүй, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулаагүй зэрэг хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан нь бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүн биелэх нөхцөлийг бууруулж байна.

Мөн Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 1 асуудал толилуулж, нийт 13 зөвлөмжийг холбогдох албан

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тушаалтнуудад өгсөн. Үүнд: Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 5, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад 3, Сангийн сайдад 1, ҮСХ-ны даргад 2, төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус бүр 2 зөвлөмжийг хүргүүлсэн. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Эдийн засгийн болон ТББХ-ны хамтарсан санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлд заасны дагуу УИХ Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэх зохицуулалттай.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.8 дахь хэсэгт заасны дагуу УИХ-ын Тамгын газраас ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл

ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Монгол УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг 6 бүлэг 23 зорилт бүхий 300 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. ЗГ-аас Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний нийт гүйцэтгэл дундаж үнэлгээ 67.5 хувьтай байна гэж танилцуулснаас Ковид 19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 89.3%, Ногоон хөгжлийн бодлого 69%, Хүний хөгжлийн бодлого 66.5%, Эдийн засгийн бодлого 61.2%, Засаглалын бодлого 70.2%, Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого 84.6 хувийн дундаж үнэлгээтэй байна.

Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр заасан нийт 1031 арга хэмжээнээс 328 арга хэмжээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхээр заасан нийт 252 арга хэмжээнээс давхардаагүй арга хэмжээний тоогоор 75 арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагджээ.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 300 төсөл, арга хэмжээнээс Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 328 арга хэмжээтэй уялдаж буй 276 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл үр дүнтэй буюу 100 хувийн 57 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хувийн хэрэгжилттэй 83 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хувийн хэрэгжилттэй 32 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 100 арга хэмжээ, үнэлэх боломжгүй буюу нууцын журмаар тайлагнасан 4 арга хэмжээ тус тус байна.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилт Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан арга хэмжээний хэрэгжилтийн хэдэн хувьд хүрсэн эсэх болон Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд заасан арга хэмжээний хэрэгжилтийн хэдэн хувьд хүрсэн эсэхийг ЗГ-аас ирүүлсэн бодлогын баримт бичгүүдийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн мэдээлэлд үндэслэн тодорхойлох боломжгүй байна.

УИХ-ын Тамгын газраас төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд гүйцэтгэл, үр дүнгийн дундаж үнэлгээ нь 65.2 хувьтай байгаа нь ЗГ-аас хэрэгжилтийг 67.5% гэж үнэлж ирүүлснээс 2.3 нэгж хувиар буурсан. Үнэлгээ буурахад хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 300 төсөл арга хэмжээнээс зураг, төсөл хэрэгжиж хийгдэж дуусаагүй, газрын асуудал шийдэгдээгүй, санхүүжилт батлагдаагүй, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь шалгуур үзүүлэлтийг хангаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй арга хэмжээ, үр дүнг тайлагнаагүй, зорилт түвшиндээ бүрэн хүрээгүй, гүйцэтгэл дутуу зэрэгтэй холбоотой 32 арга хэмжээг аргачлалын дагуу бууруулж үнэлсэн нь нөлөөлсөн байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй 105 арга хэмжээ байгаа нь Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоолол судалгаа хийгдээгүй, ТЭЗҮ зураг төсөл боловсруулаагүй зэрэг хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан нь бодлогын зорилт, хүрэх үр дүн биелэх нөхцөлийг бууруулж байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулахдаа зарим төсөл, арга хэмжээний суурь түвшин,

зорилтот түвшиний тоо болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгийн хэмжээг урьдчилан тооцоолоогүй байна. Мөн Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-д заасны дагуу Үндэсний аудитын газар Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын тайландаа хэрэгжилтийг 61.1 хувьтай зорилтот үр дүнд хүрээгүй байна гэжээ.

Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Х.Булгантуяа ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон төлөвлөгөөний гүйцэтгэлийг дүгнэхэд ашигласан аргачлалын талаар, Таван толгойн 450 мегаваттын цахилгаан станцын дэд бүтцийн бүтээн байгуулалтын эхлээгүй ажлыг 66.6 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн талаар, УИХ-ын гишүүн Х.Ганхуяг эрчим хүчнээс суурилагдсан хүчин чадлаараа 100 хувийн импортын эрчим хүч 30 хувийн биелэлттэй гэж дүгнэснийг хэрхэн ойлгох талаар, Шинэ хот болон томоохон хэмжээний хотхон барих бүтээн байгуулалтад шаардагдах эрчим хүч, дулааны бэлтгэл ажил, эрчим хүч, дулааны чиглэлээр хэрэгжүүлэх хэтийн төлөвлөгөө, 2022 онд эрчим хүчний дутагдлыг арилгах чиглэлээр хийгдсэн ажлуудын талаар болон сэргээгдэх эрчим хүч зэрэг дараагийн хувилбарыг боловсруулсан эсэх талаар, УИХ-ын гишүүн Н.Ганибал хөгжлийн төлөвлөгөөнд тухайн жилдээ хэрэгжих боломжтой арга хэмжээг тусгаж байх талаар болон эрүүл мэндийн салбар ялангуяа хөдөө орон нутгийн эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний биелэлт хангалтгүй байгаа талаар, УИХ-ын гишүүн Б.Баттөмөр төсвийн орлого давж биелж байгаа үед 2022 оны төлөвлөгөөний биелэлт 67.5 хувьтай 300 төсөл, арга хэмжээг 11.7 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээс 4.1 их наяд төгрөгөөр 35 хувийг нь

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

санхүүжүүлж, 22 арга хэмжээ биелэгдээгүй ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн биелэлт 39 хувьтай, 1087 арга хэмжээ төлөвлөснөөс 153 төсөл арга хэмжээ биелэгдээгүй талаар, эрхтэн шилжүүлэн суулгах төв, сүрьеэгийн эмнэлэг байгуулах шинжлэх ухаан технологийн зардлыг 4 дахин нэмэгдүүлэх, Асгатын ордыг ашиглалтад оруулах асуудлууд хэрэгжээгүй шалтгаан, үлдэж байгаа хугацаанд хийх боломж байгаа эсэх талаар, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт туссан 1 хүнд ноогдох ДНБ-ий хэмжээг үлдсэн хугацаанд 517.-д хүрэх боломж байгаа эсэх талаар, банк бус санхүүгийн салбарын хөрөнгийн үнэлгээ, эдийн зас цэцгийн үр өгөөжийн талаар, Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар, УИХ-ын гишүүн Г.Ганболд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр томсгосон дүнгээрээ яг өнөөдрийн байдлаар хэдэн хувьтай байгаа талаар, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах боломжийн талаар, УИХ-ын гишүүн М.Оюунчимэг хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг хөгжүүлж, өргөжүүлж, Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлсэн байна гэсэн зорилт арга хэмжээ хэрэгжээгүй талаар, гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартад нийцүүлж өөрчилсөн байна гэсэн зорилт арга хэмжээний хэрэгжилтийн талаар, Дэнжийн мянга, Дамбадаржаагийн дэд төвүүдийн тухай газар чөлөөлөлтийн асуудал болон гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах талаар, УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн 2022 оны жилийн эцсийн байдлаар ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр хэдэн хувьтай байгаа талаар, ЗГ-ын зүгээс салбарын яам, агентлагуудад төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох эсэх талаар, өнгөрсөн онд инфляцын түвшинтэй уялдаагүй шалтгаанаар төрийн албан хаагчдын цалин нэмэгдээгүй, цаашид үүнийг хэрхэн уялдуулж нэмэх талаар, банкны зээлийн хүү өндөр, арилжааны банкнуудын

зээлийн олдоц муу, эрсдэл ихтэй байгаа үед ЗГ-аас ямар бодлого барьж байгаа талаар, ХАА-н бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар, УИХ-ын гишүүн Ч.Ундрам Үндэсний аудитын газрын дүгнэлтэд Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнгийн хэрэгжилтийг 61.1 хувьтай буюу зорилтот үр дүнд хүрээгүй байна гэж дүгнэсэн бөгөөд цаашид хөгжлийн төлөвлөгөөг улам боловсронгуй болгох талаар, Алтанбулаг боомтын шинэчлэлийн асуудлаар боомт болон чөлөөт бүс хоорондын уялдаа холбоог хэрхэн ханган ажиллаж тус чөлөөт бүсэд ямар бодлого зохицуулалт, төсөл, арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгжүүлж байгаа талаар, Атрын 4 дүгээр аяны хүрээнд Сэлэнгэ аймгийн Сант суманд ХАА-н агротехникийн үйлчилгээний төв барьж, МСҮТ байгуулах ажлын явц байдал, түүний хэрэгжилтийн талаар, УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны биелэлт хангалтгүй байгааг хэрхэн шийдвэрлэх, үүнд хариуцлага тооцох эсэх, ЗГ хөтөлбөрт туссан ажлуудаа хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд багтаан бүрэн гүйцэтгэх боломж байгаа эсэх, ТӨК-уудын эдийн засгийн үр өгөөж бүтээмж нэмэгдсэн эсэх, олон нийтийн хяналтыг бий болгох, хувьчлах асуудлаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар, УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур эрх, ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн чадварлаг зэвсэгт хүчнийг бий болгох зорилгын хүрээнд цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, технологи, инновацыг нэвтрүүлэх замаар батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн эхлэлийн тавих асуудлаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, хийгдэж буй ажлууд, түүний биелэлт олон улсын жишигт нийцэж буй эсэх, Монгол Улсын хил хамгаалах систем, хилийн хамгаалал дахь технологи, инновацын дэвшил, хилийн зурвасын дагуу хамгаалалтын шинэ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

системүүдийг нэвтрүүлэх, хил хамгаалах техник хэрэгсэл, хүний нөөц, хилийн заставуудын барилга байгууламжийн шинэчлэл, хилийн цэргийн нийгмийн хамгааллын асуудлыг хэрхэн шийдвэрлэж буй талаар, УИХ-ын гишүүн Ц.Цэрэнпунцаг ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүний хөгжлийн бодлогын хүрээнд халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлтэй уялдуулж хийсэн ажлын үр дүнд нийгмийн дундаж давхарга нэмэгдсэн эсэх, газрын тос боловсруулах үйлдвэр Дарханы арьс шир боловсруулах үйлдвэр зэрэг томоохон төслүүдийн явц, бүтээн байгуулалт хугацаандаа амжиж буй эсэх, төсөв хэтрэх, хугацаа удааширах зэрэг асуудлыг хэрхэн шийдвэрлэж буй талаар, УИХ-ын гишүүн Т.Доржханд ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн биелэлтийн эдийн засгийн бодлогын хүрээнд банк санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжих, банкны зээлийн саналын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгох, банкны эрсдэл даах чадамжтай болгох зэрэг зорилтууд банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийсэн ч зээлийн хүү хангалттай буураагүй, зээлийн хүртээмж хангалтгүй байгаа шалтгааны талаар, Монголбанкны алдаатай бодлогын үр дүнд маш олон хувийн сектор алдагдал хүлээсэн. Инфляц үнийн өсөлтийг хэрхэн бууруулах, бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн арга хэмжээ, реформын шинэжтэй ямар бодлого баримталж байгаа талаар, чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих арга хэмжээний биелэлт хангалтгүй байгаа талаар, гадаадын хөрөнгө оруулалт бизнесийн салбарыг хэрхэн дэмжих талаар, экспортын баталгааны

сангийн зохицуулалтын талаар, түүхий эдийн биржийг бэхжүүлэх талаар, УИХ-ын гишүүн Ж.Батсуурь ЗГ-аас Сүхбаатар аймагт хийгдэх ДЦС-ын өргөтгөл, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, “Дарьганга” хүүхдийн зусланг шинэчлэх, Зүүн бүсийн аялал жуулчлалыг 1 маршрутад оруулах зорилгоор авто зам, замын байгууламж, Бичигтийн боомтын сэргэлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, УИХ-ын гишүүн Н.Энхболд Төв аймгийн Борнуур суманд хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд Борнуур сумын тариалангийн талбай усалдаг усан хангамжийн ус хураагуурын байгууламжийн засвар шинэчлэлийг хэрхэн хийх талаар, 2023 онд хийгдэх засвар үйлчилгээний талаар, 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр улс орны хөгжлийн төлөвлөлт түүний гүйцэтгэлийн талаар томоохон шинэчлэлийг хийж, хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой байна гэж зохицуулсан талаар дурдаад ЗГ-ын ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний биелэлтэд хангалтгүй байвал хариуцлага тооцдог, дотоод хяналтын тогтолцоогоо бэхжүүлэх, ЗГ дахь хяналтын тухай, Монгол УИХ-ын хянан шалгалтын тухай хуульд заасан зохицуулалтын дагуу арга хэмжээ авах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн баримт бичгийг хэлэлцэхдээ хооронд нь уялдаа холбоотой, бодит төлөвлөсөн эсэхэд УИХ-ын гишүүд өөрсдөө хариуцлагатай хандаж, гүйцэтгэлийг түүний дагуу дүгнэдэг байх, 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн зарим сайдад хариуцлага тооцох талаар Шадар сайдын мэдээллийг УИХ, Байнгын хороо анхааралдаа авсан. Үүнийг хэрэгжүүлэх талаар тус тус асуулт асууж, саналаа хэлсэн болно.

Мөн Байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон нийт гишүүд Монгол Улсын хөгжлийн тухай жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, үндсэн

чиглэлийн биелэлт, Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт болон бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсоод өнгөрөх биш хэрэгжилт, биелэлт хангалтгүй дүгнэгдсэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага заавал тооцдог байх хуулийн зохицуулалтыг нэг мөр биелүүлж ажиллах талаар нэгдсэн байр суурь илэрхийлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

### **Г.Занданшатар:** Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан, БОАЖ-ын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр, Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч Ядамсүрэнгийн Сарансүх, Монгол Улсын ГХЯ-ны ТНБД Нямдоржийн Анхбаяр, Монгол Улсын Сангийн яамны ТНБД Жигжидийн Ганбат, Монгол Улсын ЭХЯ-ны ТНБД Нансалын Тавинбэх, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Гантөмөрийн Түвдэндорж, СЗХ-ны дарга Баярсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Идэшийн Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Даваасамбуугийн

Эрдэнэбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн судалгааны газрын дарга Лувсанжанцангийн Эрдэнэбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны ХШУДАГ-ын дарга Дэмбэрэлийн Очирваань, Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ТЗУГ-ын дарга Буриадын Дашипүрэв, Эдийн засгийн, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Лхагвасүрэнгийн Балчинлуvsан, Үндэсний аудитын газраас Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Энхболд хаачсан юм. Аудитын менежер Баясгалангийн Долгосүрэн, Машдэлгэрийн Наранжаргал Ахлах аудитор, Баатарын Булган аудитор, Алимаагийн Мөнхбадрал аудитор, Наранчимэг аудитор, ТӨБЗГ Болдын Цэнгэл дарга байна уу, байна. Та яагаад тийм холуур суугаад байна. ХЗДХЯ-ны ТНБД Пүрэвжавын Сайнзориг яагаад алга байна, байна уу. Байна. БХБЯ-ны ТНБД Сандагийн Магнайсүрэн, БОАЖЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сүхбаатарын Цогтгэрэл, Батлан хамгаалахын яамны ТНБД Дагвадоржийн Ганхуяг, БШУЯ-ны ТНБД Лхагвын Цэдэвсүрэн, ЗТХЯ-ны ТНБД Сандагдоржийн Батболд, Соёлын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чойдогдэмидийн Энх-Амгалан, УУХУЯ-ны ТНБД Баяраагийн Бямбадагва, НХХ-ын яамны ТНБД Гомбосүрэнгийн Өнөрбаяр, ХХААХУЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батаагийн Батцэцэг, ЭМЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сувдын Төгсдэлгэр, ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ТЗУГ-ын дарга Буриадын Дашипүрэв, түрүүн танилцуулчихсан шүү дээ энэ чинь яагаад давхардаад байна.

ЗГХЭГ-ын дэд дарга Барсүрэнгийн Баасандорж, ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын ЗГ-ын референт Дашигэрэлийн Бямбадулам,

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын ЗГ-ын референт Сурмаажавын Нямбаяр, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач Баярсайханы Анар, ЗТХЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын газрын дарга Авсайн Мөнхбат, БШУЯ-ны ХШУДАГ-ын дарга Нямсамбуугийн Нарангэрэл, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамьяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны БХЗГ-ын дарга Лхагвасүрэнгийн Энхбат, ЭХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Батмөнхийн Ерэн-Өлзий, УУХЯ-ны ХШУДАГ-ын дарга Төмөрбаатарын Баасанпүрэв, ХХААХҮЯ-ны ХШУДАГ-ын дарга Бямбадоржийн Санчирдорж, ХХААХҮЯ-ны Хүнсний БХЗГ-ын дарга Даваасүрэнгийн Довчинсүрэн, Хүнсний үйлдвэрийн БХЗГ-ын дарга Мэндбаярын Дондогдорж. Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Тайлантай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү.

Энэ сайд нар юу хийж яваа юм бэ? Энэ чинь ЗГ-ын ажлын тайлантай танилцаж байгаа шүү.

Балжиннямын Баярсайхан гишүүнээр, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнээр тасаллаа. Дашидондогийн Ганбат гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хамт явж байгаа гэдгийг сануулъя.

**Д.Ганбат:** Сая Их Хурлын дарга энэ ЗГ-ын ажилладаг, барьдаг энэ дарга нарыг танилцуулах шиг боллоо. Ямар ч олон албан тушаалтай, ямар ч олон хүн байдаг юм бэ. Тэгээд өнөөдрийн энэ ЗГ ажиллаад 2 жил болж байгаа байх, МАН 65 суудалтай болоод 7, 8 жил болчихлоо. Энэ Засгийн газруудын үе үеийн Засгийн газруудын үүнээс хойш ингээд дараалаад явчихсан мөрийн хөтөлбөр нь хэрэгжчихсэн юм уу. Сая би орон нутаг тойргоороо явж байгаад ирлээ. Тэнд амьдрал маш хүнд байна. Энэ ЗГ-тай юм уу, үгүй юм уу бид нар. Нэг аравхан жилийн өмнө 3 хүний нэг нь ядуу байдаг байсан бол өнөөдөр 3 хүний 2 нь ядуу байна. Тэгээд энэ хэдэн яамтай юм бэ, энэ чинь 17, 8 яамтай, 20-оод сайдтай. Тэгээд төрийн албан хаагчдын тоо нь 200000 болчихсон, төрийн өмчтэй компаниуд нь 50, 60 хувьтай ийм байх ёстой юм уу. Энэ хэзээ өөрчлөгдөх юм бэ. АН-ын үед 9 яамтай, 10 сайдтай ингэж ажиллаж болдог байсан. Нэг үе ядуурлын тоо 27, 26, 25% руу очиж, төрийн оролцоо бүр 20% руу орж ирсэн. Одоо бол 40, 50 хувьтай, хаана байна та нар. Ерөөсөө очдоггүй юм байна лээ шүү дээ та нар.

Энэ олон хүмүүс, зайлуул, нөгөө тэнд төрийг төлөөлөн ажиллаж байгаа багийн дарга нар, суманд ажиллаж байгаа хэдэн төрийн албан хаагчид бол томилолтын зардал ч байхгүй юм байна лээ. Өнөөдөр багийн дарга хорьхон литр бензинтэй ийм хүйтэн хэцүү үед ингээд тойроод явж байна. Нөгөө эмч нар дуудлагад очихоороо явахаараа өмнөөс нь бараг зодуулж байна шүү дээ. Ард түмний бухимдал тиймдээ хүрчихсэн байна.

Энэ ноолуурын үнэ хэдээсээ эхлэх гэж байна та нар. Тэгээд энэ ЗГ-ын бодлого тодорхой байхгүй. 1 өдөр бид нар үйлдвэр заводуудаа дэмжиж байна гээд л самнасан ноолуур гаргана гэдэг, тэгээд буцаагаад хаадаг. Буцаагаад нээдэг. Одоо ноолуурын үнэ 180000-аас л эхлэхгүй бол энэ хөдөө орон нутагт МАН-ын гишүүд энэ төрийн албан хаагчид очиж

чадах ч үгүй. Яагаад гэвэл дэлхийн зах зээл дээр өнөөдөр ноолуурын хани бараан нь 100 доллартой байгаа. Цагаан нь 130 доллартой байгаа самнасан ноолуур, түүний 50 хувиар бохир ноолуур гардаг, энэ ийм байж чадах уу, чадахгүй юу.

Малаас гарч байгаа түүхий эдийн үнэ бүгд уначихсан, ганц тэр банканд өр төлбөрөө төлөх юм нь ноолуурын үнэ болчихоод байгаа. Бүгдийг нь унагаачихсан та нар энэ 8 жилд. Тэгээд энэ орон тооны цомхотгол энэ тэр гэж байх ч үгүй, ийм албан хаагчид энд суучихсан ингээд яриад байж байдаг. Үүнийг хэлдэг, ярьдаг хүмүүс аягүй цөөхөн болчихсон. Одоо намайг ингээд ярингуут л хөөе их сонин болж байх шиг байна. Их атар онгон болчихсон энэ улсууд. Ингээж удаан явж болохгүй байна. Тэгээд энэ Ерөнхий сайд чинь хаачсан юм бэ? Үгүй тэгээд Ерөнхий сайд нь байхгүй бол энэ ЗГ-ын мөрийн хөтөлбөр ярина гэж юу байдаг юм. Энэ чинь Монгол Улсын Ерөнхий сайд юм байгаа биз дээ. Тэгээд Монгол Улсын бага ард түмэн энд сууж байна. Ийм юмаа ярьж чадахгүй бол энэ Их Хурал гэж хуралдаад ч яадаг юм. Их Хурал нь ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатарт танилцуулна. Бидний баталсан дээгн тухай хуулиар Ерөнхий сайд эсхүл үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна. Асуултад хариулна гээд заачихсан. Ингээд Чимэдийн Хүрэлбаатар сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Ганбат гишүүний хэлж байгаа олон асуудлууд бас амьдрал дээр бодитой зүйл л дээ. Бид нар Монгол Улс энэ ковид, дайн, инфляц гээд энэ их олон юмны дунд явж байгаа. Хил хаалттай, бид нар өөрсдөө масктай, гэр гэртээ хоригдчихсон байсан цаг саяхан шүү дээ. Тэгээд тэр бүгдээ мартчихаад хэдүүлээ хамаагүй улс төр хиймээргүй байх юм.

Арьс ширтэй холбоотой ХАА-н гаралтай бүтээгдэхүүний тухай би ярьж гэж бодож байгаа юм. 2013 оны 8 сарын 26-ны ЗГ тогтоол гаргаад энэ түүхийгээр гарч байгаа ХАА-н гаралтай бүтээгдэхүүнүүдийг хорьсон юм байна лээ. Тухайн үед ХАА-н сайдаар энэ Женко Баттулга гэж хүн байсан. Тэр АН. Нам ярьж улс төржих гэж байгаа бол. Тэгээд 13 оноос 2023 он хүртэлх энэ 10 жилийн хугацаанд ХАА-н экспорт 9 дахин унасан, ХАА-н гаралтай бүтээгдэхүүнүүд бүгдийнх нь үнэ унасан, ХАА-н гаралтай бүх бүтээгдэхүүнүүд хог болоод хаягдаж байгаа шүү дээ. Тэгээд малчдын өрхийн орлого буусан. Тэгээд харамсалтай нь энэ хил хаалттай, корона гээд тээврийн зардлууд өссөнтэй холбоотойгоор хэрэглэж байгаа барааны үнэ нь өсөөд байгаа учраас энэ Монголын бүх өрхийн амьдралд сөргөөр нөлөөлсөн ийм зүйлүүд явагдаж байгаа.

Тэгээд сая ЗГ дээр ярьж байгаад тэр арьс ширийг хилээр чөлөөтэй гаргах тийм шийдвэр гаргачихсан байж байгаа. Үр дүн нь гарч байна. Одоохондоо Замын-Үүдээр боолтгоор гарч байна, мах гарч байна, арьс ч гарч байна, шир гарч байна, хонины нэхий гарч байна, адууны шир гарч байна, зумласан нооснууд гарч байна. Эргээд энэ нь эцсийн эцэст энэ чинь явсаар байгаад орлого нь малчдадаа нөлөөлөх ийм шийдвэрүүд байж байгаа. Энэ чинь хөдөөгийнхөө орлогыг нэмэгдүүлье гээд.

Ноолуур дээр мөн ялгаа байхгүй, манай энэ Их Хурлаас зөвхөн санасан ноолуур гаргах тогтоол гаргаж өгсөн. Их Хурлын тогтоолтой энд. Үйлдвэржилтийн байнгын хороо оруулж ирж гаргасан. Тэгээд үе шаттай гэж байгаа учраас ЗГ дээр ярьж байгаад яг энэ ноолуурын зах зээл дээр хуучин тэр угаасан ноос гаргадаг, ноолуур гаргадаг, самнасан ноолууртайгаа хамтдаа гардаг энэ шийдвэрийг эргээд гаргачихсан байж байгаа. Энэ нь зах зээлд эерэг мэдээ болж очиж байгаа. Ялангуяа ийм амаргүй цаг



үед энэ ХАА-н гаралтай түүхий эдийн үнийг өсгөх энэ шийдвэрүүдийг гаргах нь эргээд цаад талдаа улсдаа валютын орлогодоо, малчдадаа хэрэгтэй.

Махны квот гэж нэг юм байсан. ХХААХҮЯ бол энэ махны экспортод гардаг квотуудыг аваад хаячихсан. Тэгээд шаардлага хангаж байгаа үйлдвэрүүд нь махаа чөлөөтэй гаргаад эхэлчихсэн байж байгаа. Ингэж байж энэ эдийн засгийг нэг жоохон өндийлгөж, дээшээ болгож, ард иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх бодлогыг энэ Оюун-Эрдэнийн ЗГ хэрэгжүүлж байгаа. Хил нээгдээд боломж гараад ирэнгүүт энэ боломжуудыг бид нар зөв ашиглаж байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн арилжааг ил тод болгодог болгож байна. Энд тэнд нь орлого бага үнээр зарагддаг байсан зүйлүүдийг нь болиулж байна. Татвар төлөгдөхгүй ам үнээр явагддаг байсан нөхцөлүүдийг хэл үнээ болгож өөрчлөх зэрэг боломжоороо л ажиллаж байгаа бид нар. Гэхдээ энэ эдийн засгийн энэ сэргэлтүүд сэргээж эхэллээ гэнгүүт үр дүн нь шууд маргааш гарахгүй. Ингээд энэ чинь ингээд тогтоод хэв болоод үр дүн нь гарна.

Бид нар энэ харин ний нуугүй хэлэхэд энэ 2023 оныг нийтээрээ үр дүнтэй маш сайн ашиглах хэрэгтэй. Төрийн бүх байгууллагууд ажиллах хэрэгтэй. Элдэв бусын саад бэрхшээл хориг, бүгдийг нь болих хэрэгтэй. Бизнесүүд рүү дайрдаг элдэв бусын аргууд том жижиг гэлтгүй элдэв бусаар дайрдаг, нэр хүндэд нь халддаг энэ ажлуудыг бид нар зогсоох хэрэгтэй.

Бизнесүүдийг дэмжиж байж энэ улсын эдийн засаг бий болно, хөгжинө, ажлын байр бий болно гэдгийг бид нар хаа хаагүй ойлгох ёстой. Гоё нэрээр бизнесүүдийг дайрдаг, доромжилдог, нэр хаяг хоч өгдөг, хувийн ти ар хийдэг юмнуудыг тал талдаа зогсоож нийтээрээ бид нар энэ улсын эдийн засгийг өсгөх чиглэлээр энэ хамтарч

ажилламаар байгаа юм шү л гэдгийг ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Дашидондогийн Ганбат гишүүн тодруулж асууна, 1 минут.

**Д.Ганбат:** Нэг байгаа юмаа л энэ Хүрэлбаатар сайд л тэгээд л ярьж байх шиг байна. Тэгээд ингээд 7, 8 жил болчихлоо. Та нар. Тэгээд юу өөрчлөгдсөн юм, юу сайжирсан юм? Энэ чинь 300, 400 саяас ядуурлаасаа гарч байна шүү дээ. Хүмүүс, 4, 5 жилээр энэ улс орнуудыг харахаар атаархмаар байна шүү дээ. Энэ хэдэн хүн ядуурлаас гарсан юм бэ? Тэр ковид ч бай, юу ч бай тийм ээ, ганцхан манай улс орныг дайраагүй шүү дээ. Тийм, бүх улс орнуудыг дэлхий нийтээрээ л тийм байсан юм шүү дээ. Тийм. Тэр байтугай эдийн засаг нь өсөлттэй гарсан маш улс орнууд байна. ЗГ-ын мөрийн хөтөлбөр чинь хэдэн хувь нь хэрэгжээд энэ Монголын ард түмэн цэнгэлийн манлайд хүрчээд байгаа юм бэ? Гадаа гараад энэ Улаанбаатар хотоо хар. Бөөн бухимдал, бөөн түгжрэл, зүгээр яриад байвал та нарын булай, муухай бол уудлаад дуусахгүй шүү дээ. Тэгээд үүнийг улс төржилт гэж бүү ойлго. Тэгээд сөрөг хүчингүй болчихоор чинь ард түмэн чинь гадаа гараад ирдэг юм, ахиад ажлаа хий гэсэн жагсаал байхгүй шүү. Би тэгж бодоод ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Ганбат гишүүний тодруулгад нь хариулъя. Ер нь ингээд энэ 22 оны байдлаар аваад үзэхээр статистикаар аваад үзэхээр нийт өрхүүдийн бодит орлого 0.7 функт буусан байгаа юм. Хөдөөгийн малчин өрхүүдийн орлого 10 функтээр буучихсан байж байгаа. Бодит орлого. Энэ чинь цаанаа айл өрхүүд дээр тодорхой хэмжээний бухимдлыг бий болгоно шүү дээ. Тэгэхээр бид нар бүгдээрээ л энэ асуудлуудаа мэдэж байгаа. Орлого буучихаар бодитой орлого буучихаар бухимдаж л таарна.

Тэгээд хажуугаар нь энэ нийгэмд төрөл бүрийн хулгай зэлгий, хууль зөрчсөн олон асуудлууд яваад очихоор чинь энгийн иргэд бүгдээрээ л бухимдаад сууж байгаа. Гишүүд маань ч гэсэн бухимдаж байгаа. АН-ын та бүгдийн ярьж байгаа шаардлага чангавтар хэлж байгаа ч гэсэн бодитой л зүйл. Тэгэхээр энэ бүгдийг бид нар бодит байдлаа мэдрээд арга хэмжээнүүдээ шуурхай аваад хэрэгжүүлээд явна гэдгээ хэлж байна.

22 оны оны зүгээр 22 оны гүйцэтгэлээр 69.8 хувь ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Бид өнөөдөр нөгөө ЗГ-ын гэхээсээ илүүтэй Монгол Улсын хөгжлийн 2022 оны гүйцэтгэл үр дүнг хэлэлцэж байгаа. Тэгээд 2 Байнгын хороо хамтарч бас хэлэлцсэн. Тэгээд хамгийн гол асуудал нь бид өнөөдөр энэ дээр алдаа оноо юу байв? Түүн дээрээ дүгнэлт хийгээд 23 он, 24 оноо тооцох ёстой, тэр утгаараа УИХ-ын энэ асуудалд гишүүд нухацтай хандаж байгаа гэдгийг би хэлье ээ. Тэгээд гол нь ийм байгаа юм. Мэдээж 20 он, 21 он ковид хатуу хөл хорио, цар тахал, хил гааль, хаалттай, тээвэрлэлт хэцүү байсан гээд эдийн засгийн хувьд үнэхээр их амаргүй зүйл байсан. Одоо 22 он арай нэг гэрэл гарч эхэлсэн. Ялангуяа эдийн засаг тал дээр. Манайх бас ингээд гайгүй болж эхэлж байна л даа. Үүнийг бид хүлээн зөвшөөрч байна. Үүнийг бас дэмжиж Их Хурал, ЗГ явж байна.

Хамгийн гол нь өөрсдөөсөө шалтгаалаад тусгасан, төсөвлөсөн юмнуудаа хэрэгжүүлж чадаагүй алдаа байгаад байна. Жишээлбэл энэ дээр Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, дундаж давхаргыг өргөжүүлнэ гэж заасан заалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэдэг хэрэгжээгүй. Энэ хэрэгжээгүй шалтгаан нь юу байна гэхээр уялдаа холбоо байхгүйтэй байна. Жишээ нь 2022 оны төсөв хэлэлцэх үед бид эрүүл мэндийн салбар дээр тэр зүрх судасны эмнэлэг дээр нь, сүрьеэгийн

эмнэлэг дээр нь, эх нялхсын өргөтгөл дээр нь, анхан шат дээр нь 97 тэрбум гээд санхүүжилтийг нь яг салбарын Байнгын хороо нь хөөцөлдөж, хөөцөлдөж тусгаж өгсөн. Яасан. Тендерээ зарлаж чадаагүй. Сангийн яамтайгаа учраа олж, мөнгөө авч чадаагүй. Мөнгөө тануулчихсан. Эсвэл компаниудтайгаа учраа олдоггүй, нөгөө лобби мафидаа баригдчихдаг юм уу. Ажил нь яваагүй. Тэгээд энэ эрүүл мэндийн хөрөнгө оруулалт, боловсролын тэгш хуваарилалт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн дундаж давхаргын амьдрал сайжруулна гэдэг заалт хэрэгжээгүй гэдэг дүгнэлтийг Аудитын газар хийсэн байна. УИХ-ын хяналт шалгалтын газар хийсэн байгаа юм. Тэгээд энэ өөрөө юу байна гэхээр нөгөө уялдаа холбоо тусгасан мөнгө төгрөгөө ажил хэрэг болгож чадахгүй. Тухайн хүмүүсийн хариуцлагын асуудал энд бас хөндөгдөх гээд байна шүү дээ. Тэгээд энэ чинь өөрөө иргэдийг бухимдуулж байна.

Би өчигдөр 1 зүйл ярьсан. Бид бизнесийг бүх талаар дэмжих ёстой, хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих ёстой, тэгж дэмжиж байгаа. Гэхдээ томоо хөрөнгө оруулагчдаа бид дэмжихийн зэрэгцээ дунд, жижиг зах зээлээ аливаа улс орон бас хамгаалдаг. Тэгээд нөгөө хуучин Өргөдлийн байнгын хороо гэж байхад бидэнд ийм хүсэлт ирчхээд байгаа байхгүй юу. Бүх дундаж давхарга, жижиг зах зээл хаагдахад хүрээд байна. Зээлд хамрагдаж чадахгүй, зээл хумигддаг, баталгаа гэдэггүй тэгээд том том компаниуд нөгөө зээлийг нь авчихдаг. Сүүлдээ ингээд гаднын том сүлжээнүүд маань бас ингээд орж ирээд бид байдал амаргүй байна. Тэгэхээр энд зохицуулдаг газар юм уу анхаардаг газар байна уу гээд бид нарт хандаад байгаа байхгүй юу. Тэгээд л би Эдийн засгийн байнгын хороон дээр жишээ нь бүгдээрээ томчуудаа манлайлж авч явж байгаа том компаниудаа дэмжье, жижиг дунд гэдэг чинь өөрөө бид нарын энд энэ ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Их Хурлын мөрийн хөтөлбөр дээр бид нар дээр заасан чинээлэг дундаж давхаргыг хөгжүүлэх,

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх гэдэг зорилт чинь энэ хүмүүс бас орчхоод байхад энэнд бас хамгаалалт хэрэгтэй байна гэж энэ яриад байгаа юм. Тэгэхээр бид нар жишээлбэл энэ дээр ямар ахиц гаргах вэ? Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 22 онд оруулж ирнэ гээд төлөвлөсөн. Энд орж ирээгүй, энэ бас биелээгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ зүйлүүдээр ер нь цаашидаа ЗГ үнэхээр анхаарал сайн хандуулахгүй бол Их Хурал ч гэсэн бас энэ хуучин тэр нөгөө Өргөдлийн байнгын хороон дээр яг энэ төвлөрөөд бид агаарын бохирдол, хөрсний бохирдол, усны асуудал, хоолны чанарын асуудал дээр өөрчлөлт хийж чадаж байсан. Одоо бас ингээд жоохон хаана хандахаа ч мэдэхгүй ийм зүйл байгаад байгаа дээр би энэ анхаарах ёстой болов уу гэж бодож байна.

2 дахь зүйл нь энд тэр гэр хорооллын нүхэн жорлонг шат дараатайгаар өөрчилж шинэчилнэ гэсэн заалт. Энэ 5 тэрбум гэсэн байгаа юм. Би түрүүн бас БОАЖ-ын сайдтай ярьж байсан, энд сайд хариулж өгөөч. Энэ хэрэгжилт нь яаж явж байгаа юм, энэ яаж хийгдэж байгаа юм, цаашидаа энэ дээр бид яаж анхаарах вэ? Энэ чинь өөрөө зөвхөн тэр гэр хорооллын айл өрхийн асуудал биш бүхэл бүтэн Монгол хүн бүрийн эрүүл мэндтэй холбоотой асуудал болж байна л даа.

Цусан дахь хүхрийн хэмжээ байх ёстой хэмжээнээсээ 5-7 дахин их болж байна гэдэг чинь Монгол хүн сульдаа, ядруу, өвчин аймаар болоод байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Хариулт хангалтгүй л гэж үзвэл тодруулж асууна. Магнайсүрэн БХБЯ-ны ТНБД. Индрийн 1 номер. Эхлээд Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулчихъя.

**Ц.Даваасүрэн:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Оюунчимэг

гишүүн бол энэ гэр хорооллын дахин төлөвлөлт, ялангуяа энэ инженерийн дэд хэсэг байгуулах тал дээр нэлээн санаачилгатай ажилласан. Харамсалтай нь жорлон ярилаа гээд ингээд энэ гишүүний санаачилсан ажлыг бас дэмжээгүй. Уг нь дэмжих ёстой ажил, тэгэхдээ гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил бас хийгдээд явж байгаа. Энэ хүрээнд 23 онд 18 байршилд 57 хэсэгчилсэн талбайд 45 төслийг хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж байгаа. Нөгөө компаниуд, гэр хорооллын дахин төлөвлөлт гээд. Энэ хүрээнд нэг 2800 гаруй айлын хашаа буюу айлын нүхэн жорлонгийн асуудал шийдэгдсэн байгаа гэсэн үг. Энэ ажил үргэлжлээд явж байгаа. Орон нутгууд ч гэлээ гэсэн бас энэ инженерийн дэд бүтцийг тэр цэвэр ус, бохирын инженерийн дэд бүтцүүд явагдаж байгаа учраас бас орон нутгуудад нэлээн их хэмжээний ийм гэр хорооллын хашааны жорлонгийн асуудлыг бас шийдээд явж байгаа юм л даа. Тухайлах юм бол манай аймагт гээд тэгэхэд 400 гаруй хашааны жорлонгийн асуудлууд шийдэгдсэн байх жишээтэй. Цаашидаа ер нь энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 18843 ийм га газар чөлөөлөлт хийх буюу ийм хэмжээний нүхэн жорлонгийн асуудал шийдэгдэхээр ингэж төлөвлөгдөөд явж байгаа. Нэг жишээ татахад энэ Ногоон нуур гээд энэ архан талд хийгдэж байгаа. Тэр Хятадын тусламжийн хөрөнгөөр хийгдэж байгаа гэдэгт нэг 50-аад хашааг чөлөөлөөд ингээд явж байна.

Мөн сургууль, цэцэрлэг, авто зам энэ тэр гээд нөгөө гадна инженерийн шугам сүлжээний зориулалтаар бас 400-аад ийм хашааг бас чөлөөлөх, нүхэн жорлонгийн асуудлыг шийдэх ийм ажил энэ онд хийгдэнэ. Мөн бусад төслийн хүрээнд бас 170 ийм нүхэн жорлонгийн асуудлыг бас хашааг чөлөөлөх ийм ажлууд хийгдээд ингээд явна.

Мөн Сэлбэ, Сэргэлт гээд бас төслийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Дамбадаржаа, Чингэлтэйн хэсгүүдэд энэ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нүхэн жорлонг шийдвэрлэх инженерийн дэд бүтэц очихоор ингэж төлөвлөгдөж байгаа. Сэлбэ дэд төв, Баянхошуу дэд төв гээд ингээд энэ дэд төвүүдийг түшиглээд бас тэнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлууд ингээд эрчимжээд, тэнд хашааны асуудлууд шийдэгдээд явахаар ингэж байж байгаа. Мөн Дамбад бас дэд төв баригдаж байна.

Бид дэд төв барих, дэд төвийг инженерийн хэсэгчилсэн дэд бүтцээр шийдэхээр төлөвлөж байгаа. Удахгүй нийслэл хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө орж ирнэ. 2 жил төлөвлөгөөгөө явчихсан байгаа. Энэ төлөвлөгөөг нийслэлтэй хамтраад оруулна. Энэ хүрээнд бид нар гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэсэгчилсэн инженерийн дэд бүтэцтэйгээр шийдэх ийм чиглэлийг барьж байгаа.

Ер нь санхүүгийн асуудал ингээд шийдэгдээд явчих юм бол эдийн засаг сайжраад явчих юм бол бид нар гэр хорооллын дахин төлөвлөлтөөр нэлээн ажлуудыг хийе гэж ингэж төлөвлөсөн байгаа.

**Г.Занданшатар:** 92 Бат-Өлзийн Бат-Эрдэнэ БОАЖ-ын сайд.

**Б.Бат-Эрдэнэ:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. 2022 онтой холбоотой асуудал буюу нүхэн жорлонтой холбоотой асуудал хөндөгдөж байна. Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд эко жорлон арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хөрсний бохирдлыг бууруулах энэ төлөвлөлт ороод явж байгаа. Үүний хүрээнд бид нар 2022 онд 5 биш нийтдээ 4.5 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр тухайн эко жорлонг бий болгохтой холбоо бүхий асуудлуудыг Улаанбаатар хотын СБД, ЧД, БЗД, Орхон аймгийн Баян-Өндөр сумдад хэрэгжүүлсэн. Зарим ажлууд дуусаагүй, гүйцэтгэл дутуу яваа ажлууд бий. Өвөл болсон учраас тодорхой ажлууд хойшлогдсон. Үүнтэй холбогдуулаад 2023

оны Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны төсөв дээр үлдэгдэл 9 орчим тэрбум төгрөг өнгөрсөн онуудын ажлуудын, тэр нь дотроо саяын хэлсэн тодорхой 2022 ондоо гүйцэтгэл гарч амжаагүй ажлын төсөв бий. 9 тэрбум гэдгийг дахиж тодруулж хэлэхэд бол өнгөрсөн оны хийгдэж дуусаагүй ажлуудын гүйцэтгэл, нүхэн жорлонгийнх дангаараа биш шүү гэдгийг бас хэлэхийг хүсэж байна. Тэгэхээр ажлууд явагдаж байгаа. Хаврын улирал ирж байгаа учраас үргэлжлүүлээд тодорхой ажлууд явна гэж харж байгаа.

Тендер сонгон шалгаруулалттай холбоо бүхий асуудал дээр тодорхой хэмжээнд гомдол өгөх, саатах, эргээд тухайн гомдлуудыг эцэслэхээс улбаатайгаар ажлууд оройтож эхэлсэн зүйлсүүд бий. Тэгэхээр ямар ч байсан 2022 онд 2000 нүхэн жорлонг эко нүхэн жорлонгоор солих ажил төлөвлөгдсөн. Энэ ажил 90 хувийн гүйцэтгэлтэй үлдэгдэл төлбөрүүдийг гүйцэтгэлээ шалгаад хүлээж авснаас хойш өгнө.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг 1 минут.

**М.Оюунчимэг:** Яг энэ хэсэгчилсэн инженер, дэд бүтэц, агаар хөрсний бохирдлыг бууруулах дээр хийх ажил дээр яг анхаарал хандуулаад бас санаачилгатай байгаад би БХБ-ын сайд Даваасүрэн сайд, Байгаль орчны сайдад ч талархаж байна. Үүнийг бас ойлгоод яриад байна. Энэ чинь бүх хүний эрүүл мэндтэй холбоотой асуудал байгаад байгаа. Хавдрын өвчлөлөөр бид эхний 3-д ороод явж байна шүү дээ, дэлхийн хэмжээнд. Тийм учраас л үүнийг яриад байгаа юм шүү гэдгийг хэлье. Тэгээд энэ дээр цаашидаа үнэхээр анхаараарай.

2 дахь зүйл нь, ЗГХЭГ-ын дарга өөрөө яг шинэ хүн, ингээд ажилтай эрчимтэй ороод явж байгаа. Энэ Үндэсний аудитынх дээр ч, УИХ-ын Тамгын газар дээр ч ийм юм байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ЗГХЭГ-аас 22 оны хэрэгжилтийн тайланг ирүүлэхдээ арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй, зорилтын хэрэгжилтийн хувийг өсгөсөн дүнтэй ингээд байгаад байдаг. Ер нь энэ яамнуудын хоорондын уялдаа холбоо муу байгаа нь нөгөө бидний төлөвлөсөн ажил, хөгжлийн зорилтууд биелэхэд садаа болж байна гэсэн дүгнэлтийг Аудитын газар ч, УИХ-ын хяналт үнэлгээ ч хэлсэн байна л даа. Тэгээд энэ дээр цаашидаа ер нь анхаарч ажиллах хэрэгтэй.

**Г.Занданшатар:** Үг хэллээ.

13 цаг болсон байна. Олон хүн оролцож байгаа учраас. Завсарлая.

Завсарлалаа. 14 цаг хүртэл завсарлая.

### **ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.**

**Г.Занданшатар:** УИХ-ын хяналт шалгалтын хуулийн дагуу Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.

Үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн биелэлт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Шадар сайд танилцуулж, Байнгын хороодын дүгнэлтийг танилцуулсан.

Үүнтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авах ажил үргэлжилнэ.

Гишүүд, ажлын хэсгийг оруулъя.

Гишүүд, ажлын хэсэг орж ирсний дараа Гонгорын Дамдинням гишүүнээр асуулт, үгийн ажил үргэлжилнэ.

Цаг бол цаг юм даа. Дабл стандарт байхгүй, ерөөсөө нэг л цаг бол цагаараа л байхгүй бол Дамдинням гишүүнд тааруулж хорвоогийн цагийг хөдөлгөх арга алга.

Ажлын хэсгийг оруулаарай. Энэ сайд нар, ТНБД хаана байна.

Ажлын хэсгийг оруулаарай.

Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Г.Дамдинням:** Байхгүй юм биш үү дарга аа, энэ асуулт асуух сайд нар нь байхгүй байгаа юм чинь, сайд нарыг нь оруулж ирж байж л асуумаар байна шүү дээ, дарга аа, хариулах хүн байхгүй байна шүү дээ, энэ чинь.

Би яг одоо хэрэгтэй л юмнууд асууна л даа. Би тэгэхээр сайд нарыг орж ирэхээр л эхэлмээр байна. Тийм. Зам, тээврийн та сайд хэрэгтэй байна, ХХАА-н сайд хэрэгтэй байна, минутаа эхнээс нь ав ...

**Г.Занданшатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн асууж байх уу. ХАА-н сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, бусад сайд нарыг дууд.

**Х.Ганхуяг:** Энэ өдрийн мэндийг хүргэе. Надад нэг 3 асуулт байгаа юм. Бид нар чинь энэ жил бол авлигын эсрэг хууль гэж ЗГ-аас зарласан байгаа. УИХ-ын дарга бас яг авлигын эсрэг бол тууштай тэмцэхээр бас байр сууриа илэрхийлсэн байгаа. Тэгээд Авлигал бол зөвхөн Эрүүгийн хуулийг чангатгаснаараа бол багасгана гэж ерөөсөө харахгүй байна. Тэгээд асуудлууд нь угаасаа энэ том ТӨК-үүд, энэ тусгай зориулалттай сангууд, өрсөлдөөнийг боомилсон энэ хуулиуд байгаад байдаг. Асуудал үүсэхээр зүгээр нүүрийг нь солиод л тэгээд нөгөөдөх юмаа дахиад л үргэлжлүүлдэг. Үгүй ээ, нэг хэсэг концесс концесс гээд л байж байгаад л дараа нь төр, хувийн хэвшлийн түншлэл гээд л хуулиа сольчихсон. Одоо ингээд Хөгжлийн банк гэж явж байгаад л

экспорт, импорт банк болгох юм уу, ямар банк болох юм мэдэхгүй байна.

Сая Тариалан эрхлэх дэмжих санг корпорац хэлбэр лүү шилжүүлээд л ингээд л ороод ирж байгаа юм л даа. Тэгэхээр бид нар энэ авлигыг төр өөрөө ийм асар их хэмжээний өмчтэй, тэгээд дээрээс нь төрийн оролцоо асар их байхаар тэрийгээ дагаад энэ авлига чинь гараад байгаа юм л даа. Хөрсөө бид нар цэвэрлэхгүй л бол энэ авлигал угаасаа багасахгүй. Тэрийгээ дагаад л энэ том, том үүнийг энэ хууль хяналтын байгууллага нь давхар давхар томроод л, хяналтаа сайжруулж байгаа гээд л энэ хууль хяналтын байгууллага нь томроод л, төсөв нь томроод л ингээд л явчхаж байгаа юм л даа. Тэгээд ингээд нэг байнгын хулгайч хайсан ийм шинжтэй л болох гээд байна л даа. Тэгэхээр энэ цаашдаа энэ төрийн энэ ЗГ-ын тусгай зориулалттай сангууд 13 сан байгаа юм. Экспортыг дэмжихээс бусад зорилгоор эсвэл яг импортын бараа бүтээгдэхүүний өрсөлдөхүйц чадах, чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл экспортыг нэмэгдүүлэх зориулалт бүхий сангаас бусад ер нь энэ сангууд ер нь багасгах бодлого байгаа эсэх, одоо бид нар энэ хэрэгжилтийн тайлан сонсохоор энэ сангуудын талаарх ерөөсөө тайлан орж ирдэггүй. Үйл ажиллагааны тайлан ч байдаггүй, санхүүгийн тайлан ч мэдэгддэггүй, үнэлгээний тайлан ч байдаггүй. Тэгээд энэ дээр ямар байр суурьтай байгааг нэг сонсчихмоор байна.

2-т, энэ төрийн өмчийн компаниуд гээд одоо бид нар бол ингээд л 45 их наяд гээд л их яриад л байдаг. Өмч болон ашгийн харьцааг нь харвал асар муу үзүүлэлттэй явдаг. Угаасаа ТӨК-ийн захирлууд ашгийн төлөө явдаггүй байхгүй юу. Ноогдол ашгийг нь бид нар улсын төсвөөр ганцхан удаа жилд нэг төсвийн хуулиар 1-2 хувийг нь л татаж байдаг. Тэгээд магадгүй энэ ноогдол ашгийг нь илүү хувиар төсөв рүү татдаг байх. Энэ яг ашгийн зориулалттай ТӨК-ууд дээр хяналтаа иргэдийн оролцоог нь хяналтыг нь сайжруулах тал дээр ямар арга

хэмжээ авах вэ? Эрдэнэс Таван толгой дээр жишээлбэл иргэд бол 15 хувийг иргэд ААН-д үүнийг 15 хувийг эзэмшдэг ч гэсэн хяналтаа тавих ямар ч боломж байдаггүй. ТУЗ-ийг нь иргэд тавихад оролцдоггүй, гүйцэтгэх захирлыг томилоход иргэд оролцдоггүй, тэгээд тэрнээсээ болоод л ингээд л нүүрсний хулгайн асуудал өнөөдрөөс сөхөгдөөд л ярьж байгаа байхгүй юу. Тэгээд бид нар авлигатай тэмцэх гэж байгаа зүгээр ингээд Эрүүгийн хууль чангатгаснаар энэ авлигал угаасаа буурахгүй шүү дээ. Нэг хулгайчийг нөгөө хулгайчаар л сольж байгаа асуудал болж байгаа. Тэгээд энэ дээр би нэг байр суурь сонсчихмоор байна.

3 дугаар асуудал, энэ зөвшөөрлийн тухай хууль байгаа юм. Бид нар өнгөрсөн жилийн 6 сард батлуулсан хэрэгжиж эхэлдэггүй, хэрэгжүүлдэггүй, зөвшөөрөл болгон дээр маш олон судалгаанууд тэгж энэ яам, тамгын газруудыг бүгдтэй нь маш олон удаа уулзалт хийж 5 дахин бууруулсан. Тэгээд үүнийг зөвхөн ганцхан би жишээ л дурдъя. Одоо витаминьг бид нар зөвшөөрөлгүй болгосон, Зөвшөөрлийн хуулиар. Тэгээд ямар ямар өөрчлөлт оруулахыг нь тухайн үеийн ЭМЯ болон агентлагт нь бид нар юунуудыг нь өгсөн, чиглэлүүдийг нь өгсөн, УИХ-ын 35 дугаар тогтоол бас гарсан.

Тэгээд яг өнөөдрийн хэрэгжилтийн байдал дээр ямар байна гэхээр онгоцны буудал дээр гаалийнхан нь 2 ширхгээс илүү ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Эхлээд хариултаа сонсоно. Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** ЗГ-ын тусгай сангуудын тухай асууж байна. Ер нь энэ нэг ЗГ-ын тусгай сангууд замбараагаа алдчихсан байсан учраас ЗГ дээр Ерөнхий сайд тухайн үедээ одоогийн Ерөнхийлөгч тухайн үед Хүрэлсүх Ерөнхий сайд байхдаа үүрэг өгч энэ дээр шалгалтууд орсон, тэгээд нэг цэгцэлсэн. Тэгэхээр ер нь

энэ тусгай сангуудтай холбоотой ямар нэгэн үүнийг асуултуудыг бол Ганхуяг гишүүн ийм 3 үед нэлээн сайн тодруулж асууж болно эсвэл бас асуулга асуугаад тодруулчхаж болно.

Нэгдүгээрт нь, энэ нэг төсвийн гүйцэтгэл орж ирэх үед үүнийг бол нэлээн сайн ярих ёстой. Яагаад гэвэл төсвийн гүйцэтгэл орж ирэхдээ аудитууд хийгдээд, дүнг нь хавсаргаад оруулж байгаа. Тэгэхээр тэр үед нь асуугаад тодруулаад явж болно. ЗГ-ын санхүүгийн тайланг мөн хэлэлцэж байх үед болно. Төсвийн хэлэлцүүлэг төсөв өргөн мэдүүлэхэд ер нь мөнгө энэ санд тавих шаардлага байгаа юу, ямар үр дүнтэй юм бэ гээд тавьж болно. Тухайн үедээ бас энэ ЖДҮ сан дээр асуудал үүсээд байсан учраас ЗГ-аас ЖДҮ сан дээр мөнгө тавилгүйгээр оруулж ирж байсан, 2 жил дараалаад 2018 онд, 2019 он дээр мөнгө тавихгүй. Яагаад гэвэл энд тавигдсан мөнгө зориулалтын аргаар зарцуулагдаж байна уу үгүй юү гэдгийг нь тавиад оруулж явуулж байсан. Ийм юм байгаа. Тэгэхээр энэ дээр одоогийн байдлуудыг эргүүлж бас нэг эргэж харж үзэх нь зүйтэй гэдгийг бол хэлье.

Дээр нь энэ хийгдсэн шалгалтын тайлангууд бол яамдын сайт дээр нь байдаг гэдгийг бас та бүгдэд хэлчихье.

ТӨК-уудын хувьд бол асуудлууд бий, бий. Тэгэхээр ер нь энэ дээрээс бид нар ингээд нэг их мундаг хүн тэнд даргаар тавьсан ч адилхан л хэдэн хугацааны дараа тавиад л тэгээд л тэр юундаа ороод л явчихдаг юм шиг байгаа юм. Тэгэхээр ер нь хамгийн сайн гарц бол энэ ТӨК-уудыг ил тод болгох, тэр нээлттэй ХК болгох чиглэл рүү нь ер нь явж ажиллах нь зөв байх гэж би хэлье.

Зөвшөөрлийн тухай хуулийн энд хэрэгжилтийн асуудлаар бол энд тэнд нугалаа гарч байгаатай бол би Ганхуяг гишүүнтэй бол санал нэг байгаа. Зөвшөөрлийнхөө хуулийг гүйцэд ойлгодоггүй эсвэл хэн нэгэн хүн эрх мэдлээ

тодорхой нэг журмаар авч үлдэх гээд суугаад байдаг. Тэгээд түүнтэйгээ холбоотой юмыг олон нийтдээ хүргэдэггүй, өөрсдөө төрийн албан хаагч байж байж энэ УИХ-аар батлагдсан хуулиа уншдаггүй, хэрэгжүүлдэггүй ийм зүйл нийтлэг байгаа. Тэгэхээр үүнийг бол нэг бүрчлэн авч, тэр хариуцлагыг нь хүлээлгэж ер нь явна гэсэн ийм бодолтой байгаа. Хууль хэрэгжүүлэхгүй байгаа хүмүүс тэр ажлаа өгчхөөд өөр юм хийгээд явж бас болно шүү дээ. Тийм байдлаар бол энэ асуудлуудад хандаж байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууна.

**Х.Ганхуяг:** Тэгээд энэ биологийн идэвхт бүтээгдэхүүн буюу витамин бусад оронд бол нэмэлт хүнс гэж ярьдаг. Тэгээд өнөөдөр энэ зүгээр ганцхан зөвшөөрөл дээр л би яриад байгаа шүү дээ. Одоо асар олон зөвшөөрөл байсан, тэгээд зарим нь бол олныг нь байхгүй болгосон. Одоо тэгээд л яг өнөөдөр ирж байгаа гомдол гэхээр өчигдөр онгоцноос буулаа, 2 ширхэг витамин оруулаа, 3 дахийг нь хурааж аваад байна. Үгүй ээ энэ зөвшөөрлийн хуулиар та нар чинь дээр баахан юм болоод л баталсан ч одоо витамин дээр зөвшөөрөл нэхэхээ больчихсон гээд л ярьсан. Тэгээд яагаад зөвшөөрөл нэхээд байгаа юм бэ гээд л гааль дээр болохоор бид нар тийм хууль мэдэхгүй ээ гэж ярьсан байгаа байхгүй юу. Тэгээд би энэ ГЕГ-аас хүн байвал яг энэ дээр тайлбар өг гэж хэлмээр байна. Яагаад хуулийг дагаж мөрддөггүй юм, хэний хуулийг дагаж мөрддөг, ямар хуулийг дагаж мөрддөг, ямар хуулийг дагаж мөрддөггүй юм бэ гэдгийг л би асуумаар байна.

**Г.Занданшатар:** 82, Сангийн яамны ТНБД Жигжидийн Ганбат.

**Ж.Ганбат:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Бид яах вэ, ингээд байгаа юм, хувийн хэрэгцээндээ яг хүний хэрэгцээтэй юмыг бол бид гааль бол нэвтрүүлнэ түүнээс дээш гэдгийг бол

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

өөрөөр хэлэхэд бол арилжааны зориулалтаар орж ирнэ гэж үздэг. Ийм байгаа. Нөгөө талдаа бид бас Монгол Улсын хилээр орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнээс бол бид бас татвараа бол бүр бүрэн авах ёстой. Энэ зарчмын үүднээс бол ингэж бас тодорхой хязгаарлалтуудыг бол хийж өгч байгаа.

Гэхдээ нөгөө талдаа тэр хүн таны хэлдгээр хувийн хэрэгцээндээ 2 витамин хэрэглэх юм уу, 3 хэрэглэх үү, тэрийг бол бас хянахад бас хэцүү. Жоохон хүндрэлтэй л дээ. Гэхдээ бидний зорилго бол яах вэ, хүн яг өөрийнхөө хэрэгцээндээ нэг төрлийн барааг тодорхой хязгаарын хэмжээнд авч болно. Түүнээс дээш орж ирсэн юмыг өөрөөр хэлэх юм бол татвараас зайлсхийх бас татвараа бүрэн төлөхгүй байх гэдэг бас ийм асуудлууд үүсээд байдаг учраас үүн дээр тодорхой хязгаарлалттай. Хууль дээр угаасаа хүний хувийн хэрэгцээндээ ашиглах зориулалтаар оруулж ирж байгаа бараа бүтээгдэхүүнд татвар ногдуулахгүй байдаг ийм байгуулалт ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Жигжидийн Ганбат 82, гаалиас хүн байгаа юм уу? 82.

**Ж.Ганбат:** Яах вэ, одоо хувийн хэрэгцээнээс илүү давсан юман дээрээ тэр хүн татвараа төлөөд авах бол бүрэн бололцоотой. Зүгээр яах вэ, би хурааж авсан гэдэг бол татвараа төлөхгүй гэдэг бас ийм асуудлууд үүсээд байгаа тохиолдолд бол юу гэдэг юм тэр хүнийг хувийн хэрэгцээнээс давсан юмыг бол татвараас зайлсхийх зорилго гэдэг байдлаар бас ийм тохиолдлууд үүсдэг. Түүнээс хүн татвараа яг өөрийн хэрэгцээнээсээ илүү юмаа татвараа төлөөд оруулах нь бол нээлттэй.

**Г.Занданшатар:** Тэгэхдээ энэ чинь онцгой татвартай бүтээгдэхүүн биш л дээ.

**Ж.Ганбат:** Үгүй ээ, яах вэ нөгөө гаалийн татвар, ингээд импортын

барааны гаалийн НӨАТ энэ тэр гээд татварууд байгаа л даа. Тэгээд яг хувийн хэрэгцээнээс давсан юман дээр хүн татвараа мэдүүлээд төлөөд л авах нь бол нээлттэй.

**Г.Занданшатар:** Архи тамхи ч юм уу онцгой албан татвартай

**Ж.Ганбат:** Яах вэ, ижил нэг төрлийн бараа гэдэг дээр бас ийм юм байдаг л даа, жишээ нь гар утсыг бол хүн. Яах вэ витамин дээр ч гэсэн бас нэг ижил төрлийн витаминьг одоо юу гэдэг юм, 3 юу гэдэг юм нэг олон ширхгээр оруулж ирж байгаа янз бүрийн тохиолдолд бол бас ийм тохиолдлууд үүсдэг л дээ. Хувийн хэрэгцээ, өөрөө хувийн хэрэгцээндээ хэрэглэх ёстой гэдгээ бас тухайн оруулж ирж байгаа иргэн маань бас нотлох ёстой. Би эмчилгээний зориулалтаар ийм ийм байдлаар гэдэг бол тэрийг нь бол нэвтрүүлнэ, тэрийгээ нотолж чадахгүй тохиолдолд татвараа төл гэдэг ийм л шаардлага тавьдаг. Татвараа төлөхгүй тохиолдолд бол бас хурааж авах ийм юмнууд бол байгаа.

**Г.Занданшатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууна.

**Х.Ганхуяг:** Ингээд хамгийн сүүлд ирсэн гомдол болохоор энэ Дангаасүрэнгийн Энхбат гээд хүний гомдол байна. Энэ нөгөө Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож байсан хүн, би одоо ингээд шуудангаар витамин захиалж авах гэсэн чинь болохгүй байна. Уг нь Зөвшөөрлийн хуулийг чинь ярьсан, хасагдсан гэж ойлгосон, гаалийнхан тийм өөрчлөлт огт сонсоогүй ээ гээд хураагаад авчихлаа гэж. Яг өнөөдөр ирсэн мессеж, гомдол байна. Тэгээд яагаад ийм зөрөөтэй тайлбар өгөөд байгаа юм бэ гээд л бид асуулт асуугаад байгаа шүү дээ.

Гаалийнхан чинь яагаад өөрөөр үүнийг тайлбарлаад байгаа юм бэ? Татварын асуудал гэвэл татварыг нь л ав л даа. Яагаад бараа бүтээгдэхүүнийг нь



хурааж аваад байгаа юм бэ л гэдэг асуулт байхгүй юу. Яагаад Зөвшөөрлийн хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ?

**Г.Занданшатар:** Жигжидийн Ганбат дарга хариулъя, 82.

**Ж.Ганбат:** Би яг энэ саяын таны хэлсэн Дангаасүрэн гэдэг хүнтэй холбоотой асуудал дээр яг ямар асуудал үүсээд байгаа гэдгийг нь яах вэ, тодруулаад танд хэлье. Түүнээс биш уг нь яг л бидний барьдаг зарчим бол хувийн хэрэглээнээс давсан юман дээр татвараа төлөөд нэвтрүүл ээ л гэдэг л зөвшөөрөгдсөн бараан дээр, ийм л зарчим барьдаг л даа.

**Г.Занданшатар:** Энэ Чинбүрэн гишүүнийг тэр зөвшөөрлийн хууль хэлэлцэж байх үед эм, эмнэлгийн хэрэгслийн болон витамин бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрлийн процедур хүндэрчихлээ. Бас энэ гааль дээр татварын асуудал гэж бас нэг асуудал хөндөж ярьж байсан юм шүү. Түүнийг бас хэрэгжилтийг уялдуулж хараарай. Харин тэр авлигатай тэмцэнэ гэдэг бол тэр дижитал шилжилт, цахимжуулах, зөвшөөрлийн хуулийг хэрэгжүүлэх, эдийн засгийн либералчлал гээд энэ ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ч, эдийн засгийн бодлогын хэсэгт ч гэсэн дурдсан асуудлуудын хэрэгжилттэй холбоотойгоор энэ дээр яригдаж болох ёстой л доо. Үүнийг төсвийн гүйцэтгэл хэлэлцэх үед энэ тусгай сангуудын хэрэгжилт, үр ашиг, сангийн удирдлага хараат бус, мэргэжлийн, ил тод, нээлттэй, үр ашигтай байгаа эсэх асуудал, сангийн эргэн төлөгдөлт, зээлүүдийн эргэн төлөгдөлт энэ тэр асуудлуудыг бас эргэн төлөгдөж байвал асуудалгүй. Тэгээд эргэн төлөгдөхгүй үүнийг өчнөөн юм байдаг тухай л энэ сонсгол юмнуудаар чинь ил болоод байна шүү дээ. Тэгээд үүнийг бол жич бас хяналтын шатанд хэрэгжиж болно. Асуулт асуулга, энэ тайлан хэлэлцэх гээд энэ УИХ-ын хяналт шалгалтын хуульд дурдсан бас төсвийн зарчим төрлүүдийг

заасан байгаа. Энэ хүрээнд бас хэлэлцэж болно.

Одоо Гонгорын Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн биелэлт бид нар яриад явж байна. Төрийн бүтээмж хэр зэрэг байгаа тухай бид нар бас ярих ёстой болчихоод байгаа юм. Би зүгээр нэг жишээ л хэлье. Зүгээр ЗГ-аас бол дээд түвшиндээ нэлээн хичээж чармайгаад ажиллаад байх шиг байна. Дунд нь бас нугалаа завхрал их гараад байх юм. УИХ-аас Дарханы замын бүтээн байгуулалтыг хянан шалгах ажлын хэсэг байгуулагдаад ажиллаад явж байгаа. Тэгээд өнгөрсөн зун Монгол даяар цемент хомсдоод Дарханы замын бүтээн байгуулалтад садаа болж байна гээд. Тэгээд цементийн нийлүүлэлт тасалдсанаас болоод барилгын үнэ өсөөд цементээр хийгдэж байгаа бүх ажлууд гацаад улсын төсвөөр хийгдэж байгаа барилга бүтээн байгуулалтын ажлууд бүгдээрээ цементгүйгээс үүнийг саатаж байна гэдэг ийм асуудал үүссэн. Тэгээд яг газар дээрээ яг юу болчихсон юм бэ гээд шалгаад харахаар Дарханы замд өнгөрсөн жил 90000 тонн цемент орсон. Дарханы замын нэрээр цемент үйлдвэрлэгчдээс 126000 тонн цемент авчихсан байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл 36000 тонн цемент Дарханы замын нэрээр аваад дамлаад зарчихсан юм уу, эсвэл өөр тийшээ хийчихсэн юм уу нэг ийм байдал руу орчихсон байгаа юм. Энэ нь өөрөө засгаас Дарханы замыг яаралтай дуусга гээд чиглэл өгөхөөр гарч ирсэн цементийг нь дамлаад зарчихсан л ийм яриа сонсогдоод байгаа юм. Тэгэхээр энэ мэт ажлууд дээр засаг бас хяналт шалгалтаа тавьж ажиллах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, Болорчулуун сайдаас бас асуулт байна. Дарханы арьс ширний цогцолборын ажил ер нь хаана яваа юм бэ, яаж шийдэж байгаа юм, ямархуу бүтээн байгуулалттай явж байгаа юм, ямар хувь хэмжээтэй явж байгаа юм бэ. Энэ ажлыг

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бид нар хийнэ гээд 2020 онд баахан амлаж байгаад гараад ирчихсэн, одоо нэхээд л байна л даа, хүмүүс. Малынхаа түүхий эдийг бид нар бас боловсруулах нь манай дотоодын үйлдвэрлэл боловсруулах үйлдвэрээ дэмжих нэг бодлого зайлиггүй мөн. Дархан-Уул аймагт барина гээд зарлачихсан, төсөл нь хэрэгжээд явж байсан. Ингээд дундаа гацчихсан. Энэ дээр ямар ахиц дэвшилттэй явж байгаагаа нэг хэлэх хэрэгтэй байна.

Дараачийн асуудал, энэ төмс, хүнсний ногоогоор дотооддоо бүрэн хангадаг болно гэсэн ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө үндсэн чиглэлд тусчихсан ийм зорилго байгаа. Энэ зорилгын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Дархан-Уул аймгийн Орхон сум буюу Монголын төмс хүнсний ногооны бараг 25 орчим хувийг дангаараа хангадаг, лууван төмсөөр хангадаг энэ суманд очиж ажиллаад, өвлийн хүлэмж, зоорь шийдвэрлэж өгнө өө гэж хэлсэн. Тэгээд энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт дээр одоогоор бол энэ ямар ч ахицгүй л байгаа. Энэ ажил ер нь хэрэгжих юм уу, яаж хэрэгжих юм бэ? Ямар нэг ахиц гарч байгаа юу? Ийм 3 асуулт байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Зам, тээврийн хөгжлийн ТНБД Батболд 1 дүгээр микрофон дээр. Сандагийн Бямбацогт сайдыг дуудъя, Зам, тээврийн хөгжлийн сайдыг.

Дамдинням гишүүний асуултад хариулъя. ЗТХЯ-ны ТНБД Батболд. Энэ асуудал өчигдөр ажлын хэсэг дээр бас гишүүнээс гарч ирж ярьсан. Өнгөрсөн жил бид нар 90.2 мянган тонн цементийг 6 үйлдвэрлэгч ААН-ээс авч хэрэглэсэн, дундуур нь бас ийм асуудал гарсан юм байна. Энэ асуудлыг бид өчигдрөөс эхлээд ажиллаж байгаа. Энэ тал дээр хяналт шалгалт хийж эргэж мэдэгдье. Түүнээс яг одоо бид нар 36000 тонныг аваад дамлачихсан гэдэг ийм баримт мэдээ бас бид нарт байхгүй байна. Тэгээд эргээд танд энэ асуудлыг тодруулж мэдэгдье.

**Г.Занданшатар:** Хаянгаагийн Болорчулуун ХХААХҮ-ийн сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Дамдинням гишүүн Дарханы арьс ширний цогцолборын талаар асуулаа. Дарханы арьс ширний цогцолборыг хувийн хэвшилээр, хувийн хэвшлийн оролцоо бүхий компани Дархан-Уул аймгийн орон нутгийн 15 өмчлөлд бүхий ийм компани гүйцэтгэж байсан. Энэ компанийн үйл ажиллагаа бас тодорхой хэмжээнд ажил хийгээд зогссон. Энэ бол хоорондын бас өөрсдийн менежмент үйл ажиллагаатай бас холбоотой. Ялангуяа компанийн тэр хийсэн ажил, тэр Хөгжлийн банкнаас зээл аваад зүй бус зарцуулсан. Энэ бүхэн хууль хяналтын байгууллага дээр бас шалгагдаж байгаа, маргаан үүссэн. Тэр нь туслан гүйцэтгэгч компаниуд хоорондын маргаан бол үүссэн байгаа. Ер нь хажууд нь өмнө нь бол ТӨК арьс ширний цогцолбор барихаар шийдвэр гараад түүн дээр нь Италийн зураг төслөөр цэвэрлэх байгууламжийг нь барьж байгуулахаар зураг төсөл хийсэн байгаа. Үйлдвэрийн зураг ч гэсэн. Одоо тэр хувийн өмчит компани Хятадын зураг төслөөр зургийг нь хийсэн байгаа. Тэгэхээр ХХААХҮ-ийн сайд, БХБ-ын сайд мөн Эрчим хүчний сайдын 3 яамны сайдын гарын үсэг бүхий яг газар дээр нь ажлын хэсэг очиж ажиллаж энд хэчнээн төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн юм, ажил хийгдсэн юм. Үүнийг шалгагч дүгнэлт эцсийн дүгнэлт гаргах ажлын хэсэг гараад аж ажиллаж байна. Хараахан эцсийн байдлаар дүгнэлт нь гараагүй байна. Манай дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Үүний дараа тэр бид нар боломжтой, одоо хийсэн ажил хөрөнгө оруулалтаас нь тэр хувийн хэвшлийн хийсэн гэж байгаа аль болохоор авахыг хичээнэ, бас авч болохгүй бас зарим ажлууд ч үлдэж болзошгүй ийм байдалтай байгаа. Ямар ч байсан Дарханы арьс ширний цогцолборыг хийхдээ эхний ээлжид дэд бүтэц, цэвэрлэх байгууламжийг төр хийнэ гэсэн ийм чиглэлтэй ажиллаж

байгаа. Ингээд хийсэн хойно нь дээр нь бол үйлдвэрийг хувийн хэвшилүүд барьж байгуулах ийм чиглэлтэй ажил хийгдэж байгаа гэдгийг бас хэлье.

Хоёрдугаарт, төмс хүнсний ногооны зоорины талаар асууж байна. Энэ Орхон суманд Дамдинням гишүүний хэлдэг бас төмс ногооны Орхон аймаг бараг 25 хувийг хангадаг нь үнэн. Энэ зоорийг барьж өгөхдөө бол улсаас социализмын үе шиг ингээд бариад өгөөд улсын зоорь байгаад байх бол энэ ач холбогдолтой биш ээ. Тийм учраас хувиараа зоорь барих ажлыг дэмжинэ ээ. Хүнсний хангамж, аюулгүй байдлын 36 дугаар тогтоолын хүрээнд манай яаман дээр зээлийн хөрөнгө оруулалтуудыг хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалтыг салбар бүрээр нь үүнийг ангилсан байгаа. Энэ зооринд гэхэд зоорь барьж байгуулж ААН бол 90 тэрбум төгрөгийг тавьсан байгаа. Хөнгөлөлттэй зээл 13 хувийн хөнгөлнө, жилийн 18 хувийн хүүтэй зээл авахад 5 хувийн хүүтэй зээл авна гэсэн үг. Тэгэхээр ийм зээлээр ААН-үүд барих боломжтой. Нэгдсэн зураг төсөвт 500 тонны зоорь, 1000 тонны зоорины зураг төсвийг ХХААЯ-наас бас олгож байгаа гэдгийг бас хэлье.

**Г.Занданшатар:** Дамдинням гишүүн тодруулж асууна.

**Г.Дамдинням:** Болорчулуун сайд аа, юу, таны ажиллаж байгаа ЗГ-ын Ерөнхий сайд Дархан-Уул аймгийн Орхон суманд очсон юм, тэгээд Дарханы ард иргэд Орхончуудад амлачихсан юм. Ямар нэг эх үүсвэрээс зоорь барьж өгнө, 1000 тонны зоорь барьж өгнө, тэгээд дулаан хүлэмжийн асуудлыг бүрэн шийдэж өгнө өө гэсэн. Ийм л үүнийг амлалт өгчихсөн юм л даа. Тэгэхээр тэгээд та хувийн хэвшилээр хийлгэнэ ээ гэдэг чиглэл рүүгээ яриад байх юм. Уг нь Польшийн ЗГ-ын буцалтгүй тусламжаар хийгдэх энэ тэр гээд төслүүд яригдаж байсан юм. Энэ ер нь яачихсан юм бэ? Тэгээд зоорь ЗГ-аас бол шийдэгдэж өгөхгүй нь ээ гэж ойлгож болох уу?

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Улсын төсөв, төсөл хөтөлбөрөөр зоорь баривал тэгээд эргээд улсын л зоорь болно шүү дээ. Ер нь тэгээд социализмын үе биш. Энэ зах зээлийн нийгэм. Харин хувийн хэвшлийг зоорь барих ажлыг нь бол жилийн 5-хан хувийн хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ ээ. Зураг төсөв нэгдсэн зураг төсвийг нь бол ХААХҮЯ-наас хангаж байгаа. Түүнээс биш бүр үнэ төлбөргүй улсын зоорь барьж өгнө гэсэн асуудал байхгүй ээ.

Ер нь төслийн зоорь чинь бол үнэ өртөг өндөртэй болоод тэгээд тэрийг дараа нь хувийн хэвшлийнхэн эргээд төлөхөд бас асуудал учирна л даа. Үүнийг больсон.

**Г.Занданшатар:** Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. 22 онд Монгол Улсаа аль чиглэлээр хэрхэн яаж хөгжүүлэв ээ гэдэг тайлангаа бид нар сонсож байна. Тэгээд үүнд бол нэг 23 зорилт, 6 бүлэг 300 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн юм байна лээ. 6 бүлгийнх нь 3 дахь бүлэг нь хүн амын амьжиргааны түвшин, ахуй амьдрал, аж байдалтай холбоотой асуудлууд, яах вэ дэвшилүүд бас байна. Эдийн засгийн өсөлт гарч байна. Ялангуяа ЗГ-аас хэрэгжүүлсэн хүүхэд бүрийг цэцэрлэгт хөтөлбөр амжилттай хэрэгжиж, иргэдтэйгээ уулзахад бол бас нэлээн сэтгэл хангалуун байна лээ.

Тэгэхдээ сэтгэл хангалуун бус асуудлууд нэлээн их байна. Ялангуяа хүн амын амьжиргаатай холбоотой, ахуй амьдралтай холбоотой асуудлууд, ядуурал 27.8 хувьтай, ажилгүйдлийн түвшин 7 хувьтай, хүн амын орлого буурсан, үнийн өсөлт гээд олон асуудлыг бол хэлж болохоор байна. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бид нар хэчнээн ажлын байр бий болгов оо? Хэдэн хүнийг

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

мэргэжлийн чиг баримжаатай болгох сургалтад хамруулаад, хэдэн хүнийг ажлын байраар хангав аа? Энэ маш чухал, хэдэн хүнийг ядуурлаас гаргачхав, ямар үйл ажиллагаа явуулсан бэ? энэ асуултад бол ингээд тодорхой хариулт авмаар байна. Яагаад гэвэл өнгөрсөн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэлээн хэдэн төсөл хэрэгжсэн. Энэ төслийн үр дүнгүүдийг би нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт, энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудал гэж нэг аюул байна. 2012 оноос эхэлсэн. Тухайлбал Яармагт 268 га газрыг чөлөөлүүлээд, тэгээд дэд бүтцийг нь төр хийгээд өгнө гээд. Өнөөдөр энэ барилгажилтын ажил үндсэндээ явахгүй, маш хангалтгүй байгаа. Ингээд хүмүүс нь айлын хажуу өрөөнд сар шинийн баяраараа золголт ч хийж чадахгүй байгаа ийм бэрхшээлүүдийг бол бидэнд ярьсан. Тэгэхээр энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлыг ер нь яах юм бэ? Би бол Даваасүрэн сайд бас идэвхтэй, аж амьдрал ойлгодог хүний хувьд энэ компаниудтай нэг ард иргэдтэй нэг уулзаад үүнийг ер нь бэрхшээл нь юундаа байгаа юм, цааш нь яаж явуулах юм? Энэ хүмүүс чинь ерөөсөө бүр ямар ч итгэх итгэлгүй болчихсон, өөрийн ганц хөрөнгө газраа чөлөөлөөд өгчихсөн ийм байдалтай байна. Энэ дээр хариулт авъя.

Хоёрдугаарт, энэ ашиглалтын шаардлага хангахгүй байгаа орон сууцуудыг дахин төлөвлөх, барилгажуулах ажил бол бас явж байгаа. Зарим газруудад сонгон шалгаруулалт явагдаад тэгээд ажил нь бас явахгүй байгаа ийм асуудлууд байна, сайд аа. Энэ дээр би бас таныг хариулт өгөөч ээ гэж хүсэх гэсэн юм.

Гуравдугаарт, өнөөдөр Улаанбаатар хотод 17 хотхон, хорооллын 25000 иргэн 2 жилийн хугацаанд зэвтэй ус ууж байна, зэвтэй ус ахуйдаа хэрэглэж байна. Бидний энэ үйл

ажиллагааны төлөвлөгөөнд ахуйн хэрэглээний усны чанарт хяналт тавих, сайжруулах гэдэг ийм заалт орсон байгаа. Тэгэхээр мэргэжлийн байгууллага ялангуяа Ус суваг ашиглалтын газрын лабораторид шинжилгээ хийхэд эдгээр 25000 хүн төмөр, цайрын агууламж байх түвшинээс өндөр ийм ус хэрэглэж байгаа, 2 жилийн хугацаанд. Иргэдтэй уулзахад бол ер нь цистерн дуудаад ингээд бид нар ер нь тээврээр усаа зөөж уудаг юм билүү гэдэг энэ түвшиндээ хүрсэн байгаа тухай ярилаа.

4 дүгээр асуудал, мөн л иргэдийн амьжиргаатай холбоотой. Бид нар Улаанбаатар хот маань газар хөдөлтийн идэвхтэй бүсэд байж байна. Ихэнх барилгууд 1958, 1963, 67 оны барилгууд. Эдгээр барилгууд хүйтэн, иргэд нь өвөл даардаг, зун болохоор борооны дусаалга тааз руу нь ороод ирдэг. Үгүй ээ, ийм байдалтай амьдарч байхад яаж иргэн хүн тайван байх вэ дээ. Энэ дээвэр, фасадын асуудлыг төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор хийхээ больсон. СӨХ үүнийг хийж чадахгүй. Тэр ойлгомжтой. Энэ дээвэр фасадын асуудлыг яаж шийдвэрлэх юм бэ? Үүнийг ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** БХБ-ын сайд хариулах уу. Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулна. Дараа нь НХХЯ нэг номерт хариулчхаарай.

**Ц.Даваасүрэн:** Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг бол эхлүүлээд НИТХ-аас 28 байриилд 65 хэсэгчилсэн талбайд хэрэгжүүлэхээр баталсан юм байна лээ. Үүний дагуу үзэх юм бол 18843 нэгж талбайд газар чөлөөлөлт хийгдээд 148000 айлын орон сууц ашиглалтад оруулахаар ингэж төлөвлөсөн байгаа юм. Одоогийн байдлаар бол 18 байриилд 57 хэсэгчилсэн талбайд 45 төсөл хэрэгжүүлэгч ингээд барилга байгууламжийн ажил эхлээд ингээд явж байгаа. Нийт 16671 айлын 153 блок ашиглалтад орсон байна. Би ажил

аваад эдгээр компанийн төлөөллүүдтэй уулзсан. Нэг л хүндрэл ярьж байна. Ерөөсөө нөгөө инженерийн дэд бүтэц нь хүрэлцэхгүй болчихсон, ялангуяа дулааны асуудал. Өнөөдөр Улаанбаатарт 13400 барилга байгууламжийн байгаагаас нийт дулааны ачаалал нь бол 3403 гига калори цаг ийм хэрэглээ үүсчихсэн. Гэтэл энэ нь суурилагдсан хүчин чадлаасаа 60 хувиар их байгаа байхгүй юу. Суурилагдсан хүчин чадлаасаа одоо байгаа энэ дулааны станцуудаас 60 хувиар их хэрэглээ бий болчихжээ гэсэн үг. Тийм учраас цаашидаа орон сууц барихад маш хүнд болсон, маш хүнд болсон. Энэ дулааны асуудлыг шийдэхгүйгээр, шинэ ДЦС барихгүйгээр эсвэл хэсэгчилсэн дулааны асуудлыг шийдэхгүйгээр. Хэсэгчилсэн дулааны асуудлыг шийдэхийн тулд Сэлбэ, Дамбадаржаа, Шар хад, Баянхошуу, Орбит, Толгойт гээд ингээд дэд бүтцүүдийг бол байгуулахаар зарим нь ашиглалтад ороод энэ Баянхошуу, Сэлбэ бол ашиглалтад орчихсон байгаа. Ингээд явж байгаа. Зүгээр одоо бид нар 2040 оны нийслэлийг хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө дээр энэ дэд төвүүдээр дамжиж тэлэх бодлогыг бол барина.

Мөн энэ зундаа багтаагаад бид нар нэг төслийг ЗГ-аас эхлүүлэхээр ингээд үүнийг нэлээн зоригтой алхмыг хийе гэж ингэж ярьж байгаа нь бол Сэлбэ сэргэлт төсөл. Энэ бол зам. Тэгэхдээ замын дагуу бол бид нар хонгилын систем буюу тэр 20 гаруй километр урт энэ Дамбадаржаа, Чингэлтэй чиглэл рүү чиглэсэн инженерийн дэд бүтцийн шугам татах ийм төслийг бол бас төлөвлөөд явж байна. Зургийн ажил бол эхэлчихсэн байна. Ингэж чадах юм бол бид нар энэ шинээр ашиглалтад орох цэвэрлэх байгууламж, мөн 2 эх үүсвэрээр бол Улаанбаатарын усан хангамжийг, мөн Био комбинатын тэр зүгээс бас Мянганы сорилын сангийн хүрээнд бас цэвэр усны шинэ байгууламж ашиглалтад орох гэж байгаа. Энэ бүгдтэй холбогдох юм. Тэгээд цэвэрлэх байгууламж, цэвэр ус гээд. Мөн дулаан тийм. Тэгээд ер нь дутагдаад явж байгаа, цаашидаа шийдвэрлэхэд

хүндрэлтэй нь бол дулааны л асуудал. Тэгэхээр хэсэгчилсэн дулааныг л үүнийг янз бүрээр шийдэх энэ чиглэлийг л манай ЭХЯ л анхааралтай хандмаар байгаа юм. Зөвхөн дулааны станц гээд байхгүйгээр санаачилгатай ажилламаар байгаа юм. Би үүнийг ЭХЯ-ныханд хэлье. Би бас тодорхой уг нь 17 онд хөтөлбөр баталсан шүү дээ, эрчим хүчний дунд хугацааны хөгжүүлэх хөтөлбөр гээд. Хэрэгжсэн юм нь маш бага, маш бага. Тийм учраас энэ адаглаад ТЭЦ-4-ийнхөө тэр нэг зуухыг үүнийг нэмж барих хэрэгтэй. Тэгээд тэр ТЭЦ 4-өөс татаж байгаа шугамуудыг ашиглалтад оруулах хэрэгтэй.

**Г.Занданшатар:** Одоо НХХЯ-наас, сая 4 минут болчихсон, нэг асуултад. 1 номер Гомбосүрэнгийн Өнөрбаяр НХХЯ-ны ТНБД.

Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. 2022 онд бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд бол НХХ-ын яамнаас 111 тэрбум төгрөг зарцуулсан. Энд бол нэг 85000 иргэн хамрагдаж, 40 орчим мянга ажлын байр бол бас хадгалагдсан гэсэн ийм статистикууд бий. Гэхдээ улсын хэмжээнд бол 51000 ажлын байрны захиалга өгөгдсөн. Эндээс бол 30000-д нь бол ажилд зуучлах арга хэмжээнүүд авагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний нэг чухал арга хэмжээ бол ажлын байрны чиг баримжаа өгөх, зөвлөх үйлчилгээ бол хамгийн бас чухал арга хэмжээнүүдийн нэг.

Ажлын байр дутагдалтай салбарууд дээр бол НХХЯ бол Боловсролын яамтай бас хамтраад дүн шинжилгээ хийгээд, сүүлийн жилүүдэд ямар ажлын байрны эрэлт хэрэгцээ, бий болж байна, ирэх жилүүдэд ямар ажлын байрнуудын эрэлт хэрэгцээнүүд бий болох вэ гэдэг холбогдох тооцоо судалгаанууд хийгээд, үүнтэй уялдсан элсэлтийн болон төгсөлтийн бодлогуудыг уялдуулах арга хэмжээнүүдийг хийж байгаа.

Сүүлийн жилүүдийг аваад үзэхэд бол хамгийн их эрэлттэй том мэргэжил дээр бол ХАА, уул уурхай, боловсрол, барилга бүтээн байгуулалт, үйлчилгээний гэсэн ийм 5 салбар бол нийт эрэлттэй ажлын байрны 80 орчим хувийг бол бас эзэлж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Зэвтэй ус 25000 хүний асуудлыг яриагүй. Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Яах вэ, зэвтэй усны асуудал бол ер нь тэр шугам хоолойтой л байна гэсэн үг шүү дээ. Солиогүй л байна гэсэн үг. Тийм учраас наадах чинь хөрөнгө оруулалттай шууд холбоотой. Ер нь энэ дулааны ч тэр, цэвэр усны ч тэр шугамын шинэчлэлтүүд хийгдээгүй маш удчихсан байхгүй юу. Маш их удсан. Би Эрчим хүчний сайдаар ажиллаж байх хугацаандаа энэ дулааны шугамын магистрал шугам өнөөдөр одоо 30-аад жил шинэчлэгдээгүй байгаа талаар ярьж л байсан, одоо шинэчлэгдээгүй л явж л байгаа. Тэгэхээр энэ чиглэлд бид нар нэг дорвитой хөрөнгө гаргаж энэ шугамуудыг шинэчлэхгүйгээр энэ асуудлыг бол шийдэж чадахгүй. Тэгээд нийслэл бас энэ дээр нэмж хариулна биз.

Ер нь нэлээн томоохон хөрөнгө оруулалтуудыг хийж байж бид нар энэ инженерийн дэд бүтцүүдийг шийдэж байж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлыг урагшлуулна.

**Г.Занданишатар:** Нийслэлээс Сандагсүрэн дарга, Нийслэлийн тэргүүн дэд дарга 1 номер дээр.

**Ж.Сандагсүрэн:** Сарангэрэл сайдын асуултад хариулъя. Дахин төлөвлөлтийн хүрээнд нийслэлийн гол хүлээж байгаа үүрэг бол төвийн дахин төлөвлөлтөд баригдаж байгаа барилгууд руу дэд бүтцийг нь татаж, ашиглалтад оруулах ийм үүргийг хүлээдэг. Нийслэлийн хэмжээнд сүүлийн жилүүдэд төсвийнхөө хүрээнд жил болгон үе шаттайгаар

асуудлуудыг шийдэж явж байгаа. Өнгөрсөн жилийн хувьд бид харьцангуй урьд жилүүдийнхээс бага төсөвт тавьсан, 6 тэрбум төгрөгийн асуудлууд шийдсэн. Энэ жил дээр бид нар түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд дахин төлөвлөлтүүдийг хийж байна. Одоогоор бас тавигдаж байгаа хүсэлтүүд их байгаа боловч бид яг техникийн нөхцөл өгөгдсөн 2 хэсэг дээрээ төвлөрч байна. Энд бол Сэлбэ болон Баянхошуу хэсэг дээр л энэ дахин төлөвлөлтийн шугам сүлжээний асуудлуудыг ярилцаж байна. Бусад байрлалуудын хүрээнд өгч байгаа техникийн нөхцөлийнхөө хувьд бол нэлээн хязгаарлагдмал ийм байдалтай байгаа.

**Г.Занданишатар:** Сарангэрэл гишүүн тодруулъя. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Цаг бага байгаа учраас бол хэлж чадахгүй байна л даа. Энэ чинь 17 хотхон хорооллын 25000 хүн 2 жил зэвтэй ус ууж байгаа талаар бид хэлээд байна л даа. Богд вилла, Белмонте, Хүннү Вилла гээд ингээд тооцох юм бол их л олон хороолол байгаа юм. Тэгээд эдгээр хорооллууд чинь өөрөө зарим нь ашиглалтад ороод гуравхан жил болоод зэвтэй ус гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр би БХБЯ-ыг зөвшөөрөл өгөхдөө та бүхэн маань стандартын шаардлага хангасан 3 жилийн ая даах ядаж нэг тийм шугам хоолой хийх ийм шаардлага тавьж байхгүй бол хуучин барилгынхан, шинэ барилгынхан бүгдээрээ зэвтэй ус уугаад энэ эрүүл бус уснаас болоод ард иргэд чинь өвчлөлд өртөж байгаа тухай үүнийг би хэлээд байгаа юм. Тэгээд би дэд төвүүдээр түшиглээд энэ дахин төлөвлөлтүүд хийх юм байна. Шугам хоолойгоо угааж цэвэрлээд энэ ард иргэдээ нэг зэвгүй ус уулгах юм байна гэж ойлголоо шүү. Дараагийн удаа та бүхэн албан ёсоор надад бичгээр хариу өгөөч ээ гэж хүсэж байна.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хоёрдугаарт, энэ ЭМЯ энэ зүрх судасныхаа төвийг хэзээ барь ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Дахиад 1 минут байхгүй. ЭМЯ Содномын Чинзориг сайд.

ЭМЯ-наас хүн байгаа юм уу. 2 номер өөрийгөө танилцуулаарай. Индрийн 2 номер.

ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Хонгорзул. Сарангэрэл гишүүний асуултад хариулья. Зүрх судасны төвийн ТЭЗҮ зураг төсвийг бол боловсруулаад бэлэн болчихсон, 20 онд магадлалаар батлагдсан байгаа. 21, 22, 23 онд санал хүргүүлсэн боловч батлагдаагүй, өдийг хүрч байна. Сая 22 оны 12 сард Японы нэг сантай юу яасан байгаа, санамж бичиг байгуулсан. Түүний ишид гарчихвал баригдаад эхэлчих боломжтой, буцалтгүй тусламжаар.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Энхбаяр:** Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар сайдаас 2 асуулт асууя.

Нэгдүгээрт нь, Байнгын хорооны хуралдааны үед энэ ЗГ-ын төлөвлөгөөний хэрэгжилт муу гарсан 5 яаманд юм уу, сайдад юм уу, хариуцлага тооцох асуудал ярьсан гэсэн ийм мэдээлэл байна. Тэгэхээр энэ төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр хамгийн сайн үнэлгээ авсан 5 яам, хамгийн муу үнэлгээ авсан 5 яамыг хэлж өгөөч ээ гэсэн эхний асуулт байна.

2 дахь асуулт нь, энэ 5 муу үнэлгээ авсан 5 сайдад хэрвээ хариуцлагын асуудал ярьсан бол энэ Ерөнхий сайдын бодлого уу эсвэл Шадар сайдын бодлого уу гэсэн ийм 2 дахь асуулт байна.

**Г.Занданшатар:** Шадар сайд Эдийн засаг хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Монгол Улсын хөгжлийг ер нь төлөвлөж, дараа нь төлөвлөснийхөө дараа тэрийгээ төсөвт суулгаж хэрэгжүүлдэг ийм бодлогын зарчмын өөрчлөлтийг энэ Оюун-Эрдэнийн ЗГ бол хийгээд явж байгаа. Тэгээд өнөөдөр бид нар энд Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаж орж ирснээс анхны тайланг хэлэлцэж байгаа. Ингэхээр ийм зүйл л энэ дээр ажиглагдаад байгаа юм. Төлөвлөгөө дээр их олон зүйл оруулчихвал сайн гэдэг. Гэтэл дараа нь төлөвлөгөөнд суусан зүйлийг нь санхүүжүүлэх эх үүсвэрүүд нь төсөв дээр болон гадаадын зээл тусламж болон бусад эх үүсвэр дээр суудаггүй. Тэгэхээр нэг их олон ажил суулгачхаад, хэрэгжүүлэх эх үүсвэр нь санхүүгийн эх үүсвэр байдаггүй. Тэгээд эргээд аваад тооцоод үзэнгүүт нь өссөн дүнгээрээ ЗГ-ын мөрийн хөтөлбөр нэг 39 хувьтай, жилийн төлөвлөгөө нь нэг 60 хэдэн хувьтай, 69 хувьтай ийм байгаад байгаа юм. Тэгээд тэр жагсаалт бол нэг тийм мөрөөдлийн шахуу ингээд биччихсэн. Тэгэхээр төлөвлөхдөө ч хариуцлагатай байя. Дараа нь төлөвлөгөө батлагдаад төсөв батлагдсан хойно үүнийг хэрэгжүүлэхдээ бид нар хариуцлагатай байх ёстой. Тухайлбал энэ Таван толгойн цахилгаан станцын тендерийг 2 удаа зарлаад үр дүнгүй, үнэхээр хийе гэж хүссэн бол тэрийг хийнэ шүү дээ. Хүсэхгүй л байгаа байхгүй юу. Одоо сайд байсан хүн энд сууж байна.

Тэгэхээр ЗГ дээр юу гэж яригдсан бэ гэхээр ер нь жилийн төлөвлөгөөгөө улс орноо хөгжүүлэхэд зориулагдаж төлөвлөөд, дээр нь санхүүгийн эх үүсвэрийг нь тавиад, арга замыг нь заагаад өгчихсөн энэ арга хэмжээнүүдийг яаж биелүүлж байгаагаар нь сайд нарыг, сайд нарыг ч яах вэ, яамнуудыг байр эзлүүлээд явна гэдэг ийм л зарчим яригдаж байгаа юм. Үүгээрээ цаашид ер нь явах ёстой. Тэгэхээр энэ бол ЗГ-ын хуралдаан дээр албан ёсоор яригдсан зүйл гэж ойлгож болно. Тэгээд жил болгон яамнуудыг байр эзлүүлдэг. Тэгэхээр энэ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

яамнуудыг байр эзлүүлэхэд хамгийн үндсэн баримтлах зүйл бол олон бичиг цаас үйлдвэрлэснээрээ биш яг энэ жилийн төлөвлөгөөгөө хийх ёстой ажлаа бодитойгоор хийсэн байна уу, эдгээр энэ бодитой ажил хийснийх нь дараагаар энэ Монголын ард иргэдийн амьдралын түвшин дээшилсэн байна уу, өрхийн орлого нэмэгдсэн байна уу, эдийн засаг өссөн байна уу, хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна уу гэдгээр нь л эрэмбэлж явах ёстой. Ийм байр суурьтай бол байгаа гэдгийг хэлье, ЗГ дээр.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулна.

**Б.Энхбаяр:** 2 тодорхой асуулт асуусан, хариулт авсангүй ээ. Хариулт өгөхгүй бол Хэрэг эрхлэх газраас асууя. Энэ үнэлгээгээр хамгийн өндөр биелэлттэй үнэлгээ авсан 5 яам. Хамгийн бага үнэлгээ авсан 5 яамыг хэлж өгөөч ээ гэсэн ийм асуулт байна.

Тэгээд ЗГ гэдэг маань ЗГ-ын бодлого оо гээд сая Шадар сайд хэлж байна. Би бол энэ хариуцлага тооцох асуудал нь Ерөнхий сайдын бодлого юм уу, Шадар сайдын бодлого юм уу гэсэн ийм тодорхой асуулт асуусан шүү дээ.

**Г.Занданшатар:** 94 хариульа.

Энхбаяр гишүүний асуултад хариульа, ЗГХЭГ Баасандорж. ЗГ-аас хууль тогтоомж болон бодлого шийдвэрийн биелэлтээ жил бүр ЗГ-ын 2020 оны 206 дугаар журам болон хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлээд дүгнэдэг. Яг саяын Энхбаяр гишүүний асуусан яг энэ Байнгын хороон дээр яригдсан асуудал бол ирэх 7 хоногийн ЗГ-ын хуралд танилцуулагдсаны дараа ЗГ-ын зүгээс холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу Их Хуралд танилцуулагдах боломжтой. Өөрөөр хэлбэл Засгийн газраа яг хэлэлцээгүй байгаа асуудал учраас танд би яг тийм ийм яам, тийм сайд гэж хэлэх боломжгүй байна, Энхбаяр гишүүн ээ.

Хариуцлагын тухай асуудал яг энэ 206 дугаар журамд бол хариуцлагын асуудал байдаг, 12 дугаар бүлэг дээр нь, Хэрвээ удаа дараа бодлого шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, үнэлэлт, дүгнэлт гарсан ийм төрийн захиргааны байгууллагуудад нь төрийн захиргааны төв байгууллагын ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Өөр асуулт байна уу. Ганибалын Амартүвшин гишүүн асууя.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Нэлээн хэдэн асуулт байна, тэгэхдээ минут нь хүрэхгүй юм чинь нэг 3 сэдэв дээр л тогтоож ярья даа.

Нэгдүгээрт, боловсрол, шинээр сургууль, цэцэрлэг барьж байна, ашиглалтад оруулж байна. Ингээд л тууз хайчилдаг. Гэтэл яг нөгөө сургууль нь ашиглалтад ороод хүүхдүүдээ аваад хичээл номоо явуульа гэхээр багш нарт нь компьютер хэрэгсэл байдаггүй. Үүнийг жишээ дурдах юм бол Хан-Уул дүүргийн 163 дугаар сургууль, 215, 34, 115 дугаар сургуулиуд. Ноднин улсын төсөвт уул нь 750 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн төсөв суулгасан боловч бас Боловсролын яам нь тэгээд ямар ч ажил хийгээгүй, энэ төсөв нь тэгээд хэрэглэгдэхгүй гээд татагдсан байдаг. Тэгэхээр энэ шинэ сургуулийн тэр ашиглалтад орж байгаа нь сайн. Гэтэл тэр сургуульд ажиллаж байгаа багш нарыг нь бас компьютер хэрэгслээр нь хангах хэрэгтэй шүү дээ. Хоосон нэг л гоё барилга, зарим ангиуд нь парт ширээ сандалгүй л байдаг юм байх чинь билээ. Тэгэхээр үүнийг бас анхаармаар байна. Хэлбэржсэн ийм хөрөнгө оруулалт хийхгүй байх.

Хоёрдугаарт, эдийн засгийн бодлого дээр зээлийн хүүг бууруулна гэж байгаа юм. Зээлийн хүү буурсан гээд бичсэн байна л даа. Тэгээд яг амьдрал дээр бол зээлийн хүү буураагүй л байна лээ шүү дээ. ААН-үүдийн авч байгаа зээл 1.3-1.6% буюу 15-19 хувьтай л байна лээ. Тэгэхээр



2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

яаж энэ зээлийн хүү буурсан гэж дүгнээд байгаа юм. Үүнийг бас сайн ойлгохгүй байна. Ер нь эцсийн эцэст эдийн засгаа хөгжүүлж, ажлын байр бий болгоё гэвэл энэ хувийн хэвшилээ л бид нар дэмжих ёстой шүү дээ. Манай дундаж компанийн ашгийн маржин бол 40 хувьтай, тэндээс татвар төллөө, нийгмийн даатгалын татвараа төллөө, Нөатаа төллөө, цаана нь цэвэр ашиг 10, 15% л үлдэж байгаа. Тэр нь тэгээд зээлийн хүүдээ идэгдээд дуусаж байгаа юм. Ийм байдлаар яаж компаниуд хөрөнгө оруулалт хийж, бизнесээ өргөжүүлж, ажлын байр нэмэгдүүлэх юм. Энэ татварын бодлого дээрээ бас анхаармаар байна. Ер нь компаниуд энэ ковидын дараа нийгмийн даатгалын өрнөөсөө үүнийг л нэг муу юм гарч байх шиг байна шүү дээ. Энэ бол бас манай эдийн засгийн хөгжлийг хойшоо татаж байгаа нэг том хүчин зүйл.

3 дугаар зүйлийн сэдэв болохоор энэ Улаанбаатар хотын шинэ орон сууц барилгажилт, шинээр баахан хорооллууд ашиглалтад ордог. Тэгээд тэрийг нь хүлээж аваад ашиглалтад оруулаад зөвшөөрдөг. Гэтэл тэр барилгууд нь сургууль, цэцэрлэгийн асуудлаа шийддэггүй, замын ачааллаа тооцдоггүй. Одоо би бол Хан-Уул дүүргийн 18 дугаар хороог жишээ болгож ярья л даа. Тэнд бол ингээд манай барилга барьдаг зарим сайд нар зөндөө л байшин барьсан байдаг. Хорооллууд. 2 эгнээ замыг нэг эгнээнд нь битүү машин тавиад нэгхэн эгнээ болгоод түгжрэл өдөр шөнөгүй. Шинэ улсын төсөвт улсын сургууль, цэцэрлэг барья гэхээр газар нь байхгүй. Тэгээд хөндлөн босоо зам ингээд хорооллын дунд тавь гэхээр тавиулдаггүй. Тэгэхээр ийм шинээр ашиглалтад орж байгаа энэ хорооллуудаа нэлээн өндөр стандарттай, зөвхөн барилгын чанар гэхээс илүү амьдрах орчныг нь бас харгалзаж энэ ашиглалтад оруулдаг, зөвшөөрлийг нь өгмөөр болдог баймаар. Тэгэхгүй бол ингээд байшин бариад л, зараад л, тэгээд л хаяад л явдаг. Тэр хавийн орчин өмнө үүнийг орон сууц худалдаж аваад тэнд амьдарч байгаа хүмүүсийн хөрөнгийнх нь үнэлгээ нь

буурдаг, амьдралынх нь чанар нь дордоод байдаг. Тэгэхээр үүнийг бас үүнийг ингээд цаашид анхаармаар байна.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Даваасүрэн сайд, Цэрэнпилийн Даваасүрэн сайд.

**Ц.Даваасүрэн:** Энэ ер нь бол яах вэ, энэ барилга дээр нэг үүсээд байгаа юм нь газар олдоод бол ямар ч төлөвлөлтгүй бариад байгаа л асуудал шүү дээ. Би бол ажиллаад 1 сар болж байна. Ер нь тэгээд хөрөнгө мөнгийг зөв ашигладаггүй л байгаа юм даа. Энэ жишээлбэл ингээд 3 их наядын хөтөлбөр гээд л барилгын салбарт Монголбанк гаргасан байгаа юм. Өчнөөн мөнгө зарсан, өөрсдөө цохичихсон, Хөгжлийн банк бас баахан мөнгө гарсан дарга нар нь өөрсдөө цохичихсон. Ингээд байхаар чинь нөгөө инженерийн дэд бүтэц, энэ нэг төлөвлөлтөөр шийдэх юмнууд нь байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд Улаанбаатар нь 2 жил ингээд төлөвлөлтгүй явж байгаа юм. Тийм учраас нэн яаралтай энэ 2040 гэсэн энэ төлөвлөлтийн асуудлыг оруулж ирж, ингээж шийдэж, ер нь төлөвлөлтийн дагуу газар олголтыг л хийж байхгүй бол газар худалдаж аваад л олоод л тэгээд л түүн дээр нь байшин босоод л байх юм бол энэ байдал үргэлжлээд л байна. Тийм учраас төлөвлөлттэй яваад, төлөвлөлтийн дагуу дэд бүтцээ хийгээд, түүнийхээ дагуу энэ гадна дотноос олдож байгаа мөнгөө, төсвийн мөнгөө зөв зараад, ингээд явах юм бол энэ нийслэл хотын асуудлыг бол шийдэж болно шүү дээ. Тэгээд энэ жил бол бид нар ер нь гол анхаарах ёстой юм бол засгийн ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя. Адъяаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адъяаа:** Өнөөдөр ЗГ-ын мөрийн хөтөлбөрийг УИХ хэлэлцэж байна. Цар тахал, геополитик гээд л олон нөхцөл байдлаас Монгол Улсын ЗГ,

Монголын төр бид хамтдаа маш хүнд он жилүүдийг үдэж байгаа. Энэ дээр бас олон асуудал дээр бас авах гээхийн ухаанаар хандаж байгаа гэж ойлгож байгаа. Энэ МАН-ын энэ Их Хурлын гишүүдэд нэг юм анхааруулъя. Өнөөдрийн ЗГ-ын мөрийн хөтөлбөр ярьж байхад социалист маягаар яамаа байр эзлүүлнэ, 5 сайд гээд энэ дотоод зөрчлөө тэр цагаан байшинд очиж ярь аа. Өнөөдрийн ЗГ-ын мөрийн хөтөлбөр яригдаж байгаа. Хэн нэгэн 5 сайдын асуудал, байр эзлүүлэх тухай асуудал энд яриааргүй байна. Ард түмэн чинь харж байгаа шүү, хийх ажил их биш байгаа шүү гэдгийг энд зориуд ард түмний төлөөллийн хувьд та бүгдэд би зөвлөе өө гэж хэлье.

Дээр нь энэ өнөөдөр олон хүнд асуудлууд байна. Бид өнөөдөр энэ экспорт нэмэгдсэн, эдийн засаг эерэг үзүүлэлттэй гарсан гэдэг ийм мэдээллийг сонсож байна. Тэгэхдээ энэ төгрөгийн хани чинь унасан, урьд хожид байгаагүй, төгрөгийн хани уналтаар л бид өнөөдөр эдийн засаг ямар байгаа вэ гэдэг дээр бас дүгнэлт хийх ёстой гэж бодож байгаа. Ингээд 2 гуравхан зүйл дээр асуулт асууж бас анхаарал хандуулахыг та бүгдээс хүсэж байна, ЗГ-аас.

Ард иргэдийн амьдралын доод түвшин, амьжиргааны доод түвшин урьд хожид байгаагүй ийм хүнд байдалд орсон, үүнийг яах вэ? Одоо бид нар тэр шинэ сэргэлтийн бодлого, боомтын хөгжлөөс илүү энэ ард түмнийхээ энэ ядуурсан үүнийг өлөн зөлмөн амьдарч байгаа, төрийн албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчид, соёл урлагийн байгууллагуудын энэ хүмүүс өнөөдөр тэтгэврийн доод хэмжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авч өлөн зөлмөн амьдарч байна. Энэ дээр бид Монголын төр, ЗГ яах юм бэ, хамтдаа яаж шийдэл гаргах юм бэ гэдэг асуудлыг нэг тодорхой хариулт авмаар байна.

Дээр нь хил хаагдсан гээд өнөөдөр бараа бүтээгдэхүүн. өргөн хэрэглээний барааны үнэ ур хожид байгаагүйгээр

нэмэгдсэн. тээвэр ложистик. Гэтэл хил чинь өнөөдөр хэвийн горимдоо орлоо. Бүх бизнес худалдаа хэвийн горимдоо орлоо. Гэтэл энэ үнийн өсөлт яагаад буухгүй байна. Бараа. өргөн хэрэглээний бараа. энд ч ард түмэн чинь нэрвэгдэж элгээрээ хэвтлээ. Энд ямар бодлого байна аа? Тээвэр ложистикийн асуудлууд бас ингээд үнийн хөөрөгдөл чинь бас тодорхой хэмжээнд буухгүй байна. Энд цаашид ЗГ ямар бодлого байна вэ гэдэг талаар нэг хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүний асуултад Шадар сайд Хүрэлбаатар сайд хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Тэр яамнуудад хариуцлага тооцох, байр эзлүүлэх нь бол ЗГ-ын дотоод ажил. Гэхдээ Их Хурлын гишүүн хүн сонирхолтой байгаад асуугаад байгаа учраас хариулсан юм, нэг.

2 дугаарт, энэ инфляц ер нь яах бол, инфляц цаашид ингээд нөхцөл нь бүрдэж байхад үнэ бас сайн бууж өгөхгүй байна гэдэг чиглэлээр хариулъя. 2022 оны 6 дугаар сарын байдлаар бол инфляцын түвшин бол 16.1 байсан юм. Энэ бол ер нь сүүлийн бараг 5, 6 жилд Монголд хүрээгүй хамгийн өндөр инфляц. Тэгээд 22 оны сүүлээр энэ нь 13.2 болж буусан. 3 сарын 21-ний байдлаар инфляц 12 хувьтай байна. Тэгэхээр энэ инфляцын түвшин бол ерөнхийдөө энэ нэг уруудах хандлагатай байна гэж Эдийн засаг, хөгжлийн яам тооцож байгаа. Тэгээд энэ 23 оны эхний хагастаа багтаад нэг оронтой тоо руу орчих болов уу гэсэн ийм тооцоолол хийж байгаа. Үүнд хэд, хэдэн зүйл нөлөөлж байгаа. Монгол Улс бол олон улсдаа худалдаа хийдэг, импортын бараа нэлээд их өндөр хэрэглэдэг. Ингэхээр манай худалдааны гол түнш болох Хятадад, Орос, Солонгос, Туркт бол сүүлийн саруудад инфляц дандаа буух хандлагатай байгаа юм. Тэгэхээр манай түншүүдэд инфляц бууж байгаа юм чинь манайд үүнийг бууна гэж бид нар үзэж байгаа. Үүнээс гадна инфляцад голлож нөлөөлж байсан зүйл бол валютын хани

хомс байсан, 2.4 болоод дараа нь оны төгсгөлд бүр 1.7 орно гэж байсан, тэгээд тэрбум доллар болно гэж байсан маань 3.4-тэй явж байна одоогоор. Тэгэхээр энэ нь бол валютын хани тогтворжиж байгааг илэрхийлж байгаа юм. Ийм учраас бид нар гаднаас нэг их инфляц бол импортлогдож орж ирэх нь гайгүй зүгээр гэж ойлгож байгаа.

Үүнээс гадна дэлхийн улс орнууд энэ инфляцтайгаа тэмцэхийн тулд бодлогын хүүнүүдээ өсгөж байна, өндөр түвшинд байлгаж байна. Энэ бол хамгийн зөв арга, мөнгөний үүнийг бодлогын хувьд. Тэгэхээр бусад улс орнуудын хувьд бол инфляцтайгаа сайн тэмцэж байгаа учраас энэ дэлхий нийтээрээ энэ инфляцын түвшин бууна гэдэг ийм хүлээлт бас дээр нь нөлөөлж байгаа. Монголчуудын хувьд бол мөнгөний бодлогын хүү хэвээрээ байна.

Дээр нь төсвийн бодлогоо бол мөнгөний бодлоготой бол уялдуулсан явж байгаа. Хамгийн гол нь нөгөө төсвийн үндсэн тэнцэл нэмэх байгаад байгаа, эерэг. Тэгэхээр төсвийн үндсэн тэнцэл эерэг гэдэг чинь олж байгаа нь зарж байгаагаас их гэсэн үг. Тэгэхээр инфляцыг бол хөөргөдөггүй ийм бодлогууд байгаа учраас бид нар энэ оны эхний хагастаа багтаад 1 оронтой тоо руу орчих болов уу гэж бодож байгаа.

Адьяаа гишүүний хэлдгээр тээврийн зардал нэлээд буучихлаа. Тэгэхээр энэ чинь яагаад амьдралд ингэж нөлөөлж орж ирж үр дүн гарахгүй байна гээд ингэхээр одоо бол нөгөө нэг тээврийн зардал өндөр байх үед татаад оруулаад ирчихсэн бараанууд нь байж байдаг, хани нөгөө өндөр байхад авчихсан бараанууд нь байж байдаг учраас энэ бүгдийн одоо эффект юу гэдэг юм. Тээврийн зардал буулаа гэнгүүт бусад бүх бараа бүтээгдэхүүний үнэ богинохон хугацаан дотор бас бууж өгөхгүй байх ийм магадлалтай байгаа. Тэгээд энэ зүйл ажиглагдаад явж байгаа болов уу гэсэн ийм байр суурьтай, бодолтой байгаа.

**Л.Мөнхбаатар:** Адьяаа гишүүн тодруулах уу? тодруулж асууя.

**Ш.Адьяаа:** Тэр түрүүн би асуугаад байна л даа, тэр нэг төрийн албан хаагчид, соёл урлагийн байгууллагын хүмүүс чинь өнөөдөр нэг тэтгэврийн доод хэмжээ 500, 600000 төгрөг аваад л байж байна шүү дээ. Энэ асуудлыг хэдүүлээ яах ёстой вэ. Энэ чинь амьдрал нь хүрэхгүй байна шүү дээ, өлөн зөлмөн амьдарч байна шүү дээ. Энд яах вэ гэж бодож байна. Нэг хариулт авъя.

Хоёрдугаарт нь, өнөөдөр энэ Солонгос бусад орнуудад байдаг юм байна лээ л дээ. Энэ үнийн хөөргөдөл гэдэг юмыг, одоо ингээд үнэ гүйх нөхцөл байхад л ашиг хараад үнэ нэмээд байдаг тийм ААН-үүд, тэр худалдаа эрхлэгчдээ бас хууль эрх зүйн хүрээнд асуудал шийддэг тийм сайн туршилага байгаа юм байна лээ шүү дээ. Үүнийг хэрэгжүүлэх тийм боломж байна уу, ийм судалсан судалгаа байна уу, энэ талаар нь хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Адьяаа гишүүний тодруулгад Шадар сайд Хүрэлбаатар хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** 22 онд бол төсөв 22 оны төсөв батлагдсан, тэгэхээр нийтдээ тэр бүх салбарын төрийн албан хаагчдын цалин нэмэгдэнэ ээ гэж хэлж чадахгүй, батлагдсан төсөвтөө багтаагаад тэр нэмэгдэх салбарынх нь хүмүүст нь нэмэгдээд явсан. Үйлчилгээний салбарын төрийн үйлчилгээний албаны албан хаагчид бол цалин бага байгаа, сайн нэмэгдэхгүй байгааг бол мэдэж байгаа, ойлгож байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр бид нар ямар арга хэмжээ авч болох вэ гэдэг талаар бол судалж байгаа. Тэгээд 20-нд одоо бидэнд нэгэнт л төсөв 23 онд төсөв суулгаж чадахгүй юм чинь 24 оныхоо төсөв дээр оруулж ирж бас үзнэ ээ гэсэн ийм одоогоор бол байр суурьтай байгаа гэдгийг хэлье.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ер нь нэг л ийм юм байгаа, үнэ өсөж байна, тээврийн зардал буучихсан учраас үүнийг шалгалт хийгээд үнэ буулгана гэдэг ийм хандлагаар ер нь бага л явмаар байгаа юм. Шалгалт, дарамт эд нар бол болсон байх. Одоо зүгээр ажлыг нь хийлгэмээр ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** ЗГ-ын 5 жилийн хөгжлийн хөтөлбөр, 4 жилийн мөрийн хөтөлбөр, 1 жилийн 22 оны гүйцэтгэл гээд яг ЗГ-ын энэ түвшний асуудлуудын тайлан хэлэлцэгдэж байна л даа. Яг энэ тайлан дээр Монгол Улсын Ерөнхий сайд энэ дээр өөрөө оролцож асуултад хариулмаар байх юм. Ерөнхий сайд ийм энэ 5 жилийн, 4 жилийн, 1 жилийн хөтөлбөрөөс ч Ерөнхий сайдаас өөрөөс нь асуух олон зүйл байдаг. Энэ чинь тайлан болохоор нэг удаа хэлэлцэгдээд өнгөрөх үү, энэ чинь яах билээ, хэдэн хэлэлцүүлэгтэй байдаг юм. Тэгээд 20 оны 2 дугаар хагасаас энэ ЗГ-ын үйл ажиллагаа эхэлсэн гээд бодохоор бараг 3 дахь жил рүүгээ энэ тайлангийн асуудал чинь орчхож байна. Өөрсдийнх нь хэлж байгаагаар гүйцэтгэл нь 30 хувьтай гэж байна. 4 жилийн үйл ажиллагаа чинь үүнийг бараг 3 дахь жил рүүгээ орчихсон байхад энэ 30 хувьтай байдаг. Энэ тохиолдолд ЗГ өөрөө яг ямар дүгнэлт хийж байгаа юм. Аль аль үзүүлэлтүүд нь хойш татаад байгаа юм. Аль аль яамд нь хойш татаад байгаа юм. Хэрвээ хариуцлага байдаг бол хаанаа юугаа ярих гэж байгаа билээ. Энэ тайлан хэлэлцээд өнгөрөх билүү, энэ дээр чинь үүнийг ямар үнэлэлт дүгнэлт гардаг билээ? Нэгдүгээрт нь энэ тухай бас асуултууд байгаа юм.

Хоёрдугаарт нь, ер нь жижиглээд яривал үүн дээр маш олон зүйл ярьж болох байх. Яг Монгол Улсын хөгжил дэвшил, хүн ардын ажил, амьдралтай холбоотой олон үзүүлэлтүүд байдаг байх. Дундаж давхарга гэдэг ойлголтыг манай энэ төрийн үйл ажиллагаанд болоод ЗГ-ын үйл ажиллагаанд энэ хөгжлийн хөтөлбөрт яг ямар байдал дээр

тусгагдсан байдаг юм. 20 онд ямар байсан юм, өнөөдөр ямар болж байгаа юм, ямар зорилт тавьсан юм, энэ тухай нэг, энэ шалгуур хэмжил, хэмжих үзүүлэлтүүд нь байдаг эсэх тухай байгаа бол яг ямар үзүүлэлтүүд гарч байгаа тухай бас нэг тайлбар өгөөч. Мэдээж дундаж давхаргын тухай ярихад нөгөө талд нь ядуурлын түвшний тухай бас заавал ярьж таарах байх. 20 онд ямар байсан юм, өнөөдөр ямар байгаа юм, 24 онд ямар болгоно гэсэн зорилтууд байдаг юм.

Өөр бас энэ чинь бид нарын эдийн засаг ярихад бусад зүйлүүд бол эдийн засаг дотоод олон зүйлүүдийг ярьж болох байх, экспортын тухай яриа байна. Бас яг энэ хөгжлийн хөтөлбөрт экспортыг тэр тусмаа уул уурхайн бус экспортыг ямар зорилго тавиад өнөөдөр ямар түвшинд байгаа юм. Мөн гадаадын хөрөнгө оруулалт дотроо уул уурхайн бус салбарын гадаадын хөрөнгө оруулалт гэдэг зөвлөлд би бас энэ цаас эргүүлээд үзсэнгүй л дээ. Шалгуур үзүүлэлт энэ тэр дээрээс нь олж чадсангүй. Өнөөдөр яг ямар түвшинд байгаа билээ. Эдгээр өөрөө бас үзүүлэлтүүд өөрөө бас их асар чухал үзүүлэлтүүд байх гэж бас бодож байгаа юм.

Эдийн засаг болоод улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг бас олон индикаторууд байдаг байх. Гаднын нэг судалгаа бас харж байсан. Монгол Улсаас брэнд рэйн буюу гадагшаа тэр уураг тархины гоожилт гадагшаа оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн чинь гадагшаа гарч байгаа хувь хэмжээ 5 жилийн өмнө 3 гэсэн индекстэй байсан бол одоо 4.3 болчихсон байна гэдэг нэг тоо харагдаж байсан. Гадагшаа оюуны хөдөлмөр эрхэлдгүүд нь гадагшаа цуваад, биеийн хүчний хөдөлмөр эрхэлдгүүд нь Солонгос руу цуваад яг энэ үзүүлэлтүүд энэ чинь өөрөө тэр бид нарын ярьж байгаа энэ олон зуун хуудас тайлангийн эхний тэр цаана нь үр дүнгүүд үүний цаана яв яваад байгаа байх л даа. Тэгэхээр эдгээр дээр ингээд нэг ийм ерөнхий гэх үү,

энэ бодлогын гэх үү, ЗГ-ын үйл ажиллагааны түвшний гэх үү, энэ үр дүнгийн энэ эдгээр асуултууд дээр бас нэг тодорхой хариултууд өгөөч ээ.

Төгсгөлд нь юунаас. Аудитын байгууллагын төлөөллөөс нэг асуулт байгаад байна л даа. ЗГ-ын үйл ажиллагаа 3 дахь жил рүүгээ 2.5 жилийн үйл ажиллагааг хэмжихэд 30 хувьтай байна гэж байна. Үүн дээр аудитын байгууллага яг ямар дүгнэлттэй байгаа юм? Энэ төлөвлөлтөд нь асуудал байгаад байгаа юм уу, хэт өндөр төлөвлөхөөд байгаа юм уу? Энэ чинь ковидын үед л төлөвлөсөн юм шүү дээ. Гүйцэтгэлд нь асуудал байгаад байгаа юм уу, аль эсвэл аль алинд нь биш энэ үнэлж байгаа арга барил, үнэлгээнд нь байгаад юунд байгаад энэ 30% гэдэг нь хэр зэрэг тоо юм, сайн тоо юм уу, муу тоо юм уу? Сурагчийн дүнгээр 60-аас доошийг л муу гэдэг, 30 хувьтай явж байгаа. Мэдээж цаана нь 1 жил байна л даа. Тэгэхдээ энэ чинь ер нь ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл гишүүний асуултад Шадар сайд Хүрэлбаатар хариулна. Дараа нь аудитын төлөөлөл нэмж хариулна шүү. Энхболд дарга яах юм.

**Ч.Хүрэлбаатар:** Энэ Цогтгэрэл гишүүн ээ, ийм юм байгаа юм аа.

**Л.Мөнхбаатар:** Хүрэлбаатар Шадар сайд аа, түр байж байгаарай. Цогтгэрэл гишүүний эхний асуултад нь Нямаагийн Энхболд гишүүн хариулчихъя. Дараа нь Хүрэлбаатар Шадар сайд хариулъя.

**Н.Энхболд:** Эхний асуулт нь ийм зүйлийг ТББХ-оор шийдэхтэй холбогдсон зохицуулалтын тухай юм байна гэж ойлголоо. Тэгэхээр ингээд яах вэ гэж байна. Бид нар энэ хуулиараа 5 жилийн төлөвлөгөө, ЗГ-ын 4 жилийн мөрийн хөтөлбөр тэгээд тухайн оны асуудлуудыг нь хэлэлцүүлээд гурвууланг нь нэгтгээд нэг дор сонсох ёстой юм байна,

хуулиараа. Тэгээд сонсоод, сонсоно л гэсэн байгаа юм. Хууль дээрээ бас сонсоод хэрэв шаардлагатай гэж үзвэл ЗГ-т чиглэл өгнө гэсэн байгаа юм. Тэгэхээр өчигдөр Байнгын хороо энэ асуудлыг авч хэлэлцэхдээ 5 жилийн төлөвлөгөө, түүн дотроос энэ ЗГ-ын 20-24 оны үндсэн чиглэл л, тэгээд 22 оны жилийн төлөвлөгөө энэ 3-ыг хамтатгаад хэлэлцээд гаргасан үүнийг санал, дүгнэлт үйлдэнэ. Түрүүн Цэрэнпунцаг гишүүний унисан тэр санал, дүгнэлт байгаа юм. Тэгээд дахиад хэлэхэд бид нар өнөөдөр үүнийг сонсчихоод тэгээд ярьж байгаад гишүүд олонх нь шаардлагатай гэж үзвэл ЗГ-т хийсэн ажилд нь тодорхой дүгнэлт тавиад, тэгээд үлдэж байгаа хугацаанд ийм ийм зүйлүүдийг хийх ёстой, ер нь энэ асуудлыг хэлэлцэхдээ ийм зүйлүүдийг анхаарах ёстой байна гэсэн чиглэл өгөх юм байна лээ.

Олон жил яригдаж ирсэн нэг асуудал юу вэ гэхээр энэ 5 жилийн төлөвлөгөө, 4 жилийн мөрийн хөтөлбөр, жилийн хөтөлбөр энэ тэрийг ингээд яриад л өнгөрчихдөг юм, өнгөрчихдөг юм. Энэ дээр нэг анзаарагдсан одоо болтол практик дээр харагдаад байгаа зүйл юу вэ гэхээр 5 жилийн төлөвлөгөөг ярихдаа гишүүд энэ бол УИХ-тай, гишүүдтэй холбоотой асуудал. Аль болохоор л их олон юм тусгахыг бодоод баахан юм оруулчихдаг. Дараа нь засгийн газрын мөрийн хөтөлбөр 4 жилийн хугацаатай ярихдаа бас баахан одоо түрүүн Хүрлээ сайд хэлж байна. Яг үнэнээ хэлэхэд зарим үед мөрөөдлийн жагсаалт шиг юмнууд ингээд гаргачихдаг. Тэгээд жилийн төлөвлөгөө дээрээ бас тэр дотроосоо авч байгаад, заримдаа нэмээд, нөгөө 5 жил, 4 жилдээ байхгүй юмнууд нэмээд ингээд оруулчихдаг. Хамгийн сүүлд төсөв ярихдаа нөгөө олон ярьсан жилийн төлөвлөгөөнд туссан юмнуудаа санхүүжүүлэх юмнуудаа бүрэн хийхгүй ингээд орхичихдог. Тэгээд эргээд үүнийгээ ЗГ-аас нэхдэг, ЗГ хариулахдаа үгүй ээ, төсөвт суугаагүй юм чинь бид нар үүнийг яаж хийх вэ гэсэн маягтай хандаад өнгөрчихдөг. Тэгээд ийм, ийм

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зохицуулалтын практикийн зөрөөтэй юмнууд байгаа юм. Цаашидаа бид нар ер нь 5 жилийн төлөвлөгөөгөө ч их ухаалаг яг хийж чадах юмаа тодорхой зорилтуудаа 4 жилийнхийгээ ч тийм, ялангуяа төсөв ярихдаа жилийн төлөвлөгөө, төсөв 2-ыг ярихдаа яг л чадах юмнуудаа хийж байж түүнийхээ дагуу төсвөө зөв зарцуулж чадаж уу гэдгээр нь дүгнэлт тавьж байхгүй бол гишүүд Их Хурал өөрснөө баахан юм оруулчихаад дараа нь яг мөнгөн дээрээ очихоор нөгөөдөх нь гүйцдэггүй. Тэгээд ингээд жилийн төлөвлөгөө гарахаар цөөхөн хувьтай гараад байдаг. Ийм асуудал өнөөдөр яригдаж байгаа энэ яагаад хэдхэн хувь байгаа юм, яагаад 39% байгаа юм гэдгийн бас нэг тал нь юм байна лээ шүү. Би үүнийг зүгээр ЗГ-ыг өмөөрөх гэж хэлж байгаа юм биш. Бид нар ч гэсэн ажлаа хийхдээ яг эхнээсээ их бодолтой, би 5 жилд үүнийг хийнэ, дотроос нь 4-д үүнийг, энэ жилдээ бол үүнийг нь хийнэ, үүнийг хийхийн тулд төсөвт нь үүнийг заавал тусгаж өгнө гэж бодоод төсвийнхөө мөнгийг дараа жилийн юмыг ярихыгаа бодож, тухайн жилийн төлөвлөгөөгөө бас хийж байх ёстой юм байна лээ. Ингэж байж энэ манай төрийн ажил эмхтэй, замбараатай ойлгомжтой байх юм байна лээ гэж л хэлэх гээд байгаа юм. Энэ бол ганцхан миний ярьж байгаа зүйл биш. Өчигдөр ТББХ-н дээр ярихад ерөөсөө олон гишүүд яг энэ агуулгаар ярьсан. Аргаа бараад ингээд жилийн төлөвлөгөө гэдэг юмтай бид нар болж байсан шүү дээ. Түрүүчийн Их Хурлуудаар. Уг нь ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр гэж гараад л түүн дотроосоо нэг юм оруулаад л зарим нь үлдээд яваад байдаг байсныгаа болиод ерөөсөө тодорхой болъё, жилийн төлөвлөгөөтэй болъё гэж хуульдаа өөрчлөлт оруулж байгаад жилийн төлөвлөгөөтэй болсон мөртөө бахь байдгаараа л нөгөөдөхөө яг төсвөө ярихдаа жилийн төлөвлөгөөндөө хамаагүй их юм оруулчихсан, төсөв нь мөнгө нь хүрэхгүй ингээд ийм асуудлууд үүсээд үндсэндээ утгагүй яриа болчихоод байсан юм. Энэ 5 ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Шадар сайд Хүрэлбаатар хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн төлөвлөгөөний хэрэгжилт бол яг ингээд өссөн дүнгээр нь аваад үзвэл 39.3% Та бас Байнгын хороон дээр 30 гээд байна лээ бас 39 гэдэг чинь бүхэл бүтэн 10% гэдэг чинь хэсэг бүлэг хүмүүсийн хийсэн ажлыг үгүйсгээд байна гэж та ойлгож болно. Тэгэхээр энэ чинь ойролцоо л бол уг нь 40 л дөө, 39.3-ыг ойролцоогоор гэвэл 40 л гэж хэлдэг л байсан санагдаад байна. Тэгэхдээ яах вэ, одоо бас юмнууд өөрчлөгдөөд үнэн юм нь худал болоод худал юм нь үнэн болоод тэгээд нүдээ хөмсгөө их сүртэй харж байгаад ярьчихаар тэр нь үнэн болчихдог ийм нийгэм рүү орох гээд байх шиг байна шүү дээ ер нь. Тэгэхээр 39.3 гэдэг бол бид нар ойролцоо л бол 40 хувь л гэж би бол ойлгож байгаа.

Энэ дээр бас ний нуугүй хэлэхэд бас хэтэрхий өөдрөг ч юу байх вэ дээ. Энэ коронагийн байдал ингэж удаан үргэлжилнэ гэж бид нар мэдээгүй. 22 он өнгөрсөн жилийн дунд үеэс л юмнууд үндсэндээ гайгүй болсон юм шүү дээ. Тэр битгий хэл сая 1 сард Хятадын хил нээгдэхэд, энэ гаднаас коронатай хүн ороод ирэх нь хаа боль, битгий оруул, пи си арыг нь ав гэдэг ийм зүйл л тохиолдоод л явж байсан. Тэгээд бид нар болохоор нөгөө нэг хэдхэн сарын байсан өмнөх үеэ бол мартчихаад байна. Тэгэхээр хил хаалттай, бид нар өөрсдөө Их Хурлын гишүүд үүнийг энэ дээр ийм шилэн юм тавьчихаад шилний цаанаас хоорондоо ярьдаг, хоорондоо бие биетэйгээ гар барьдаггүй, бие биеийнхээ өрөөгөөр ордоггүй ийм л цаг үе саяхан байсан гэдгийг л би нэг хэлмээр байх юм. Үүнтэй холбоотойгоор энэ хил хаалттай байгаа нь эргээд яах аргагүй ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд бол нөлөөлсөн гэдгийг би хэлье. Тэгэхээр гэхдээ ингээд энэ дээр зөвхөн шалтаг тоочоод суугаад байх шаардлага алга. 23 оныг бид нар бол гүйцэд сайн ашиглаж байж нэлээн сайн үр дүнд хүрэх болов уу

гэсэн ийм бодолтой байгаа. Тэгэхээр Брэнд рэйн гээд одоо хүн чадалтай чадалтай хүмүүс гадагшаа гараад явчхаж байна. Солонгост хүмүүс гарч ажиллаж байна гэж. Яах аргагүй тэнд цалингийн түвшин өндөр, хүнд илүү боломжийг нь өндөр цалин өгөөд явчхаж байгаа юм чинь тэр хүмүүсийг бид нар битгий гар гэж хэлэлтэй биш. Бас Монгол чинь ардчилсан улс байна шүү дээ, өөрсдөө гараад явна.

Тэгэхээр эндээс бид нар яаж гарах вэ гэхээр ерөөсөө л ний нуугүй хэлэхэд энэ эдийн засагтаа жоохон либерал хандмаар байгаа юм. Хөрөнгө оруулалтуудыг бид нар дэмжих ёстой, гадна дотнын бүх хөрөнгө оруулалтуудыг дэмжих ёстой. Тэгэхгүй хөрөнгө оруулагч нараа бид нар нэг дайсны цэрэг орж ирж байгаа юм шиг хараад байхаар чинь болохгүй байна шүү дээ. Тэгээд гаднын хөрөнгө оруулалт нь жил жилээс буучихсан. Монгол Улсынхаа хуулийн дагуу ажиллая, шаардлага тавья, тэгээд бас боломжийг нь бүрдүүлээд ажиллах ёстой. Ингэж ажиллаж байж Монгол Улс бусад орнуудаас илүү хурдацтай хөгжиж байж, бидэнд нөхцөл байдал үүснэ. Удаан ингээд яваад байх юм бол яах вэ, болно л доо. Гэхдээ бусад орноос хөгжил хоцроод л байх болно. Тийм учраас бусдын хийж байснаас илүү хурдтай ажиллаж, илүү таатай нөхцөлийг бүрдүүлж, илүү чармайж, хичээж байж л бид нар энэ хөгжлийг авчирна. Тэгэхгүй бол таны хэлдэг тэр сөрөг зүйлүүд бол тохиолдоод л байна. Тийм учраас тэр Монголд томоохон ААН-үүд нь орж ирээсэй, банк санхүүгийн салбар нь либерал болоосой. Арилжааны банкнууд нь чөлөөтэй зээлээ олгодог, өрсөлддөг, шударга өрсөлддөг. Түүнээс биш нэг цөөхөн хэдэн банкны хараан дотор орчхоод тэд нарын үгээр, тэд нарын чиглэлээр энэ улс оронд явж байгаа хэлэлцүүлгээ хүртэл хийгээд суугаад байж болохгүй шүү дээ. Монгол Улс хөгжье өө л гэх юм бол бид нар өөрсдөө л зөв байх ёстой. Тэгээд хаадаг, боодог хорьдог ийм юмыг л бид нар хэдүүлээ нэг их хиймээргүй л санагдаад

байгаа шүү. Бүхэл бүтэн улсынхаа хил хаагаад үзлээ шүү дээ. Тэгээд байгаа байдал нь энэ. Тэгэхээр ер нь жоохон чөлөөтэй байсан нь дээр байх.

**Л.Мөнхбаатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Харин тийм ээ, Хүрэлбаатар сайд аа. Тийм учраас л би тэр сая 3, 4 тоо асуусан юм л даа. Яагаад гадагшаа ингээд зугтацаагаад байгаа юм бэ? Боломж нь гарвал бүгдээрээ дүрвэчих гээд байгаа юм бэ? Тэгэхээр тэр гадаадын хөрөнгө оруулалт гэдэг зүйл маань тэр тусмаа энэ уул уурхайн бус салбарт экспорт гэвэл бас уул уурхайн бус салбарын экспорт гэдэг энэ зүйлүүд чинь өөрөө тийм хөдөлмөрийн шингээлттэй хөдөлмөрийн зах зээлийг тэлдэг, ажлын байрыг бий болгодог энэ салбарууд дээр ямар тоонууд байна вэ? Ямар ахиц гарсан бэ? Мөнгөн дүнг нь харвал тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулалт гэвэл Оюутолгойг хасвал бараг байхгүй л болж байгаа шүү дээ, одоо. Уул уурхайн бус экспорт гэвэл бас л бүр байхгүй. Гэтэл үүний чинь цаана тэр ажлын байрууд нь бий болоод байна. Уг нь бол үүний цаана чинь тэр чанартай ажлын байр нь бий болоод байна. Чанартай ажлын байр нь. Тэгэхээр энэ бүгдийг чинь илэрхийлдэг илэрхийлэл нь тэр дундаж анги, ядуурлын түвшин буурах гээд энэ нэг цогц үзүүлэлтүүд дээр тойроод таныг бас нэг хариулт өгөөсэй л гэж хүссэн. Яагаад гадагшаа зугтаад байгаа нь ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Хүрэлбаатар Шадар сайд хариулъя. Дараа нь аудитаас бас нэг асуулт асуусан байгаа, бэлтгэж байгаарай. Шадар сайд Хүрэлбаатар хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Ийм л байгаад байгаа юм. Нийт энэ ардчилал зах зээлийн тогтцоо руу шилжиж орсноос хойш Монгол Улсад 39.8 тэрбум америк долларын хөрөнгө оруулалт бол орж ирсэн. Тэгээд орж ирж байгаа хөрөнгө

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

оруулалтын хэмжээ, орж ирж байгаа ААН-үүдийн тоо бол жилээс жилд л буурч байгаа. Мэдээж энэ коронагийн жилүүдийн үед бол эрс бага байсан. Тэгэхээр тэр үед бол голлож орж ирсэн хөрөнгө оруулалт бол таны хэлсэн уул уурхайн салбар гэдэгтэй санал нэг байгаа юм. Тэгэхээр яг одоо түрүүн та ч бас өөрөө хэлчихлээ. Энэ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр бид нар өөрсдөө сэтгэлгээнээсээ аваад хандлага хүртлээ ер нь өөрчилмөөр байгаа юм. Дотоодын ААН-үүдээ болохоор төрөл бүрээр нь дарамталдаг, хүнд суртал үзүүлдэг ийм байхаар гаднынхан нь бас орж ирэхгүй байна шүү дээ. Тэгэхээр ер нь хэдүүлээ нэг ийм чөлөөтэй байх талдаа л ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Үндэсний аудитын газраас гишүүний асуултад хариулъя. Хэд вэ? 81 дүгээр микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад тодорхой хариулъя.

Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газраас Монгол улсын ерөнхий аудиторовын орлогч Сарансүх. ЗГ-ын дунд хугацааны хөтөлбөрт аудитын дүгнэлтийг тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэх жилд нь дүгнэлт гаргадаг учраас энэ жил ЗГ-ын дунд хугацааны хөтөлбөрт дүгнэлт гаргаагүй байгаа. Энэ удаа улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж дундаж үнэлгээг 60.1 хувьтай байна гэж аудит бас дүгнэсэн байгаа.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан энэ зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв санхүүгийн эх үүсвэрийг тусгасан ийм төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг байгаа. Энэ тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Хариулт хангалттай юу, Цогтгэрэл гишүүн ээ, нэмээд хариулчихъя гүйцээгээд хариулчих. 81 дүгээр микрофоныг өгье.

**Я.Сарансүх:** Үнэлгээ ийм доогуур байгаа нь гол нь төлөвлөлттэй холбоотой байгаа, төлөвлөлтөд энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11.2 дээр байгаа энэ шалгуур шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж чадахгүй байна гэж аудитаас дүгнэсэн байгаа. Тухайлбал төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг бодитой тодорхойлоогүй ийм 27 төсөл, арга хэмжээ байна, ТЭЗҮ зураг төсөвгүй баталсан ийм 20 төсөл, арга хэмжээ байна. Мөн санхүүжилтийн эх үүсвэрийг нь тусгаагүй 21 арга хэмжээ мөн энэ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд үүсэх эрсдэлийг урьдчилан төлөвлөж удирдах ийм төлөвлөгөөгүйгээр ажиллаж байна гэсэн ийм дүгнэлтийг өгсөн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Цогтгэрэл гишүүн, Хүрэлбаатар сайд хоёрын харилцан яриан дээр нөгөө ганц санаа нэмчихэд мэдээж бид нар илүү либерал, илүү чөлөөтэй хөрөнгө оруулалтаа дэмжмээр байгаа юм. Тэгэхдээ хамгийн гол юм миний бодлоор бид нар энэ байна шүү дээ. Яг төр, эдийн засгийн ажиллагаанд хаана оролцох юм, юунд нь оролцох юм, ямар хэмжээтэй оролцох юм гэдгээ л их ойлгомжтой тогтоож өгөхгүй бол хувийн бизнес ороод л салбараа аваад л нэг явж байтал төр нь орж ирээд л эсвэл нэг том ААН байгуулчихдаг, эсвэл баахан хөнгөлөлттэй зээл олгочихдог. Тэгээд л нөгөө зах зээлээр явж байсан зах зээлийн голдирлыг нь оруулаад хаячихдаг. Тэгээд төрийн өмчит баахан үйлдвэрийн газрууд байгаад байдаг. Мэдээж эрчим хүчээс авхуулаад л байх л ёстой л доо. Тэгэхдээ яг юунд нь төр оролцож, юунд нь оролцохгүй, юунд нь дэмжлэг үзүүлж,



юунд нь дэмжлэг үзүүлэхгүй өөрийнхөөр нь явуулах юм гэдгээ нэгдүгээрт их сайн тогтоож өгмөөр байгаа юм. Тэрийгээ л бид нар ойлгомжтой болгочих юм бол гадаад дотоодгүй бизнесүүд сигналаа аваад тэгээд хууль тогтоомж нь тогтвортой байх юм бол макро эдийн засгийн үзүүлэлтүүд нь тогтвортой байх юм бол төр, бизнес 2 энэ улсыг хөгжүүлээд явчихна.

Энэ 22 оны төлөвлөгөөнөөс би нэг 2 юм асуух гэсэн юм. Энэ 2.1.13 дээр ийм заалт байгаа юм. Энэ эрүүл мэндийн салбартай холбоотой. Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлэх, биелэлт нь 100 хувь гэгчихсэн байгаа юм. Тэгэхээр энэ бодвол ЭМЯ-наас хүмүүс байгаа биз. Энэ удирдамжийн эмнэл зүйн удирдамжийн цахим сан гэж энэ нөгөө аптудит системийг л хэлээд байх шиг байгаа юм л даа. Тэгээд энэ дээр би 2 асуулт байна.

Нэгдүгээрт, энэ аптудитыг хэлж байгаа бол энэ эмнэл зүйн удирдамж яг энэ биш шүү дээ. Энэ чинь бол зүгээр л Дата бааз шүү дээ. Тэгээд эмнэл зүйн удирдамж гэгчихээр чинь энэ чинь заавал яг ингэж эмчил гэдэг зааварчилгаа гэж нэг талаас ойлгогдох гээд байдаг. Тэгээд энэ нь үүнийг аптудитаа яриад байна уу, өөр юм яриад байна уу?

Хоёрдугаарт, яг үүнтэй уялдуулаад асуухад энэ аптудит систем ер нь манай эмч нарын гар дээр хэр очсон бэ? Өрхийн эмч нарын гар дээр хэр очсон бэ? Очсон бол хэр хэрэглэгдэж байна? Эмч нарт яг хүрч байна уу? Энэ чинь англи хэл дээр байж байгаа шүү дээ. Тэгээд эмч нар маань үүнийгээ ашиглаж чадаж байна уу? Үүнийг орчуулаад манай эмч нар хэрэглэж чадаж байна уу? Энд хэдэн төгрөг зарцуулчхаад байна, үр дүн байна уу? Үүнийг нэг хэлээд өгөөч.

2 дахь асуулт, яг доод талд нь ингээд биччихсэн байгаа юм. Эм ханган нийлүүлэх байгууллагуудад эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтын нэгдсэн

программ хангамж нэвтрүүлнэ ээ. Хэрэгжилт 100 хувь гэгчихсэн байгаа байхгүй юу. Монгол Улсад энэ эм ханган нийлүүлдэг байна шүү дээ, бараг 300, 400 байгууллага компани байгаа даа, бөөний, жижиглэнгийн, импортлогч нар, үйлдвэрлэгч нар гээд. Тэгээд бүр жижиг одоо нэг эмийн лицензтэй хүмүүсийг нь компаниудыг нь тоолох юм бол 600, 700 гараад явчихна. Тэгээд эд нар яг ямар программ хангамжаар хангагдчихаад байгаа юм бэ? Бид нар сүүлийн 4 жил энэ УИХ дээр яриад, ЭМЯ, ЗГ-тайгаа яриад, одоо нэг ЗГ-аас орж ирэх гэж байгаа эмийн хуульд нэг жоохон ахиц гарч байгаа юм бол энэ эмийн чанарын асуудал байгаа шүү дээ, чанарын асуудал. Тэгэхээр энэ дээр болохоор ерөөсөө бүх эм хангамжийн байгууллагуудаа программ хангамжаар нийлүүлчихсэн, тэд нар үүнийг ингээд программ хангамжаар аюулгүй байдлыг нь хангана гээд байгаа. Тийм юм байхгүй шүү дээ. Эмийн чанар муу байгаа, бид нар мэдэж байгаа. Нэг эмийг олон нэртэйгээр 3000-32000 төгрөгийн нэг ширхэг нь 3000-32000 төгрөгийн үнэтэйгээр 25, 6 төрлийн эм бид нар нийлүүлж байгаа. Чанарын асуудал одоохондоо ярих бололцоогүй байгаа. Тэгээд энэ ямар ажил хийчхээд хэрэгжилт нь 100 хувь болчихоод, эмийн чанар дээр өөрчлөлт гарчхаад байна. Энэ 2 асуултад хариулт авах гэсэн юм. Тэгээд би подруулж асуумаар байна, бас.

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүний асуултад хэн хариулах вэ? ЭМЯ-ны төлөөлөл хүн байна уу? 2 номерын микрофон дээр очоод асуултад хариулъя. Нэр, албан тушаалаа тодорхой хэлээд хариулаарай.

ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Хонгорзул байна. Мөнх-Оргил гишүүний асуултын хариултыг албан бичгээр хүргүүлье.

**Л.Мөнхбаатар:** Танайхаас өөр ямар хүн байгаа юм бэ? Энэ асуултад хариулах эрх бүхий хүн хэн байна. ТНБД

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

чинь байхгүй байгаа юм уу? Баасандоржийнх хэд юм. Энэ асуултад Баасандорж дарга хариулъя, 94 номерын микрофоныг өгье.

Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ Баасандорж. ЗГХЭГ дээр бол яамнуудаасаа ирсэн тайланг нэгтгээд ЗГ-ын хуралдаанаараа хэлэлцүүлээд, ингээд УИХ-д дэгийн тухай хуульд заасны дагуу танилцуулж байгаа юм. Манай ЭМЯ-наас ирсэн юугаар бол саяын яг Мөнх-Оргил гишүүний хэлсэн систем бол эрүүл мэндийн салбарт аптүдэйт олон улсын цахим платформыг нэвтрүүлэн, уг платформыг хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор үүнийг эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын багц цагийн 3-ны 1-ийг бүрдүүлэх боломжтой болсон. Яг өнөөдрийн байдлаар. Уг сурталчлах эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан платформын талаарх сургалтыг манай эрүүл мэндийн салбар бол тогтмол хийж байгаа. Энэ нь бол 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 45112 хэрэглэгч ашигласан нь яг тухайн оныхоо 8 сартай харьцуулбал 19.8 мянга буюу 1.7 дахин нэмэгдсэн байна гэж ЭМЯ-наас бол тайлагнасан байгаа.

Мөн уг платформын талаар 2022 онд зохион байгуулсан 2 удаагийн сургалтад бол төр, хувийн хэвшил болон нийслэл орон нутаг дахь 1.1 32 эмнэлгийн үүнийг мэргэжилтэн хамрагдаж байна. Та мөн сая тэр нөгөө эмийн бүртгэлтэй холбоотой юу системийг ярьсан энэ Лайс мед программд байгаа. Уг программд бол нэвтэрч эмийн аюулгүй байдлын тайлан илгээх боломжтой болсон. Үүнд 384 эм ханган нийлүүлэх үйлдвэрлэх байгууллагыг цахимжуулсан, цахимжуулах ажил бүрэн хийгдсэн байгаа өнөөдрийн байдлаар. Үүнд нь бол 89 эмийн аюулгүй байдлын тайланг Эм судлалын салбар зөвлөл хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн байна. Тус тайлангуудад эмийн аюулгүй байдал зөрчигдөөгүй, өөрчлөлт ороогүй байгаа гэсэн тайланг өнөөдрийн байдлаар гаргасан байна.

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүн тодруулах уу? тодруулж асууя.

**Ц.Мөнх-Оргил:** Баасандорж даргад баярлалаа. Тэгээд ЭМЯ энэ асуултыг дахиж эргүүлж харж байгаад бичгээр хариу өгнө биз дээ. Энэ 2 юм санаа зовоогоод байгаа байхгүй юу. Эмнэл зүйн удирдамж гээд энэ аптүдитаа орчуулчаад байгаа байхгүй юу. Удирдамж гэдэг чинь заавал гэсэн үг шүү дээ, тийм ээ, яг л хүн юу гэдэг юм нэг өвчин эмгэгтэй болчихсон байвал яг үүгээр эмчилнэ шүү л гэсэн ерөнхий чиглэл, заавар. Энэ аптүдит чинь бол зааварчилгаа биш шүү дээ. Удирдамж биш, энэ чинь зүгээр л дата бааз буюу энэ ийм төрлийн эмийн эмчилгээг ингэж хийвэл үр ашигтай байна гэсэн эмч нарт өгч байгаа зүгээр л референс, дата бааз. Ядаж нэрээс нь авхуулаад үүнийгээ зөв болгомоор байгаа юм.

Хоёрдугаарт, энэ их чухал юм байгаа юм. Энэ манай ЭМЯ-ныхан олон жил ярьж байж үүнийг нэвтрүүлж байгаа, эмч нарт маш их хэрэгтэй. Тэгэхдээ, тэгэхдээ маш сайн хэл устай хүн л үүнийг чинь хэрэглэж чадахаар байгаа байхгүй юу. Энэ чинь Монгол хэл ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүн бас чухал асуудлууд яриад байна, юу яачихъя гүйцээгээд та юу тодруулгаа ярьчихъя. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнх-Оргил:** Энэ өөрөө их үнэтэй систем л дээ. Сар болгон мөнгө төлдөг, тэгээд улсын төсвөөс бид нар 2020 оны эрүүл мэндийн хуульд 2020 онд өөрчлөлт оруулаад улсын төсвөөс мөнгийг нь гаргуулаад, эмч нарт нийлүүлж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ их мөнгө яг эмч нартаа тэр зөв мэдээлэл болж очиж чадаж байна уу, үгүй юү гэдгийг зүгээр нэг хүнд программ өгөхөөсөө гадна яг тэр эмч болгонтой нь бараг уулзаж мэдмээр байгаа байхгүй юу.

Тэгээд зарим нэг яг манай Монголын нөхцөлд хамгийн их тохиолддог тэр тохиолдлуудыг нь бол тэр удирдамжийнх нь удирдамж биш ээ, тэр дата баазыг нь Монгол хэл рүү орчуулж өгч, эмч нарт хүргэмээр байгаа юм. Тэгж байж энэ мөнгө үр ашигтай зарцуулагдах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг Мөнхбаатар дарга аа, ЭМЯ-нд хэлээд манай Байнгын хороон дээр ч юм уу, Их Хурал дээр бүүр тусад нь нэг танилцуулмаар байна. Хайран мөнгө, хайран боломж ингээд хоосон үрэгдээд алга болчих гээд байгаа юм шиг санагдаад байх юм.

Тэр эмийн чанарын программын тухай асуудал бол тэр шал тусдаа асуудал. Тэрийг бол яриад ч нэмэр байхгүй. Дараа нь л бичгээр хариу ирэхээр нь ярья. Ер нь Их Хурал дээрээ хэдүүлээ нэг энэ эмийн хангамж, чанарын асуудлыг бүр тусад нь нэг ярих цаг болчихоод бид нар ажлын тусгай дэд хороо байгуулаад, одоо дэд хорооныхоо ажлын дүнг нэг хэлэлцмээр байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Чинбатын Ундрэм гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундрэм:** Энэ Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний зорилтот түвшинд хүрсэн 68 төсөл, арга хэмжээ байна л даа. Тэгээд энд 2.3-д хүн бүрд чанартай боловсрол эзэмших, тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ гэгчихсэн байгаа юм. Тэгээд үүнийхээ дотор 2.3.15-д дээд боловсролын чанарын тогтолцоо судалгааны чадавхыг олон улсын жишиг туршилагад үндэслэн сайжруулна гэгчихсэн байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор 2 асуудал байгаа.

Нэгдүгээрт, энэ ЭЕШ-ын агуулга, арга зүй, тест боловсруулах, үнэлэх арга зүй, аргачлалыг бид нар сайжруулж энэ олон улс шиг болгоё. Жишээлбэл Америкт байдаг Эс Си Ти тестийг олон удаа хүүхдүүдээс авдаг шүү дээ. Хүүхэд нэг удаа унаж болно. Сандраад. Дараа нь

дахиж бэлдээд, сайжруулаад дүнгээ ингээд дээшилүүлээд авдаг ийм тогтолцоог оруулъя.

Мөн дээрээс нь энэ үнэлгээний аргачлал нь өнөөдөр энэ МУБИС дээр 100 онооноос 18 авсан хүүхдийг багшийн ангид элсүүлэх ийм босго оноо тавьчихсан байна гээд нийгэмд өчнөөн шүүмжлэл болоод байна. Тэгэхээр энэ тал дээр энэ манай энэ Боловсролын үнэлгээний төв, Боловсролын яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байна уу? Үүнийг 2021 оноос эхлээд би ярьсаар байсан. Тэгээд ЭЕШ-аа олон удаа авдаг болно, сайжруулна гээд л зөндөө л ийм хариултаудыг сонсоод өнөөдөр улам нөхцөл байдал нь дордсон ийм асуудлууд нийгэмд яригдаад байна. Тэгэхээр энэ дээр нэг асуулт.

2-т нь, энэ Боловсролын зээлийн сантай холбоотой. Одоо нийгэмд маш бухимдал үүсгэсэн ийм асуудал гарч байна. 2020 онд 2.5 сая доллар, 21 онд 3.8 сая доллар, 22 онд 1.1 сая долларыг энэ боловсролын зээлийн сангаар дамжуулж, гадаадад их дээд сургуульд сурч байгаа хүүхдүүдэд өгсөн байна. Тэгэхээр энэ яг ямар журам, зарчмаар олгогддог юм бэ. Олон нийтэд нээлттэй зарлаад тэгээд тэнд нь яг ижилхэн шалгуур тавиад, нээлттэйгээр өрсөлдөөд ингээд авдаг юм уу яадаг юм. Энэ өнгөрсөн хугацаанд энэ шүүмжлэл бол зөндөө явсан шүү дээ. Тэгээд энэ дээрээ үндэслээд журмаа сайжруулсан асуудал байдаг юм уу, үгүй юү. Нийгэмд бол дандаа дарга нарын гэр бүлийнх нь хүмүүс, хамаатан садан нь явдаг ийм зээлийн сан байна гээд л шүүмжлэл яваад байна. Тэгэхээр үүнтэй холбоотой асуудлыг асуумаар байна.

Энэ 2.4-д эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулна гэгчихсэн байгаа юм. Тэгээд энэ хэрэгжилт нь бас 100 хувь. Тэгэхээр яг ямар, ямар үндэсний төвүүд байгуулагдчихсан юм бэ? Энэ 2.4 дүгээр заалт ямар, ямар ажил хийгдээд яг хэрэгжчихсэн гэж өөрсдийгөө 100 хувиар үнэлээд оруулаад ирсэн юм бэ. Энэ

шинжлэх ухааны салбар чинь бол элгээрээ хэвтэж байна шүү дээ. Энэ дээр ямар сайжруулалтууд өнгөрсөн хугацаанд гарсан юм бэ? Ерөөсөө бодитойгоор нүдэнд харагдахгүй байна.

3 дугаарт, энэ соёлын салбарт 2 ажил л биелэлт нь 100 хувь гэсэн байгаа. Нэг нь бол энэ Чингис хааны музей байгуулсан асуудал. Нөгөөдөх нь баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчилсэн гээд байгаа юм. Энэ соёлын салбарт орон нутагт байгаа соёлын төвүүд бол үнэхээр хэцүү байна. Соёлын төв, номын сангууд барилга нь хуучирчихсан дотроо ямар ч техник тоног төхөөрөмж, бүр сандал ширээ ч байхгүй, компьютер ч байхгүй гэсэн асуудал ярьж байна. Ажилчдын цалин нь маш бага тэгээд босоо тогтолцоотой учраас үүнийг сумдын ч юм уу тийм ээ, орон нутгийн санхүүжилтээр ямар нэгэн шинэ юм техник, тоног төхөөрөмжийг нь сайжруулах ямар ч боломж байхгүй гэж байна. Тэгэхээр орон нутгаар чинь дамжиж энэ Монгол Улсын нийт ард иргэдэд соёлын үйлчилгээ чинь хурч байгаа шүү дээ. Тэр хаа байсан алслагдсан сумд байгаа ард иргэдэд. Тэгэхээр ийшийгээ чиглэсэн нийт энэ 330 сумыг хамарсан ямар ажил хийсэн юм бэ?

**Л.Мөнхбаатар:** Ундрам гишүүний асуултад БСШУЯ-ны ТНБД Лхагвын Цэдэвсүрэн хариу хэлье. Индэрийн нэгдүгээр микрофоныг өгье. Дараа нь Соёлын яамны ТНБД хариултаа бэлдэж байгаарай.

**Л.Цэдэвсүрэн:** Ундрам гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын ЕБС төгсөх сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөөс ЭЕШ-ыг жилд нэг удаа авдаг байсан тогтолцоог бид нар ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт өөрчлөлт оруулснаар жилд 2 удаа авдаг болсон. Энэ нь яг таны хэлж байгаагаар хүүхдүүд нэг удаа жилд шалгалт өгөхдөө тэнцээгүй тохиолдолд бүтэн жил хүлээдэг байсныг болиулж боломж олгосон ийм

зохицуулалтуудыг хийсэн. Тэгээд 11 сард нэг авч байгаа, 6 сард ЭЕШ-ыг бол ингээд авч байгаа.

Дээрээс нь бид нар Монгол хэлний шалгалтыг бас хүүхдүүдийг дахин өгөх боломжийг нь бол хангаж байгаа. Яагаад гэхээр ЭЕШ өгөх бүх хүүхдүүд Монгол хэлний шалгалт урьдчилж өгч байж дараа нь холбогдох хичээлүүдээрээ ЭЕШ-ыг өгдөг байгаа.

Боловсролын зээлийн сангаас дотооддоо болон гадаадад суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөр тэтгэлэг болон амьжиргааны зардалтай холбоотой асуудлуудыг шийддэг. Сүүлийн хэд хоногт энэ иргэдийн зээл авалттай холбоотой чөлөөлөлттэй холбоотой мэдээллүүдийг бид нар Нийтийн ил тод байдлын багц хуулийн хүрээнд бол бас ХЗДХЯ болон Монголбанктай хамтраад нэлээн удаан хугацаанд судалж байж ингэж ил болголоо.

Зэлийн чөлөөлөлт бол одоо юу гэдэг юм, нийгэмд гараад байгаа энэ өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүсийн хүүхдүүд ч гэдэг юм уу эсвэл танил талынхаа хүмүүсийн хүүхдүүдийг зээлээс чөлөөлж байгаа юм ерөөсөө биш ээ. Энэ бол ЗГ-аас баталсан журмын хүрээнд зээл аваад хүн Монгол Улсдаа нийгмийн даатгалаа 5 жил төлөөд, үр бүтээлтэй ажиллаж байгаа тохиолдолд зээлээс чөлөөлдөг. Яг л энэ журмаараа зээлийн чөлөөлөлтийг хийж байна.

Олголтын хувьд журмыг шинэчилсэн үү гэж асуусан. 2022 онд ЗГ-ын тогтоолоор дотоодод болон гадаадад суралцагчдад олгох зээл болон Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын тэтгэлгийг хэрхэн ямар шаардлага хангасан хүүхдүүдэд өгөх вэ гэдэг журам бол бүхэлдээ шинэчлэгдсэн байгаа.

Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудын болон их, дээд сургуулиудын хамтын ажиллагаа, энэ хамтарсан үндэсний

төвүүдийг яаж байгуулж ажиллаж байна вэ гээд. Өнөөдрийн байдлаар эрдэм шинжилгээний байгууллага болон их, дээд сургуулиудын хамтын судалгаа шинжилгээний ажлыг хамтарч хийх энэ тогтолцоонууд бол нэлээн бас хийгдээд явж байгаа гэж үзэж байгаа. Яагаад гэхээр хуучин бол одоо юу гэдэг юм ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд яг өөрсдийнхөө чиглэлээр судалгаагаа хийнэ, МУИС ч юм уу ШУТИС-тай хамтрахгүй. Бид нар яг тус тусдаа ийм юм хийнэ гэдэг нэг ёсны амбиц байдаг байсан нь бүгд сүүлийн 2 жилийн хугацаанд бол хамтарсан судалгаанууд бол нэлээн идэвхтэй хийгдэж байгаа. ШУТИС болон МУИС сүүлийн 2 жил АШУҮИС, ХААИС дээр хамтарсан судалгааны төвүүд байгуулагдаж дотоодын улсын төсвийн хөрөнгөөр болон Япон улсаас үүнийг хэрэгжүүлж байгаа 1000 инженер төслийн хүрээнд энэ төвүүд байгуулагдаж, үйл ажиллагаанууд нь бол явсан.

Та бас мэдэж байгаа. Бид нар улсын төсвийн хөрөнгийн 94 тэрбум төгрөгийн санхүүгийн зардалтайгаар Амгалан БЗД-т шинжлэх ухааны цогцолборыг барьж байгаа. Энэ оны 11 сард бид нар эхний 5 объектыг хүлээж авахаар ингээд ажиллаж байна. Ашиглалтад оруулахаар, хэрвээ үүнийг бид нар ашиглалтад оруулж чадах юм бол жинхэнэ утгаараа энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаа хамтарсан судалгааны төвүүд бий болох юм. Тэгэхдээ одоогийн байдлаар бол МУИС, ШУТИС, ХААИС болон Анагаахын шинжлэх ухааны их сургууль дээр байгаа энэ судалгааны төвүүдийг сургууль болон эрдэмт шинжилгээний байгууллагууд бүгд хамтраад эзэмшээд судалгааны ажлаа хийж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Ундрам гишүүний 2 дахь асуултад Соёлын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чойдогдэмидийн Энх-Амгалан хариулья.

**Ч.Энх-Амгалан:** Соёлын салбарт үүнийг хөрөнгө оруулалт дээр бол 77 барилга явж байгаа. Үүнээс бол 23 онд 27 барилга ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа. 23 оны төсөв дээр бол тоног төхөөрөмж дээр мөнгө төгрөг суугаагүй ээ. Зөвхөн орон нутгийн 2 барилга, Улаанбаатарын 4 барилга дээр 2 тэрбум орчим төгрөгийн тоног төхөөрөмжийн зардал суусан. Тэгэхээр бид нар энэ 2022 онд ашиглалтад орсон 14 барилга, 23 онд ашиглалтад орох 27 барилга үндсэндээ 40 гаруй барилга дээр бол тоног төхөөрөмжийн зардал шаардлагатай байгаа.

Ер нь соёлын салбарын орон нутгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 40 орчим тэрбум төгрөг бол шаардлагатай байгаа. Тэгэхээр бид энэ 23, 24 оныхоо төлөвлөлтөд бол үүнийг оруулаад явж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Ундрам гишүүн тодруулах юм уу? тодруулж асууя, Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Энэ ЭЕШ-ыг 2 удаа авдаг болсон нь бас нэг ахиц юм. Гэхдээ Цэдэвсүрэн дарга аа, энэ шалгалтынхаа агуулгыг бид нар сайжруулмаар байна. Үнэлгээ хийж байгаа энэ арга зүйгээ бид нар сайжруулмаар байна шүү дээ. 100 онооноос 18 авсан хүүхэд их сургуульд элсэнэ гэдэг чинь байж боломгүй, гадаад улсад олон улсад байхгүй зүйл шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ та нар жоохон ажилла л даа. Ерөөсөө зүгээр 2 удаа зохион байгуулдаг ийм зохион байгуулалтын ажлыг бол хийчихсэн байна. Одоо агуулга руу нь оръё л доо хэдүүлээ. Тэгж байж энэ ирээдүйн багш нараа бид нар чадавхжуулж байж энэ боловсролын салбар чинь босож ирэх үндсэн суурь нь болно шүү дээ. Мэдээж багш нарын цалин нэмэх гээд зөндөө асуудлууд байгаа. Гэхдээ ЭЕШ-аа бас бид нар сайжруулаад явах шаардлага байна.

Энэ соёлын салбар дээр энэ та хэдийн 70 хэдэн барилгыг харахаар

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Үндэсний номын сангийн барилга 0 гэж байгаа юм. Тэгээд Соёлын өвийн бүртгэл хяналтын ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ундрам гишүүний асуултад тодруулж нэмж хариулъя. Хэн хариулах вэ? Цэдэвсүрэн дарга хариулах юм уу, 1 номерын микрофон өгье.

**Л.Цэдэвсүрэн:** ЭЕШ-ийн ерөнхий шалгалтын агуулгыг сайжруулах талаарх таны саналыг хүлээж авч байна. Тэгээд ЭЕШ-ийн ерөнхий шалгалтын 800 онооноос тодорхой хэмжээст оноо буюу чанарын оноогоороо хүүхдүүд уг нь эрэмбэлэгдэж сургуульд ордог. Тэгээд 100 онооноос 18 авсан хүүхэд МУИС-д орж байгаа гэдгийг судалъя. Яг бодит байдал нь бол арай л үгүй байх гэж бодоод байна. Тэгэхдээ энэ тал дээр танд бас дэлгэрэнгүй мэдээлэл өгье.

**Л.Мөнхбаатар:** Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр улсын 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны зорилтуудын хэрэгжилт, 22 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бид ярьж байна. 2022 он бол ковид тэр зэвсэгт мөргөлдөөн, энэ дэлхийн бас нөлөө бүхий гүрнүүд хэдэн биедээ тавьчихсан эдийн засгийн хоригууд гээд олон хүндрэлтэй зүйлүүдийг давж туулж, энгийн амьдралын хэв маяг руугаа шилжилт хийсэн ийм он жил байсан. Тийм учраас бүх зүйл дэвшүүлсэн зорилтын хэмжээнд санаж бодсоноор хэрэгжих гадаад хийгээд дотоод хүчин зүйлүүдийн нөлөөлөл бас тааруу байсан нь ойлгомжтой. Үүнийг бид ойлгох ёстой. Гэхдээ хүнд цаг үеийг бас боломжийн түвшинд давж байна уу даа гэж ингэж харагдаж байгаа. Эрүүл мэндийн салбар талдаа бид бас гайгүй. Энэ эрүүл мэндийг дэмжих төвүүд гээд энэ орон нутгуудын эрт илрүүлэг, үзлэгийн гайгүй нэгжүүдийг бий болгоод авчхаж чадлаа. Цэцэрлэг дээр бас гайгүй алхмууд хийлээ. Аж ахуй, бизнесийн салбарууд дээрээ тэр тусмаа

ХАА-н салбар энэ хүнсний салбар дээрээ бол үндэсний хөдөлгөөн өрнүүлж байгаад бас өмнөх жилүүдэд төдийлөн үр дүн гарч өгдөггүй байсан зүйлүүд дээр бас ахиц нааштай тийм үр дүнгүүдийг бий болгосон ийм он жил байлаа. Гэхдээ бүх зүйл санаснаар яваагүй. Гэхдээ 2, 3 зүйл харах ёстой юм уу гэж бодоод байгаа.

Энэ мэдээллийн сан, статистик мэдээлэл, энэ тайлан мэдээлүүдийг нэгтгэж удирдлага төлөвлөлт, хяналтын хэрэглэгдэхүүн болгож ашиглах талаар бид ер нь их бага ажиллаад байх шиг байна. Нөхцөл байдалдаа, цагийн байдалдаа зөв үнэлэлт өгч авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ илүү нарийсгаж тодорхой болгож ажиллахад яах аргагүй энэ цаг үеийн ажил асуудлуудын чинь гүйцэтгэлийн мэдээ мэдээлэл дээр л бид дүн шинжилгээ хийж, юун дээрээ анхаарах ёстой гэдэг юмнууд их тодорхой гарч ирэх ёстой. Үүнийг би ер нь бүх салбар дээр тийм тэгш би явчихсангүй дээ л гэж л хараад байгаа даа. Үүнийгээ нэг бодоцгоовол яасан юм гэж.

Мэдээж 300 зорилтоос 100 гаран зорилт нь асуудал байна гэж, удаан хийгээд хэрэгжээгүй юм байна гэж. Гэхдээ энэ зорилтуудын цаана энэ улс орны эдийн засгийн хөгжлийг хангах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхтэй холбоотой том зорилтууд байсан. Одоо энэ зорилтуудыг 2023 онд үргэлжлэн хэрэгжүүлэх бэлтгэл зохион байгуулалтыг нь хангаж ажиллах ёстой. Тийм учраас энэ 3 том баримт бичгийн гүйцэтгэлийг сонсож байгаа Их Хурал тов тодорхой үүрэг чиглэлийг ЗГ-т өгөх ёстой. Үүнийг бол зориуд тэмдэглэж хэлмээр байна гэж.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл, энэ валютын нөөц, ханшийн өсөлтийн асуудал байгаад байгаа юм. Тэгээд уул уурхайн салбар экспортын 94 хувийг эзэлж байгаа. Тэгээд энэ салбараас орж ирэх ёстой орлогууд яагаад бүрэн орж ирж болохгүй байна вэ. Эрдэнэс Таван

толгой гэж нэг компани баахан урьдчилсан төлбөртэй гэрээнүүд хийгдсэн. Үүнээс болоод бартерууд хийчихсэн, үүнээс болоод мөнгө нь орж ирэхгүй, энэ хэмжээгээр энэ валютын чинь ханишийг нөөцийг үймүүлээд байна.

Нөгөө талд нь Оюутолгой гэж Монголын заяагдмал баялаг дээр бий болчихсон Монголын ААН мөн юм бол яагаад экспортлсон бүтээгдэхүүнүүдийн төлбөр тооцоо Монгол руу орж ирэхгүй байна аа? Үүнээс болж энэ Монголын эдийн засаг, Монголын ард иргэдийн амьдрал үнэхээрийн тийм амар ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Жигжидийн Батжаргал гишүүний асуултад хариулъя. Бямбацогт сайд хариулчихъя. Дараа нь Хүрэлбаатар сайд нэмээд хариулъя.

**С.Бямбацогт:** Батжаргал гишүүн бас чухал асуудал хөндлөө. Өнөөдөр бид нар ганцхан 22 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний биелэлт яриагүй. Энд 5 жилийн үндсэн чиглэл 20-25 онд Монгол Улсыг нийгэм эдийн засгийг яаж хөгжүүлэх үндсэн чиглэл, 20-24 оны ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлт хамтдаа яригдаж байгаа. Урьд нь бол дандаа тусдаа яригддаг байсан, мөрийн хөтөлбөр хаа байна гэхээр энэ байна. Биелэлт нь хаа байна гэхээр энэ байна. Жилийн төлөвлөгөө нь биелэлт хаа байна гэхээр энд байна. Ингээж ярьдаг. Төлөвлөгөө гаргахдаа бид нар төлөвлөгөөгөө төсөвтэйгөө уядаггүй. Төсвийн хүрээний мэдэгдэл, төлөвлөгөө, төсөв дандаа тусдаа ингээж явдаг байсан л даа. Үүнээсээ болоод үндсэндээ л нэг сүүлийн 20, 30 жил бие биеэ хуурсан ийм байдалтай явж ирсэн. Үүнийг л цэгцлэх гээд 2020 онд бид нар хөгжлийн бодлого, 19 онд Үндсэн хуульдаа Монгол Улсын үүнийг урт хугацааны хөгжлийн бодлого тогтвортой байна, хөгжлийн бодлого төлөвлөлтийг хооронд нь үүнийг уялдуулж хийнэ ээ гэсэн заалт оруулсан. Энэ хүрээндээ Хөгжлийн бодлого

төлөвлөлтийн хуультай болсон. Төлөвлөлт, төсөвлөлт, тэгээд гүйцэтгэл, хэрэгжилт, хяналтыг хооронд нь уялдаатай байх асуудлыг нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиар зохицуулсан. Энэ дээр ЗГ үндсэн чиглэлийн биелэлт, мөрийн хөтөлбөрийн биелэлт, дээрээс нь үүнийг 22 онд төлөвлөгөөний биелэлтийг хамтад нь үүнийг цогцоор нь өргөн барьсан. Өнөөдөр ярьж байгаа. Аудит бас дүгнэлтээ хийсэн. УИХ-ын Тамгын газар Хяналт шалгалтын газар бас дүгнэлтээ хийсэн. Энэ дээр бидэнд бас анхаарах асуудал гараад байгаа юм. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо нэлээн сайн ажиллачихмаар байгаа юм бас. Бид Жишээ нь манай салбар дээр хэлэхэд 3.2 их наядын төлөвлөгөөг 2022 онд хийгээрэй гэж баталж өгсөн байдаг юм байна лээ, 3.2 их наядын төлөвлөгөө. Намар нь төсөв батлахдаа бидэнд 250 тэрбумаар батлаад өгчихсөн. Төлөвлөгөө дээрээ 3.2 их наядыг ажил хийнэ шүү гээд төлөвлөгөө өгсөн. Төсөв дээрээ 2,5 тэрбум өгсөн. 10 дахин бага, 12 дахин бага, тэгээд төлөвлөгөөний биелэлт нь муу гардаг. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр олон ажлууд хийнэ шүү гээд үүрэг өгдөг. Нөгөө тухайлах юм бол Баруун-Урт чиглэлийн авто зам 5 удаа тендер зарласан. Концессын тендер. 1 ч компани ордоггүй. Төмөр зам барих гэж байгаа юм чинь хажуугаар нь авто зам бариад яах юм бэ ашиггүй гээд ордоггүй ийм асуудлууд байж байдаг.

Улаанбаатар хотод баахан одоо юу гэдэг юм газрын болон цахилгааны зогсоолууд иийдээрэй гээд өгчихсөн байдаг. Улаанбаатар хотын асуудал нь хотын захиргааны асуудал. ЗТХЯ-ны асуудал биш. Нэг иймэрхүү, иймэрхүү одоо юу гэдэг юм бас нэг алдаатай, асуудалтай бас. Хэдийгээр бид нар бас өмнөх 30 жилийнхээ алдааг засаад явж байгаа ч гэсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль батлаад төлөвлөгөө, төсөвлөлт тийм үү, гүйцэтгэл, урт, дунд, богино хугацаа энэ бүгдийг хооронд нь уялдуулах гээд оролдож байгаа ч гэсэн бас бага зэргийн алдаанууд байна, асуудлууд

байна. Тийм болохоор үүнийг бас нэгэнтээ ярьж байгаа дээрээ бас нэлээн сайн яриад Их Хурал дээр ингээд хоорондоо бас дахиад юу гэдэг юм 23 оны төлөвлөгөө удахгүй бид нар батална, 6 сарын 1-нээс өмнө. Одоо 23 оны төлөвлөгөө ЗГ дээр явж байгаа. Ингэхдээ бид нар яаж уялдуулах юм. Дараа нь бид нар төсвийн хүрээний мэдэгдлийг батална, 24 оны. Тэгээд дараа нь үүнийг араас нь дагаад намар төсвөө батална. Дахиад 22 онд гарсан энэ төлөвлөгөөний алдаан дээрээсээ суралцаад сургамж аваад 24 оны төлөвлөгөө, 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 24 оны төсөв энэ бүгдээ бас нэг алдаагүй хийчих юм сан. Энэ тал дээр тийм учраас Эдийн засгийн байнгын хорооноос нэлээн анхаараад бас ажиллаад өгөөсэй. Иймэрхүү бас алдаануудаа засаад явчих юм сан.

Тийм учраас таны хэлж байгаа санал дээр бол санал нэг байна.

**Л.Мөнхбаатар:** Батжаргал гишүүний асуултад Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Батжаргал гишүүн ерөнхийдөө ийм л юм болсон юм байна лээ. Эрдэнэс таван толгой дээр. Нүүрс гардаг, орж ирж байгаа валютын хэмжээ их цөөхөн. Яагаад вэ гээд ингэхээр оптек гэрээ хийгээд тэр мөнгөөрөө жишиэлбэл төмөр зам барьдаг бусад бүтээн байгуулалтуудын ажлыг хийнэ гээд хэлчихсэн байдаг, нэг ийм мөнгө гарчхаж байгаа юм. Эсвэл нөхцөл байдал хүнд байна гээд мөнгө урьдчилаад авчихсан. Одоо БЭТ томилогдож байх үед бол 600 сая долларыг урьдчилаад авчихсан байсан. Тэгэхээр бид нарын хувьд ямар асуудал байж байна гэхээр тэгээд яг тухайн үедээ ямар нөхцөл байдал үүсчихсэн байсан бэ гэхээр нөгөө мөнгийг нь урьдчилаад авчихсан эсвэл оптек хийчихсэн компаниуд чинь бүх нүүрсээ түрүүлээд гаргаад байдаг. Тэгэхээр экспорт гараад байсан ч мөнгө орж ирдэггүй, валют орж ирдэггүй.

Тэгээд л Монгол Улсын валютын нөөц доошлоод л, доошлоод л, доошлоод л, 2.4 тэрбумд хүрээд л оны төгсгөл дээр 1.7 тэрбум долларт хүрнэ ээ гэдэг ийм тооцоо хийчихсэн байсан. Тэгэхээр үүнийг яаж өөрчилсөн юм бэ гэхээр яг доллароо юу төлдөг, валютаа төлдөг, нүүрсийг бид нар нэлээн жоохон түлхүү гаргаад эхэлсэн. Ингэж явсаар байгаад одоо валютын нөөц бол нэг одоогийн 3.3 тэрбум америк доллар хүрчихсэн, нөгөө 500 саяын ЗГ-ынхаа бондыг бүтцийг нь өөрчлөөд тэгээд рефайнанс хийчихсэн ийм байдалтай байгаа учраас одоохондоо дарамт багатай ийм байгаад байгаа юм.

Тэгэхээр ер нь бол ингээд ЗГ ч гэсэн, төрийн өмчит ААН-үүд ийм оптек гэрээ хийхдээ сайн бодож хийхгүй валютынхаа урсгалыг бодож хийхгүй бол хэтэрхий бүх мөнгөө тэр оптек юм уу, урьдчилгаа төлбөрийнхөндөө гаргачхаад, валютгүй суухаар эргээд энд нь валютын нөөц унадаг, нөөц унангуутаа хани хөдөлдөг, төгрөгийн хани унадаг. Тэрийгээ дагаад үнийн өсөлт явагддаг ийм зүйлс байсан. Энэ бүгдийг бид нар ингээд зогсоочихсон л байж байгаа. Тэгэхээр энэ дээр дахиж гаргахгүй байх тал дээр нь анхаарч ажиллаж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Батжаргал гишүүн тодруулъя, тодруулж асууя.

**Ж.Батжаргал:** Тийм, байдал яг тийм байгаа. Тэгээд одоо хил, гааль нээлттэй болсон. Сая статистик харсан, төлбөрийн тэнцлийн чинь алдагдал 700 сая доллар хүрчхээд байгаа. Тэгэхээр зэрэг бид экспортын орлогоо нэмэгдүүлэх, импортын төлбөрийг багасгах чиглэл дээр ер нь ямар бодлого авах юм? Тэгэхгүй бол наад долларын чинь хани баригдахгүй нь байна шүү дээ, улам нэмэгдэх гээд байна. Эдийн засаг угаасаа энэ 3 сарын сүүлч 4 сарын эхээр идэвхэждэг, долларын хэрэгцээ үүсдэг. Тэгээд үүнийг ер нь яаж барина гэж төсөөлж харж байна вэ гэж. Нэг.



2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

2 дахь зүйл, 23 онд энэ баялаг бүтээгчдийг үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг дэмжихээр жаал хөрөнгүүд бид нар төлөвлөсөн, 1 их наядын зээл ч гэдэг юм уу, баахан тусгай сангуудын хөрөнгө. Энэ хөрөнгүүд одоо яг бэлэн байгаа юу, шийдлээ олж чадсан уу? Технологид хугацаатай цаг үеийн ажлууд эхэллээ. Шаардлагатай үйлдвэрлэгч нар гүйцэтгэгч нарт бид нар зээлийн хөрөнгө гаргах шаардлага байна. Цаг хугацаа ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Батжаргал гишүүний тодруулгад хэн хариулах вэ? Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Одоо яг экспортоо нэмэгдүүлэх л ийм л гарц байгаа юм. Бид нар одоо юу гэдэг юм импортоо хязгаарлана гээд төрөл бүрийн юм хааж хорих юм бол ер нь нэг их авч хэрэгжүүлэх шаардлагагүй. Яагаад вэ гэхээр энэ нь эргээд эдийн засагтаа учруулдаг тэр сөрөг үр нөлөө нь дэндүү өндөртэй. Ийм учраас бид нарын хувьд бол ерөөсөө л экспортоо л нэмье. Нэгэнт л УИХ-аас төсвийг нь батлаад өгчихсэн, эдийн засгийг тогтвортой байлгах нөхцөлөө ЗГ-т Монголбанк нь анхаараад явж байгаа үед бид нар яаж их хэмжээний валют олох вэ гэдэг дээрээ л онцгой анхаарч ажиллаж байгаа. Энэ чиглэл рүү ЗГ-ын манай бүх сайд нарыг бүгдээрээ нийлж чиглэж ажиллаж байгаа.

Төсөв дээр суусан ЗГ-ын тусгай сангаас санхүүжигдэх мөнгөнүүд бол бүгд байгаа. Энэ дээр янз бүрийн төлбөр саатах ямар нэгэн тийм зүйл байхгүй байгаа. Бүгд мөнгө бэлэн байгаа.

**Л.Мөнхбаатар:** УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

**С.Одонтуяа:** Тэгэхээр би асуулт асуухгүй, асуухаар хариултыг нь мэдэж байна л даа. 7, 8 жилийн өмнөх юмыг л

Хүрэлбаатар сайд ерөөсөө шууд ингээд бүгдийг нь АН руу чихээд хариулчихдаг л, би асуулт байхгүй, зүгээр бодлоо хэлье.

Би зүгээр сүүлийн үед нэг юм ойлгохоо больчихоод байна л даа. Ямар нийгэмд амьдраад байгаа юм гээд. Социалист нийгэм юм уу гэхээр биш, капитализм гэхээр бүр биш, хүнлэг ардчилсан нийгэм гээд л аргалчих бололтой юм. Тэгэхээр энэ зоригтой реформуудаа яагаад хийхгүй байна гэдгийг л би бас энэ засгаас шаардах гээд байна л даа. Эдийн засаг өссөн өссөн л гээд байх юм гэтэл төгрөгөөр бол өссөн байж болно, валютаар бодохоор эргээд л өссөн юм харагдахгүй л байгаа байхгүй юу. Яг л нөгөө л нэг 10 тэрбум дээр л байсан, 10 тэрбум доллар дээрээ л байгаа. Сүүлийн 10 хэдэн жил. Тэгэхээр энэ эдийн засгийн өсөлт чинь айл өрхийн хаалгаар орохгүй бол энэ өөрөө өсөлт бол ач холбогдол байхгүй. Тэгэхээр өнөөдөр айл өрх ямар хүнд байна. Та нар мэдэж байгаа, махны үнэ өссөн, гурилын үнэ өссөн, бид нар Их Хурал дээр татварыг нь чөлөөлчих юм бол чухамхүү сайхан амьдралтай болно гэсэн. Одоо бүгд өсөөд л байдаг, өсөөд л байдаг, энэ яагаад ингээд байдаг юм? Нэг гараараа тэтгэврийг нь нэмээд, нөгөө гараараа инфляцаар бид нар иргэдийнхээ кармаг дээрэмдээд л байгаа. Тэгэхээр энэ юмны үнийн өсөлтөд бол ард иргэд бол үнэхээр маш үүнийг хүнд байдалд орсон.

Би бол зүгээр хоосон дүн ярихгүй. Энэ ҮСХ-ны мэдээлэл байна. Хүн амын 42.2% нь ядуу бөгөөд ядууралд өртөхөд бэлэн байна гэсэн. Тэгэхээр ийм тоонууд дээрээ бид нар жоохон ядуурал бууруулах дээр бас ажилламаар байна. Ажил эрхлэлт бол буурсан, ялангуяа эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт бол буугаад байгаад би бол санаа зовж байна. Энэ энэ статистикийн тоо харахад ерөөсөө 62, 60 гээд л байж байснаа одоо бүр 49% руу орчихсон. Тэгэхээр энэ эмэгтэйчүүд чинь бүгдээрээ ядууралд хамгийн их өртөөд байгаа. Тэгэхээр энэ дэлхийн улс орнууд чинь хөгжлөө хүний

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хөгжлөөр хэмждэг болчихоод байна шүү дээ. Иргэд нь эрүүл байна уу, боловсролтой байна уу гэтэл манайд ерөөсөө энэ хүнийхээ хөгжилд мөнгө зарахгүй юм. Сүүлийн хэдэн жил ганц эмнэлэг барьсан уу, бариагүй. Өнөөдөр нас баралтын тэргүүлэх шалтгаан зүрх судас. Үгүй ээ, зүрх судасныхаа эмнэлгийг бариач ээ гээд л гадаадынхан төслөөр бүх тоног төхөөрөмжийг нь өгчихлөө, бүх зургийг нь хийгээд өгчихлөө. Ганц эмнэлэг л барьж чадахгүй байгаа шүү дээ. Тэгэхээр ард иргэд чинь зүрх судасны өвчлөлөөр нас бараад л байна, нас бараад л байна. Тэгээд нас барж л байг уу.

Хавдраар дэлхийд бүх юмаар тэргүүлчихсэн, одоо амиа хорлолтоор дахиад л тэргүүлж байна. Тэгэхээр энэ яагаад Монгол хүнийхээ энэ сайн сайхан амьдралын төлөө хөрөнгө мөнгө ерөөсөө зардаггүй юм бэ. Үнэт зүйлийнхээ эрэмбийг та нар маш буруу тогтоож байна. Энэ ЗГ. ҮАБЗ-ийн 25 шалгуур үзүүлэлтээс 23 нь огт биелэгдээгүй, 2 нь биелэгдэх шатдаа гэж байгаа юм. Тэгэхээр бид нар ерөөсөө энэ улс орны аюулгүй байдал энэ ард иргэдийн эрүүл, хүнсний аюулгүй байдлыг чинь бүгд алдагдчихсан байна. Хамаг залуучууд нь гадагшаа гараад явчихлаа. Бизнес эрхлэх ямар ч хүсэл зорилгогүй болсон. Тэгээд хүнээ ёс суртахуунтай, зөв иргэн энэ зүйлд хөтөлбөр бичээд орохоор хасаад л хаячихдаг. Үгүй ээ, байшин барилга, цементэд өгнө өө, хүнд хөрөнгө оруулалт хөтөлбөр болохгүй ээ гээд л хасчихдаг.

Одоо энэ Дарханы замаа дахиж яримааргүй байна. Бүр ярихаар бүр ичээд байх юм. Батбаяр Эдийн засгийн сайд байхад БГД дээр түгжрэлийг бууруулахад хоёрхон жилийн дотор 11 уулзварыг өөрчилж байсан шүү дээ. Тэгж түгжрэлийг бууруулж, бүтээн байгуулалт хийж бууруулдаг болохоос зүгээр ингээд л нэг хэдэн авлигач, хулгайчид нь мөнгийг нь идэж уугаад, улс орон хөгжил сайхан болно гэж байдаггүй юм.

Одоо энэ утаагүй түлш гэдгээ больчихмоор байна. Одоо Монголчуудыг үй олноор нь хорт утаанд, бөөнөөр нь ингэж устгах ийм бараг зэвсгийн хэмжээнд оччихлоо. Зүгээр бусад оронд орон сууцны сайхан сайхан, шинэ шинэ хороолол барьдаг шүү дээ. Тэгээд л барь л даа. Одоо сүүлдээ айлын нүхэн жорлонг янзална гээд. Энэ чинь одоо бүр арай ч дээ хэддүгээр зуун бэ? Тэр гаднах амбаарыг нь гоё болгохоор хөрсний бохирдол алга болчихдог юм уу, тийм юм байхгүй. Одоо энэ нэг заваан мөнгө үрдэг, мөнгө угаадаг ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одонтуяа дарга үг хэллээ. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Би шууд асуултаа асуучихъя гэж бодож байна. Үнэхээр Монгол Улсын ЗГ-ын мөрийн хөтөлбөр болон зорилт хөтөлбөрийн хүрээнд 2 дугаар зүйл заалт нь бол хүний хөгжлийн бодлого гэсэн ийм бодлого байгаа. Энэ дээр бид эрүүл Монгол хүнийг л бий болгохын төлөө зорьж ажиллах энэ том зорилтыг тавьсан гэж би ойлгож байгаа. Бидэнд бол хийж байгаа сайн зүйлүүд зөндөө байгаа. Зөвхөн эрт илрүүлгээр харах юм бол ганцхан жишээг дурдаад хэлэхэд эрт илрүүлэгт хамрагдсан хүмүүсээс элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 182270 хүн хамрагдсанаас 122 тохиолдол хорт хавдар оношлогдсон байна гэдэг энэ мэдээлэл байна. Зүгээр яг үнэхээрийн зүгээр ганц жишээгээр харах юм бол өвчлөл энэ хэмжээнд байгаа. Энэ өвчлөлийг бий болгохгүйн тулд бид нар иргэдээ эрүүл мэндийн боловсролтой болгох, нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх зайлиггүй шаардлага байгаа. Энэ ажилд ер нь ямар хэмжээнд хийгдэж байна вэ гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Бидний бас мөрийн хөтөлбөрт маш олон ЭМТ-үүдийг, том том эмнэлгүүдийг босгох ажлууд тусгагдсан

байгаа боловч яг өнөөдрийн байдлаар мэдээллийг харах юм бол Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв, судалж байна. Зурх судасны төв, судалж байна. Сүрьеэгийн эмнэлгийн үйл ажиллагааг түр зогсоогоод байна. Нөгөө л миний яриад байдаг Геронтологийн үндэсний төв, асуудал шийдэгдээгүй 46 хувьтай барилга нь явагдаж л байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг бид яах ёстой юм бэ. Ургийн гэж хөгжил нэмэгдээд байна. Тархины саажилттай оюуны хомсдолтой ийм хүүхдүүд нэмэгдээд байна. Үүнийг бид нар яах ёстой юм бэ гэдэг зүйлийг би Энхболд сайдыг бас сайд байхад төсөв батлагдаж байх цаг мөч тавьж байсан. 4 оношилгооны төвийг босгоно гэдэг энэ зүйлийг ярьж байсан. Өнөөдөр энэ 4 төвийн үйл ажиллагаа ямар хэмжээнд явагдаж байгаа юм бэ? Баригдаж байгаа юу, үгүй юу. АШУҮИС-ийн дэргэд Скрининг оношилгооны төв байгуулагдсан. Энэ дээр бас бид нар бүх хүүхдүүдээ хамруулж чадах юм бол бас хүүхдүүдээ ургийн гэжгаас үүнийг нярай үед нь оношилж чадах юм бол ургийн гэжгаас сэргийлж чадна гэдэг ийм тоон мэдээлэл байгаа. Тэгээд энэ ажил ямар хэмжээнд явагдаж байгаа юм бэ?

Нөгөө талаар соёлын салбар дахь хөрөнгө оруулалт бас л байхгүй. Байгалийн түүхийн музей дээр улсаас төсөвлөсөн тодорхой хэмжээнд төсөв тавиад л байдаг. Батбаяр сайдын хариулж байгаагаар, Номин сайдын хариулж байгаагаар төсөв шалгарсан нэг компани шалгарчихсан байгаа шүү гишүүн ээ л гэж байсан. Яг өнөөдрийн байдлын энэ мэдээлэл дээр бол музейн барилгыг гүйцэтгэх сонгон шалгаруулалт хийгдээгүй байна гэдэг л ийм мэдээлэл байна. Тэгэхээр бид нарын энэ ажил жоохон хоцрогдолтой яваад байна уу, ийм удаан байна уу, юундаа байна шалтгааныг нь хэлж өгөөч ээ гэдэг зүйлийг авах гэсэн юм.

Нөгөө л номын сан, нөгөө л Үндэсний урлагийн их театр, драмын театр, ДБЭТ-аа бид нар буулгахааргүй уг

нь хүчитгэл хийгээд бүрэн засварлая гэсэн боловч бас санхүүжилтийн асуудал нь шийдэгдээгүй нэг ийм асуудлууд байна.

Нөгөөтээгүүр нэг манай дүүрэгт нэг асуудал байна, ашиглагддаггүй барилга. Би Даваасүрэн сайдтай бас уулзаж байсан. Магнайсүрэн дарга дээр бас нэг асуудал яригдаж байгаа байх гэж бодож байна. Ашиглагдахгүй байгаа орон сууцыг төсөл хөтөлбөрөөр дахин барих тийм үү, өөрчлөх, шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтөөр биш. Гэтэл энэ төсөлд нөгөө дэд бүтэц байхгүй гэдэг шалтгаанаар компаниуд нь оролцдоггүй. Тэгвэл үүнийг төр хариуцаж тодорхой хэмжээний нөхөн төлбөр олгодог юм уу, тийм ээ, энэ дээр бас шийдвэрлэх гарц бидэнд ер нь юу байна вэ. Манай тойрог дээр ёстой маш олон айл байгаа 72 айлын орон сууц, 6 дугаар хорооны 6 байр, цэргийн хотхоны 6 байр ашиглагдах боломжгүй орон сууцыг дахин төлөвлөх энэ эрх зүйг орчныг бид нар яаж бий болгох юм бэ гэдэг дээр БХБЯ-наас бас тайлбар сонсмоор байна.

Нөгөөтээгүүр хүүхдийн мөнгөний асуудал, сая тойргоор явлаа. Би ч хасагдчихлаа, би ч хасагдчихлаа. Өчигдөр гэхэд л бид нар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв дээр очоод ажиллахад 680000 төгрөгийн цалин авч байгаа эмч нар маань бас л нөгөө хүүхдийн мөнгөнөөсөө хасагдчихсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Статистикийн үндэсний хороо судалгаагаа дахиж шинэчилж чадсан уу. Одоо ирэх сараас бид нар зорилтот бүлгийн хүүхдүүддээ хүүхдийн 100000 төгрөг олгож чадах уу, үгүй юү гэдэг дээр тайлбар аваадахъя. Тэгээд дараа нь тод ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Жаргалмаа гишүүн тодорхой 4 асуудал асууж байна. ЭМЯ-наас төлөөлж хариулах хүн хэн байна. Эхлээд ингэе. Даваасүрэн сайд хариулчихъя БХБ-ын сайд Даваасүрэн сайд хариулаад, дараа нь Соёлын яам хариулна, ЭМЯ бас хариултаа бэлтгэж

байгаарай. Даваасүрэн сайд асуултад хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Тийм, Жаргалмаа гишүүн манайд хандсан. Би яг тэр чиглэлээр нь холбогдох улсуудаас судлуулж байна. Ер нь яах вэ, Баянхошуунд бол бид нар Баянхошуу дэд төв гээд тэгээд тэр дэд төвийг дамжуулаад гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийх ийм юмнууд хийж байгаа юм. Түрүүн би яриандаа бас хэлсэн. Ер нь энэ гэр хорооллын дахин төлөвлөлт дээр гацаж байгаа юм бол ерөөсөө л дулаан хангамжийн асуудал болчихоод байгаа юм. Тэгэхээр үүнийг нэг ЭХЯ-тай хамтраад хэсэгчилсэн дулаан хангамжийн шийдлүүдийг гаргаад явах уу гэдэг дээр л тохирох хэрэгтэй. Ер нь хүйтэн нөхцөлийн Скандинавын хойгийн орнууд нарыг ашиглачхаж байна. Тэгээд дулааны пампан насосыг ашиглаж байна, салхитай хослуулчхаж байна. Мөн газрын гүнд ингээд дулааны хуримтлуурын том байгууламжууд барьчихаж байгаа юм. Тэгээд нэг гол шийдэх ёстой юм бол ерөөсөө дулаан алдагдалгүй байшин барих л асуудал. Энэ бол харин манай яаманд хамаарна. Тийм учраас цаашидаа бид нар Барилгын тухай хууль шинэчилсэн найруулга энэ тэрийг оруулж ирээд мөн норм норматив шинэчлэхдээ бол нэг анхаарах юм бол барилгын дулаан алдагдлыг бууруулна. Ийм л байшин барьдаг болно. Тэгэхгүй бол манайд байгаа өнөөдрийн байшингууд бол ерөөсөө зүгээр л тэр үйлдвэрлэсэн дулааныг салхинд хийсгэжхээд байгаа байхгүй юу. Хэрвээ бид нар ингэж дулаан алдагдлыг бууруулж чадах юм бол одоо байгаа энэ дулааныхаа үйлдвэрлэлийн тэр 60 хувиас давчхаад байгаа хэрэглээг бол нөхөх боломж бол энэ дээр гарч ирнэ. Зөвхөн дулаан хэмнэлтийн аргаар бол бид нар гаргаж ирэх боломжтой. Тийм учраас энэ гэр хороололд тэр Жаргалмаа гишүүний яриад байгаа энэ ашиглагдахгүй байгаа барилгын асуудал энэ тэрийг бид нар бас гэр хорооллын энэ дахин төлөвлөлтийн хүрээнд инженерийн дэд бүтцийн шийдэх шийдлийн хүрээнд авч

үзье ээ гэж ингэж бодож байгаа. Тэгээд бид танд ойрын үед холбогдох яамдтай ярьсны дараа хариуг хүргүүлнэ ээ.

**Л.Мөнхбаатар:** Дараагийн асуултад нь Соёлын яам хариулъя. Соёлын яамны ТНБД-ын үүргийг орлон гүйцэтгэгч Энх-Амгалан хариулна. Нэг номерын микрофон өгөөрэй.

**Ч.Энх-Амгалан:** Байгалийн түүхийн музейн тендер сүүлийн 3 жилийн хугацаанд 9 удаа явагдсан. Тэгээд төсөвт өртөг багатай гэдгээр 93 тэрбум төгрөгөөр 7 удаа зарлагдсан. Төсөв 2023 оны төсөвт 138 тэрбум төгрөг болж зураг магадлагдсан. Үүний дагуу бол энэ оныг гараад 2 дахь удаагаа зарлагдаад байж байна. Тэгэхээр 4 сарын 05-нд энэ жилийнх нь дүн гарна. Тэгэхээр энэ ажил бол ингээд явахаар байгаа.

2 дахь нь номын сангийн барилга. Төв номын сангийн барилга өнөөдөр 80 гаруй хувьтай явж байгаа. Гүйцэтгэгч компанийн захирал нь сая нөгөө ковидоор бурхан болсонтой холбоотой 1 жилийн хугацаанд бас саатсан. Тэгэхээр энэ ажлыг бол бид нар энэ жил 9 сарын 01 гэхэд бүрэн оруулахаар Соёлын яамнаас ажиллаж байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** ЭМЯ-наас хариулъя. 2 номерын микрофон дээр очоод нэр албан тушаалаа хэлээд хариулаарай.

ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын даргын үүргийг түр гүйцэтгэгч Хонгорзул байна. Гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн зураг төсөл, ТЭЗҮ-г боловсруулсан, төсвийг шинэчлээд үүнийг хөрөнгийг шийдвэрлэх асуудлыг хөөцөлдөж байгаа. Зүрх судасны төвийн хүрээнд бол Зүрх судасны төв байгуулах ажлын хүрээнд бас зураг төсөв ТЭЗҮ нь бэлэн. Тэгээд 2022 оны 12 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар Японы Токиука групптэй Зүрх судасны

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

төв байгуулах ийм санамж бичигт гарын үсэг зурчихсан. Одоо энэ үйл ажиллагаанд хүлээж байна. Сүрьеэгийн эмнэлгийн барилга барих ажил худалдан авах ажиллагааны шатанд шүүхийн маргаан гарсан. Шүүхийн маргаан давж заалдах шатны шатанд явж байгаа. Энэ асуудал удахгүй шийдэгдэнгүүт дахин зарлах байх. Геронтологийн төвийн барилгыг бол одоо баригдаж байгаа барилгын асуудал нь мэргэжлийн байгууллага болон Үндэсний аудитын газрын дүгнэлтийн дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байгаа. Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд баригдаж байгаа 36 ортой эмнэлгийн барилгад Геронтологийн төвийг шилжүүлж оруулахаар барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж ажиллаж байна. 6 дугаар сард ашиглалтад оруулна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Ургийн гаж хөгжлийг эрт илрүүлэх энэ ажлын хүрээнд БНХАУ-ын Энхтайваны хөгжлийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр ЭХЭМҮТ-ийн хашаанд 2022 онд барилгыг нь бариад, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаад одоо үйл ажиллагаа нь эхэлж байна.

**Л.Мөнхбаатар:** Жаргалмаа гишүүн бас НХХЯ-аас асуулт асуусан. Өнөрбаяр дарга байгаа юу? Өнөрбаяр дарга хариулчихъя, 1 номерын микрофоныг өгье.

**Г.Өнөрбаяр:** 2022 онд бол нийт хүүхдэд хүүхдийн мөнгө 100000 төгрөгөөр өгсөн. Энд бол УИХ-аас бол 1.4 их наяд төгрөг бол батлагдсан. Энэ жил бол нийт хүүхдийн 91 хувьд буюу 1139200 хүүхдэд бол хүүхдийн мөнгө олгож байгаа. Энд бол УИХ-аас 1.3 их наяд төгрөг батлагдсан. Сүүлийн үед энэ энэ жил хүүхдийн мөнгийг өгөхдөө нийт өрхийн 91 хувьд олгохдоо ҮСХ, Нийгмийн даатгал, АТҮТ татвар, улсын бүртгэл гээд 5 байгууллагын төрд байгаа мэдээллийг ашиглаж, хүүхдийн мөнгө олгож байгаа. Гэсэн хэдий ч гэсэн үлдсэн

9 хувьд хамаарах хүүхдүүдэд өөрөөр хэлбэл хүүхдийн мөнгийг тэгш шударга өгөх санал хүсэлт бол ХНХЯ-нд олноор ярьж байгаа. Одоо өөрөөр хэлбэл үлдэж байгаа 9 хувьд бол 100 гаруй мянган хүүхэд байгаа. Энэ дээр холбогдох тооцоо судалгаанууд бол хийгдэж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууя. Тодруулах юм уу? Жаргалмаа гишүүн тодруулчихъя. Түүний дараа Доржханд гишүүн асууя.

**Б.Жаргалмаа:** Би яамныхаа, ЗГ-ын хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг бол ямар нэгэн байдлаар үгүйсгээгүй. Эрт илрүүлэг үр дүнтэй байгаа. Гэхдээ өвдсөн хойно эмчлэх биш бид нар өвдөхгүй байх, урьдчилан сэргийлэх тэр үйл ажиллагааг идэвхтэй явуулаач ээ гэдэг ийм саналыг бас маш ихээр хэлж байгаа шүү гэдгийг бас дахиад хэлье.

Ер нь зураг төсвийн ажлыг бид өөрсдөө юунаас болж алдаад байгааг бас нэг алдаагаа олоод хараасай. 2023 оны төсөв хэлэлцэгдэж байх тэр цаг мөчид аливаа барилгын гүйцэтгэлийг гүйцэд тийм ээ, барилгаа барья, ажлаа дуусгая гэдэг ийм саналыг маш ихээр тавьсан. 23 оны төсөвт тэр хэмжээгээр дутуу орхигдсон барилгуудаа дуусгая гэдэг ийм төсвийг баталж байсан. Дутуу орхигдсоноос болоод Геронтологийн үндэсний төвийн барилга 46 хувьтай, Арвис гэдэг компани өнөөдрийг хүртэл тэр барилга ашиглагдах боломжгүй болчихсон байгаа. Түүнтэй адилхан Байгалийн түүхийн музейн 25 хувьтай байгаа гүйцэтгэл чинь ашиглагдахаа болиод, улсын мөнгө үргүй хаягдах вий гэдэг ийм зүйлээр л би дахин дахин энэ дутуу орхигдсон барилгуудаа гүйцээгээч ээ гэдэг ийм зүйлийг ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад хэн хариулах вэ? Санал болчихлоо доо, ер нь

тийм ээ. Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууя.

**Т.Доржханд:** Би энэ төлөвлөгөөний биелэлтээс асуухгүй ээ. Яагаад тэгээд, тэгэхээр энэ төлөвлөгөө маань бодитой биш ээ. Түрүүн бас Нямаагийн Энхболд гишүүн хэлж байна. Тэгээд бид нар нөгөө ингээд худлаа төлөлт хийчхээд, түүнийхээ бас худлаа биелэлт хийгээд явмааргүй байна. Үүнийг маш энгийн жишээ гээд хэлэх юм бол 20-25 оны нийт төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр чинь 50 их наяд шүү дээ. Гэтэл өнөөдрийн байдлаар 2023 оны хөрөнгө оруулалтын зардал 2.6 их наяд, 2022 оных 2.2 их наяд, 2021 оных 1.6 их наяд гээд нийтдээ энэ сүүлийн 3 жилийн байдлаар 6.4 их наядын л хөрөнгө оруулалтын боломж байгаа юм. Цаад талд нь бол гадаадын хөрөнгө оруулалт байхгүй, дотоодын хөрөнгө оруулалт байхгүй. Тэгээд энэ байдлаараа цаашаагаа ингээд 2024, 25 он гээд явах юм бол дээд тал нь 10 их наядын л орон зай бай байгаа юм. 10 их наядын хөрөнгө оруулалтын орон зай байж байхад бид нар 50 их наядаар энэ төлөвлөгөөгөө баталчихсан байхгүй юу. Тэгэхээр чинь хэрэгжилт 20 хувиас их гарна гэж бол байхгүй шүү дээ. Нэг ганц нэг өм цөм нь л тэгж явахаас биш.

Тэгэхээр ингээд бид нарын төлөвлөлт чинь худлаа болчихоод байгаа юм. Тэгээд ийм зузаан цаас оруулж байж төлөвлөөд л, түүний үр дүн гээд л баахан хүмүүс суулгаад л тэгээд л тэрийгээ ингээд яриад, тэгээд энэ маань өөрөө ингээд бодитой биш байдлаар явж байгаа болохоор энэ нөгөө хэлэлцүүлэг маань бас ач холбогдол байна уу, үгүй байна уу? Тэгээд бид нар үүнийгээ бас эргэж харах нь зүйтэй байх.

Төлөвлөлт хэзээ бодитой болдог вэ гэхээр ард талд нь хөрөнгийнх нь эх үүсвэр батлагдсан тэр нь бодитой тохиолдолд явдаг юм шүү дээ. Гэтэл манай энэ төлөвлөгөөний ард чинь бодитой эх үүсвэр байхгүй байна, үсрээд

нэг 20 хувьд нь л байна. Тэгэхээр энэ худлаа цаас шүү. Тийм болохоор үүнийг Хөгжлийн яам шинээр байгуулагдсаных юу билээ. Энэ Хүрэлбаатар сайд энэ төлөвлөлт дээрээ бас анхааруулаад, цомхон болгох тал дээр бол оруулж ирэх нь зүйтэй байх. Тэгээд бодитой юм яриулж суугаад ярьж болж байна. Үгүй бол ийм бодитой биш юман дээр цаг алдмааргүй л байна шүү дээ. Үүнийг нэг ингээд хэлчихмээр байна.

2 асуулт байна. Энэ нэгдүгээр асуулт нь юу байна гээд тэгэхээр ханшины асуудал хүнд байгаа, долларын төгрөгтэй харьцах ханиш. Нөгөө талд нь инфляцын асуудал өндөр хэвээрээ байгаа. Тэгээд яг ийм тохиолдолд яах юм бэ? Америкт бол бодлогын хүүгээ өсгөөд л явж байна шүү дээ, 5% руу оруулж байна. Инфляц нь бууж өгөхгүй байна, санхүүгийн байдал нь хүнд байна гээд. Тэгээд дэлхий даяараа энэ долларын энэ үнэ цэн чинь ингээд өсөөд ирэх юм бол үүнийгээ дагаад хөрөнгө оруулалт чинь тийшээ татагдаад явчихна. Энд хөрөнгө оруулалт байхгүй. Үүнийгээ дагаад ханшаа бид нар бол алдана. Дэлхий даяар өсөж байгаа тохиолдолд, тэгээд ийм тохиолдолд бид нар инфляцаа яах билээ? Энэ дээр нөгөө Монголбанкнааа ингээд найдаад хаях гээд байна уу? Энэ дээрээ бодож байгаа зүйл байна уу, үгүй байна уу? Тэгээд ингээд бас нөгөө бизнесийн улирал эхэлж байгаатай холбоотойгоор ханшины асуудал дахиад сөхөгдөнө. Түрүүн Батжаргал гуай асууж байх шиг байна. Түүн дээр тодорхой хариулт бас гарч ирсэнгүй. Тэгэхээр 3.4 тэрбум долларын нөөц байгаа гэж байгаа ч гэлээ гэсэн энэ чинь бол яг өнөөдрийн байдлаар хангалттай биш шүү дээ. Импортын б сараас дээш байж байж л энэ чинь тогтвортой түвшиндээ очдог. Тэгэхээр яг энэ дээр яг ямар бодлого явах юм бэ гэдэг тэгээд нэг асуучихмаар байна.

Хоёрдугаарт, энэ Хөгжлийн банкны 500 сая долларын бондын эх үүсвэрийг оны сүүлд төлнө өө гээд Эдийн засгийн байнгын хороон дээр хэлсэн. Яг

ямар аргачлалаар яаж төлөх билээ. Төсөв дээр чинь мөнгө байхгүй. Тэгээд Хөгжлийн банканд эх үүсвэр байхгүй, гадаад орчин чинь ингээд цонх байхгүй болчихсон, гарч ирэх юм уу үгүй юм уу? Тэгээд яг энэ дээр та бүгд маань яг яаж харж байгаа юм бэ? Төлөвлөгөөгөө та нар нэг хэлээдхээч.

Гуравдугаарх нь, энэ цахим биржийн асуудал байна. Энэ дээр чинь борлуулалтаа хийж байгаа нь бол маш сайн. Гэхдээ эсрэг ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Доржханд гишүүний асуултад эхлээд Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар сайд хариулъя. Хэрвээ нэмж шаардлагатай гэвэл Сангийн яамнаас нэмж хариулж болно.

**Ч.Хүрэлбаатар:** Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 0.25 функтээр өсгөчхөж байна гэдэг чинь үндсэндээ долларын үнэ цэнийг улам л нэмээд байгаа юм. Энэ нь эргээд бид нарын хувьд бол бас яах вэ, тодорхой хэмжээний бодлогын эмх цэгцтэй байх байдлыг л улам л шаардаж байгаа юм. Тэгээд Батжаргал гишүүн асуусантай би тодорхой хариулсан. Ер нь ЗГ бол экспортоо нэмэх дээр л онцгойлж анхаарна. Импортыг бид нар юу гэдэг юм энэ боль, хорих, мөнгө өгөхгүй гэдэг ийм бодлого бол дэмий гэж үзэж байгаа юм. Тийм учраас бид нар экспортынхоо орлогыг л нэмэх юм бол сайн нэмж чадах юм бол энэ хүндрэлийн ар талд бол гарчихна гэдэг ийм бодлого барьж явж байгаа гэдгийг би дахиад хэлье. Гэхдээ үүнийгээ дагаад бодлогын хүү бууж болохгүй. Шаардлагатай бол дахиад нэмэх ёстой.

Төсвийн хувьд бодлогоо яаж зохицуулж явах ёстой вэ гэхээрээ нөгөө праЙмери баланс байдаг буюу бид нар орчуулахдаа үндсэн тэнцэл гээд байгаа. Үндсэн тэнцлийг дандаа нэмэх байлгаж авч явах ёстой, Сангийн яам. Тэгээд мөнгөний бодлогоо зөв хийгээд тэр

праЙмери балансаа нэмэх аваад яваад байхад бол энэ инфляцыг бол бид нар яг зохицуулдаг ном журмынх нь дагуу бодлогоор нь зохицуулаад явчих ийм л зүйл байгаа юм. Өөр нэг их илүү дутуу юм хэрэггүй болов уу гэсэн ийм бодолтой байгаа. Тэгээд энэ нэгэнт л энэ улс орнууд авч хэрэгжүүлж байгаа энэ арга замаараа явсан нь дээр байх гэж бодож байгаа.

Хөгжлийн банк. Хөгжлийн банкиЙг энэ евро бондоо өөрөө мөнгөө олж төл гэдэг ийм шаардлага л тавьж байгаа. Дотроо попорч олон юм ярьж, нэвтрүүлгүүдээр элдэв бус юм ярьж суухаар илүүтэйгээр тэр гадаадад бонд яаж олох вэ гэдэг юмаа тэр Хөгжлийн банк анхаарч ажиллах ёстой. Чадахгүй байгаа бол ажлаа өгөөд явж болно. Тэгэхээр Хөгжлийн банк өөрөө 500 сая тэр евро бондыг төлөх арга механизмаа хийж, гэрээ хэлцлүүдээ хийж явах ёстой. Тэгээд үүнийгээ хийж чадахгүй гэвэл Сангийн яамандаа хандана. Ийм л хандлагаар бид нарын байр суурь бол тодорхой байгаа. Одоо явж тэр бондоо босгох арга ажлуудыг хийлгэдэг ийм л юм байгаа.

**Л.Мөнхбаатар:** Доржханд гишүүн тодруулж асууя.

**Т.Доржханд:** Тэгэхээр Хөгжлийн сайд бол маш тодорхой хэлж байна. Тэр бодлогын хүүгээ бол бид нар буулгаж болохгүй өсгөнө өө, шаардлагатай бол гээд. Нөгөө тал чинь бизнес идэвхэжлээ, одоо ингээд хүүгээ бууруулья гээд нөгөө популизм явдаг юм шүү дээ. Тэгээд түүн дээр нь нөгөө Монголбанкныхан нь очоод буулгана гээд ингээд нөгөө эдийн засгийн онолоосоо зөрөөд явчихдаг юм болох вий. Тэгэхээр та бол энэ байр суурин дээр байгаа юм байна. Үүнийг нь би баталгаажуулж сануулж байна.

2 дахь нь, Хөгжлийн банк өөрөө төлнө өө гэж ярьж байна шүү дээ, өөрөө төлнө өө гээд. Төлж чадахгүй бол Сангийн яам руу шилжисж ирнэ ээ гээд.

Тэгэхээр энэ ийм байр суурьтай байгаа юм байна гээд.

Тэгэхээр дараагийн асуудал нь юу байна вэ гэхээр энэ цахим биржийн худалдаа бол сайн явж байгаа. Яагаад вэ гээд тэгэхээр энэ үнийн зөрөө маш өндөр байна. Гэхдээ буцаагаад энэ бол борлуулалтаа хийж чадахгүй юм байна, буцаая. Хуучин системээрээ явъя, худалдан авагч нэг хятад нөхрийгөө авчраад сайхан түүгээрээ ингээд яриад шийдчихдэг ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Бас тодорхой байр сууриа илэрхийлээч ээ гэж хэлж байгаа юм байна. Хүрэлбаатар Шадар сайд та энд нь хариулчихъя. Хүрэлбаатар сайдын микрофоныг өгье.

**Ч.Хүрэлбаатар:** ЗГ бол тогтоолоо гаргаад шийдчихсэн. Нүүрс бол биржээр цаашид байнга явна. Үүнийг буцаачих юм сан гэсэн бодолтой хүмүүс бий. Энэ танхим дотор ч бий. Буцахгүй. Монгол Улс газрын хөрсөн доорх баялгаа өрсөлдөөн оруулж, үнэ хүргэж, зарж явдаг энэ зүйл бол цаашидаа тогтмол явна. Тэгэхээр энэ дээр ерөөсөө эргэлзэх хэрэггүй, нүүрсээ хилийн үнээр зарна. Харин цаашидаа биржээр бид нар нэмээд зэсээ зарах ёстой, төмрийн хүдрээ зарах ёстой, жоншиоо зарах ёстой гээд бүх энэ газрын хөрсөн доороос гаргаж ирж байгаа энэ баялгуудыг бид нар биржээр зарж явах учиртай. Биржээр зарахаар юу болох вэ гэхээр тэнд чинь өрсөлдөөн бий болно. Дунд нь нэг аваад мөнгө аваад дамжуулаад байдаг даа биш яг эцсийн хэрэглэгч нар нь өөрсдөө ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Доржханд гишүүн яах юм? Ахиад 1 минут тодруулах юм уу? 1 минут тодруулж асууя.

**Т.Доржханд:** Харин тэгэхээр Хүрэлбаатар сайд аа, надад ирж байгаа мэдээллээр болохоор зарим танай ЗГ-ын гишүүд болоод зарим Их Хурлын гишүүд бол энэ бүтэхгүй юм байна, бирж чинь

бүтэхгүй юм байна, тийм болохоороо экспортынхоо орлогыг нэмэхийн тулд урагшаагаа нүүрсээ бол хуучин хэлбэрээр нь явуулдаг байя. Худалдан авагчтайгаа суугаад ярьдаг байя гэдэг ийм мэдээлэл ирээд байна. Тэгээд яг статистикийг нь аваад үзэх юм бол өнөөдрийн байдлаар 312000 тонн ийм нүүрсийг л биржээр гаргачхаад байна. Гэтэл та бүхэн чинь 32 сая тонныг гаргах ёстой байдаг. Энэ чинь нийт гаргах ёстой төлөвлөгөөнийхөө нэг хувьд байна, харж байна уу, ийм болохоор бүтэхгүй ээ гэдэг юм яриад байгаа байхгүй юу, сонсогдоод байна. Тэгэхээр энэ дээр хатуу байгаад шаардлагатай бол тэр гишүүдтэй нь бол ингээд ил болгох асуудлыг бас ярина шүү гэдгийг бас хэлчихмээр байна. Нэг.

Хоёрдугаарт, би танд хэллээ, үүнийгээ цомхон болгох тал дээр би нэг санал хэлье. Энэ дээр та нэг байр сууриа илэрхийлээдхээч. Энэ чинь үр дүн байхгүй байна, төлөвлөгөө чинь өөрөө бодь .../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Доржханд гишүүн бас тэр цомхон болгох талаар нь байр сууриа илэрхийлээч ээ, тодорхой арга замын талаар гэж байх шиг байна. Энд нь тодруулаад хариулчихъя. Хүрэлбаатар сайд. Шадар сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Бид нар биржээр цаашиа зарна. Энэ 30 жил хийгдээгүй, анх удаагаа хийж байгаа учраас бага сага зүйл дээр бид нар алдаж байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ цаашидаа бид нар дан тасралтгүй биржээр явна гэдгийг хэлье. Энэ дээр бол эргэлзэх зүйл байхгүй. Харин та тэр биржээр биш хуучных шиг гарын үсэг зураад, нүүрсээ заръя гэж яваад байгаа тэр гишүүд, сайд нарыгаа ил нэрийг нь хэлж өгөөрэй бас, мэдэж авах хэрэгтэй шүү дээ тэр. Дараа нь тэр нүүрсний хулгай гэж яригдаад байдаг, түүн дээр очиж давхар шалгагдах хэрэгтэй шүү дээ. Тэр хүмүүс бол. Өөрсдөө өргөдлөө өгөөд. Түүгээрээ цаашидаа. Ер нь энэ хөгжлийн төлөвлөгөөгөө бид нар нэг эргэж харж



үзэх юман дээр бол ажиллаж байгаа, ажиллаж байгаа. Тэгээд нэг хүслийн жагсаалт бол болгоод хувиргачихмааргүй байна. Эргээд хүн болгон түүнд нэг дур дурын юмаа оруулчихаад тэгээд дараа нь үүнийгээ хийж өг гэдэг ийм шахдаг ийм байдлаар биш бас бодлоготой, төлөвлөгөөтэй хийж үндсэн гол асуудлууд дээрээ фокус ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 67.5%, Аудит бол 60 хувь гэж байгаа. Үүнийгээ яг нарийвчлаад үзэх юм бол 60 хувь ч хүрэхгүй л юм байна. 2020-24 оны төлөвлөгөөний биелэлт өссөн дүнгээр 39% гэж байгаа. Бас яг нарийн үзэх юм бол 33, 4% ч юм уу, ийм л байна л даа. Тэгээд энэ төлөвлөлт маань бүтэлгүйтсэн байна. Төлөвлөлт бүтэлгүйтнэ гэдэг чинь бүтэлгүйтэл рүү л төлөвлөсөн гэсэн үг л дээ. Тэгээд ер нь яагаад ингээд байна гэхээр энэ эдийн засгаар баталгаажсаагүй ямар ч үйл ажиллагаа амь сүнсгүй байдаг юм. Бид нар энэ 30 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг нэг 15 тэрбум доллар, төсвийн орлого нэг 5 тэрбум доллар л байна шүү дээ. Маши их боломж байдаг. Тэгээд нэг ийм жижигхэн хайрцаг дотор яваад байдаг. Энэ цаашидаа яах юм бэ, ямар сургамж авч байгаа юм бэ. Ингээд яваад байх юм уу. Яг ийм байдлаар явах юм бол Монголын ард түмний амьдрал бол дээшлэхгүй. Монгол Улс хөгжихгүй. АХБ-ны гаргасан судалгаагаар ядуу улс гэж ингэж тооцож байна шүү дээ. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 10000 доллароос доош орох юм бол ядуу улс гэж үздэг болчихож, дэлхийд. Тийм учраас бодмоор юм байна. Үүнийг ингээд л мэдсэн ч мэдээгүй юм шиг ингээд яваад байж болохгүй шүү дээ. Нөгөө нохой хуцсан ч бараа дөрвөлжин л гэдэг шиг ингээд л үүнийг 1 жил болгон ингээд л яриад яваад байж болохгүй.

Үүнийг эрс шинэчлэл хийх ёстой. Энэ яг миний ойлгож байгаагаар энэ ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгэм байгуулах хамгийн муу загвар Монголд хэрэгжиж байгаа. Энэ эдийн засгийн үзүүлэлтүүд нь харуулж байна шүү дээ. Авлигал, хээл хахууль нь гаарчихсан, хулгай гаарчихсан, баялгийн тэгш бус хуваарилалт өссөн, баян хоосны ядуу дээд цэгтээ тулчихсан, ядуурал 42% болчихсон, гэмт хэргийн өсөлт асар их хэмжээнд болчихсон. Богино өөлчлөгч санхүү эдийн засгийн хямрал байнга болчихсон, өрийн хямрал үүсчихсэн. Ингээд энэ хөгжлийн мухардалд орчихсон. Үүнийг юу гэж үздэг вэ гэхээрээ чөтгөрийн тойрогт орсон гэж үздэг. Монгол Улс чөтгөрийн тойрогт орчихсон хөгжлийн. Үүнээс гарахын тулд 10-20 жил хэрэгтэй. Үүнийг яах юм.

Гадаад худалдаа 3.8 тэрбум долларын ашигтай ажил гараад байдаг. Гэтэл төлбөрийн тэнцэл нь санхүүгийнхээ дансны алдагдалаар нөхөөд 728 сая долларын алдагдалтай, энэ валют орж ирэхгүй байна шүү дээ. Яаж оруулж ирдэг болох юм? Өрхийн орлого 0.7 хувиар буурчихсан, энэ чинь ДНБ-ний өсөлтийн гол тэтгэгч байдаг юм чинь өрхийн орлого шүү дээ, үүнийг яах юм. Бүтээмж гэдэг юм ерөөсөө ярьдаггүй, цалин хөлс нэмнэ гээд байдаг, бүтээмжээ нэмж байж цалин хөлс нэмнэ шүү дээ. Тэр үед тэр яах юм түүнийгээ.

Энэ хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлт гээд бас нэг үзүүлэлт байдаг юм. Энэ ийм юмнуудыг ерөөсөө ярихгүй. 9.1 байсан 21 онд, 23 онд үүнийг 9.3 гээд, ерөөсөө буурахгүй. Үгүй ээ ийм л юм л яваад л байна л даа. Тэгээд ямар сургамж авах юм, яах юм энэ дээр ямар арга хэмжээнүүдийг авах юм, яаж эдийн засгийн реформыг хийх юм, үүнийгээ бол тодорхой. Хөгжлийн яам байгуулагдсан энэ юмаа тодорхой яримаар байна. Монголын ард түмэнд ил тод ярих хэрэгтэй.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Дараагийн асуудал юу гэхээр энэ болзошгүй аюулын асуудал байгаа шүү. ЗГ юу гэж тооцож байгаа юм. Энэ газар хөдлөлийн аюул. Зөвхөн он гарснаас хойш 300 удаа чичирхийлэл мэдрэгдчихээд байна шүү дээ. Тэр Жайкагийн гаргасан айхтар судалгаа байдаг юм байна лээ шүү. Ямар үүнийг арга хэмжээ авах юм энэ, юу хийх гэж байна, юу бодож байна. Энэ чинь бид нарын нүдэн дээр янз бүрийн асуудал их болж байна шүү дээ. Энэ дээр ямар арга хэмжээ авах гэж байна. Ийм асуу ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүний асуултад Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Монголд бүтэхгүй юм бий бий. Бас энэ хил үндсэндээ хаалттай корона гээд 2 жил бүх юмаа хаагаад бид нар бас амьдарч үзлээ. Тэгээд энэ дээрээс нэг л том сургамж гарч ирж байгаа. Бүр улсаараа хаагаад үзэхэд ер нь юмыг хааж хорьж бол дэмий юм байна шүү гэдэг ийм маш энгийн сургамжийг бол Монголчуудад өгсөн. Ямар нэгэн бизнесийн юмыг ч гэсэн бид нар хааж, боож бол тэгээд хааж, боосноор хөгждөггүй ээ гэдгийг бас харуулж байгаа юм.

Арьс ширний экспортыг хаагаад л арьс ширний үйлдвэрүүд зүгээр мөөг шиг ингээд л ургаад гараад ирнэ гэж яриад л 10 жил өнгөрсөн чинь байхгүй. Нөгөө арьс шир нь хог болоод л малчдынх нь орлого унаад л ийм л байдалтай. Энэ дээрээс юу харуулж байна вэ гэхээр ямар нэгэн юмыг хааж боож, боодог ч юм уу, хязгаарласнаар улс орон нь хөгждөггүй, тухайн салбар хөгждөггүй гэдгийг л бидэнд бол бид нарын яс махан дээр ойлгуулж өглөө. Тэгээд бас энэ өнгөрсөн хугацаан дээрээс алдсан зүйл бол бий бий. Монгол Улсын хувьд. Улс төрийн хүчнүүдийн хувьд ч тэр, бид нарын хувьд ч тэр, алдаа бол байгаа. Гэхдээ би бол Монгол Улсынхаа ирээдүйд хөгжил дэвшилд бол итгэж явдаг, сайхан болно

гэж бодож явдаг, болгохын тулд алдаатай зүйл болгоныг л бид нар засах гэж хичээх хэрэгтэй. Нэг зүйл буруу болчихлоо энэ газрынхаа баялгийг бид нар буруу зараад байна, энэ дээр асуудал үүсээд байна гээд ийм юм байвал бүгдээрээ нийлээд л засаад яваад баймаар байгаа юм. Түүнээс биш энэ асуудлуудыг буруу юмыг засах гээд оролдохоор нэг мөнгөтэй хүмүүсийн гар хөл болж хэдэн хүн нь нөгөө хийх гэж байгаа хүмүүс рүүгээ дайрдаг нэг балиар зангуудаа бид нар тал талдаа зогсоогоод, буруу юмаа л засаад яваад байх юм бол бид нар энэ Монгол Улс дорхноо сэргэчихнэ шүү дээ.

Өнгөрсөн жилийн 9 сард макро эдийн засаг тийм бас амар байгаагүй шүү дээ. Тэгээд л бүгдээрээ Их Хурал нь дэмжээд л, бүгдээрээ нийлээд л, ингэхэд засаад л, зөв горьдол руу нь ороод л дорхноо л үр дүн нь гараад эхэлчээж байгаа юм. Тэгэхээр эрүүл мэндийн салбар дээр, эдийн засгийн салбар дээр, банк санхүүгийн салбар дээр, төрийн өмчийн ААН дээр байгаа алдаануудаа гэх мэтээр бид нар ингээд л хүн болгон л юм хум нэг нэг юмаа ингээд засаад яваад байхад энэ Монгол Улсын эдийн засаг ер нь хэвэндээ орчихно доо, зөв болно. Тэгэхээр хүн болгон л өөрсдөө хичээчихмээр байгаа юм. Тал талдаа. Тэрийг би бол хичээх үүрэгтэй хүмүүс нь ялангуяа би энэ төр, ЗГ, энэ төрд ажиллаж байгаа хариуцлагатай албан тушаал хийж байгаа хүмүүс бол илүү санаачилгатай ажиллах ёстой. Элдэв бусын хэл амнаас, дайралт доромжлолоос няцахгүйгээр өмнөө тулгамдсан ажлуудаа л зөв хийгээд байхад болж байгаа юм.

Махны экспортыг аваад үзье л дээ. Болорчулуун сайд ирээд л тэр квот гээд ямар шаардлагатай тэр квот олгодог байсан юм, тэрийг хэрэггүй гээд л хэлчхэнгүүт энэ салбар дээр маш том асар том дэвшил гараад л эхэлж байна шүү дээ. Нэгхэн жижигхэн өгүүлбэр л засаж байгаа шүү дээ. Ийм зүйлийг л хүн болгон салбар салбартаа хийчихвэл эдийн засаг сэргэнэ ээ. Би бол Баттөмөр

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

гишүүнийг ойлгож байна. Санаа зовж олон зүйл хэлдэг. Тэгэхээр бид нар ингээд л нэг нэгээр зүйлийг л засаад яваад байхад бол болчихно оо. Би бол Монгол Улсынхаа ирээдүй хөгжил дэвшилд бол итгэдэг, Монголчууддаа итгэдэг. Тийм учраас би сайхан болно гэдэгт бол итгэж явдаг.

**Л.Мөнхбаатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн маань ахиж юу яах юм уу, тодруулж асуух юм уу та? тодруулж асууя, Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Ингээд энэ хөгжлийн яам байгуулагдаад Хүрэлбаатар сайд ажиллаж байгаа. Ер нь энэ яамнаас маш их том их хүлээлт байгаа. Миний хэлэх гэж байгаа юм бол өнөөдрийг хүртэл хөгжиж ирсэн энэ хөгжлийн загварынхаа юмнуудыг үзээч ээ, хөгжлийн бодлогоо шинэчлээч ээ гэсэн ийм юутай бол сайд санал нэг байгаа юм байна.

Энэ өнгөрсөн жил нэг гарсан нэг зэрэг үзүүлэлт бол юу гэхээр энэ банкны бус салбар энэ зах зээлийн үнэлгээ 25.7 хувиар өссөн байгаа. Монгол Улсад нэг 20 компани IPO хийж байгаа юм. Үүний 12-ыг нь ингээд аваад үзэхээр зэрэг үндсэндээ Монголын төсөвт ордог орлого 4.5 дахин өссөн байгаа. Тэгээд цаашидаа бид нар бол юу гэхээр энэ IPO хийх энэ үйл ажиллагааг дэмждэг, татварын бодлогоор дэмждэг, төрийн бодлогоор дэмждэг ийм үйл ажиллагааг явуулж өгвөл энэ Монголын хөгжилд бол их том хувь нэмэр болох нь ээ. Жишээлбэл энэ Инвескор бүрэн бус хариуцлагатай компани гээд энэ байна л даа. Тэгсэн 1.1 их наяд ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг үг хэлэхээр асуулт асуухаар нэрээ ирүүлсэн байна. Гэхдээ өнөөдөр бол үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн биелэлт, ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, түүний тайланг хэлэлцэж байгаа. Тийм болохоор сайд нар сайд нараасаа асуух нь зохимжгүй ээ. Тийм учраас Чинзориг

сайд, Бямбацогт сайд, Бат-Эрдэнэ сайд нарын нэрсийг хаслаа.

Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Монгол Улсын ЗГ 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө хүний хөгжлийн нэгдсэн бодлоготой болно гэсэн ийм зорилт тавьсан. Эдийн засгийн хөгжлийн яам шинээр байгуулагдаж байх үед эдийн засаг таслал тавиад хүний хөгжлийн яам байгуулах талаар миний одоо би санал дэвшүүлж байсан боловч энэ дэмжигдээгүй. Шинээр үүсэн байгуулагдсан Эдийн засгийн хөгжлийн яаманд Монгол Улсын хүний хөгжлийн нэгдсэн бодлогоор хангана гэдэг чиг үүрэг орсон. Тэгэхээр Хүрэлбаатар сайдаас асууя. Энэ хүний хөгжлийн бодлогыг боловсруулахад ямар ажил өнөөдрийг хүртэл хийгдэж байна вэ? Судалгаа өнөөдрийн хэрэгжиж байгаа хууль, эрх зүй, хөгжлийн бодлогодоо үнэлгээ дүгнэлтээ хийж байгаа юу? Энэ дээр нэг хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт, энэ хүний хөгжил хэсэгт Монгол хүний удмын сан, зорилт 2.7.2 цус ойртолтоос сэргийлж удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг нэмэгдүүлэхэд 1.5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан ба хэрэгжилт нь 50 хувиар ингээд үнэлэгдээд явчихсан байна. Тэгэхээр ургийн гажиг илрүүлэх, хромосомын өвчнийг жирэмслэлтийн эрт үед нь оношлох, судалгаа хийх тоног төхөөрөмжтэй болсон нь бол сайн хэрэг ээ. Гэхдээ цус ойртолтын нарийвчилсан судалгааг бүс нутгаараа гаргасан уу? Энэ цус ойртолт гэдэг асуудал бол Монгол Улсын өнцөг булан бүрд бол бараг гамигийн хэмжээнд хүрч байгаа гэж хэлэхэд бол хилсдэхгүй байх. Энэ талаар судалгаа шинжилгээ хийж байгаа хүмүүс нь бол үнэхээр санаа зовж ярьж байгаа. Монгол хүний удмын санг хамгаалах нарийн бодлогоо тодорхойлж төлөвлөгөө

гаргаж байгаа юм уу? Иргэддээ сануулах, ойлгуулах, соён гэгээрүүлэх мэдээллийн ажлаа хийж чадаж байгаа юм уу? тоног төхөөрөмж авах гээд гэдэг бол нэг хэрэг боловч урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх тийм ээ, гэрлэсний дараа ингээд цус ойртсоны дараа шинжлэх биш гэрлэхээс нь өмнө энэ залуу хүмүүсийг энэ аюул бэрхшээлээс урьдчилан сэргийлж хамгаалах энэ ажил хэр хийгдэж байгаа юм бэ гэсэн ийм асуудал байна.

Зорилт 4.2.15 дээр ЗТЯ хариулах байх. Энэ Арцсуурь боомтыг нэм Нөмрөг сумтай Улиастай хотыг Алтай хоттой холбосон авто замуудыг барих ажлын хэрэгжилт хангалтгүй байгаад байна. Энэ жил хэдийгээр хөрөнгө оруулалтын асуудлыг зогсоосон боловч энэ АХБ-ны төслийн хүрээнд хийгдэх ажил хэзээ эхлэх юм бэ гэдэг энэ асуултад хариулт өгөөч?

БСШУЯ-наас энэ 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бүх цэцэрлэг сургуулийг дуу хөгжмийн хичээл, биеийн тамирын хичээлийн хэрэгслээр бүрэн хангана гэдэг зорилт тавигдсан. Энэ зорилт өнөөдөр хэдий ямар хэмжээтэй явагдаж байгаа юм бэ?

ЭМЯ-наас асуулт байна. Энэ 20-24 онд мөн Монгол Улсынхаа бүх иргэдийг эрүүл мэндийн боловсрол олгож, зохистой хөдөлгөөн энэ таргалалтаас урьдчилан сэргийлэх, хавдрын бус халдварт бус өвчнөөр өвдүүлэхгүй байх тал дээр дорвитой арга хэмжээ авна гэсэн. Одоогийн байдлаар өөрсдийнхөө ажлыг 90 хувьтай гээд дүгнээд 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн гээд байна. Би энэ дээр энэ эрт илрүүлгийн шинжилгээ гэдгээ урьдчилан сэргийлэх ажил гэж ойлгоод байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа. Эрт илрүүлэг гэдэг бол тэртээ тэргүй энэ өвчтэй хүмүүс рүүгээ анхаараад санхүүжилтийнх нь энэ салбарт тавьсан бүхий л төсөв ийшээ явж байгаа. Гэтэл ЭМД-ын сангаасаа 60 тэрбум төгрөг аваад ингээд эрт илрүүлэг гээд яриад яваад байгаа. Яг өнөөдрийн байдлаар энэ таргалалтын эсрэг ямар

хоол бид нар идэх ёстой юм, яаж хөдлөх ёстой юм. Энэ 25-37 насны залуучуудад хүртэл таргалалт 2.5 дахин ихэсчихсэн, хүүхдүүдийн таргалалт ДЭМБ-аас 7 дахин ихэсчихсэн гээд байгаа үед ЭМЯ яагаад энэ соён гэгээрүүлэх ард түмнийг энэ тал руу чиглүүлэх ажлаа хийхгүй байгаа юм бэ? Энэ асуудлууд дээр хариулт авъя, тэгээд тодруулъя. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Баярсайхан гишүүний асуултад Шадар сайд Хүрэлбаатар сайд хариулъя. Дараа нь ЗТХ-ийн сайд, Боловсролын яам, ЭМЯ-ны холбогдох төлөөлөл асуултад хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** ЗГ-ын тухай хууль дээр бол хүний хөгжлийн нэгдсэн бодлогыг хангах гэдэг үүрэг бол Эдийн засаг, хөгжлийн яам дээр байдаг. Тэгэхээр ер нь хүний хөгжлийн асуудлыг бол энэ бодлого төлөвлөлтдөө Эдийн засаг, хөгжлийн яам бол анхаарч ажиллаж байгаа. Яаж Монгол хүнээ ажилтай, төрөлтэй байлгах вэ. Мэдээж боловсролтой эрүүл хүмүүс байж байж ажил төрөлтэй байна, орлоготой байна, үр хүүхдүүдээ бас аятайхан аваад явчих боломж нь бол бүрдэнэ. Тийм учраас энэ чиглэлээр нэгдсэн бодлогоороо бид нар авч явах юм байна лээ. Тэгээд боловсролын салбар дээр юун дээр илүү анхаарч явж байна вэ гэвэл мэдээж Боловсролын яам байна. Тэр бодлогоо бас хариуцан явахаас гадна одоо Хөгжлийн яам бол ямар илүү мэргэжил нь Монголд дутуу байна вэ, ямар мэргэжил эзэмшвэл тэр хүн дараа сургуулиа төгссөний дараа ажилтай төрөлтэй болж болох уу, ямар мэргэжил нь юу гэдэг юм боловсрол юу авсны дараагаар ямар мэргэжлээр ажиллах илүүдэлтэй байна вэ гэдгээ гаргаж Боловсролын яамандаа нэгдүгээрт нь өгдөг.

Дээр нь эдийн засгийн хөгжлийг сайн хангаж чадвал, хувийн хэвшлийг сайн хангаж чадаж өсөлтийг хангаж чадах юм бол хүмүүс чинь ажилтай төрөлтэй байна. Үүнээс гадна хүн болгон дээд

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

мэргэжил эзэмшээд байхгүй, яг нарийн мэргэжсэн мэргэжлийн дадлагыг бол нэлээд сурах ёстой. Тэгэхээр нөгөө МСҮТ-ийн боловсрол бол нэлээд тийм хүчтэй орж ирж өгөх ёстой гэж ойлгож байгаа. Одоо 10 жилийн боловсрол дээр нэлээд анхаарал тавилаа. Их, дээд сургуулийн боловсрол дээрээ анхаарал тавьсан бол одоо МСҮТ буюу яг нарийн мэргэжлийг олгодог тэр боловсролын тогтолцоог нэлээн илүү хүчтэй болгох ёстой гэж үзэж явж байгаа.

Эрүүл мэндийн салбар дээр санхүүжилтийн тогтолцооноосоо гадна тэр эм яаж хямдхан, тэгсэн мөртөө сайн чанарын эм нийтэд нь очих вэ гэдэг тэр бодлогын асуудлуудыг анхаарах зэргээр Эдийн засаг, хөгжлийн яам жилийн төлөвлөгөөнд ийм бодлогуудаа томъёолж орж ирэхээр бол ажиллаж байгаа, Баярсайхан гишүүн ээ. Бас дөнгөж байгуулагдаад бас алдаа оноотой дунд ингээд л явж байна. Туршилага сураад явж байна. Ер нь бол Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсан нь их зөв яам болжээ. Энэ бодлогынхоо энд тэнд байгаа алдаатай зүйлээ хараад, засаад, олж байгаа ололтуудаа улам дэмжээд, зөв юм явж байгаа бүгдээрээ урам өгч явдаг ийм л юм байж байж Монгол Улс хөгжих ёстой.

Тэгээд тэр Монгол Улсын хөгжлийн төв нь бол хүн байгаа гэдэг дээрээ бол итгэж байгаа. Энэ чиглэлээр бодлогоо бол нэгдэж гаргаж дээр анхаарал тавьж ажиллаж байгаа Баярсайхан гишүүн ээ.

**Л.Мөнхбаатар:** Баярсайхан гишүүний дараагийн асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогт хариулъя.

**С.Бямбацогт:** Тэр Алтай-Улиастай чиглэлийн зам, Ховд-Улаангом чиглэлийн зам АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр барих гэж байгаа. Ерөнхийдөө Сангийн яам дээр үндсэндээ бичиг баримт нь хүлээгдэж байгаа. Сангийн

яам бас АХБ-тай санамж бичгээ байгуулсан.

Тун удахгүй УИХ-аар үүнийг оруулах ёстой, энэ орчих юм бол энэ жилдээ багтаагаад бид нар ажлаа эхлүүлэхэд бол бид хийчихнэ ээ. Ер нь бол зураг төсөв хийгдсэн. Үндсэндээ Их Хурлаар нэг соёрхон батлуулаад л, тендерээ зарлаад, сонгон шалгаруулалтаа зарлаад, барилгын ажлаа эхлүүлэх ийм бас бололцоотой болсон байгаа. Аль болох хурдан эхлүүлэх ийм бодлого барьж байгаа.

Арцсуурь, Нөмрөг чиглэлийн зам шинэ сэргэлтийн бодлогод туссан байгаа. Шинэ сэргэлтийн бодлогод үндсэндээ 54 зорилтот арга арга хэмжээ тусгаснаас үүнийг 40 гаруй нь үүнийг манай яамтай холбоотой. Гэхдээ бид нар бол боомтын чиглэлийн замуудыг аль болох ТЭЗҮ-гээ хийнэ. Гэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд энэ замуудыг барьж байгуулах ийм бодлого барьж байгаа. Яагаад гэвэл улсын төсөвт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийх мөнгө алга. 2023 онд нэг ч шинэ хөрөнгө оруулалтын ажил хийгдэхгүй байгаа.

Мөн өнгөрсөн 22 оны төлөвлөгөө дээр гэхэд чинь түрүүн би хэлсэн шүү дээ. Төлөвлөгөө дээрээ 3.2 их наяд төгрөгийн ажлууд хий гээд төлөвлөгөө батлаад өгчихсөн. Их Хурлаас. Дараа нь хавар нь, намар нь төсөв баталж өгөхдөө 250 тэрбум төгрөг баталж өгсөн. Тэгээд төлөвлөгөө дээр 3.2 их наядын ажил хий гэххээд хийх санхүүжилтийн эх үүсвэр нь 250 тэрбум буюу 10 гаруй дахин бага байхаар чинь нөгөө төлөвлөгөөний гүйцэтгэл төлөвлөгөөний биелэлт чинь маш бага гарч байгаа юм. Тийм болохоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд боомтуудад чиглэсэн замууд, одоо тэр Нөмрөгөөс Арцсуурь боомт чиглэсэн зам байгаа. Одоо бид нар бас Ховдын Булган, Үенчээс Байтагийн чиглэл зам гээд барьж байна. Сүхбаатар аймгаас Бичигтийн чиглэлд авто зам бас барьж байгаа. Ингээд олон зам байгаа.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Энэ замуудыг бол үндсэндээ төр, хувийн хэвилийн түншилэлийн хүрээнд барьж байгуулах ийм л бодлого, зорилт барьж ажиллаж байгаа. ТЭЗҮ-ийг бол энэ жилдээ хийхээр ажиллаж ажиллаж байна.

**Л.Мөнхбаатар:** Баярсайхан гишүүний 3 дахь асуултад БШУЯ-ны ТНБД Лхагвын Цэдэвсүрэн хариулъя. 1 номерын микрофон өгөөрэй.

**Л.Цэдэвсүрэн:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт СӨБ, ЕБС-ийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж түүндээ нийцүүлсэн шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангана гэсэн ийм үйл ажиллагаа тусгагдсан. 2014 онд цэцэрлэг, ЕБС-ийн сургалтын агуулга хөтөлбөр шинэчлэгдэж батлагдсан 14, 15, 16 онд ингээд дараалаад. Циклийнхээ хувьд бол 2024 оноос эхлээд бид нар энэ сургалтын агуулга хөтөлбөрийг бас шинэчлэх ёстой. Үүний бэлтгэл ажил болгож Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр олон төрлийн судалгааны ажлууд бол хийгдээд, сургалтын хөтөлбөр агуулгын шинэчлэл эхэлж байна. Өнгөрсөн онд 2022 онд бид нар улсын төсвийн хөрөнгөөр СӨБ буюу цэцэрлэгт 320 сая, ЕБС-д 320 сая төгрөгөөр хөгжмийн хичээлийн шаардлага хангасан техник тоног төхөөрөмжийг худалдаж авч, сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлсэн байгаа.

ЕБС-ийн спорт зааланд шаардлагатай техник тоног төхөөрөмжийг 650 сая төгрөгөөр авч нийлүүлсэн. Мэдээж энэ нь бол өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа 1400 гаруй цэцэрлэг, 800 гаруй сургуульд бол хангалттай бус нь тодорхой. Гэхдээ 2023 оны төсөвт бас салбарын хөрөнгө оруулалт дээр тусгагдсан зардлаасаа тодорхой хэмжээний төсвийг бас яг энэ үйл ажиллагаанд зарцуулахаар ингээд баталсан байгаа. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шаардлагатай гэвэл танд бас өгч болно.

Ганцхан улсын төсвийн хөрөнгийг бас манай яам болон ЗГ-ын зүгээс шүтээд ажиллаад байдаггүй. Бид нар ЗГ-ын болон яам хооронд байгуулсан энэ олон улсын хөтөлбөр, төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг бол үе шаттай зохион байгуулж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуултаа асууя. Өнөрболор гишүүн асуултаа асуучихъя.

**Д.Өнөрболор:** 22 оны төлөвлөгөөний хэрэгжилт 60.1 хувьтай, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт бол 39 хувьтай явж байгаа юм байна. Аудит бол үр дүнд хүрээгүй ээ гэсэн ийм дүгнэлт өгсөн байгаа юм байна. 22 онд 11.7 их наяд төгрөгөөр 300 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа юм байна. Үүнээс үр дүнгүй 59 арга хэмжээнд 510 тэрбум төгрөг, эрчимжүүлэх шаардлагатай 88 арга хэмжээнд 1.3 их наяд төгрөг зарцуулсан байна. Тэгээд энэ үр дүнгүй арга хэмжээнд зарцуулж байгаа мөнгөн дүнгийн талаар бас жоохон ойлгомжгүй асуудал байгаад байна. Энэ дээр бас тайлбар хэлж өгөөч ээ гэж хүсье. Тэгээд энэ эрчимжүүлэх шаардлагатай үр дүнгүй гээд байгаа энэ асуудлуудыг үндсэндээ нэг задлаад харах юм бол хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого мөн засаглалын бодлогуудын хэрэгжилт бол хангалтгүй байна гэж үзсэн байна л даа. Тэгээд энэ яг цар тахал болон энэ дайн бүхий нөхцөл байдлаас бусдаар яг ямар шалтгаан байна вэ? Яагаад ийм хангалтгүй үр дүнд хүрэх шалтгаан болов оо гэдгийг бас тайлбар сонсьё.

Энэ хөгжлийн төлөвлөлтийг бид нар бас оновчтой хийж чадаж байна уу? Энэ тайлангаас харахад 20 орчим хувь нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөртэй жоохон уялдаа муу байдалтай ингээд харагдаж байна. Тэгэхээр энэ төлөвлөлт дээр энэ салбарын яамнууд нэгдсэн төлөвлөлт хийж байгаа яам нэн ялангуяа

Хүрэлбаатар сайд, Амарбаясгалан сайд нар бол бас анхаарлаа хандуулна гэж бас бодож байна.

Тэгэхээр бид ер нь ингээд нэг ийм зах зээлийн эдийн засагт шилжсэн гээд байгаа болов ч ер нь ингээд хуулийн хугацаатай байгаа болохоор ер нь тооны хойноос хөөцөлдсөн зөвхөн үнэлгээгээ гайгүй авахын тулд л бид нар бас ингэж тайлан тайлагнадаг байж бас болохгүй ээ гэдгийг энэ цаг хугацаа бол харуулж байна. Тийм учраас бол бид үр дүнд чиглэсэн юм алдаа оноогоо бодитоор хардаг тал дээр бол ЗГ-т анхаарлаа хандуулах байх гэж бас найдаж байна.

Ялангуяа энэ эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд энэ худалдааны хууль маш чухал хууль байгаа. Миний бие УИХ-ын даргын захирамжаар Худалдааг дэмжих тухай хуулийг бас энэ УИХ дээр ахлаад бол ажиллаж байгаа. Манай ажлын хэсэг бол нэлээдгүй хугацаанд энэ олон улсын судалгаан дээр ажилласан байж байгаа. Монгол Улсад бас энэ анх удаа Худалдааг дэмжих тухай хуулийг боловсруулж байгаатай холбогдуулаад бол валютын урсгалыг нэмэгдүүлэх, экспортын зах зээлийг нэмэгдүүлэх, иргэн аж ахуйд өргөн боломж бий болгох талаасаа ч аваад үзсэн. Мөн эдийн засгийн эрх зүйн шинэтгэл талаасаа ч аваад үзсэн маш эерэг ийм ач холбогдолтой хууль болно. Тийм учраас Хүрэлбаатар сайдтай ч бас энэ талаар санал солилцож байгаа. Энэ тал дээр бас онцгойлон анхаарлаа хандуулах байх гэж бол найдаж байна. Хүрэлбаатар сайдыг. Бас таны байр суурийг сонсьё гэж бодож байна.

Дараа нь энэ засаглалын бодлого дотроос энэ ёс зүй болон сахилгын зөрчлийн талаарх нэгдсэн бүртгэлийн систем бий болгох ажил хэрэгжээгүй байна. Энэ бол маш чухал ажил. Би саяхан үүнийг энэ тойргийн иргэдтэйгээ бас нэлээн их уулзалт хийж байгаад ярилцаж байхад ер нь ард иргэд энэ хоол хүнсээр бид өлсөөгүй байна, харин ёс зүй,

хариуцлага, шударга ёсоор бас дэндүү өлсөж байна гэдэг асуудлыг нэлээн хатуу шүүмжилж ярьж байгаа. Тэгэхээр энэ албан тушаалтны ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг бас ил тод бид нар нээлттэй мэдээлдэг баймаар байна. Дүн шинжилгээ хийж бас тодорхой арга хэмжээнүүдийг авдаг байх ёстой юм болов уу гэсэн бас ийм асуудлуудыг бас хэлье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Өнөрболор гишүүн маань ер нь хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ерөнхийдөө байр сууриа илэрхийлчих шиг боллоо. Гэхдээ нэмж хариулах юм уу, ажлын хэсгээс. Хүрэлбаатар сайд Шадар сайд асуултад хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Өнөрболор гишүүний хэлсэн бүх зүйлтэй бол санал нэг байгаа. Худалдааны хууль дээр бол Өнөрболд гишүүнтэй ярьж байгаа. Тэгээд манай яам нөгөө ЗГ-ын тухай хуулиараа гадаад худалдааны бодлогыг бол хариуцдаг учраас Худалдааны хууль дээр бол хамтраад ажиллая гээд үүнийг ойлголцсон байгаа. Тэгээд хэлж ярьж байгаа зүйлтэй нь бүгдтэй нь санал нэг байна, дэмжиж байна, тийм ч болоосой гэж хүсэж байна, бас.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцлээ.

16.56 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.  
Дараагийн асуудал.

**Женев хотноо 1958 онд баталсан дугуй, тээврийн хэрэгслүүд тэдгээрт**

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

*суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн үндэстний байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. ЗГ 2023 оны нэгдүгээр сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн. Соёрхон батлах асуудал байна. Төслийг хэлэлцье.*

*Хууль санаачлагчийн илтгэлийг Зам тээврийн, хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.*

**С.Бямбацогт:** УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улс 1993 оноос эхлэн авто тээврийн гадаад харилцааг өргөжүүлэн, өнөөдрийн байдлаар 7 улс олон улсын 7 гэрээг соёрхон баталж ЗГ хоорондын хэлэлцээрийг 12 улстай байгуулан олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагааг явуулж байна.

Сүүлийн жилүүдэд тус яамны зүгээс олон улсын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, авто тээврийн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсад мөрдөгдөж буй эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх, тээвэрчдийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд олон улсын тээврийн гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудалд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын олон улсын тээвэрлэлтийн гэрээ хэлэлцээрийн нэг болох Женев хотноо 1958 онд батлагдсан дугуйт тээврийн хэрэгслүүд тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх тухай нөхцөлийн тухай хэлэлцээрт нэгдэхээр хэлэлцээрийг соёрхон батлах тухай

*хуулийн төслийг боловсруулсныг Монгол Улсын ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд, УИХ-д өргөн мэдүүлэх тухай ЗГ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 61 дүгээр тэмдэглэл гарсан.*

Монгол Улсын ЗГ-аас хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Уг хэлэлцээрт нэгдэн орсноор тээврийн хэрэгсэл түүний эд ангийн үйлдвэрлэл болон ашиглалт, аюулгүй байдлын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлнэ. Тээврийн хэрэгсэл түүний эд ангийг олон улсад мөрдөгдөж буй хийцийн аюулгүй байдал болон ашиглалтын техникийн дүрмүүдийн дагуу үйлдвэрлэж улмаар экспортлох боломж үүснэ. Монгол Улсад үйлдвэрлэсэн тээврийн хэрэгсэл түүний эд ангийг хэлэлцээрийн хэлэлцэн тохирох талууд ажиглагч болон зөвлөх гишүүнчлэлтэй орнууд бүрэн хүлээн зөвшөөрнө. Бусад оронд үйлдвэрлэсэн тээврийн хэрэгсэл, эд ангийг өөрийн улсад ашиглах нөхцөлийг хөнгөвчлөх боломж бүрдэнэ. Бусад улс оронд үйлдвэрлэсэн тээврийн хэрэгсэл эд ангид хяналт тавих тэдгээр нь техникийн дүрэмд тавигдсан шаардлагад нийцээгүй бол доголдол гэмтэл гарсан бол мөн үйлдвэрлэгчийн мэдүүлсэн техникийн үзэлд тохирохгүй бол энэ тухайгаа бүрэн эрхийнхээ дагуу тогтоох, мэдэгдэх, мэдэгдлээ хамгаалах, өөрийгөө гэрчилгээжүүлэх чадамжтай байгууллагыг томилон ажиллуулна.

Иймээс Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасны дагуу дугуйт тээврийн хэрэгслүүд тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн үндэстний байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн үндэстний байгууллагын эдгээр дүрэмд үнэ үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн



2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Бямбацогт сайдад баярлалаа.

Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Г.Амартүвшин:** УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, УИХ-д Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Женев хотноо 1958 онд батлагдсан дугуйт тээврийн хэрэгслүүд тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж эд ангид зориулсан Нэгдсэн үндэстний байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийн хэрэглэх болон Нэгдсэн үндэстний байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хуулийн төслийн хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Амартүвшин гадаадаас импортлож байгаа тээврийн хэрэгсэл хуурамч дуураймал тоног төхөөрөмж, сэлбэг, стандарт бус тоноглол суурилуулах зэрэг асуудлууд үг хэлэлцээрийн соёрхон баталснаар цэгцрэх, импортоор оруулж ирдэг машины түүх, арлын дугаар нь дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил нэгдсэн системд бүртгэгдэх эсэх тухай болон буруу талдаа жолооны хурдтэй тээврийн хэрэгслийн цаашид хэрхэн шийдвэрлэх талаар, УИХ-ын гишүүн Энхболд уг хэлэлцээрийг соёрхон баталснаар БНСУ-аас манай улс руу тээврийн хэрэгслийг импортлохоос өмнө Нэгдсэн үндэстний байгууллагаас тавьдаг шаардлагад

нийцсэн эсэхэд хяналт хийж, оруулж ирэхгүй байх нөхцөл бүрдэх эсэх талаар ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, 70 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Женев хотноо 1958 онд батлагдсан дугуйт тээврийн хэрэгслүүд тэдгээрт суурилуулан ашиглах болон болох тоног төхөөрөмж эд ангид зориулсан Нэгдсэн үндэстний байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн үндэстний байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт ийг хэлэлцэн шийдвэрлэж хуулийн төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт, ЗТХЯ-ны ТНБД Сандагдоржийн Батболд, ЗТХЯ-ны АТБЗГ-ын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга Энхтайваны Мөнхнасан, ЗТХЯ-ны АТБЗГ-ын ахлах шинжээч Цэвэгжавын Нэргүйбаатар, ЗТХЯ-ны АТБЗГ-ын шинжээч Цэвээннамжилын Баяржаргал, ЗТХЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажлын албаны мэргэжилтэн Анжимын Энхболд, АТҮТ төрийн өмчит үйлдвэрийн газрын Судалгаа хөгжил чанарын удирдлагын төвийн дарга Норлоогийн Зориг, ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн тээврийн салбарын эрхлэгч Ичинноровын Базаррагчаа нар оролцож байна.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье. Жаргалмаа гишүүн, Адышаа гишүүнээр тасаллаа.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Ингээд хэлэлцээрт нэгдээд явах нь зөв байх. Үүнийг дэмжсэн юм, Байнгын хорооны хурал дээр. Тэгээд яах вэ, зарим нь үүнтэй холбоотой, холбоогүй 2 асуулт байна.

Нэгдүгээрт нь, энэ Стокгольмын тунхаглалд тодорхой замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэлхийн зорилтууд 2030-д тусгагдсан 12 зорилтын 2 зорилт 2030 он гэхэд бүх улсууд замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой энэ юунд хүлээн зөвшөөрч нэгдэнэ ээ гэж байгаа юм.

2 дахь асуудал, техникийн зохицуулалт бүхий бичиг баримттай нишцэх үндэсний шаардлагууд өндөр чанарын аюулгүй байдлын стандартуудад нийцсэн байна гэсэн ийм заалтууд байгаа юм л даа. Тэгээд энэ дээрээс ингээд үзэхээр 1 дэх асуулт бол юу вэ гэхээр энэ нэг Приус машин Монголчууд их унаж хэрэглэж байгаа. Энэ машины нэг яндангаас тодорхой тийм бүтээгдэхүүн бодис аваад, нэг машинаас нэг 500-700 грамм орчим бүтээгдэхүүн авдаг юм байна. Тэгээд гаалийн статистик мэдээллийг ингээд харахаар 37 тонн орчмыг БНХАУ-д экспортолсон байгаа. Тэгээд энэ машинд байгаа юмыг аваад экспортлоод тэгээд тэр машин нь нэг хуурамч яндан тавиад, ямар ч шүүлтүүргүй энэ Монголын ард түмнийг ингээд хордуулаад явж байгааг юу гэж ойлгох вэ. Манай энэ ЗТЯ-ныхан холбогдох улсууд энэ дээр юу байдаг юм? Энэ бизнес энэ хууль бус үйл ажиллагаа яваад Монголд удаж байна шүү дээ. Гаалийн байгууллагын мэдээгээр бол ЗГ-т оруулчихсан, үүнийг хориглосон заалт бол

байхгүй байгаа гэж байгаа юм. Үүнийг ер нь цаашидаа яах юм бэ?

Улаанбаатар хотын энэ уур амьсгалын энэ бохирдол энэ юм чинь нэг хэсэгт үүнтэй холбоотой шүү дээ. Үүнийг яах гэж байна гэж? Нэгдүгээр асуулт.

2 дахь асуулт, энэ асфальтан замаар 40 тонноос дээш даацтай машиныг явуулахгүй ээ гээд. Тэгээд үүнээс болоод энэ дандаа шөнө явж байна шүү дээ. Энэ урагшаа Замын-Үүд чиглэж байгаа, хойшоо Сэлэнгэ, Дархан чиглэж байгаа энэ машинууд шөнө битүү явж байна шүү дээ энэ чинь. Энэ чинь одоо Монголд баялаг бүтээж байгаа улс хүмүүст энэ том машин ашиглаж байгаа шүү дээ. Тэгээд ингээд ярьж үзсэн чинь, үгүй ээ хар замаар явуулахгүй шороон замаар явна биз гэж байгаа юм. Хар зам хажууд байхад нь шороон замаар тэр хүнд даацын машин яваад байхгүй шүү. Хэрвээ энэ хар замаар явуулахгүй гэж байгаа юм бол энэ хүнд даацын машинаа нэгэнт ашиглаж болохгүй юм чинь хориг тавих юм уу, яах юм. Энэ дээр ямар бодлого байх гэж байна. Ийм 2 асуултад хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүний асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт хариулъя. Нэмж ажлын хэсгээс хариулах бол дараа нь хариулж болно. Бямбацогт.

**С.Бямбацогт:** Эхний асуулт бол үнэхээр Баттөмөр гишүүн бол маш чухал асуудал хөндөж байна. Өнөөдөр Улаанбаатар хотын түгжрэл, түүнтэй холбоотой агаарын бохирдол, утаа үнэхээр асуудал болсон. Монгол Улс сая 200 гаруй мянган машинтай түүний тал нь Улаанбаатар хотод явж байгаа. Энэ явж байгаа авто тээврийн хэрэгслүүдийн бас хэдэн хувь нь бүрэн бүтэн байна, техникийн шаардлага хангасан байна гэдэг асуудалтай. Зарим нь оношилгоо хийлгэдэг, зарим нь оношилгоо хийлгэдэггүй, оношилгоо хийлгэхдээ бас тийм худлаа, үнэн байдлаар янз бүрийн

байдлаар тэнцүүлдэг. Иймэрхүү олон асуудлууд байгаа. Тэгэхээр энэ дээр бол бас ЗТХЯ-наас тодорхой бодлого дэвшүүлээд үндсэндээ хариуцлагатай ажиллана, ил тод ажиллана, нээлттэй ажиллана. Ямар нэгэн байдлаар хууль зөрчихгүй, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажиллах ийм шаардлагыг тавьж байгаа.

Үүнээс гадна бас энэ тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ялангуяа үүнийг энэ приус машин нүүрсэн яндантай холбоотой асуудал бол бас биднээс онцгой анхаарал татаж байгаа. Энэ дээр би яг сайд болгохоосоо өмнө гишүүнийхээ хувьд, УИХ-ын гишүүнийхээ хувьд хууль санаачлаад энэ нүүрсэн яндангаас болж тийм нүүрсэн яндан хулгай хийж байна. Хулгай хийж байгаатай холбоотойгоор энэ агаарын бохирдолд автомашины яндангаас гарч байгаа утаа бол их хувь нэмэр оруулж байна, их сөрөг нөлөөлж байна. Тийм болохоор нүүрсэн янданг хилээр гаргахыг хориглох ийм УИХ-ын тогтоолын төсөл санаачилсан. Энэ ЗГ санал аваад ЗГ дэмжчихсэн байгаа. Энэ тогтоолын төслийг бас таныг оролцуулаад бас ойрын үед бид нар бас Их Хуралд өргөн барих бодолтой байгаа. Ингэх юм бол үндсэндээ нүүрсэн яндан хилээр гарах асуудал шийдэгдэнэ ээ.

Энэ конвенцод нэгдэж байгаа бид гэрээг соёрхон батлах гэж байгаа асуудал бол үндсэндээ энэ стандартын бус тээврийн хэрэгслийг Монгол Улсад оруулж ирэхийг, хуурамч сэлбэг орж ирэхийг, мөн бас харилцан Монгол Улсаас үүнийг тийм үү, энэ стандарт бус сэлбэг, материал хилээр гарахыг харилцан хаана хаана тийм үү, хориглох хязгаарлах, үндсэндээ Монгол Улсад орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл болон түүнд хэрэглэдэг сэлбэг, эд ангиудыг стандартын шаардлага хангасан байх. Ийм байдлыг л олон улсдаа хүлээн зөвшөөрөлцөөд, харилцан үүнийг хүлээн зөвшөөрөлцөөд хаана хаана хамтарч асуудлаа шийддэг болох. Машиныуд

хүртэл үндсэндээ ингээд эвдэрхий машин, осолд орсон машин, шаардлага хангахгүй машинууд орж ирээд Монгол Улсад тээврийн хөдөл тээврийн хөдөлгөөнд оролцоод явж байгаа. Энэ бүхэн бүгд бол энэ конвенцод нэгдэн орсноороо шийдэгдэх юм.

2 дугаар асуулт даацтай холбоотой асуудал. Авто машинуудад даац хэтрүүлээд зам эвддэг, тэр эвдэрхий зам дээгүүр нь иргэд, ААН-ийн машинууд зорчдог, үүнээсээ болоод эвдэрхий замаас болж эд хөрөнгөөрөө, эрүүл мэндээрээ, амь насаараа хохирдог. Зам тээврийн ослоуд гардаг. Одоо Дорнодын тамын тавь гээд үүнийг асуудалтай зам байна. Дундговийн мийтлинг тээвэрлэсээр байгаад эвдчихсэн замууд байна. Үнэхээр эвдэрчихсэн, тэгээд л энэ замууд дээр хамгийн наад зах нь дугуй нь хагардаг, хурдтай явж байгаад аваар осол хийдэг, эд хөрөнгөөрөө хохирдог, цаашилаад амь насаа алддаг, ерөөсөө энэ юутай холбоотой нэгдүгээрт нь, даац хэтрэлттэй холбоотой, хоёрдугаарт нь, замын чанартай холбоотой. Тийм болохоор эхний ээлжид ямар ч байсан даац хэтрэлтийн асуудалтай тэмцье ээ. Олон улсын хэмжээнд бол ерөөсөө нийт жин 44 тонн, нэг тэнхлэг дээр 11 тонн гэсэн энэ стандартыг л барьж байгаа. Дэлхийн үүнийг бүх улс орнууд. Тусгай зориулалтын технологийн зам дээр бол өөр даац барьж байгаа.

Гэтэл Монгол Улсад оруулж ирж байгаа машинууд нь технологийн зам дээр явна гэж тийм үү, нүүрсний тээврийн ч гэдэг юм уу тийм ээ, шатахуун тээврийн машинууд оруулж ирдэг, оруулж ирсэн машинаа өнөөдөр улсын чанартай авто зам дээгүүр явуулаад даац хэтэрвэл зам эвддэг, эцэст нь чанаргүй зам барьсан гэж замчид нь буруутгагддаг. Яг үнэндээ бодит байдал дээр даацаа хэтрүүлж, зам эвдэж байгаа. Тийм болохоор үүнтэй бол ЗТХЯ бол хатуу тэмцэнэ ээ. Энэ замаа эвдүүлэхгүй ээ, даац хэтрүүлэхгүй ээ.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүн тодруулах уу? тодруулга 1 минут.

**Б.Баттөмөр:** Яах вэ, зам эвдэж байгаа, даац хэтэрч байгаа юмнууд бол байгаа л байх. Тэгэхдээ энэ хилээр оруулж байгаа шүү дээ. Хүн чинь үүнийг гаднаас худалдаж аваад, тэрийг гааль, Нөатын татвар төлөөд ингээд авч байгаа юм. Тэгээд орж ирээд явахгүй болохоор одоо яах вэ? Ян ингээд та нар тэмцэх юм бол энэ дээрээ тэр хоригийг нь тавьдаг ч юм уу яадаг ч юм. Одоо энд авчраад ашиглаж чадахгүй, дандаа хулгайгаар явж байгаа шүү дээ. Тэгээд энэ тэр зарим хүмүүст нь карманд нь мөнгө хийж байж тэгээд явдаг. Энэ бол нууц биш шүү дээ. Ийм л байгаа шүү дээ, өнөөдөр. Тэгээд яах юм одоо тэгээд. Үүнийг ээ бүр ил тод зарла, одоо өнөөдөр ч гэсэн гааль дээр бүрдүүлэлт хийх гэж л байх. Том том машинууд. Үүнээс дээш машиныг бол Монголын замд явуулахгүй шүү тэр шороон замаараа явбал явна биз гэдэг юм уу, үүнийгээ зарлах л ёстой л гэж. Тэгээд л орж ирээд л хэдэн мянган машин байна шүү дээ. Яах вэ тэр нүүрсний машин нь тэндээ байдаг юм байгаа биз.

Энэ Улаанбаатарт байж байгаа энэ явж байгаа машинууд дээрээ бас бодмоор, иргэддээ анхааруулмаар юмнуудаа бас ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад ажлын хэсэг харуулах уу? хэн хариулах вэ? Бямбацогт сайд хариулъя.

**С.Бямбацогт:** Баттөмөр гишүүн маш зөв асуудал хөндөж байна. Би ч бас иргэдээ мэдээллээр хангах ёстой, тэгээд мэдээлэлгүй байлгаж байгаад сүүлд нь хэрэг зөрчил гаргахаар нь торгоод шийтгээд байж болохгүй. Тийм болохоор урьдчилаад сануулдаг, анхааруулдаг, зөвлөдөг, тусалдаг, ингэж байгаад арга хэмжээ авна. Тийм учраас ЗТХЯ-наас ажлын хэсэг гарсан, тээврийн цагдаагийн албатай хамтраад үүнийг олон нийтэд тийм үү? Мэдээлэх, сурталчлах, даац хэтрэхгүй шүү. Даац хэтэрснээс болж

иргэд тийм үү, энэ эвдэрсэн зам дээгүүр зорчоод амь нас, эрүүл мэндээрээ, эд хөрөнгөөр маш их хохирч байна. Үүнтэй холбоотойгоор даац хэтрүүлэхгүй шүү, гэдгийг бас л сайн сурталчилгаа сайн явуулж байгаа, мэдээллийг сайн хүргэж байгаа. Цаашидаа бас яг тэр технологийн замуудаар явах машинууд технологийн зам дээрээ явуул гэдэг асуудлыг ч гэсэн бас гааль дээр машин орж ирэхэд нь бас таны хэлж байгаа байдлаар шийдэх ёстой. Оруулж ирэхдээ гаалийн бүрдүүлэлт хийхдээ бид нар технологийн зам дээр нүүрсээ тээвэрлэнэ ээ, бусад, үүнийг ачаа тээвэрлэнэ ээ гэж оруулж ирдэг. Оруулж ирсэн хойноо технологийн зам дээр биш улсын чанартай нийтийн зориулалттай замууд дээгүүр явдаг. Мөн бас хөдөө шороон замаар бас наашаа уул уурхайн тоног төхөөрөмж зөөх ёстой байтал заавал залхуураад эдийн ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Тэгэхээр энэ Женевийн хэлэлцээрт нэгдэх энэ саналыг бол дэмжиж байгаа. Мэдээж хэрэг дэмжсэнээрээ бид юуг Монгол Улсдаа ямар ашигтай зүйлийг хийх гэж байгаа вэ гэдгийг бас иргэддээ бас товчхон танилцуулах юм бол энэхүү хэлэлцээрээр шинэ механикжсан тээврийн хэрэгсэл болон механикжсан тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн тухайд ижил төрлийн шаардлагыг тогтоох мөн энэ хэлэлцээрт хавсаргасан Нэгдсэн Үндэстний байгууллагын техникийн дүрмүүдийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг зохицуулна гэж ингэж заасан байна л даа. Энэ дээр нэг зүйлийг тодруулъя. Монгол Улсад бас машин үйлдвэрлэдэг нэг хэд хэдэн компани, магадгүй угсардаг ч байж болно тийм ээ, хэд хэдэн компани байгаа. Эд нар маань бас гадагшаа гаднын зах зээлд гарах бүрэн боломж нь нээгдэх юм байна гэж ойлгож байгаа.

Нөгөө талаар сая Баттөмөр ах ярьчихлаа. Нөгөөдөх шаардлага хангахгүй техник том машин техник маш ихээр гаднаас оруулж ирдэг ээ. Япон, Солонгост үер ус боллоо, цунами боллоо, одоо яг нөгөө машин Монголд орж ирнэ тэгэхээр үед нь машин хямдарчихдаг байх жишээний. Монголд тийм ээ, орж ирсэн приусүүд нь хямдарчихдаг байх жишээтэй. Яг ер нь өнөөдрийн байдлаар Монгол Улсад нийт хэчнээн авто ком буюу тийм ээ, машин оруулж ирдэг, ийм компаниуд үйл ажиллагаа явуулж байдаг юм. Яг тэд нар дээрээ бид нар хяналт тавьж чаддаггүй, эвдэрсэн машинаа оруулж ирээд нөгөө угсраад засаад байдаг энэ нөхцөл байдал бол арилна гэж би ойлгож байгаа. Өөрөөр хэлэх юм бол энэ хэлэлцээрээр. Тэр хяналт тавих механизм нь тогтолцоо нь өнөөдөр Монгол Улсад байгаа юу, яг энэ бүхэн дээр. Энэ дээр нэг хариултыг өгөөч ээ.

Нөгөө талаар бас нэг зүйлийг тодруулах гэсэн юм. Түгжрэлээ бид нар яаж шийдэх вэ гэдэг асуудал яригдаад байгаа. Тэгэхээр бид нар үүнийг нэгэнт энэ хэлэлцээрт нэгдэж байгаагийнх улсад бүртгэлтэй болон бүртгэлгүй хөдөлгөөнд оролцдог болон оролцдоггүй тээврийн хэрэгслийнхээ тоог буюу бүрэн гүйцэд гаргаж чадсан болов уу. Хэрвээ энэ шаардлага хангахгүй тээврийн хэрэгслээ замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх тэр боломж ер нь бүрдэх болов уу? Тээврийн хэрэгслийн ашиглалт аюулгүй байдлын үзүүлэлтээс үзэх юм бол ер нь Монгол Улсад бүртгэлтэй 1243445 машин байсан бол энэ тоо 10.35 хувиар нэмэгдсэн гэдэг ийм тоо байна шүү дээ, тийм ээ. Тэгэхээр энэ бүхэн дээр бид нар хяналт тавиад тодорхой хэмжээний зохицуулалт хийх боломж байгаа юм болов уу энэ дээр ингээд 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт. Урин дулааны цаг ирж байна. Цахилгаан дугуй, моторт дугуй гэдэг зүйл маш ихээр хүүхдүүд маань унаж байгаа. Замын цагдаагийнхнаасаа асуухаар А зэрэглэлийн тийм ээ, эрэгтэй хүн унана

гэдэг болов ч насанд хүрсэн хүүхэд хүн унана гэдэг болов ч хүүхдүүд маань цахилгаан моторт дугуй унасаар байгаа. Бид дугуйн замаа шийдвэрлэж чадаагүй энэ цаг мөчид ингээд цахилгаан дугуйг ингээд ихээр унах юм бол нөгөө осол аваар маань нэмэгдээд байгаа. Энэ дээр ер нь ямар зохицуулалт хийх ёстой юм бэ гэдэг дээр бас албаны хүмүүсээс тайлбар сонсьё оо.

Бид нар ер нь яг нөгөөдөх сэрэмжлүүлэг мэдээллээ ер нь хангалттай өгч чадаж байгаа юу, үгүй юү гэдэг дээр бас тайлбар авъя.

**Л.Мөнхбаатар:** Жаргалмаа гишүүн 3 сэдэвт асуулт асуулаа. Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогт хариулъя.

**С.Бямбацогт:** Жаргалмаа гишүүн бас чухал асуудал хөндөж байна. Зарим асуултад би хариулчихъя. Заримыг нь Батболд дарга хариулчихаарай. Энэ хэлэлцээрт нэгдэн орсноор Монгол Улсад үйлдвэрлэсэн автомашины сэлбэг, хэрэгсэл, эд ангиудыг экспортлох, олон улсад хүлээн зөвшөөрүүлээд тийм ээ, харилцан үүнийг борлуулалт хийх бас бололцоо боломж бүрдэх юм. Өөрөөр хэлэх юм бол бид нар Үйлдвэр технологийн паркийн тухай хууль баталсан. Үүнтэй холбоотойгоор Эрдэнэтэд зэсийн баяжуулах зэс хайлуулах үйлдвэр байгуулагдана. Одоо бас зэс хайлуулж байгаа, цэвэр зэс гарч байгаа шүү дээ, нөгөө юу билээ нөгөө нэг катодын аргаар ч билүү, Эрдмийн нөгөөдөх нь юу билээ. Нэг компаниуд Ачит эх, тэр цэвэр зэсээрээ бид нар бас автомашины зэс, эд ангиудыг хийгээд экспортод хийх, гаргах ийм бол боломжууд бүрдэнэ ээ гэж бас ойлгож болно. Монгол Улсын экспортын орлого нэмэгдэх. Одоо өнөөдөр баяжмал ямар үнэтэй гаргаж байгаа билээ? Түүнийг ээ цэвэр зэс болгоход хэдэн зуу дахин Монгол Улсад орох өгөөж нэмэгдэж байгаа. Тэгвэл эцсийн бүтээгдэхүүн гэвэл өшөө дахин

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нэмэгдэнэ. Ийм ингэхэд энэ энэ бас протокол бас хувь нэмрээ оруулна.

Хоёрдугаарт нь, 1200000 авто тээврийн хэрэгслүүдээ ЗТХЯ бас энэ жил авто тээврийн нэгдсэн үзлэг, тооллого хийхээр болж байгаа. Эдгээрээс хэд нь хөдөлгөөнгүй хашиандаа хэвтэж байгаа юм, хэд нь ингээд хуучраад муудаад зүгээр ингээд юу гэдэг юм үзмэр болчихсон, музей болчихсон байдаг юм. Тэгсэн мөртөө бүртгэлд ордоггүй, тэгсэн мөртөө татвар төлдөггүй маш олон байж байгаа. Эдгээрийг үндсэндээ бол үзлэг тооллого хийгээд үүгээрээ үндсэндээ цэгцэлье ээ. Шаардлага хангахгүй тээврийн хэрэгслүүдийг жагсаалтаас жагсаалаас гаргая. Аав, ээжийнхээ эдэлж, хэрэглэж байсан автомашинуудыг зүгээр сайхан хадгал аа гээд үүнийг бүртгэлээс хасуулаад зүгээр юу гэдэг юм үзмэр байдлаар хадгал аа гэдэг асуудлыг энэ жил компаничилж авто тээврийн хэрэгслийн нэгдсэн үзлэг тооллогыг Монгол Улсын хэмжээнд явуулж эхлэх гэж байгаа.

Хүн амын тооллого гээд бид нар 5 жилд нэг удаа хийдэг. Түүнтэй адилхан анх удаагаа авто тээврийн 1200000 хэрэгслээ бас бүгдийг нь нэг бүрчлэн тоолъё. Ингээд нэг яг хөдөлгөөнд оролцдог шаардлага хангасан бүрэн тээврийн хэрэгслийн тоог гаргая гэдэг ажлыг бас энэ жил бас ЗТХЯ-наас томоохон бодлого зорилт болгож ажиллаж байгаа гэдгийг хэлье. Тэгээд үлдсэн асуултууд Батболд дарга хариулчих уу.

**Л.Мөнхбаатар:** Жаргалмаа гишүүний асуултад нэмж хариулъя. ЗТХЯ-ны ТНБД Сандагдоржийн Батболд хариулъя. Хэд байна, 88 дугаар микрофон уу.

**С.Батболд:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт нь, ач холбогдлын талаар сая сайд бол бас дэлгэрэнгүй танилцуулчихлаа. Энд албан бусаар энэ авто тээвэртэй холбоотой

үйлчилгээ эрхэлдэг, сэлбэг автомашин борлуулдаг 1000 гаруй иргэн байдаг гэсэн тооцоо байдаг. Яг албан ёсны автомашин борлуулдаг эрх бүхий байгууллага Монголд 1 дистрибьютер 28 диллер ажиллаж байгаа гэсэн ийм мэдээллийг өгье.

Хяналт тавьж байгаа асуудлаар сая сайд хэллээ. Монгол Улсын хэмжээнд нэгдсэн ийм шинэчилсэн бүртгэлийн ажил явагдаж байна. Зам, тээврийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар үүрэг даалгавар өгөөд ингээд эхэлж байна. Одоогоор ашиглагдахгүй байгаа 150000 орчим тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах шийдвэр гаргаад явж байна. Цаашидаа ашиглагдахгүй байгаа 280 орчим мянган тээврийн хэрэгслийг цаашид эзэдтэй нь холбож энэ бүртгэлээс хасах асуудлыг бас яригдаж байна.

Ер нь бол энэ саяын таны хэлж байгаа 1200000 орчим тээврийн хэрэгслийн нэг 65-67 найм орчим хувь нь л техникийн хяналтын үзлэгт ордог, татвар төлдөг, бусад нь бол олон жил ашиглагдахгүй ингээд татвараа төлөхгүй, ингээд энд тэнд үүнийг ашиглалтаас хасагдчихсан байдаг юм уу, эсвэл үүнийг хулгайгаар хөдөлгөөнд оролцож явдаг юм уу ийм байдлаар явж байгаа. Тийм учраас энэ нэгдсэн ийм хяналт хэрэгжээд саяын энэ 1000200 гэдэг тоо бол нэлээн үүнийг буурч ирж байгаа. Тийм.

3 дахь асуудал нь энэ цахилгаан дугуй. Манайхан скуүтер мопед гэж ярьж байгаа. Энэ асуудлаар бид Хууль зүйн яам, ЦЕГ, Тээврийн цагдаагийн алба манай Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алба өнгөрсөн жил хамтраад бас энэ талаар дүгнэлт гаргаад ийм хэрэгслүүд замын хөдөлгөөнд оролцох эрх зүйн зохицуулалт бол манайд бас бүрэн байгаа юм байна. Харин энд дээр яг ашиглалтын байдалд нь хяналт тавих асуудал л чухал юм байна гэж байгаа. Ингээд энд удахгүй нэг ийм яг саяын дулааны улирал эхэлж байгаатай

холбоотой Тээврийн цагдаагийн алба манай ийм байгууллагууд хамтраад урьдчилан сэргийлэх ийм ажлууд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Одоо 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууя.

**Ш.Адьшаа:** Энэ хэлэлцээрийг соёрхон батлах нь хамгийн зүйтэй байх гэж бодож байна. Тэр конвенц гэж энэ конвенцын дагуу Монгол Улс 2003 онд Женевт очиж энэ хэлэлцээрт элсэж байсан. Тэгэхэд би гаалийн байгууллагад байсан. Одоо энэ ЗТЯ-ны Баяржаргал бид нар очиж энэ Монгол Улсыг анх тийр конвенцод элсүүлж байсан юм. Түүнээс хойш ингээд энэ хугацаанд бол энэ тийр конвенцын дагуу Монгол Улсын энэ тээврийн хөгжил тодорхой сайн шатад гарсан гэж ойлгож байгаа. Тэгээд энэ тийр конвенцын дагуу явагдаж байгаа энэ тээвэр бол хамгийн хурдан, хамгийн сайн чанартайгаар энэ Европ олон оронд тийр конвенцыг энэ галт тэрэгнээс илүү өргөн хэрэглэж байгаа. Ингээд 2, 3 зүйлийг бас асууя.

Ингээд сүүлийн жилүүдэд Европын зах зээл 3 дахь орон руу Монгол Улсаас бас энэ ачаа тээврийг энэ тэр конвенцын хэлэлцээрийн дагуу явуулж байгаа гэсэн мэдээлэл байна. Энэ ачаа эргэлтээр ер нь хэр зэрэг ямар хувьтай байна гэдэг ийм нэг мэдээллийг авъя.

Нөгөө талаасаа ингээд Европ руу явах гэж байна. Энэ зам дээр энэ дайн байлдаантай, олон мянган километр замыг туулж байхад энэ жолооч нарын эрүүл мэндийн асуудал, аюулгүй асуудал дээр төрийн бодлогын хэмжээнд яам ямар бодлого баримталж байгаа гэдэг талаар нэг хариулт авъя.

Нөгөө талаасаа бас нэг зүйлийг тодруулахгүй бол болохгүй байгаа юм. Дэлгэрсайхан гишүүн бид 2 их олон удаа

асууж байсан. Халтар сайдыг байхад Халтар сайд байвал би дахиад асуумаар байгаа юм. Монгол Улс тэр конвенцод элсэн орсноор 2 улсын бусад улсын стандартын дагуу явж байгаа тээврийн хэрэгслийг өөрийн нутаг дэвсгэр дээгүүр ямар ч саадгүйгээр нэвтрүүлэх, ачаа тээвэрлэх боломжийг хангах ийм үүрэг хүлээсэн байдаг. Гэтэл Хятад улсын нутаг дэвсгэр дээр Хятад улсын замаар явж байсан том оврын ачааны машиныг зарим ямар нэгэн шалтгаангүйгээр Замын-Үүд бусад боомтууд дээр олон хоног явуулахгүй стандарт бус байна гэдэг янз бүрийн ийм шалтаг зааж, чирэгдүүлж байсан ийм асуудал гарч байсан. Энэ талаар энэ асуудал дахиж давтагдаж байна уу, тэр асуудал ямар шатад очсон бэ гэдэг энэ талын нэг хариулт авъя.

Нөгөө талаас үүнийг Бямбацогт сайд байж байна. Энэ дээр бас нэг санал хэлье гэж бодож байгаа. Өнөөдөр ингээд түрүүн Өмнөговь, Дундговийн замаар энэ мийтлинг зөөгөөд зам эвддэг ийм ноцтой асуудлуудын тухай ярьсан. Гэтэл үүнийг Бямбацогт гишүүн бид хоёрын сонгогдсон Ховд аймгийн АХБ-ны санхүүжилтээр баригдсан хамгийн сайн чанарын замаар Наранбулагаас төмрийн хүдрийг тэр баруун хил рүү зөөдөг асуудал сүүлийн жилүүдэд байсан. Ковид гараад энэ түр саатсан юм шиг байгаа юм. Энэ дээр сайд бас онцгой анхаарч, энэ замаар стандартын бус их хэмжээний ачаа тээвэр ачсан, төмрийн хүдэр ачсан тэр машиныг явуулахгүй байх талын зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байгаа гэдгийг би бас ийм саналыг хэлж байгаа юм. Энэ Наранбулагаас их хэмжээний хүнд даацын машинаар төмрийн хүдэр ачаад, Мянгадын гүүрэн дээр ирээд тэр замын цагдааг аргалаад л явчихдаг. Тэгээд өнөөдөр хэн хохирдог вэ? Тэр зам элэгдэж гэмтэж олон арван сая доллароор тавигдсан ийм хохирол учрах ийм нөхцөл байгаа учраас энд бас анхаарч ажиллахыг би хүсэж байгаа юм. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүн яг минутдаа багтаагаад асуултаа асууж байна. Бямбацогт сайд хариулъя.

**С.Бямбацогт:** Адьшаа гишүүний сүүлийн асуултаас эхлээд хариулъя. Тэгээд маш чухал асуудал хөндөж байгаа. Энэ тээврийн Увсын Наранбулагаас үүнийг баруун хил рүү Булган руу даац хэтрүүлж бас төмрийн хүдэр зөөдөг байсан. Үүнийг сайд болохоосоо өмнө өнгөрсөн үүнийг 16-20 онд нэлээн хатуу бас тэмцэж байсан, харьцангуй бол багассан байсан, ингээж байгаад ковидтой залгасан. Одоо бас явах асуудал бас яригдаж магадгүй. Дөнгөж сая би өчигдөр, уржигдар 2, 3 хоногийн өмнө Ховдод ажилласан. Энэ үедээ тээвэрчидтэй уулзсан. Мөн Авто тээврийн төвийнхөнтэй уулзсан. Бас манай замын хяналтынхан Азза-ийнхан энэ бүх хүмүүст хатуу үүрэг өгсөн. Ховд аймгийн нутаг дэвсгэр дээр 1 ч тээврийн хэрэгсэл даац хэтрэхгүй ээ. Намайг сайд байгаа хугацаанд та бүхэн үлгэр дуурайлалтайгаар ажиллана шүү. Үлгэр дуурайлал гаргаж, манлайлж, цементэд нэг юу даац хэтрүүлж тээвэрлэж болохгүй, төмрийн хүдэр даац хэтрүүлж тээвэрлэж болохгүй, нүүрс даац хэтрүүлж тээвэрлэж болохгүй гэдэг хатуу үүргийг өгсөн. Энэ байнга хяналт тавьж ажиллана.

Дараагийн асуудал бол олон улсын тийр конвенцод нэгдсэн маш чухал асуудал болсон. Энэ хүрээндээ үндсэндээ бас баруун босоо тэнхлэг Орос, Хятадыг, Ази, Европыг холбосон Азийн авто замын сүлжээнд өнгөрсөн жил бид нар бас холбогдсон. Урьд нь бол ганцхан Алтанбулаг, Улаанбаатар, Замын-Үүд гэсэн чиглэлд холбогдож байсан. Үүгээр Хятадаас Орос руу, Оросоос Хятад руу бол тийр конвенцоор, тийрүүдээр ачаа тээвэрлэдэг байсан. Одоо ингээд Дарханы замын эвдрэлтэй холбоотой юу, засвартай холбоотойгоор бас энэ үндсэндээ түр зогсоод байгаа. Тэгвэл сая бас ингээд Ховдод явж байх явцад Булганы Ярантын боомтоор өдөр болгон

хамгийн багадаа 10-аас доошгүй машин ОХУ-аас, Хятадаас Оросын холбооны улсын чиглэлд ачаа тээвэрлэж байна. Тээвэрлэж байна. Ийм байдлаар бол бас тодорхой хэмжээнд юу гэдэг юм Монгол Улс маань бас Азийн авто замын сүлжээнд энэ тээвэр логистикийг хөгжүүлснээрээ тодорхой үр өгөөжийг нь хүртэж эхэлсэн байна. Яг энэ хүрээндээ бас бид зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр явахаас гадна Европоос Монгол руу тээвэрлэж байгаа энэ тээврийн хэрэгслүүд дээр бас илүү бас тээвэрлэгч дээр бас анхаарал тавьж байгаа. Урьд нь бол Оросын холбооны нутгаас ингээд Польшоор дамжаад явдаг байсан одоо хаагдсан. Одоо бол үндсэндээ Казахстанар дамжаад ирж байна. Энэ бол Оросын тал дээр бас нэг жоохон торгуулдаг бас жоохон бас нэг дарамтлуулдаг асуудлууд байгаа. Үүнийг бас бид нар бас мэдээлэл авч бас тодорхой нэг дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа.

Одоогийн байдлаар бид нар Герман улс, Польш улс, Словак, Узбекистан гэсэн 4 улстай авто тээврийн хэлэлцээр байгуулах гэж байгаа. Авто тээврийн хэлэлцээр. Энэ байгуулагдах юм бол үндсэндээ Орос дээгүүр бид нар тээвэрлэхгүйгээр үндсэн Казахстан ингээд юу гээд ер нь юу гэдэг юм, Оросын нутгаар аль болох богино тээвэр хийгээд Европоос наашаагаа бас Монгол тээвэрчид маань бас ачаа бараа тээвэрлэх бололцоо бүрдэнэ ээ. Цаашдаа бас Европын тээврийн хэлэлцээрт нэгдэж орно. Тэгэх юм бол зөвхөн Монгол руу тээвэрлэхээс гадна Европ улс дотроо Европын холбооны улсууд дотор нь тээвэр хийх бас бололцоо боломжийг бүрдүүлэх ийм бас боломжууд бүрдэх юм. Ийм байдлаар үндсэндээ тээвэрчдээ дэмжсэн бас бодлого үйл ажиллагаа явуулж байна. Энэ цаашдаа бол бас Тяньжиниэс үүнийг ачаа барааг үүнийг юу гэдэг юм заавал вагоноор биш тэр контейнеруудыг Монгол Улс руу бас авто тээвэрээр тээвэрлэх ийм асуудлыг бас



2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

анхаарч бас хөөцөлдөж байгаа гэдгийг хэлье хэлье.

*Батболд дарга нэмээд асуулт байвал хариулчихъя.*

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүний асуултад нэмж хариулъя. Ажлын хэсэг 88 дугаар микрофон өгье. ЗТХЯ-ны ТНБД Батболд.

**С.Батболд:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Тийр конвенцын ач холбогдол бол их байсан. Конвенцод нэгдэн орох үед орсноор зөвхөн Замын-Үүдээр, Алтанбулагаар тийр тээвэрлэж явж байсан бол энэ хугацаанд бас Ховдын Булганы боомтоор бас тийр конвенц явах ийм боломжтой болсон байж байгаа. Ер нь бид бол Монголын тээвэрчид бүс нутгийн болон олон улсын тээвэрлэлтэд оролцох ийм боломжийг бүрдүүлэх чиглэлээр нэлээн эрчимтэй ажиллаж байна. 2016 он гэхэд бид нар 9 улстай ЗГ хоорондын авто тээврийн хэлэлцээртэй байсан бол өнөөдөр нэг 20-оод улстай тээвэрлэж явах боломжтой байгаа. Ер нь явагдаж байна. Одоогоор 12 улстай ЗГ хоорондын хэлэлцээр байгуулчихсан, 9 улстай хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна. Хэлэлцээр байгуулагдаагүй ч гэсэн 5 улстай зөвшөөрлийн бичиг солилцоод тээвэрлэлт явагдаж байгаа. 15 оноос 22 онтой харьцуулахад нийт улс хоорондын тээвэрлэлт нэг 2.6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа юм. 2015 онд жишээ нь тийр тээвэрлэлтээр явж байгаа тээврийн зөвхөн 1 хувийг Монголын тээвэрчид эзэлж байсан бол өнөөдөр бол энэ тийр тээвэрлэлтийн 31 хувийг Монголын тээвэрлэгч нар эзэлж байгаа. Тийм учраас энэ бид нарын зорилт бол бас тодорхой хэмжээгээр хэрэгжиж, Монголын тээвэрчид энэ тээвэрлэлтэд нэлээн идэвхтэй оролцож байгаа.

Дараагийн асуудал нь таны хэлдэг хол замд жолооч нараа яаж хамгаалж байна вэ гэж. Өнгөрсөн жил бид энэ олон улсын тээврийн бас нэг хэлэлцээрт нэгдэн орсон. Энэ тээврийн багийн ажил

амралтын дэглэмийн асуудал байж байгаа. Энд бид нар нэгдэж ороод хэрэгжилтийг нь ингээд хангах ажил явагдаж байна.

Мөн энэ ногоон картын систем гэж энэ олон улсын тээвэрлэлтэд энэ даатгалыг хүлээн зөвшөөрөх бас ийм конвенцод нэгдэж орохоор бид ажиллаж байгаа боловч харамсалтай нь бас газар зүйн байршлаасаа шалтгаалаад Монгол Улс орох боломжгүй байгаа. Гэхдээ орчихсон улсуудаар дамжаад бид орох ийм боломжийг хайж ажиллаж байна.

**Л.Мөнхбаатар:** Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

**Б.Дэлгэрсайхан:** Та бүхэнд баярлалаа. Тэгээд энэ конвенцод нэгдэн орохыг дэмжиж байна. Тэгэхдээ нэг 3 асуудал байна. Нэгдүгээрт, энэ ЗТЯ-ны газрын дарга Жаргалсайхан саяхан энэ Эрээн гараад, Эрээний дэд даргатай уулзаад жижиг тэрэг суудлын машин гаргах асуудлыг яриад тэгээд Хятадын тал бол энэ Хятад, Монгол Улсын хоорондын авто тээврийн хэлэлцээрт өөрчлөлт оруулж байж шийднэ гээд ингээд нэг хариу өгсөн бололтой юм шиг байгаа. Тэгээд одоо болтол ингээд Замын-Үүдийн иргэд хохироод ялангуяа тэнд амьдардаг жижиг суудлын автомашинтай улсууд ингээд өөрийнхөө машинтай хил гарч чаддаггүй. Тэгээд автобусанд суудаг ч юм уу ингээд тодорхой хэмжээний төлбөр мөнгө ингээд хохирч байна л даа. Тэгэхээр үүнийг яаж хэзээ шийдэх юм бэ? Энэ гэрээ хэлэлцээрт хэзээ өөрчлөлт оруулах юм бэ? Үүнийг та нар нэг хариулж өгөөч ээ гэж, нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол энэ Замын-Үүдээр өнгөрсөн энэ ковидоос өмнө нэг нэлээн олон тээврийн хэрэгсэл орж ирсэн та нар бүгдээрээ мэдэж байгаа. Миний нэг ганц яриад байдаг юм тэгээд явуулна явахгүй, оношилгоонд оруулна, оруулахгүй гээд л ингээд баахан хоорондоо хэрэлдсээр байгаад өнөөдрийг болтол шийдээгүй.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Энэ нэг өргөний хэмжээ нь болохгүй байна энэ тэр гээд. Тэгээд энэ тээврийн хэрэгслийг яах гэж тэгвэл анхнаасаа гаалиар оруулж ирж, хүн хохироож байгаа юм бэ? Тэгээд энэ хүн жолооч нар нь ингээд банкнаас нэг баахан зээл авчихсан, тэгээд үүгээрээ үүнийг ашиг орлого олоод банкны зээлээ төлнө гээд ийм асуудалд орчихоод тэгээд одоо болтол ингээд тээврээ хийж чаддаггүй. Тэгээд үүнийг яаж зохицуулах юм? Нэгэнт Монгол Улсын хилээр ороод та нар оруулчихсан юм чинь болно, бүтнэ гээд л оруулсан байж таараа. Тэгээд эсвэл энэ цагаас хойш оруулахгүй гээд нэг тушаал шийдвэр гаргаад ингээд иргэдийг хохироомооргүй байгаа юм. Тэгэхээр үүнийгээ нэг талдаа шийдэж өгөөч ээ.

3 дахь асуудал бол энэ босоо тэнхлэгийн зам. Ялангуяа энэ бол Дорноговь, тэгээд энэ Говьсүмбэрээс урагших замыг л яриад байгаа юм л даа. Энэ зам эвдэрч дууслаа. Тэгээд ерөөсөө үүгээр шөнийн цагаар үүнийг ингээд жонш, нүүрс зөөгөөд байгаа юм. Тэгээд энэ нь бол танай нөгөө постууд бол зүгээр ингээд нүдээ аниад өнгөрөөж байна. Хэдхэн хоногийн өмнө ингээд бид өөрсдөө ингээд Дорноговь яваад ирэхэд шөнийн 1, 2 цагт ингээд хорь гучаараа ингээд шуудайнд ачсан, шуудайлчихсан бүр нүүрс ачаад явж байгаа шүү дээ. Нүүрс чинь бүр алтан болсон байна шүү дээ. Шуудайлчихсан, өнөө 3 тоннын шуудайнд хийгээд. Тэгээд та нарыг зөвшөөрсөн гэж ярьж байх юм, үнэн юм уу. Тэгээд зөвшөөрсөн бол тэгээд яахаараа тэрийгээ заавал шуудайлаад нууж хаагаад тэгээд ингээд явуулдаг юм. Тэгээд ганц өнөө бүх л муу юманд барьдаг цагдаа л ганцаараа тэнд байна. Тэгээд үүнийг яаж шийдэх юм бэ? Энэ босоо тэнхлэгийн зам чинь эвдэрч дууслаа шүү дээ. Шөнө хулгайгаар явсаар байгаад таарлаа шүү дээ. Тэгээд энэ постууд чинь ажлаа хийхгүй юм уу, эсвэл ингээд 5 цаасны авлигад хууртаад шан харамж аваад ингээд л нэвт нүдээ аниад л өнгөрөөх юм. Тэгээд ямар учиртай юм бэ? Энэ 3 асуултад нэг хариулаад өгөөч тэгэх

үү. Тэгээд асуу нэмж тодруулах юм байвал асууя гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Дэлгэрсайхан гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. Бямбацогт сайд эхэлж хариулаад, ажлын хэсэг нэмж хариулъя.

**С.Бямбацогт:** Энэ одоо яг үнэндээ энэ Улаанбаатараас урагшаа Чойр, Мааньт, Олон Овоот гээд эндээс төмөр замаар нүүрс хулгайгаар тээвэрлэдэг бас авлига, ашиг сонирхлын асуудал үүсгэдэг. Сүүлийн үед төмөр замаар тээвэрлүүлэхгүй болохоор автомашинаар тээвэрлэдэг ийм асуудал гарч байгаа. Өдөр болгон боомтын мэдээ авдаг юм. Автомашинаар нүүрс нэлээн их гардаг нэмэгдэж байгаа юм байна лээ. Энэ хаанаас вагоноор аваачиж тэнд буулгачхаад Замын-Үүдээр буулгачхаад Замын-Үүдээс автомашинаар ачдаг юм болов уу гэхээр үгүй л юм байна л даа. Энэ дээр манай яамныхан би бас хатуу үүрэг өгөөд байгаа. АТҮТ гэж байгууллага байгаа. Дорноговь аймагт бас АТҮТ-ийн бас салбар байгууллага байгаа. Энэ байгууллагууд ажлаа сайн хийхгүй байна. Энэ дээр хатуу анхааръя. Хариуцлага тооцъё.

Их Хурлын гишүүд нь бид нар тийм ээ, аймаг орон нутгийн удирдлагатайгаа тээврийн цагдаагийн албатайгаа хамтраад л энэ зам эвдүүлэхгүй байх, даац хэтрүүлэхгүй байх энэ тал дээр анхаарах ёстой. Бид нар ингээд нэг л дуутай байх ёстой. Манай бүлгийн дарга Тогтохсүрэн дарга бас Өвөрхангайн зам эвдүүлэхгүй гээд нэлээн дуугардаг, энэ БХБ-ын сайд Даваасүрэн сайд бас зам эвдүүлэхгүй гээд дуугардаг, Дэлгэрсайхан гишүүн маань дуугарч байна. Тэгээд даац хэтрэхгүй байх ёстой. Тийм ээ, Тогтохсүрэн дарга аа, зөв биз.

Тийм болохоор энэ дээр хэрвээ тийм авлига аваад, машин нүдээ аниад явуулж байгаа асуудал байх юм бол бүгдээрээ тал талдаа анхааръя. Энд бид

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нар нэг бодлого гарч байгаа юм. Зөвхөн тэр ачаа ачаад даац хэтрээд явж байгаа жолооч тээвэрчдийг торгоож шийдэхээс гадна бид нар ачаа илгээж байгаа байгууллага, хаанаас ачаа эхлэлтэй байна. Тэндээс яагаад даац хэтрүүлж ив. Тэр байгууллагууд дээр нүүрсний уурхайнууд дээрээс авхуулаад арга хэмжээ авна. Үйл ажиллагаа нь зогсоох хүртэл арга хэмжээ авна.

Дээрээс нь ачааг хүлээж авч байгаа байгууллага бас даац хэтэрсэн ачааг хүлээж авдаг. Энэ байгууллагуудаар арга арга хэмжээ бас авч байгаа. Ийм байдлаар ганцхан тээвэрлэж байгаа тээвэрлэгч нар биш ачаа илгээж байгаа, ачаа хүлээж авч байгаа, даац хэтрүүлсэн ачааг, зам эвдэж байгаа энэ бүх хариуцлагыг бол энэ хүмүүстэй хамтад нь тооцохоор ийм байдлаар явж байгаа.

Бусад асуултад нь Батболд дарга нэмээд хариулчихъя.

**Л.Мөнхбаатар:** Батболд дарга хариулъя.

Тур суудлын машины асуудлыг би нэмж хариулчихъя. Суудлын, хуучин бол гардаг байсан. Замын-Үүд дээр ингээд суудлын машинууд гараад нөгөө жаран еснүүдээр тийм үү жинхэнэ бизнес хийдэг байсан, бөөн үүнийг бас овойж оцойтол нь хэдэн тонн ачаа ачаад орж гардаг, одоо бол тэгж орохгүй. Гэхдээ суудлын автомашиныг Замын-Үүдээс Эрээн, Замын-Үүдийн хооронд чөлөөтэй зорчих, боомтуудаар тийм ээ, чөлөөтэй зорчих боломжийг яаралтай бүрдүүлэхээр манай яамныхан холбогдох бас байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа. Энд бас ГХЯ, ХХЕГ бид нар бас үйл ажиллагаа уялдуулах ёстой, орон нутгийн ялангуяа Замын-Үүд сумын Засаг дарга, Эрээн хотын Засаг дарга тийм ээ, консул бид бас үйл ажиллагаа уялдуулах ёстой юм байна лээ. Ийм байдлаар зөвхөн автобусаар нийтийн тээврийн хэрэгслээр гарахаас гадна иргэд маань аятай тухтай өөрсдийн хувийн унаагаараа бас

хил хооронд 2 боомтын хооронд бас гарах бололцоо боломжийг бас ойрын үед бүрдүүлэх талаар бас анхаарч ажиллаж байгаа гэдгийг бас хэлье. Өнгөрсөн 7 хоногт манай яамныхан газар дээр нь ажиллаад ирсэн, тодорхой шийдлээ энэ 7 хоногт бидэнд танилцуулна.

**Л.Мөнхбаатар:** Дэлгэрсайхан гишүүний асуултад ажлын хэсгээс нэмж хариулъя. 88 дугаар микрофон Батболд дарга хариулъя.

**С.Батболд:** Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ Замын-Үүд Эрээний хооронд суудлын автомашин явахыг манай талаас бол хориглосон зүйл бол байхгүй. БНХАУ-ын талаас хил нээхдээ бол энэ зөвхөн зорчигч тээврийн том оврын автобусаар авна гэдэг ийм байдлаар явж байгаа юм. Гэхдээ энэ суудлын автомашинаар явж байгаа энэ тээвэрлэлт бол манай авто тээврийн хэлэлцээрээр зохицуулагддаггүй эд байгаа. Авто тээврийн хэлэлцээрээр зорчигч тээвэр гэдэг нь бол 8-аас дээш хүний суудалтай ийм үүнийг тээврийн хэрэгслээр явдаг. Тээвэрлэлтийг манай авто тээврийн энэ хэлэлцээр зохицуулж байгаа. Үүнээс дооших таны хэлж байгаа энэ суудлын автомашинаар явагдаж байгаа тээвэрлэлт бол боомтын дэглэмийн хэлэлцээрээр явагдаж байгаа. Энэ боомтын дэглэмийн хэлэлцээр дээр журам байх ёстой гээд заачихсан. Энэ журмыг гаргах талаар Хууль зүйн яам, ГХЯ, манай 3 хамтарч ажиллаж байгаа. Манайх бол саналаа өгчихсөн. Энэ хэлэлцээрээр бол зохицуулагдаж байгаа. Тэгэхээр Хятадын талд манайхан, ГХЯ, Хууль зүйн яам бол энэ дэглэм юу хэлэлцээрийнхээ хүрээнд журмаа хурдан боловсруулаад, 2 тал ярилцаад энэ тээвэрлэлтийг явуулъя гэж тохирсон байгаа юм байна лээ. Түүнээс яг авто тээврийн хэлэлцээрээр энэ бол зохицуулагддаггүй, үүгээр хориглосон ийм асуудал бид одоогоор тавиагүй байгаа.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тодруулах юм уу, Дэлгэрсайхан гишүүн тодруулга 1 минут.

**Б.Дэлгэрсайхан:** Үгүй ээ, Батболд дарга аа, ингээд байгаа юм л даа, манай Замын-Үүдийн иргэд маань энэ Истана ч билүү нэг энэ нэг бага оврын нэг 8 хүний суудалтай машинаар л гаръя гээд байгаа шүү дээ. Тэгэхээр та сая бол энэ бол болно гээд байгаа юм. Тэгээд автобус бол тэртээ тэргүй энэ авто тээврийн газар өөрөө зохион байгуулаад орон нутгаас нэг ч автобус гардаггүй. Улаанбаатараас л автобус явдаг. Тэгэхээр тэнд байгаа иргэд бас нэг амьдрахын тулд бас нэг тодорхой хэмжээ, нэг хэсэг нь нэг тэр жижиг оврын тэр машинаараа зорчигч тээвэрлээд тэр орон нутгийн иргэдээ оруулж гаргаад ингээд явъя л гээд байгаа юм шүү дээ. Яг ч бас тэнд нэг тансаг машин уначихсан иргэд бас байхгүй. Тэгэхээр үүнийг бас нэг ялгаж салгаад яг тийм 8-аас дээш юмыг зохицуулж болж байгаа юм бол үүнийг нь нэг зохицуулаад өгөөч ээ гэдэг юм яриад байгаа юм.

Хоёрдугаарт бол энэ босоо тэнхлэгийн замаар угаасаа нэг юмыг хэлмээр байгаа юм. Энэ юу гэдэг юм энэ ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Дэлгэрсайхан гишүүн гүйцээгээд асуучих, 1 минут.

**Б.Дэлгэрсайхан:** Энэ босоо тэнхлэгийн замаар ерөөсөө энэ уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэхгүй байх асуудлыг л ярихгүй юм бол энэ ерөөсөө ингээд юу ч байсан ялгаагүй ингээд яваад байгаа юм. Тэгээд энэ сая сайд ярилаа. Энэ төмөр зам дагасан нэг баахан ачаа ковидын үед явсан. Уул нь бол аль хэдийн танай яам зогсоочихсон мөртөө энэ өртөө зөрлөгүүд дээр байгаа ачаа нь ерөөсөө багасдаггүй. Одоо та нар өөрсдөө явж үзсэн шүү дээ. Яагаад багасахгүй байгаа юм гэхээр нөгөө л нэг туг тойроод тэгээд янз бүрийн жижиг уурхайнуудын нэр бариад ирээд буугаад л байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг яах юм. Үүнийг хэн хяналт тавих юм. Тэгээд нэг

300 хэд байна гээд түрүү сард хэлсэн одоо 490 мянга байна л гээд. Тэгээд нөгөө буцаад л ингээд овоороод байгаа байхгүй. Тэгээд энэ асуудлаа тэр чинь дандаа л шороон замаар Таван толгойгоос ирсэн байж таараа шүү дээ. Ямар шувуу шиг нисээд ирээгүй нь л лав байгаа юм. Тэгэхээр энэ ерөөсөө тийм шийдэгдэхгүйгээс болоод тэгээд энэ тээвэр хулгайн тээвэр тэгээд энэ вагоны асуудал чинь ингээд үргэлж ингээд хэрүүл ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Дэлгэрсайхан гишүүн их тодорхой асуулт асуугаад байна шүү дээ. Энд нь нэг тодорхой хариулчихъя. Ажлын хэсэг хариулах уу. Батболд дарга 88 дугаар микрофон.

**С.Батболд:** Таны саяын эхний асуулт тэр 8-аас дооших нь бол тэр боомтын хэлэлцээр буюу тэр боомтын хэлэлцээрийг яг хэрэгжилтийг нь ГХЯ, Хууль зүйн яам 2 хариуцаж байгаа юм. Тийм түүнээс яг манайх бол хэрэгжилтийг нь хариуцаж байгаа биш. Тэгэх дээр энэ тал дээр харин тэр журмаа гаргахаар энэ бол шийдэгдчих боломжтой асуудал. Бид бол журмынхаа төслийг өгчихсөн. Өшөө эрчимжүүлэх тал дээр бид ажиллая тэгээд энэ болох байх.

Яг тэр босоо тэнхлэгийн авто замын дагуу хэрвээ магадгүй бид нар уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж болохгүй гэдэг ямар нэгэн эндээс чиглэл өгвөл тийм шийдвэр гарвал үүнийг хориглож болох байх. Түүнээс бид нар тэр даацдаа л хэтэрч явж байвал яг үүнийг ачааны төрлөөр нь бас шууд ялгаварлаад зогсоох бас боломжгүй байгаад байгаа юм. Энэ дээр. Энэ олон улсын гэрээгээрээ ч гэсэн бид хүлээчихсэн. Энэ коридор маань өөрөө олон улсын авто зам байгаад байгаа.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Байнгын хорооны саналаар хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг маргааш өглөө 10 цагаас санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг маргааш өглөө 10 цагт явуулъя.

17.44 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

**УИХ-ын гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, УИХ-ын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Гишүүд танхимдаа орж ирье. Уг асуудлаар санал хураалт явагдах учиртай.

**Н.Энхболд:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, УИХ-ын гишүүн Жамьянгийн Мөнхбат Монгол УИХ-ын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасны дагуу УИХ-ын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ УИХ-д 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн.

ТББХ УИХ-ын гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг Монгол УИХ-ын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

УИХ-ын гишүүн Жамьянгийн Мөнхбатаас ирүүлсэн УИХ-ын гишүүнээс чөлөөлөх тухай хүсэлтийг ТББХ-ны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзлээ.

Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Их Хурлын гишүүнийг чөлөөлөх тухай асуудлаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Адьшаа гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүн асуултаа асууя.

**Б.Энхбаяр:** Мөнхбат гишүүн бол өөрийн саналаараа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан гэж ойлгож байгаа. 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталснаас хойш сүүлийн 30 жилд өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байгаа хэд дэх гишүүн болж байгаа юм бол? Бавуугийн Лхагвасүрэн гуай, Жанцанноров гуай, Цахиагийн Элбэгдорж, Хүрэлсүх, Шаравдорж, Амаржаргал гээд бас олон гишүүд өөрийн хүсэлтээ гаргаж байсан. Нэлээд нь бол УИХ хүлээж авч шийдвэрлэж байсан. Зарим тохиолдолд бас шийдвэрлэхгүй, чөлөөлөхгүй гэсэн шийдвэр гарч байсан тохиолдлууд бас байдаг.

Тухайлбал Шаравдорж гишүүнийг бол чөлөөлөхгүй ээ гээд авч үлдэж байсан юм байна лээ. Амаржаргал гишүүнийг бол чөлөөлөхгүй ээ гээд авч үлдэж байсан юм байна лээ. Тэгэхээр энэ кэйсүүд бол бас парламентын ёсны төлөвшилд цааши цаашидаа бас ийм тохиолдлууд бас гарах байх. Тэгэхээр үүний цаана ямар шалтгаан хүчин зүйл байдаг юм? Тэр хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийг бас яг хууль зүйн хувьд юу гэж ойлгож хэрэглэдэг байх болох юм бол. Үүнийг ер нь зүгээр улс төрийн утгаар нь заавал үндэслэл шаардахгүйгээр хэрэглэдэг байх уу? Гарцаагүй үндэслэл гэдгийг ер нь яг бас яг юу гэж ойлгодог байх вэ гэдэг асуудал бол бас энэ чухал асуудал. Яагаад гэхээр УИХ бол Үндсэн хуульд зааснаар 4-ний гурвын ирцтэйгээр УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжтай гэж Үндсэн хуульд заасан байдаг. Энэ нь бол 57 гишүүн байгаа, 57-оос доошоо орвол УИХ бүрэн эрхийн чадамжгүйд тооцогддог учраас бас энэ асуултыг асуумаар байна.

**Л.Мөнхбаатар:** Энхбаяр гишүүний асуултад УИХ-ын гишүүн, УИХ-ын гишүүний халдашгүй байдлын

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дэд хорооны дарга Нямаагийн Энхболд хариулъя.

**Н.Энхболд:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Ер нь байнгын үйл ажиллагаатай УИХ үйл ажиллагаа явуулж ирснээс хойш УИХ-ын гишүүнээс чөлөөлж байсан 13 тохиолдол байна. Үүнд: Бямбасүрэн өөрийнхөө хүсэлтээр Д.Бямбасүрэн, М.Энхсайхан хүсэлтээр нь, Н.Жанцанноров өөрийнх нь хүсэлтээр, Элбэгдорж Ц.Элбэгдорж өөрийнх нь хүсэлтээр, Ж.Бямбажав өөрийнх нь хүсэлтээр, Ерөнхий сайдаар томилогдсонтой нь холбогдуулаад ишг санаж байна. Ж.Бямбадорж өөрийнх нь хүсэлтээр, Ерөнхийлөгчөөр сонгогдсон Энхбаяр энэ хуулиараа, Ухнаагийн Хүрэлсүх 12 онд өөрийнх нь хүсэлтээр, 18 онд өөрийнх нь хүсэлтээр Дорждугарын Гантулга, 20 онд өөрийнх нь хүсэлтээр Б.Батзориг, 20 онд мөн өөрийнх нь хүсэлтээр Сумъяабазар нарыг чөлөөлж байсан байна. Нэгдүгээр асуултад хариулахад.

Байнгын хороон дээр энэ асуудлыг хэлэлцэх үеэр бол асуусан, санал хэлсэн гишүүн гараагүй. Тэгэхдээ Энхбаяр гишүүний энэ ярьж байгаа асуудлыг бол цаашдаа УИХ анхаарах нь зүйтэй гэж бодож байна. Ялангуяа ер нь 57 гишүүнтэй болчиход бүрэн эрхээ хэрэгжүүлэх ийм чадамжтай болсон гэж үздэг.

Нөгөө талаар жишээ нь орон, гарвал нөхөн сонгууль явж байх ёстой ийм хуулийн заалттай. Тэгээд энэ цаг хугацааны асуудал бусад нөхцөл байдлуудыг зөвхөн энэ удаа ч биш ер нь цаашдаа харгалзаж үзэж энэ тохиолдолд яаж байх ёстой гэдгийг ярилцах шаардлагатай юм байна лээ. Хуулийнх нь зохицуулалтыг харж байхад. Одоо бол хэд хэдэн шалтгаанаар Их Хурлын гишүүнээс чөлөөлөх ийм заалтууд байгаа. Энэ дотроос өөрийнх нь хүсэлтээр чөлөөлж болно гэсэн заалт байгаа. Үүний дагуу өргөдлөө өгсөн байгаа, гишүүн маань. Түүний дагуу ТББХ дээр хэлэлцээд

олонхоороо хүсэлтийг нь хүлээж авах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан.

**Л.Мөнхбаатар:** Үг байгаа. Асуултын дараа үг байгаа. Энэ дээр үг хэлж болно. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр Мөнхбат гишүүн УИХ-ын гишүүнээс чөлөөлөгдөх асуудлыг УИХ хэлэлцэж байна. Тэгэхээр бол ТББХ-ны даргын үүрэг гүйцэтгэгч, Халдашгүй байдлын дэд хорооны дарга Энхболд дарга л хариулах юм байна гэж ойлгож байгаа. Энэ Их Хурлын дарга нь хаачсан юм бэ, энэ чинь одоо энэ өөрөө парламентын гишүүний асуудал ярьж байхад Их Хурлын удирдлага уул нь байж байвал зүгээр юм ишг санагдаж байна.

Тэр түрүүн УИХ-аас чөлөөлөгдөх кэйсүүдийн тухай ярьж байна. Тэгэхээр Шаравдорж гуайн тухайд бол Монгол Улсын Дээд шүүхийн дарга болно гэдэг үндэслэлээр чөлөөлөгдөх гээд УИХ хүлээж авахгүй байсан тийм түүхэн баримт байдаг юм байна лээ. Дээр нь энэ чөлөөлөгдөх гэсэн бүх хүмүүс өөрсдөө энэ Их Хурлын танхим дотор сууж байсан. Гэтэл өнөөдөр Мөнхбат гишүүн өргөдлөө өгсөн гэгчхээд өөрөө байхгүй байна. Тэгэхээр энэ өөрөө байхгүй байгаа хүний асуудлыг ингэж хэлэлцдэг тийм хууль эрх зүйн талаасаа ямар үүнийг боломж ямар хууль, эрх зүйн үүднээс үүнийг хэлэлцэж байх ийм боломж бүрдсэн гэж үзэж байна.

2 дахь асуудал. Ингээд энэ Их Хурлын гишүүнийг байхгүй байхад нь ингээд энэ Их Хуралд санал хураалт явуулаад, бүрэн эрхээс нь энэ чөлөөлчихвөл ингээд энэ УИХ-ын гишүүнийх нь бүрэн эрх дуусгавар болсон гэж үзэх үү, юу гэж үзэх вэ гэдэг энэ 2 асуултын хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүний асуултад ТББХ-г төлөөлж Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

**Н.Энхболд:** Түрүүчийн асуултыг үргэлжлүүлээд арай дэлгэрэнгүй тайлбар өгчихье. Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон, хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрөө чөлөөлөх хүсэлтээ гаргасан, хүндээр өвчилсний улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлтэд гарсан, цэцийн зааснаар гишүүнийг эргүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Их Хурал зөвшөөрсөн. ҮХЦ гишүүнийг тангаргаасаа зөрчсөн гэж үзвэл тэрийг нь УИХ хүлээн зөвшөөрсөн, гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийдэх тогтоолоор тогтоогдсон, нас барсан ийм 7 тохиолдолд УИХ-ын гишүүнийг бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох хуулийн үндэслэлүүд болж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт яг энэ асуудлыг хэлэлцэх үеэр тухайн хүсэлт гаргасан, өргөдөл гаргасан хүнийг өөрийг нь заавал байлгаж байж хэлэлцүүл гэсэн эрх зүйн зохицуулалт байхгүй. Бид бас Их Хурлын зүгээс холбогдсон, өөрөө өргөдөл дээрээ их тодорхой бичсэн байгаа. Ээжийгээ эмчлүүлэхээр гадагшаа явсан гэж гадагшаа эмчлүүлэх шаардлагатай байна гэж. Тэгээд би очиж чадахгүй байна, ээжийгээ эмчлүүлэх ажилтай яваа. Миний асуудлыг хэлэлцэж УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хүсэлтийг ёсоор болгож өгөөрэй, өгч болно гэсэн ийм бас зөвшөөрөл гэхэд хаашаа юм, ямар ч байсан өөртэй нь холбогдсон. Тэгээд хуулийн зохицуулалт өөрөөр байхгүй учраас Байнгын хороон дээрээ ирээд шийдсэн гэдгийг тайлбарлая.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүн яах юм тодруулах юм уу, та тодруулга 1 минут өгчихье.

**Ш.Адьяа:** Энхболд гишүүний хариултыг сонслоо. Тэгэхдээ бид нар энэ өнөөдөр энэ хэвлэлийн хэмжээнд, сошиалын хэмжээнд л ингээд мэдээлэл

аваад байгаа л даа. Тэгээд сүүлийн үр дагавар нь юу болохыг сайн мэдэхгүй байна. Гэтэл бас энэ Аюурсайхан гишүүн бас л өргөдлөө нэг өдөр өгсөн гээд л ийм асуудал яригдаад байсан. Тэр яг өгсөн юм уу, өгөөгүй юм уу. Энэ бас Халдашгүй байдлын дэд хорооны даргаас асууя.

Ингээд Мөнхбат гишүүнийг бид санал хураагаад эрхийг нь ингээд цуцалчихдаг юм байна. Бүрэн эрхийг нь. Тэгээд 6 сард сонгууль болох уу, яах вэ? Энэ талаар бас нэг хариулт авмаар байна.

**Л.Мөнхбаатар:** Адьшаа гишүүний тодруулгад ТББХ-г төлөөлж Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

**Н.Энхболд:** Нэгдүгээрт, Мөнхбат гишүүний өргөдлийг хэлэлцэх хуралдааны үеэр гишүүдээс ямар нэгэн асуулт, ямар нэгэн санал гараагүй ээ. Ингээд саналаа өөрөө олонхоороо шийдсэн. Хуулиар бол орон, гарсан нөхцөлд дараагийн сонгууль болохоос 6 сарын өмнө орон, гарсан нөхөн сонгууль явах ийм зохицуулалт байгаа. Тэгээд үүнийг ярих хэрэг гарах байх гэж бодож байна.

Тэгэхдээ дээр нь дахиад тэр сая Энхбаяр гишүүний тавьсан асуулт бас өөрөө их утгатай, бодох ёстой асуулт байгаа юм. 57 гишүүн байхад УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэн чадамжтай үйл ажиллагаагаа явуулж ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Энхболд гишүүн гүйцээгээд хариулчих уу. Хариулт болсон гэж үзэж байна.

Нямаагийн Энхболд гишүүн гүйцээгээд хариулчих.

**Н.Энхболд:** Аюурсайхан гишүүн УИХ-ын гишүүнээсээ чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тухай өргөдөл хүсэлт манай Байнгын хороон дээр ирээгүй ээ.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Үг хэлэх УИХ-ын гишүүд байна уу.  
Алга байна.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууссан байна.

Одоо УИХ-ын гишүүн Жамьянгийн Мөнхбатыг УИХ-ын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг ирүүлсэнтэй холбогдуулаад Жамьянгийн Мөнхбатын УИХ-ын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн ТББХ-ны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтыг, саналын томьёоллоор илээр явуулна.

Санал хураалт явуулна. Чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн ТББХ-ны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

59.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал дэмжигдсэн тул УИХ-ын гишүүнээс чөлөөлөх тухай УИХ-ын тогтоол баталсанд тооцогдлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

УИХ-ын гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол УИХ-ын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 10.2, 10.3 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1. Жамьянгийн Мөнхбатыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн УИХ-ын гишүүнээс чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

Тогтоол учраас ингээд энгийн горимоор шийдэгдэж байгаа.

ЗГ-ын гишүүнээс чөлөөлөх тухай Ерөнхий сайдын танилцуулгыг маргааш танилцуулъя гэсэн үү. ЗГ-аас маргааш танилцуулъя гэсэн саналыг ирүүлсэн юм байна.

Тэгэхээр өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**  
**П.ОЮУНГЭРЭЛ**